

ГЭЛЭН ЛАМ ТҮВДЭН ЖАМЦ

БУДДИЗМ БИДНИЙ АМЬДРАЛЫН ХЭМНЭЭЛД...



Уг номоо орноо *Энэ номоогийг шашин*
дүүрэн саран тэт арвидангүйн гуанз зориулсан
43 талдан орувчой

Буддизм бидний амьдралын хэмнэлд

Зохиолч: Түвдэн Жамц

Орчуулсан: Г.Гүнжиймаа

Редактор: Б.Идэрбаяр

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Удиртгал

Арванзургаадугаар зууны үед Монголын цэрэг дайчид Хятадад “Гэлүгвэ” (“Шар малгайтан”) ёсны нэгэн хуврагыг олзлон баривчилжээ. Хуврагын биеэ авч явах намба байдал нь цэргүүдэл ихэд гайхагдсан тул өөрийн Алтан Хаанд аваачжээ. Монголын их хаанд өнөөх хуврага өндөр сэтгэгдэл төрүүлсэн тул хуврагын багш Содном Жамцыг Монголд ирэхийг тушаалаа. Энэ зарлиг нь цаанаа, хэрэв ирэхгүй бол Төвд орныг дайрна гэсэн утгатай байжээ. Тиймээс, 1578 онд, Содном Жамц Монголд морилж, Алтан хааны багш боллоо. Хаан зарлиг буулган, Бурханы шашиныг Монголчууд шүтэх болсноор түүний аймшигт дайчид эрс хуяг дуулга, жад сэлмээ буулгаж, хувраг болцгоожээ.

Алтан Хаан, Содном Жамц багшаа “Далай мэт гүн мэдлэгтэй” гэсэн утгыг бэлгэдэн “Далай Лам” хэмээх болжээ. Гэлүгва ёсыг үндэслэгч Богд Зонховын хоёр их шавийн нэг Гэндэн Дүвийн хойд дүр Гэндэн Жамц, Гэндэн Жамцын хойд дүр нь Содном Жамц байсан учраас түүнийг Гуравдугаар “Далай Лам” хэмээн алдаршуулжээ. Өмнөх хоёр дүрд энэ алдрыг мөн адил дуурсгах болжээ.

Монголчуудад Бурханы шашин шүтэхийг хүчээр хэзээ ч тулгаагүй юм. Урьд байгаагүй цэргийн амжилтаар Монгол удирдагчид болон цэргүүд хүссэн эд зүйлээ олох эрх мэдэл, эд хөрөнгөтэй байсан ч эрсэн аз жаргалд хүргэж чадахгүй байсан нь Бурханы сургаалийн үндсэн үнэнд сэтгэлээ нээхэд хүргэсэн юм. Өнөөдөр хөгжилтэй орнуудад Бурханы шашиныг сонирхож байгааг мөн ийм шалтгаанаар тайлбарлаж болно. Жаргалд цэнгэх өргөн бололцоо байсаар байтал сэтгэл ханахгүй, таагүй үнэнийг мэдэн урам хугарах нь олон хүн жинхэнэ жаргал, зовлонгийн шалтгааныг хайхад хүргэсэн бөгөөд Бурханы сургаал тэдгээр бүхний хариултыг өгсөн юм.

Монголчууд Төвдийн Бурханы шашиныг өвлөн авсан, зөвхөн суралцах болон хэрэгжүүлэхэд мэргэшээд зогсохгүй түүний салбар ухаанууд, жишээ нь, урлахуй ухаан зэргийг эзэмшсэн хурд нь өнгөрсөн олон зуунд дэлхийд урьд өмнө гарсан хурдан эзэрхийлэлтэйгээ адил байлаа. Бурханы сургаалийн ачаар Монголчуудын зонхийн сэтгэлзүй Бурхан болон Бурханы сургаал, энэрэнгүй сэтгэл, билиг ухаанд сүжиглэх эрхэм чанаруудын адислалыг хүртсэн юм. Бурханы хутгийн зам мөрт олон эрдэмтэд дээд шид бүтээлийг олж, ирээдүй хойчийн үед зориулан тэрхүү сургаалийг хадгалж өвлөсөн түүхтэй.

Хорьдугаар зууны эхэн үед Монгол орны нүүр царай огцом өөрчлөгдөн хувирсан юм. Оросын коммунистууд энэ улсыг хяналтдаа авч, долоон зуу гаруй сүм хийдээс тавыг л үлдээж, хуврагуудыг хомроглон хөнөөсөн юм. Улаанбаатар хотын захын хороолол болох “Шар хад”-ны нэр нь газар зүйн онцлогоос бус шар нөмрөгтэй хүмүүсийг тэр газар алж, оршуулахад уул хад шиг болсон учраас тийм нэртэй болжээ. Бурханы ном сургаалыг үзэх, түүгээр явах нь хориотой болж, Монголын гурван үе өөрийн соёл, өвөөсөө хагацсан юм.

1999 онд Монгол оронд ирэхээсээ өмнө би багш нарынхаа нэг болох хүндтэй Төвд лам багшдаа өргөл өргөж, Монголд Бурханы номыг заах ажлыг маань амжилттай болгоход адис авахаар очсон юм. Лам багш маань: “Өргөл өргөх ёстой хүн бол харин би байх ёстой. Монголын ард түмэн их энэрэнгүй сэтгэлийг төлөвшүүлэх болон хэрэгжүүлэх талаар үнэт

эрдэнэ сургаалыг хадгалан өвлөж ирснээрээ дэлхий нийтэд цаглашгүй их буянтай ард түмэн билээ. Одоо тэдэнд туслах цаг болсон, тэдний ачийг хариулахад туслахаар явах гэж байгаа нь сайн хэрэг” гэж билээ.

Миний хувьд, Монгол орны талаар мэдэхгүй байлаа. Энэ орныг мэдэхэд нөлөөлсөн болов уу гэмээр эсвэл гашуун үнэнийг мэдэх эх үүсвэр болсон цөөн хэдэн урьдчилан тогтсон бодолтой байлаа. Христосын эвангелистууд Бурханы шашины сүүлийн хэсгийг устгахыг оролдож байгаа тухай зарим мэдээллийг сонссон юм. Нээрээ ч, Христосын бүлгүүд Монголын ард түмнийг өөрийн шашинд оруулах оролдлогыг хийж байгаа нь тодорхой, гэхдээ энэ нь дангаараа төвөгтэй зүйл гэж би бодохгүй байна. Миний ажигласнаар, жинхэнэ ёсоор Бурханы сургаалийн боловсролыг сүм хийдүүд болон сүсэгтнүүдэд олгох нь дөнгөж сэргэж эхлээд байна. Монголчуудын ихэнх нь эргэлзэхийн аргагүй Бурханы шашинтанууд боловч сүжгээ түшиж тулах хангалттай мэдлэггүй учраас Бурханы шашины эсрэг Христос номлогчдын ухуулга, буруу мэдээллийг няцаах чадвар хязгаарлагдмал байдаг.

Буддистууд хэрэв эе эвтэй зэрэгцэн оршиж, тэрсэлдэгч талд хуваагдахгүй бол Монголчууд Бурханы шашины өвөө дахин сэргээж, дэлхийд энх амгалан, харилцан ойлголцлын бүсийг буй болгож чадна. Бурханы зам мөр нь нийгмийн үзэл баримтлал биш гэдгийг ойлгох нь чухал. Сургаалийг хувь хүмүүст зориулсан байдаг. Тэдгээр сургаал нь Бурханы хутагт хүрэх бүрэн бололцоондоо хүрэхийг хүсэж байгаа хүмүүст зориулсан зам мөрийг заадаг. Энэ зам мөр нь бусдыг хорлохгүй байх ариун сахил санваарыг сахиж амьдрахаас эхлэх ба түүгээр дамжуулан өөрийн номоо үргэлжүүлэн суралцах зохимжтой газар төрөх шалтгааныг бүтээдэг. Төгс төвлөрөлийн байдалд эцэст нь бодит байдлыг үздэг, энэ билиг ухаан нь мунхаг буюу өөрийн эрхгүй төрөх болон бүх зовлонгийн үндсийг арилгадаг. Зам мөрийн сүүлд бусдын төлөө ариун сэтгэлийг төрүүлж, Бурханы хутгийг олох бөгөөд түүгээр зургаан төрлийн дотор хаа ч төрж чадах ба бусдыг мөн тэр мөрд хөтөлдөг.

Тухайн нийгэм жинхэнэ утгаараа амар амгалан байх эсэх нь хичнээн олон хүн мунхаг, уур, шуналаас ангижиран, билиг ухаан, асран хайрлах сэтгэлийг дадуулан хөгжүүлэх зам мөрийг дагахаас хамаарна. Өнөөдөр дэлхийн аймшигтай байдал нь шунал, соёлын дээрэнгүйлэл, тэвчээргүйдэл ба үзэн ядалтын зам мөрийг дагасны үр дагавар юм. Дэлхийн салхийг дагахын оронд, харин Буддын шашины өв уламжлалаа сэргээснээрээ Монгол улс дэлхийд тэргүүлэх цаг ирнэ гэдэгт би итгэл төгс байнам.

Миний багш Түвдэн Зопа Ринбүүчий намайг Монголд ирж, өөрийн нээхээр зэхэж байсан Бурханы шашины төвд сүсэгтнүүдэд ном айлдахаар ирэхийг хүссэн юм. 1989 онд Монголын ард түмэн шашин болон улс төрийн эрх чөлөөтэй болоход Монгол Улсад суух Энэтхэг Улсын анхны Элчин сайдын албыг хашиж байсан Ладагийн их ламтан Бакула Ринбүүчийн шинээр үүсгэн байгуулсан хийдэд яриа хичээл хийснээр Монголд дахь үйл ажил маань эхэлсэн юм. Миний онцгой сайн туслагч бөгөөд тайлбарлагч Гүнжиймаа дээрх ярилцлагуудыг монгол хэлнээ тайлбарласан юм. Мөн хугацаанд өөрийн гэрт Монголд суугаа гадаадынхан болон англиар яригч монголчуудад зориулан долоо хоног бүр англи хэлээр ярилцлага хийж, бясалгал заадаг байлаа. Англиар хэвлэгддэг Монгол Мессэнжер сонины дэд эрхлэгч байсан Майкл Кон тус ярилцлагад хэдэн удаа суусны эцэст тогтмол нийтлэл бичиж дээрх сонинд хэвлэн гаргах саналыг гаргасан билээ. Энэ номд багтаж байгаа өгүүллэгүүд нь тус сонины

2001-2002 оны дугааруудад цувралаар гарсан нийтлэлүүдийг дахин шүүсэн хувилбар юм.

Уг нийтлэлүүд нь Бурхан багшийн сургаалийг өөрийн туршлага, ойлголтын үүднээс тодорхой тайлбарлахыг хичээсэн оролдлого юм. Янз бүрийн сэдэв сонгосон боловч ерөнхийдөө Бурхан багшийн сургаалийн гол утга санааны дийлэнхийг агуулсан бөгөөд анх нийтлэгдсэн дарааллыг өөрчлөөгүй болно. Өгүүлэл бүрийг дангаар байлгах бодолтой байсан боловч түүвэр дунд зарим давталтыг тойрч гарах аргагүй байсан нь тухайн санааг онцолж байгаа хэрэг юм.

Олон хүмүүс надтай гудамжинд тааралдахдаа түр саатаж, нийтлэл бичсэнд талархлаа илэрхийлж байсан болохоор монгол хэлнээ орчуулах талаар Гүнжиймаад хандсан бөгөөд ном болгон хэвлэж, үнэ төлбөргүй тараасан юм. Энэхүү ном нь орчин цагийн монгол хэлээр гарсан Бурханы сургаалийн талаархи анхны номуудын нэг гэж хүмүүс надад хэлсэн юм. Өмнө гарсан энэ чиглэлийн ном бичвэрүүд төвд хэл болон сонгодог монгол бичгээр үлдсэн байдаг учраас жирийн хүмүүс ойлгох бололцоогүй байдаг.

Энэхүү анх удаа англи хэлээр эмхэтгэн хэвлэх нийтлэлүүдийг дахин бичих ажилд урам зориг хайрласан бүх хүмүүст талархалаа илэрхийлье.

Адриэн Фельдман (Түвдэн Жамц)

2003 оны 1-р сар

Энэрэнгүй сэтгэл

Энэрэнгүй сэтгэл бол амьдралын гачаал, зовлон тулгарсан нэгнийг ойлгон мэдэрч, тэдэнд туслах санаа бүхий буяны сэтгэл бөгөөд энэ сэтгэлийг их шашнууд дээдлэн хүндэлж, номлодог билээ. Энэрэнгүй сэтгэл нь Бурханы шашинтан хүний амьдрах хэв маягийн хоёр тулгуурын нэг нь бөгөөд удаах нь, бидний зовлонгийн уг гарвал ба түүнээс гэтлэн гарч түр зуурын хийгээд туйлын амар амгаланд хүрэх аргыг танин мэдэх билиг ухаан байдаг. Өөрийн дүр төрхийн (имиж) хуурамч мөн чанарыг алдаагүй үнэнээр таньсан уг билиг ухаан нь муу сэтгэлийн үндэсийг тасалж, үүрдийн амгаланг олгодог. Өөрийгөө хэрхэн авч үзэх талаархи төөрөгдөл нь амьдарлын хүрдэнд олон дахин төрөл авахад хүргэдэг. Бурхан багшийн сургаал ёсоор, буяны үйл нь их амгалан орны тэнгэр хийгээд хүний төрлийг олоход хүргэдэг бол нүглийн үйл нь адгуус, тамын амьтан, цөл газрын өлсгөлөн бирд болж төрөхөд хүргэдэг. Эдгээр бүх төрлүүд түр зуурын байдаг учраас удалгүй үхэж, үйлийн үрээсээ хамааран өөр төрөлд төрцгөөдөг. Энэ хүрдний хаана ч бодит байдлын тухай төөрөгдөл болон түүнээс үүдэн гардаг зовлонгоос эрх чөлөөгүй байх учраас хүрдэн дотор төрөл авдаг бүх төрөлхтөнийг энэрэнгүй сэтгэлээр тэтгүүштэй.

Сансарын хүрдэнд хүлж байгаа цалмыг тасалсан цагт л гагцхүү зовлонгоос бүрэн гэтэлнэ. Энэ бол бүхнийг устгаж үгүй болгох юмуу бусдыг орхиж байгаа хэрэг бус. Энэ бол жирийн амьдралд тохиолдох бэрхшээлд хорлогдолгүй эрх чөлөөтэйгээр оролцох буюу энэ ертөнцөд байгаа хирнээ энэ ертөнцийнх биш байхыг хэлж байгаа юм. Ийм байхыг хичнээн их хүсэж залбирдаг билээ дээ?

Хэдийгээр бид тодорхой хэмжээгээр энэрэнгүй сэтгэлтэй боловч голдуу жигд бус бөгөөд хүчгүй байдаг. Зарим хүмүүсийг хайрлан, нөгөөд дургүй хүрнэ, дуртай хүмүүстэйгээ ч гэсэн тодорхой хязгаарт нөхөрлөдөг. Миний анхны лам багш нарын нэг Түвдэн Ешэ багш барууны орны шавь нарынхаа хооронд болдог өчүүхэн юманд маргаж, өрсөлдөж, атаархаж, уурлах гэх мэт байдлыг анзааран, тэдэнд хандаж: “Та нар хүмүүс байж нэг нэгийгээ гэрийн тэжээврээ хайрлахаас ч доор байгааг хараад би гайхширч байна” гэж билээ.

Би одоо хүртэл ийм нэг бэрхшээлтэй тэмцсээр байгаа. Үүнд: надад дургүй юмуу үнэлэмжийн хувьд тэс өөр хүмүүсийг энэрнэ, сайн сайханд нь санаа тавина гэдэг хэцүү байдаг. Хүн өөрийн өссөн нийгмийнхээ ёс суртахуунд тулгуурласан ертөнцийг үзэх үзэлтэй болж, өөрт хуримталсан туршлага, итгэл үнэмшилээр цутгасан хэв загварт орсон байдаг. Хүн бүр өөрийнхөө үнэлэмжийг мэдээж хамгийн зөв гэж боддог, хэрвээ тэгж боддоггүй бол түүнийг баримтлахгүй шүү дээ. Өөрийгөө төвчлөх дотоод үзлээс шалтгаалж бидний үзэл бодол амиа хичээх бодлоор бохирддог тул бусдын үзэл бодлыг ойлгох юмуу хүлээн зөвшөөрөхөд хаалт болдог. Үүнээс болж өөрчлөлтөнд эсэргүүцдэг. Өөр сонголтын хандлагад нүдэн балай болж, өөрийн бодолдоо хөдөлшгүй хатуу зогсож, түүндээ мугуйдлан туйлшрагч хүн болон хувирч энэрэхүй сэтгэлийг огоорч орхидог.

Тийм биш байхыг би өөрөө хичнээн хүсэвч өөрийгөө мугуйдлагч гэдгээ мэдэрдэг. Гэхдээ тийм ч бүр хөдөлшгүй хатуу биш байж магадгүй, Ешэ лам багшийнхаа бусдыг ажиглаад, үзэл бодлыг нь хүндэлж үзэхдээ гайхамшигтай уян хатан, түвшинд нь харьцдаг чадварыг нь дуурайх бололцоо байгаа. Энэ нь өөрийгөө доорд түвшинд аваачиж байгаа юм шиг санагдах

юмуу тийм ч байж магадгүй, гэхдээ өөрийгөө доошлуулж байгаа хэрэг мөн, биш эсэх нь тухайн хүний чин энэрэнгүй сэтгэл хийгээд түүний тулгуур билиг ухаанаас хамааралтай.

Өөрийгөө төвчлөх үзлээс үнэхээр чөлөөтэй болно гэдэг нь бусдад хэрэгтэй дүрийг сонгох чадвар ба өөрийн гэсэн жүжгээ тавьж чадахыг хэлнэ. Амьдрал сайхан болж, хэтэрхий нухацтай байх алдааг гаргалгүйгээр бусдад тусалж чадна. Тэр нь зөв, энэ нь буруу гэж хатуу тогтоосноос болж бүх уян хатан байдлыг алдаж, өөрийн санааг зөв гэж багтай хамгаалах, эсрэг санаа болон түүнийг баримталж байгаа хүмүүсийг дайран үгүйсгэх үүрэгтэй гэж боддог. Дараагаар нь, бусадтай харьцаж чадахгүй болдог. Гэхдээ зөв, бурууг ялгаж салгаж болохгүй гэсэн үг биш, харин тухайн хүн, зарчим хоёрын хүн нь илүү үнэтэй, хүнийг өөрчилж болно, зарчмыг өөрчилж болохгүй юм.

Хоол унд, орон байр, эм тан зэрэг түр зуурын амарыг энэрэнгүй сэтгэлээр өгөх нь сайн, гэхдээ хангалтгүй. Бусдад үнэхээр туслахын тулд зовлонгийн үндсэн шалтгаан буюу би хэмээх мунхаглалыг хэрхэн таних, түүнийг гэтлэн давах аргыг зааж өгөх хэрэгтэй юм. Тэр нь өөрийгөө төвчлөх мунхаглалыг даван туулахыг шаардахаас бус ном бичигт зөвхөн итгэхийг хэлэхгүй. Хүмүүсийг өөрсөддөө хөнөөлтэй тогтсон зуршлаа орхиход нь урам зориг нэмэхийн тулд тэдэнтэй харьцаж чаддаг байх ёстой. Тэдэнтэй харьцахын тулд түвшинд нь зохицуулах ёстой. Амьдралын тайзан дээр тоглож байгаа жүжигчин гэдгээ санаж чадаж байгаа цагт өөрийн зарчмаас ухарсан гэж айлгүй, зарчимдаа үнэнч байх тал дээр санаа зоволгүйгээр бусадтай учир начиртай харьцаж чадна. Билиг ухаан түшсэн энэрэнгүй сэтгэл бол амьдралын төгс дүүрэн бөгөөд ариун зорилго мөн тул үүнийг хэн ч няцааж чадашгүй. Бидний энэрэл бусдад тайвшрал, аз жаргалыг хүртээх бөгөөд түүний зэрэгцээ бусдад хайр, энэрэл хүртээснээрээ хариуд нь өөрөө дээдийн аз жаргалыг мэдэрдэг.

Та тэгвэл ”Хортон амьтан, хүнийг мөн энэрэх хэрэгтэй гэж үү? Тэд нар зовж л байвал зохих шагнал нь тэр гэж баярлах хэрэгтэй юу? гэж асуух байх. Энэ асуултад шууд “Үгүй” гэж хариулна. Зовлонг Ертөнцийн эзний гэсгээл эсвэл муу үйлийн боловсрол гэж үздэг талтай ч бүгд л жаргахыг хүсдэг, зовлонгоос зайлсхийдэг нь яг адил учраас хортой гэж бодож байгаа хүн, амьтныг ч энэрэх хэрэгтэй. Үзэн ядах хийгээд бусдад зовлон хүсэж, өс хонзон санах нь компьютерийн хэллэгээр “үхлийн алдаа” юм. Уураар амар тайвныг хэзээ ч бүтээдэггүй ба харин ч бэрхшээлийг улам ихэсгэдэг. Амгалан хийгээд зовлонгийн жинхэнэ шалтгааны талаарх төөрөгдлөөсөө болж бид бүгд алддаг боловч үр хүүхдээ алдаа гаргасан ч уучилж, хайрласан хэвээр байдаг шиг бусдын алдааг мөн нигүүлсэн хайрлаж чаддаг байх хэрэгтэй. Гэхдээ алдаатай буруу явдлыг өөгшөөж, шийтгэж болохгүй гэсэн үг биш; эсэргүүцэл, тэр байтугай шийтгэлийг ч гэсэн энэрэнгүй сэтгэлээр үйлдэж болдог.

Яагаад бүгдийг хайрлах албатай юм бэ? Яагаад гэвэл, бид урьд төрөлдөө төрөлхтөн бүхэнтэй удаа дараалан ойр шадар байсан юм. Хамаг төрөлхтөн урьд нь бидэнд зүйрлэшгүй их сайхан сэтгэлээр хандаж байсан бөгөөд бүгд бидний садан учраас тэднийг хайрлах нь зүй ёсны хэрэг.

Эдгээр үгсийг би их энэрэнгүй Ешэ багшийн айлдвараас сонссон бөгөөд та бүхэнд давгаж хэлж байгаа юм. Тэглээ ч гэсэн би одоо болтол хувиа бодох үзэлтэйгээ тэмцэж байгаа бөгөөд тэр нь энэрэнгүй сэтгэл төрүүлэх чадварт саад учруулдаг. Буруу зуршлыг нэг өдрийн дотор өөрчилж чадахгүй нь ойлгомжтой. Тийм болохоор өөртөө л өчүүхэн энэрэх сэтгэл үзүүлж

дураараа явна.

Дулаан сэтгэл

Хэзээний анд найзууд уулзах болгондоо нэг нэгэндээ амьдарлаа ярьцгааж, баяр жаргалд нь баясаж, зовлонд нь хамт харуусдаг. Бусдын жаргалд баясах хийгээд түүнтэй холбоотой зүрх сэтгэлээрээ дулаан дотно байх нь хайрын гол утга билээ. Энд өгүүлж байгаа халуун зүрх сэтгэлийн хайр энэрэнгүй сэтгэлийн суурь болдог, яагаад гэвэл, хайрладаг хүмүүсийн сэтгэл зовлонтой байгааг мэдвэл тэднийг зовлонгүй болгох гэсэн энэрэнгүй хүсэл төрдөг. Асрал хайр буюу хайр ба энэрэнгүй сэтгэлийн хослолыг Бурханы шашинд хамгийн дээд, сэтгэлийн гүйцэд боловсрол гэж дээдлэн үздэг. Асрал хайр нь хамаг жаргалын эх булаг бөгөөд энэ ертөнцийн хамгийн үнэт зүйл юм.

Асрал хайр нь амьдралыг тэтгэгч рашаан билээ. Эх хүн хөхөөрөө үрийнхээ биеийг өсгөдөг шиг зүрхнийхээ асрал хайрын илчээр ухааныг нь тэжээн торниулдаг. Хайр энхрийлэл үзээгүй хүүхэд сэтгэл санааны хямралтай, тэр байтугай сэтгэц мэдрэлийн тогтолцоо нь доголдолтой болдогийг анагаах ухаан зөвшөөрч байна. Зөвхөн нялх хүүхдүүд биш. Бид бүгдээрээ амьдралынхаа турш аз жаргалтай, бие сэтгэлийн амгаланд оршихын тулд бусдын асрал хайрд шүтэж байдаг. Яагаад ийнхүү шүтэлцээтэй байна вэ гэвэл, хэдийгээр эхийн хөхнөөс гарсан боловч элэг зүрхнээс нь холдоогүй байдагтай холбоотой. Тиймээс ч эхийн хайр эхнэр нөхөр, найз нөхдийн асрал хайрын хэлбэрээр хэрэгтэй болж, бүр заримдаа эрж шаарддаг. Тийм байх албагүй юм. Жинхэнэ том болсон хүн бол амьдарлын дээд аз жаргал нь бусдад хүртээх хайраас үүдэлтэйг ойлгон, түүнийг ч биелүүлж байгаа, эхийн хайр дутагдахаас чөлөөлөгдсөн хүнийг хэлнэ. Бусдыг төгс хайрлах хэмжүүр нь эхнэр нөхөр, найз нөхдийгөө хайр шаардах хорт зуршлаас нь тэвчээртэйгээр хөтлөн гаргах юм. Тэд ч мөн адил хариу нэхэлгүйгээр бусдыг аз жаргалтай болгох эрх чөлөөт сэтгэлийн цэнгэлийг нээж болно шүү дээ.

Гүн талаас нь үзвэл, асрал хайр нь энэ дэлхийн хамаг жаргалын эх сурвалж юм, учир нь, жаргалтай болоход шаардлагатай дотоод нөхцлүүдийг бий болгодог. Жаргал эдлэхийн тулд тухайн сайхан зүйл байхаас гадна зөв сэтгэлийн болон буянт үйлийн чадамж хоёрын дотоод нөхцлүүд хэрэгтэй. Энэ чадамж бол урьд үйлдсэн хорлолгүй үйлийн үр дагавар бөгөөд хорлолгүй зан төлөвтэй болохын тулд сайхан сэтгэлтэй хөтлөгчийн үлгэр дуурайл хэрэгтэй болдог, үүнд Христ хийгээд Бурхан багш нар юм. Эдгээр хөтлөгч нар өөрсдийн асрал хайраар бусдыг сайн сайхан зан төлөвт удирдан чиглүүлдэг. Тэдэнд өөр бусад зорилго үгүй.

Далаад оны дундуур Бурханы шашинтан болохоос өмнө Төвдийн анагаах ухаан сонирхдог сонирхолдоо хөтлөгдөн би Энэтхэгийн хойд нутагт очиход Дарамсалад суудаг Дулмаа гэдэг уламжлалт анагаах ухааны төвд эмчтэй танилцсан юм. Гималай уулын бэлд Дээрхийн гэгээн Далай лам багштан болон Төвд цагаачид суудаг тэр газар Төвдийн Анагаах ухааны төв нь сургалт, эмчилгээний үйл ажиллагааг нэгэн зэрэг сайн явуулж байсан юм. Дулмаа эмч намайг дагуулж, ажлаа ажиглуулахыг зөвшөөрсөн ба өвчтөнүүдээ үзэж байхад Дулмаа эмчийн ажлын өрөөг өөрийн саяхан ажиллаж байгаад ирсэн Австралийн хүнгүй шахам тасгуудтай харьцуулахгүй байж чадахгүй байлаа. Харьцуулах ямар ч боломжгүй байсан юм. Судас барих болон шээсний хөөсөөр оношлох аргууд нь нэг хэрэг, өвчтөнтэйгээ харьцах байдлаараа үлэмж их ялгаатай байлаа. Тэр өвчтөнүүдээ энэрч, өвчтөнүүд түүнийг хайрлаж байсан юм. Эмнэлэг тэр аяараа асрал хайрын илчээр дүүрэн байсан нь өвчтөнүүдийг хүн гэхээс илүү “өвчин” гэж үздэг миний ажиллаад ирсэн хүний төлөө мэдрэмжгүй эмнэлгийн

уур амьсгалаас тэс өөр байлаа. Тэрээр оношилгоо, эмийн ургамлаар гайхамшигтай эмчлэх арга барилтайн дээр сайн эмч гэж нэртэй болсон нь Дулмаа эмчийн асрал хайрын хүчтэй холбоотой гэдэгт би бүрэн дүүрэн итгэлтэй байлаа.

Барууны анагаах ухааны эмч гэж би биеэ тоосон бардам зантай байсан ч гэсэн Дулмаа эмч надад Төвдийн анагаах ухаанаас зааж өгөхийг зөвшөөрлөө. Надад судас барих, шээсний шинжилгээг тайлбарлаж заасан боловч асрал хайрын тухай ганц үг цухуйлгаагүй билээ. Ердөө л өөрөө харуулсан юм. Хожим нь би Төвдийн анагаах ухааныг гүнзгийрүүлэн судалж байхдаа сурах бичгийн ёс суртахууны тухай бүлэг нь зөвхөн асрал хайрлалын тухай өгүүлсэнийг мэдэж авч билээ. Манай Анагаах ухааны сургуулийн ёс суртахууны лекцүүд нь эмчилгээний асуудлаар шүүхэд дуудагдахаас хэрхэн зайлсхийх тухай байсан даа. Асрал хайрлалын тухай юу ч байгаагүй.

Бурхан бол ариун, болзолт бус, асрал хайрлалын сэтгэлтэй болоход учирдаг саад тотгор бүхнийг даван гэтэлсэн, асрал хайрлалыг үйл хэрэгтээ хүчлэлгүй хэрэгжүүлж чадах билиг ухаан, хүч чадалтай гэгээрсэн хүнийг хэлнэ. Бурханы даван туулж чадсан тэдгээр тотгорууд нь аминч бодол, уур, шунал, омог бардам зэрэг хорт сэтгэлийн хэлбэрээр илрэн гардаг, өөрийн тухай дотоод, буруу бодлоос үүсэлтэй. Бидний бодож байгаагаар “би” оршдоггүй гэдгийг оносон билиг ухаан нь тэдгээр саад тотгорын ерөндөг юм. Тиймээс Бурханы шашины шүтээн, тэмүүлэл нь дотоод билиг ухаан хийгээд асрал хайрлах сэтгэлийг олоход оршдог. Асрал хайрлал, өөрийгөө золиосолсны бэлгэ тэмдэг болсон загалмайг Христосууд шүтэж, түүнд залбирснаар аминч сэтгэлээ дарж, сэтгэлдээ билиг ухаан, асрал хайрыг цогцлоох зориг тэмүүлэлтэй болохыг хүсдэг шиг Бурханы шашинтанууд билиг ухаан хийгээд асрал хайрыг төрүүлж сурахын тулд гадаад бэлгэ тэмдэг болох 26 метр өндөр гайхамшигт Энэрэн нигүүлсэхүйн бурхан Жанрайсиг бурханыг Улаанбаатар хотод Гандан хийдэд шүтэж байна. Бурханы шашины үүднээс бол золиосолж байгаа “би” нь оршин буй хүн бус харин алдаатайгаар “би мөн” хэмээн бодох тэр “би”-г л зольдог. “Би”-г золиослох утга нь үнэндээ хуурмаг үзлийг үгүй болгоход л оршино.

Жанрайсиг бурханы баруун мутарт амьдралыг тэтгэгч мөнхийн рашаан болох асрал хайрын бумба байна. Зүүн мутарт ямар ч хиргүй гайхамшигт тунгалаг толь байх бөгөөд бодит байдлыг илт үзэх билгүүнийг бэлгэддэг. Энэхүү төгс байдал нь Жанрайсиг бурханы зүрхэн тарни ОМ МАНИ БАДМЭ ХУМ-д багтдаг. ОМ нь Бурханы бүх эрдэм чадал. МАНИ нь асрал хайрын эрдэнэ. БАДМЭ нь билгүүний лянхуа. ХУМ нь билиг ухаан ба энэрэл нигүүлсэлийг сэтгэлд нэгдмэл болгохыг тус тус бэлгэддэг. Энэ маанийг уншиж байх үедээ хүмүүс, “Би билгүүний лянхуан дахь асрал хайрлалын эрдэнэ болсон Бурхан лугаа адил гэгээрнэ” гэж бодож байх ёстой.

Бурханы шашинтанууд билиг ухаан хийгээд энэрэнгүй сэтгэлийг дотоод сэтгэлдээ төрүүлэх гэж түүнд шүтэн мөргөдөг бөгөөд тэд гадаад материаллаг эд юмс, алт, мөнгө, эсвэл банкны зузаан дэвтэр зэргээс аврал, аз жаргалыг эрдэг мод чулуунд сүсэглэгчид биш юм. Бурханы шашиныг ингэж мод чулуун барималд шүтэгч гэж үзэх нь мунхаглал хийгээд мухар үзлийн туйлын хязгаар юм. Бурхан багш, энэрэнгүй сэтгэл болон билиг ухааны үнэн нь түгээмэл бодит байдал мөн хэмээн сургажээ, энэ үнэн бол Бурханы шашин ч бай өөр ямар ч шашины ганц өмч бус.

Өнөөдөр Монголын ард түмэн өөрийн Бурханы шашины үлэмжийн гайхамшигт өв уламжлалаа алдах аюултай үед ирсэн байгаа нь нэн гунигтай. Энэ үед Жанрайсиг бурханы баруун мутарт байх рашааны оронд зарим Монголчууд орос архийг харж буй цөвүүн цаг иржээ. Нэн тэргүүнд

1974 онд бусад хоёр зуун залуу аялагчдын хамт нэг сарын турш Катманду уулын орой дахь жижигхэн хийдэд Төвдийн Бурханы шашины тухай Лам багш нарын тайлбарлахыг сонсон сууж байлаа. Анагаах ухааны боловсролтой байсан учраас тэр сургаалийн сэтгэл зүйн талыг нь амархан хүлээн зөвшөөрч байсан ч, миний шинжлэх ухаанч сэтгэл маань үйлийн үр хийгээд хойд төрлийн тухай үзэл санааг багтааж чадахгүй байлаа. Эдгээр хоёр үзлийг зөв гэдэгт итгэлтэй болохын тулд есөн сар гүн нарийн бодож тунгаасан юм. Энэ өгүүлэлд ертөнцийн тухай Бурханы шашины үзлийг тодорхой дүрслэхийг хичээе.

Ертөнцийн үүслийг тайлбарлах мөнхийн маргаанд Бурханы шашины оруулсан хувь нэмэр маш энгийн юм: ертөнц эхлэлгүй. Энэ дэлхий үүсэхээс өмнө өөр гариг дэлхийд амьдрал байсан ба энэ ертөнцөөс өмнө өөр ертөнцүүд дээр амьдрал байжээ. Амьдрал хоёр хэлбэртэй: нэг нь сэтгэл, сэрэхүйтэй хүн, адгуус амьтан зэрэг амьд төрөлхтөн, хоёр дах нь төрөлхтөн бус болох ургамал, мод, мөөг, бактери зэрэг байдаг. Хоёр хэлбэрийн эдгээр амьдрал нь нэг нэгнээс харилцан хамааралтай оршдог бөгөөд сэтгэлтэй амьтад давамгайл байр суурьтай байдаг нь тэдгээр амьтдын ухамсарт ертөнцийг бүтээгч агуулга бүхий хүч буюу үйлийн үр оршдогтой холбоотой.

Бидний бие мэдээж гени болон хоол тэжээлээс хамааралтай оршдог бөгөөд удалгүй бүрэлдэхүүн хэсэг бүртээ задрах түр зуурын үзэгдэл юм. Бурханы шашинд, атом бүр нь байнга өөрчлөгдөн хувирдаг физик энергийн үргэлжлэл байдаг бөгөөд оргүйгээс үүсэх бололцоогүй хэмээн үздэг. Одоогийн атомын энерги нь өмнөх атом буюу энергиэс зайлшгүй үүсэх ба гэх мэтээр эхлэлгүйгээс мохоолшгүйд буцааж болно. Зарим хүмүүс материйг оргүйгээс үүсээд тэр нь эхлэл болсон хэмээн үздэг. Энэ санаа нь ямар ч тодорхой шалтгаангүйгээр бүх зүйлийг бүхнийг чадагч нэгэн тэнгэр сахиус бүтээсэн гэсэн итгэл үнэмшлийн нөгөө хязгаар юм. Бурханы шашин дээрх хоёр үзлийг няцаадаг.

Бидний сэтгэлийн, биетэй төстэй тал нь үргэлж хувирал өөрчлөлтийн үргэлжлэл байдаг. Гэхдээ сэтгэлийн бүрэлдэхүүн нь материаллаг бус бөгөөд танин мэдэх буюу ухамсарын энерги байдаг. Одоогийн мөчийн ухамсар нь шууд өмнөх мөчөөс үүсэх бөгөөд хариуд нь, ухамсарын ирээдүйн мөчийг үүсгэдэг. Тиймээссэтгэлийн үргэлжлэл нь ухамсарын өмнөх мөч, мэдрэлийн тогтолцоо, эрхтэнүүд, танин мэдэж байгаа эд зүйлсээс хамаарсан танин мэдлийн урсгал юм. Таван эрхтэний мэдэлтэй: харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүрэлцэх, зургаа дахь мэдэл нь сэтгэлийн тийн мэдэл юм. Зургаан тийн мэдэл нь тус бүрдээ янз бүрийн байдлаар жаргал, зовлонг сэрэх болон хайр, уур хилэн, тэвчээр, шунал, өгөөмөр зэрэг сэтгэлийн хөдөлгөөнтэй холбоотой. Ухамсарын энерги нь оргүй хоосноос үүсэх бололцоогүй учраас сэтгэл ч гэсэн эхлэлгүй өнгөрсөн үетэй байх нь.

Бидний сэтгэлийн тийн мэдэл голдуу бодлууд буюу концепцийн түвшинд ажилладаг. Бодлууд нь гадаад болон хийсвэр зүйлүүдийг сэтгэлийн дүрслэлийн оролцоотойгоор сэтгэлд үзэгдэж байгаа зүйлсийг мэдэхийг хэлнэ. Бодлууд ихэнхдээ алдаа агуулсан байдаг нь бодож байгаа оногдохууны тухай сэтгэлийн дүрслэлийг жинхэнэ тэр оногдохуун мөн байна гэж төөрөлддөг.

Уг төөрөгдөл нь тийн мэдлээр тухайн оногдохууныг сэтгэлийн дүрслэлийн оролцоогүйгээр шууд мэдэх үед үгүй болдог. Сэтгэлийн тийн мэдлийн дээд зэргийн энэ чадварыг бясалгалын аргаар хуримтлуулдаг бөгөөд энэхүү тийн мэдлийг туйлын бодит байдалд чиглүүлж төвлөрүүлэх нь Бурханы сургаалийн зам мөрийн хоёр чухал хэсгийн нэг юм. Хоёр дах чухал зүйл нь амьтан бүрийг энэрэн нигүүлсэх сэтгэлийг үүсгэх байдаг.

Төрөлхтөн бүр өөрийн гэсэн онцлогтой ухамсарын үргэлжлэлтэй байдаг бөгөөд анги тусдаа хуваагддаггүй. Түүнчлэн хоёр үргэлжлэл нэгдэнэ гэж үгүй. Хэдийгээр Бурхан таалал сэтгэлтэй боловч төрөлхтөн биш, яагаад гэвэл төрөлхтөн хэмээх ойлголт зөвхөн амьдарлын хүрдэнд хүлэгдэж баригдсан нэгнийг хэлнэ. Амьдрал эхлэлгүй учраас анхны Бурхан гэж байхгүй. Урьдын олон Бурханы сургаалийг дагаснаар нисваанисаас ангижиран, төгс билиг ухааны оргилд хүрч, энэрэн нигүүлсэнгүй сэтгэлийн хүчээр олон төрөлхтөн Бурханы хутагт хүрчээ. Өөрт буй угийн бурханлиг чанартаа хүрсэн үедээ энэ дэлхийг орхин явдаггүй. Зовлонг амьдрал оршиж байгаа цагт, бидний зүгээс бэлтгэлтэй, бурханыг сонсох бололцоотой байгаа цагт бид бүхнийг зөв мөрт дагуулан хөтлөхийн тулд үргэлжид байж байдаг.

Бүхнийг анхлан бүтээгч гэж байхгүй ч гэсэн одоогийн энэ дэлхий хийгээд түүний оршин суугчид шалтгаанаас бий болсон нь дамжиггүй. Тэгвэл дэлхийн шалтгаан нь юу вэ? Бурханы сургаал дотор алдартай нэгэн зарлигийн эхний хэсэг нь ”Төрөлхтөний энэхүү олон янз төрөл ба амьдрах гадаад орчин нь өөрсдийнх нь үйлийн үр дагавараас гаралтай” гэж эхэлдэг.

Үйлийн үрийн шууд утга нь үйл. Ялангуяа үйлийн үйлдэх болсон цаад санаа, зорилгыг заадаг. Үйлдэж, хэлж, бодож байгаа үйлүүдийн цаана санаа байдаг. Үйлдсэн үйлээс шалтгаалан гадаад ертөнцөд шууд үр дүн гарахаас гадна үйл бүрээс дотоод үр дагавар буюу сэтгэлд энергийн чадамж үүсдэг. Энэхүү чадамж буюу үйлийн ул мөр нь сэтгэлийн урсгалыг ирээдүй хойчид дөнгөж сая санаатайгаар үйлдсэн үйлтэй төстэй үйл явдалтай холбож өгөх чадвартай байдаг. Энэ нь сайн хийгээд муу үр дагаварыг бий болгох түлхэц буюу зөн совингийн санаанаас бүтдэг. Тиймээс, одоогийн бидний мэдэрч байгаа бүхэн бидний энэ хийгээд урьд төрлүүдийн зан байдлын тусгалууд юм. Хорон муу санаагаар үйлдсэн үйлүүд зовлон тохиолдох чадамжийг үүсгэнэ, сайн санаагаар үйлдсэн үйлүүд сайхан зүйл тохиолдох чадамжийг үүсгэдэг.

Биеэс ялгагдах сэтгэлийн онцлог тал нь, үхлийг даван туулах чадвартай. Маш нарийн биеийн энергийн тусламжтайгаар зүүд адил зуурдын төрлөөр дамжин гарч хойд төрөлд шилжихдээ урьд төрлүүдийн асар их үйлийн чадамж хийгээд сайн, муу сэтгэлийн бүх чанаруудын үрийг тээдэг. Амгаланд шунан дурлахад жолоодуулж, зовлонгоос дутаахдаа, жаргал, зовлон гарахын жинхэнэ шалтгааныг үл ухан мэдсэнээр төрөлхтөнүүд өөрсдийн сэтгэлийн оногдлууд болох зургаан төрлийг олон дахин ээлжлэн сольсоор байдаг. Энэ нас эцэслэхэд жаргалд шунах ханашгүй хүсэл үүссэнээс болж үйлийн чадамж идэвхжин боловсорч, сэтгэл буюу сүнс зогсоохын аргагүй хүчээр хойд төрөлд шилждэг. Там болон бирдийн төрлийн амьтадын биес нь биеийн жаргалтай байх бололцоотой мэт үзэгдэвч урьд төрөлдөө бусдыг хорлож өөрийн амийг бодож байсан учраас үйлийн үр нь зөвхөн тэсвэрлэшгүй зовлонд хөтөлдөг. Адгуусан амьтаны хувьд жаргалтай байх бага зэрэг илүү бололцоотой. Сэтгэхүйн хөгжлийн өчүүхэн дорой байдлаас болж тэд гадаад орчны бэрхшээл, амьдаараа араатны хоол болох, хүнд

боолчлогдох зэрэг зовлонг шийдэж чаддаггүй.

Хүн болж төрсний хамгийн эрхэм давуу тал нь уураг тархиараа оюуны бүрэн чадварыг ашиглаж болно. Оюун ухааны хүчээр жаргал хүсэх, зовлонг үл хүсэх хийгээд зовлонгийн гол шалтгаан болох үйлийн үр, муу сэтгэлийг ойлгож болно. Дараа нь зөв ёс суртахуун, энэрэнгүй сэтгэл, билиг ухааныг төлөвшүүлэх замаар дээрх шалтгаануудаас ангижрах уу, үгүй юу гэдгээ сонгож болно. Асури болон тэнгэрийн төрөлхтөнүүд бие, сэтгэлийн жаргалтай байх бүр илүү бололцоотой боловч жаргалдаа ташууран оюун ухааны чадвараа хөгжүүлдэггүй ба хүсэл шуналаа огоорохыг төдийлөн эрмэлздэггүй. Зургаан төрөл бүхэнд бид тоолшгүй олонтаа төрсөн боловч одоо хүртэл сэтгэл дүүрэн болж чадахгүй, эгэл жирийн амьдрал дундаас хуурамч төсөөлсөн төгс жаргал, эрх чөлөөг хөөсөөр байгаа билээ.

Билиг ухаан хийгээд энэрэн нигүүлсэхүй сэтгэлийг өөрт төгөлдөр цогцлуулснаар мунхаглалаас үүддэг төрөл авах, үйлийн үр, муу сэтгэлийн шалтгааныг арилгаж, бурханы хутагт хүрч чадна. Тиймээс, хэдийгээр тэргүүлшгүй цагаас оршоор ирсэн ч гэсэн хүн өөрийн орчлон хорвоогийн хүрдээ зогсоож болно.

Сэтгэл

Сэтгэл гэдэг бол өөрчилж болдог, оролт, гаралтын сувагтай багтаамж бүхий зүйл юм. Тэгвэл сэтгэл гэж юу вэ? гэдгийг тодорхойлохоос нааш түүний тухай ярих аргагүй. Хэрвээ арван сэтгэл судлаач тус бүрт энэ асуултыг тавьбал арван өөр хариу хэлнэ. Дотны нөхөр болсон толь бичгээс энэ үгийг харвал сэтгэл судлаач биш ч гэсэн “Сэтгэл бол бодох, сэтгэлийн хөдөлгөөнийг мэдрэх, юмсыг танин мэддэг” гэж тайлбарлажээ. Тэгвэл “Бодох, сэтгэлийн хөдөлгөөн, танин мэдэх гэж юу вэ?” гэж өнөөх сэтгэл судлаач нөхдөөс асуувал тэд уураг тархины үйл ажиллагааг ярьж эхэлнэ. Ихэнх хүмүүс сэтгэл хийгээд уураг тархины үйл ажиллагаа буюу мэдрэлийн тогтолцоо хоёрыг ялгаж чаддаггүй.

Бурханы сургаалд, бие, сэтгэл хоёр хоорондоо харилцан холбоотой хэдий ч өөр зүйлүүд гэж үздэг. Сэтгэлийн бүрдэл нь атом, молекултай ямар ч холбоогүй, өөрөө танин мэдэхүйн энерги юм. Бодол, сэтгэлийн хөдөлгөөн, танин мэдэх зэрэг нь сэтгэл юм. Танин мэдэхүйн зургаан суваг бий: эрхтэнээр мэдэх тав ба зургаа дахь нь сэтгэлийн тийн мэдэл юм. Сэтгэлийн тийн мэдэлд бодох чадвар, зөн билгээр мэдэх зэрэг багтана. Сэтгэлийн тийн мэдэл нь биеийн амгалангийн тухай бодож байдаг бөгөөд биеийн дээд амгаланг олох хийгээд хамгийн бага зовлонтой байхад чиглэгдсэн зан байдлыг санаачлан бий болгодог.

Бурхан багш, сэтгэл бол тодорхой бөгөөд танин мэдэхүйн чадвартай хэмээн үндсэн хоёр шинж чанартай тодорхойлжээ. Тодорхой нь сэтгэлийн мөн чанар юм: сэтгэл нь биегүй ба аливаа зүйлийг толь адил түүнд тусаж байгаа зүйлийн шинжийг агуулдаг. Танин мэдэхүй нь ухамсар, мэдлэгийн ойролцоо утгатай үг бөгөөд сэтгэлийн үйлдэлийн чанар юм. Сэтгэл нь тухайн нэг зүйлийн тухай мэддэг, мөн тухайн зүйлийг сэтгэл өөрөө хэрхэн хүлээн авч мэдэрч байгаагаа мэдэрч байдаг. Толь юмсыг тусгаж авч байгаа хирнээ юу тусаж байгааг мэддэггүй. Комьпьютер олон зүйлийг тооцоолох боловч юу тооцоолж байгаагаа мэддэггүй. Комьпьютер хэзээ нэг цагт бодож чаддаг болох уу? гэсэн асуултанд Дээрхийн гэгээнтэн Далай лам багш: “Хэрвээ ухамсар байрлах зохимжтой суурь болгож чадсан тохиолдолд магадгүй” гэж айлдсан байдаг.

Дээрхийн гэгээнтэн багшийн энэ айлдварын утга бол комьпьютер ухамсарыг бүтээж чадахгүй, урьд нь оршсон сэтгэлийг компьютерт байрлуулж чадсан тэр цагт бодож чадна гэсэн үг юм. Үүнтэй адил бидний биеэс сэтгэл үүсэн бий болохгүй, учир нь мэдэхүйн чадвар нь биет чанаргүй юм. Одоогийн мэдэхүйн чадвар гагцхүү өнгөрсөн мөчийн мэдэхүйн чадвараас бий болно, тиймээс бидний биеэс өмнө оршиж байсан мэдэхүйн үргэлжлэл байх албатай бөгөөд ухамсарт зохицсон суурь бүрэлдсэн үе буюу эхийн хэвлийд өндгөн эс боловсрох үед сэтгэл бие дотор байрлана.

Эрдэмтэд: “Сэтгэл нь эволюцийн бүтээгдэхүүн” гэж үздэг.

Буддистууд: “Үгүй, эволюци бол сэтгэлийн бүтээгдэхүүн” гэнэ.

Манай дэлхий хувьсагнасан хийн бөөгнөрөлөөс үүсэхээс өмнө хүн төрөлхтөний өмнөх төрөл маш нарийн биетэй, сэтгэлийн амгалантай, ер бусын сайхан амьдардаг байжээ. Амгалантай байх буяны үйлийн үр барагдан доройтох үед урьдын төрлийн сэтгэлийн амгалангийн

дадлаар биеийн бүдүүн амгаланг хүсэх болсон байна. Хөрст шороон дээр амьдрах бидний хамтын үйлийн үр хийгээд атом, молекулын хими, физикийн үйл ажиллагааны хамтаар эгэл биетүүд үүсэн бий болсоны зарим нь сэтгэлтэй байхад зохилдсон суурь байжээ. Дээд тэнгэрийн оронд хальсны дараа, бидний сэтгэл одоогийн бүдүүн биед төрөл дамжин ирсэн бөгөөд хүслийн нөлөөгөөр биеийн жаргал эдлэхэд улам дэвшсээр буй нарийн зэмсэг болжээ. Адгуусан амьтан ба ургамал хоёрын ялгаа нь, амьтны бие харах, сонсох, үнэртэх, амтлах, хүрэлцэхийн жаргалыг мэдрэхэд зориулагдсан, ялангуяа хүний хувьд бодох чадвартай байдаг байхад харин ургамлын бие нь ургах, үржих, үхэхдээ сэтгэл юмуу сэрэхүйн оролцоогүй явагддаг.

Хэдийгээр ургамалд сэтгэл оршихгүй боловч түүнийг хэрэглэж байгаа хүн, амьтан, бирд, тэнгэрийн төрөлхөтний хамтын үйлийн үрээс хамааралтай байдаг. Халуун хийн бөөгнөрөлөөс манай дэлхий үүссэн нь хамтын үйлийн үртэй холбоотой, анхны эгэл биетүүд үүссэн нь хамтын үйлийн үртэй мэдээж холбоотой. Тиймээс сэтгэл

нь дэлхий ертөнцийг бүхэлд нь хөдөлгөгч зүйл болдог. Бурханы сургаал, эволюци хөгжлийг үгүйсгэдэггүй, гэхдээ нэгэн сонирхолтой зүйл нэмдэг, тэр нь эволюцийн хөдөлгөгч хүч нь биеийн жаргалыг хүсэмжлэх аминч үзэл гэж үздэг.

Тэгээд юу нь буруу гэж? Хэрвээ бидний бие жаргалтай байхад зориулагдсан юм бол яагаад амьдрал ийм зовлонтой байдаг вэ? Бид яагаад жаргалыг ололгүй, зовлонтой учирч байдаг вэ, олсон жаргалдаа сэтгэл ханахгүй, хүссэн хүмүүс, эд зүйлээс яагаад байнга хагацахад гашуун уйтгартай байдаг вэ? Үүний учир нь энэ бүхнийг зохион бүтээгч сэтгэлд мунхаглалын алдаа байгаа учраас тэр.

Бодит байдалд юмс хэрхэн оршдогийг эс мэдсэнээс үүдэн ертөнц болон өөрсдийнхөө тухай алдаатай урьдчилсан таамаглал үүсгэдэг. Эдгээр буруу бодол санаа нь сэтгэлийн угийн тодорхой чанарыг бүрхдэг учраас нөлөөтэй толь шиг сэтгэлд туссан бүхнийг буруу гуйвуулдаг. Хамгийн их буруугаар үзэгддэг зүйл бол “би” өөрөө бүтэж гарсан, бусдаас ангид тусгаар мэт санагддаг. Энэхүү буруу үзэгдлийг бидний сэтгэл үнэн хэмээн барьж, тэр мөчөөс эхлэн бидний амьдрал гамшиг болдог, учир нь, оршихгүй байгаа өөрөө бүтсэн “би”-г оршиж байгаа хэмээн аргаа барагдтал батлахыг хичээж, энэхүү ханадаггүй хуурамч хий үзэгдлийг жаргалтай байлгах гэж, зовлонгоос хамгаалах гэж мэрийдэг.

“Би” оршдог боловч зөвхөн нийтийн тохиролцооны төдийд. Бие, сэтгэлд хамааруулж “би” гэж нэр өгч байгаа бодол юмуу “би” хэмээн бодож байгаа байдлаас оршиж байгаа нь тодорхойлогдоно. Тийнхүү нэрлэх үйл явцаас өөрөөр “би”-г зааж болохгүй.

Ертөнцийн хувьд, бидний амьдралд сэтгэлийн гүйцэтгэж байгаа субъектив үүргийг мэддэггүй, тиймээс бид өөрсдийгөө бие даасан “гадаад ертөнцийн” идэвхгүй туулан амьдрагчид хэмээн мунхагаар итгэдэг. Бид өөрсдийнхөө талаар алдаатай боддог учраас ертөнцийг ч мунхагийн эрхээр өөрийн гэсэн мөн чанартай гэж үздэг, гэтэл ертөнц нь үнэндээ нэрийн төдийгөөр оршиж байдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүс, юмс, үйл явдлууд нь бидний сэтгэлийн чанартай болохоос бус өөрийн мөн чанараар оршдоггүй.

Жишээ нь, нэг хүнд дурлалаа гэж бодоход тэр хүн нь энэ дэлхийн хамгийн сайхан хүн байдаг.

Харин салж сарних цагт уурласан сэтгэлд тэр хүн дэлхийн хамгийн муухай хүн болж харагддаг. Гэтэл түүнтэй амьдрах гэж байгаа өөр нэг хүнд хамгийн сайхнаар харагдана. Тэгэхээр сайхан, муухай харагдах нь тухайн харагдаж байгаа хүнтэй холбоогүй, харин харж байгаа хүний сэтгэлийн чанартай байна. Тиймээс, хэдийгээр гадаад нөхцөл байдлууд байдаг боловч тэдгээрийн үзэгдэх байдал нь харж байгаа хүнээс хамаарах ба жаргал, уйтгарын гол шалтгаан нь сэтгэл болохоос бус гадаад ертөнц биш. Зовлон гарахын шалтгаан нь гадаад ертөнцийг муу муухайгаас арилгаад сайн сайхнаар дүүргэнэ гэсэн хэзээ ч үл биелэх бодлоос үүдэлтэй. Амгалан жаргалангийн орны цэцэрлэг гадаад ертөнцөд биш сэтгэлд оршдог ба энэ оронд орох түлхүүр нь билиг ухаан, энэрэн нигүүлсэхүй сэтгэл юм.

Тэр түлхүүрийг олоогүй цагт хий хоосон зүйлийг хөөж, сүүдрээсээ бусган зугтаж байх болно. Энэ дэлхий орших хугацаанд цөөн хэд нь тэр цэцэрлэгт орох ба үлдсэн нь “амьдралын хүрд”-нээ жаргал зовлонг ээлжлэн эдэлсээр оршино. Дэлхийн оршин тогтнолын эцэст, түлхүүр олоогүй нь сэтгэлийн амгалангийн ер бусын оронд дахин төрөх бөгөөд тэнд байх буян эцэстээ барагдахад биеийн жаргалыг хүсэх хөрст шинэ ертөнцөд дахин төрнө. Тэргүүлшгүй цагаас аваад энэ мэтээр амьдралын хүрд эргэсээр иржээ.

Би гэж юу вэ?

Дэлхийн гарал үүсэл, үхлийн дараа юу болдог вэ зэрэг нь батлахад хэцүү нарийн баримт. Тэгвэл би гэж юу вэ? Би бол хүн, та хүн, бидний эргэн тойрон бүгд хүн учраас хүн гэж юу вэ гэдгийг хариулахад амархан баймаар. “Хэнд хамаатай юм бэ? Би идэж, ууж, унтаж, дурладаг, өөрийгөө хэн бэ гэдгийг яг сайн мэдэхгүйгээр нохой шиг төгс байж чадна” гэх байх.

Гэхдээ та өөрийгөө “нохой шиг” гэж хэлэхгүй нь мэдээж. Ийнхүү хэлэхийн учир нь хамаагүй зөн совингоо дагах хандлагаар хувь хүн гэдэг талаасаа ямар ч ойлголтгүй байвал жаргалыг хүсдэг, зовлонг хүсдэггүй, адгуусан амьтнаас өөрцгүй болно. Цаашилбал, төгс сайн байж чаддаг билүү? Нохой бүү хэл, хүн төрөлхтөн эрээд байгаа жаргалаа олж, түүнийгээ хадгалах болон айгаад байгаа зовлонгоос зайлсхийхдээ төдийлөн ухаалаг бус. Адгуус амьтан угаасаа амьтныхаа хувьд ямар вэ гэдгээ ойлгох оюуны чадваргүй байхад хүн ойлгож чадна, оюун ухаанаа ажиллуулж, би гэж юу вэ гэдгийг нээн ойлгох нь хамгийн их чухал. Зөвхөн ингэсэн цагт төөрөлдсөн сэтгэлийн манан дундаас гарч, хүсээд буй жаргалдаа хүрэх, зайлсхийж байгаа зовлонгоос холдоход яавал зохистойг тодорхой ойлгож чадна.

“Би”-гийн жинхэнэ мөн чанарыг ойлгохыг онцлох учир бол хүн өөрийн тухай төөрөгдөл, буруу үзэлтэй байх нь бэрхшээлүүд үүдэн гарах уг сурвалж ба аз жаргалаа олох, түүнийг барьж тогтооход хүнд хэцүү байхын шалтгаан хэмээн Бурханы сургаал үздэг. Бид өөрсдийгөө юу вэ гэдгийг олж тогтоож, өөрсдийн талаархи буруу бодлуудыг арилгах нь нэн чухал бөгөөд эс тэгвэл жаргалыг өөрөөсөө хөөж, зовлонг далласаар байх болно.

Өөрийн тухай ухамсар, би-гийн тухай мэдлэг адгуусан амьтан болон бүх амьтанд дотоод түгээмэл шинжтэй байдаг, гэхдээ өөрсдийгөө тийм хэмээн бодож байгаа, өөрийн дүр төрхийг тодорхойлсон байдал нь бодит байдалтай нийцдэггүй. Бодгаль утгаараа хэрхэн оршдог вэ гэдгийг бид мэддэггүй учраас бидний сэтгэл жинхэнэ орших мэт үзэгддэг нэгэн хуурамч өөрийн дүр төрхийг ургуулан бүтээдэг. Тийнхүү харагдаж байгаа би-г үнэхээр би мөн гэж итгэж насан турш амьдардаг. Жишээ нь, гэрийн үйлчлэгчээ цаг хулгайлсан байна гэж сэрдэхэд сэтгэлд үүссэн буруу бодлоос болж тэр эмэгтэй хулгайч болж харагдана. Бидний андуурсан сэтгэл үйлчлэгчийн гэм буруугүй байдлыг хулгайчийн нарийн заль мэтээр санана, ингэснээр хилэн төрж, үйлчлэгчийг ажлаас хална. Үйлчлэгчээ хулгайч болгосон буруу ташаа бодолдоо итгэж, түүнийгээ дагаад зан байдал, сэтгэл хөдлөл зэрэг маань буруу болж байгаа дээрх жишээтэй адил өөрийн буруу дүр төрхөд буруу итгэснээс болж бидний зан байдал ба сэтгэлийн хөдлөл орвонгоороо эргэдэг. Дараа нь, өөрийн буруу төрхөд сайн, муу чанаруудыг буруугаар тусгаж, тэдгээр тусгалуудыг бас л жинхнээсээ оршиж байгаа хэмээн боддог ба анхны буруу алдааг улам олон бүтэцтэй болгодог.

Дунд сургуульд байх үес шинжлэх ухааны хичээлийг сонгон суралцъя гэж намайг хэлэхэд аав минь өөр шигээ адилхан хүмүүнлэгийн ухааныг сонгохыг шахаж байхдаа ”Би математикт хэзээ ч сайн байгаагүй, чи яаж шинжлэх ухаанд сайн байж чадах билээ?” гэж хэлж билээ. Азаар, аав маань намайг сөргөгч байхаар хүмүүжүүлсэн байсан учраас би байгалийн ухааны хичээлийг сонгож билээ. Хожим нь, тоогоо бодож чадахгүй болохдоо математик ойлгодоггүй генийг би өвлөж авсан юм болов уу гэж санадаг байлаа. Үүнд алдаа нь гэвэл, би өөрийгөө угаасаа математик бодож чадахгүй гэсэн сэтгэл зүйн хаалт байсан юм. Бид бүгдээрээ

өөрийгөө доогуур юмуу дээгүүр үзэх хагуу тогтсон, буруу итгэл үнэмшилтэй байдаг учраас тэр нь энэхүү өөрчлөгдөн хувирч байгаа ертөнцөд арга замаа олж, баяр баясгалантай явах чадварыг ихээхэн хязгаарладаг.

Өөрийн дүр төрхийн тухай гол алдаа бол би нь ганцаар, бусдаас үл хамааралтай оршдог гэсэн үзэл юм. Жинхэнэ, бодитой, баригдахуйц БИ нь бие ба сэтгэл хоёр дээр оршиж байна хэмээн үздэг. Хэрэв тийм би байсан бол түүнийг эрвэл олдох байсан, гэвч нэг ч хүн ангид тусгаар би-г нээж олоогүй байна. Энэхүү алдаатай өөрийн төрхийг хайрласнаар бардам байдалд нь ямар нэг зовлон, хор хүргэж байгаа ямарваа зүйлд нарийн эмзэглэн хандаж, дургүйцэн хонзоглож, харин “би”-г жаргааж, бардам зангий нь ихэсгэж байгаа ямарваа зүйлд ойр барих шуналаар ханддаг. Өсөөрхөл, хүсэл шунал ба тэдгээрийн шалтгаан болох буруу дүр төрхийг хайрлах эд гурав нь бидний сэтгэл ба түүний бүтээл болох-хувь хүний ертөнцийн үндсэн гурван төөрөгдөл болдог.

Бидний өөрсдийн бодож байгаа би нь зөвхөн санаанаас зохиосон байдаг, тэгвэл оршиж байгаа би нь юу вэ? Идэж, унтаж, дурлаж чаддаг би нь бидний бие, сэтгэлд чиглэсэн “би” бодлоор үүсгэгдсэн нэр төдий юм. Энэхүү нийтээр тохиролцсон төдий би нь өөрийн гэсэн мөн чанаргүй, бие, сэтгэлийн нэгдэл ч, нэр ч бас би биш. Би оршдог, гэхдээ түүний оршиж байгааг хаанаас ч олохын аргагүй учраас зөвхөн нийтийн тохиролцоо төдий юм. Дэлхий ертөнцийн аливаа бүхэнд энэ хамааралтай. Дэлхийн бөмбөрцөг тохиролцоо төдий, дурлалт хүн тохиролцоо төдий, Бурхан ч тохиролцоо төдий оршино. Мөн чанараас оршсон ганц ч зүйл үгүй. Бүх юмс нэрэнд зохилдох суурь дээр үндэслэсэн нэрээс хамааралтай төдийд оршино.

Хэдийгээр би, та бид нийтийн тохиролцоо төдий оршиж байгаа боловч бид оршиж байна, тус бүр өөр бие, сэтгэлтэй учраас хувь хүмүүс байдаг. Бие, сэтгэлийн нэгдэлд нэр өгөх нь би-г оршиж буйг заахад хангалттай. Би бол бие ба сэтгэлд өгсөн нэр төдий, үүнээс өөр юу ч үгүй. Мунхаглалаас болж өөрсдийгөө илүү мөн чанартайд боддог. Би мөн чанартай оршдоггүй төлөвтэй байхаас айсандаа, мөн чанартай би-г хоосон атал бардам сэтгэлээр ойр барьж; шунал, хомхойгоор бордож; өсөөрхөл, атаархал, хорон санаагаар хамгаалж; ямагт би, би, би үзлээр туйлширдаг учраас бусад намайг тоохгүй байна гэсэн сэтгэцийн хүнд хямралын намагт живэх юмуу өөрийгөө хэтэрхий дээгүүр үзэх хөөсөнд хөвдөг!

Эдгээр өөрийн зовлонгууд хийгээд тэдгээрээр дамжуулан бусдад хүргэж байгаа зовлонгоос гарах арга зам бол би-г түүнийг тухай санаанаасаа зохиосон тусгалуудаас хоосон гэдгийг ойлгох явдал. Ингэсэн цагт сэтгэл өс хонзон, шунал хүслээс чөлөөлөгдөж, амар тайван болно. Хүүхэд нь хар дарж зүүдлээд уйлахад эх нь тайтгаруулдаг шиг бүхний үнэмлэхүй чанар-тусгаар ангид би-г хоосон гэдгийг оносон билиг ухаан уур хилэн, шунал, омог бардам сэтгэл гэх мэт муу сэтгэлийг тайтгаруулж, хамаг жаргалын эх булаг болсон асрал хайрлалыг төвөггүй хэрэгжүүлнэ.

Уур хилэн

Гэр бүлийн хэрүүл маргааны дараа нөхөр нь уурандаа бульдозер машин хөлслөөд өөрийнхөө суудаг байшинг газрын хөрстэй тэгшилсэн тухай нэг удаа уншиж билээ. Тэр үед сэтгэлд нь юу болж байсан гэж та бодож байна? Уур нь гарч, тайвширсныхаа дараа тэнэг зүйл хийснээ хараад ямар санагдсан бол? Уур бол энэ дэлхий дээрх хамгийн их хөнөөлт хар хүч юм. Уур нь дотоод амар амгаланг эвдэж, гэр бүл, найз нөхөдтэйгээ бие, хэлээрээ зохисгүй харьцах, өөрийнхөө өмч хөрөнгийг устгах, архи, тамхи хэтрүүлэн хэрэглэж, биеэ хордуулах, балмад үйл хийх, амиа хорлоход хүргэдэг. Хамгийн сайхан нүүр царайг муухай болгож, бие махбодийн эрүүл мэндийг дордуулж, ууртай хүнээс хэн хүн төвөгшөөдөг учраас тусгаарлагдмал, ганцаардмал түгжрэлд оруулдаг. Уурын хамгийн муу нөлөө нь шууд мэдэгдэхгүй хэмээн Бурхан багш айлджээ: уурлах нь хураасан хамаг буяныг устгаснаар ирээдүйн жаргаланг хаах бөгөөд уураар үйлдсэн үйлийн үрээр төрөл төрөлдөө зовлонд унадаг.

Уурын тодорхойлолт бол бусад төрөлхтөн, өөрт юмуу амьгүй зүйлийг хорлох санаа бүхий сэтгэлийн түгшүүртэй байдал юм. Уураас үзэн ядалт, түрэмгийлэл, дургүйцэл, дайсагнал тэр байтугай айдас үүсэн гарч, тус бүрдээ хорт хавдар мэтээр бидний аз жаргалыг хэмлэн үгүйрүүлдэг. Уурыг даван гарах эхний алхам нь түүний гэмийн талаар бодож, дараа нь энэ чөтгөрөөс салахаар хатуу шийдэх хэрэгтэй. Уур маш хортой бөгөөд бусдад хорлохыг санаархах нь зөвгөж болшгүй, амьгүй эд болон өөртөө уурлах нь утгагүй гэдгийг ойлгох ёстой. Хамгийн аюулт гадаад дайсан бидний аминд хүрнэ, харин дотоод дайсан уур гараа ардаа боолттойгоор бидний амийг хөнөөж дөнгөхөөс гадна гадаад дайсны үл чадах тамын зовлонд түлхэн унагааж чадна.

Уур нэгэнт дэлбэрвэл хянахад хэцүү. Түүнийг хянахаар оролдохын тулд уурлуулаад байгаа зүйлээс холдох, жишээ нь, гадагш гарч алхах. Хэрвээ бололцоотой бол ууртай бодлуудыг зориудаар сарниулах буюу өөр зүйлийн тухай бодож сэтгэлээ тайтгаруулах хэрэгтэй, ээж хүн хүүхдүүдээ зодолдохыг нь болиулахын тулд чихэр өгдөг шиг. Мэдээж ийм байдлаар тайтгарахад уур түр зуур намдана, нэгнийх нь бялуу нөгөөхөөс бага зэрэг илүү байхад хайртай хүүхдүүд нь дахиад уурладаг. Дээрх аргаар уураа багахан ч болов намжаасны дараа энэ чөтгөрөөс ангижрахын тулд дараагийн ерөндөгүүдийг хэрэглэнэ.

Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл гэх мэт үзэн ядалтын зарим хэлбэрүүд энэ насанд үүсдэг олдмол шинжтэй байдаг бөгөөд хэн ч ууртай байхыг зааж өгдөггүй. Нялх хүүхдүүд өсөлтийн эрт үед ууртай нь илэрдэг бөгөөд энэ уурын үр сэтгэлд нь оршиж байгаатай холбоотой. Уурын хамгийн гүн үндэс нь урьд төрлүүдээс өвлөн авсан “би” хэмээх мунхаглал бөгөөд уурыг төгс үгүй болгох арга зам нь би-гийн хоосон чанарыг онох билиг ухаан юм. Үүнд хүрэхэд урт хугацаа хэрэгтэй; тэр хооронд уур хүрэхэд түлш болдог зовиуртай байдалд орохгүйн тулд тэвчээрт суралцах хэрэгтэй.

Уурын нэг дэх ерөндөг бол тэвчээр бөгөөд энэ нь өдөөн хатгалгад тайван сууж, хариу муугаар харьцахгүй байх гайхамшигт чадвар юм. Бидний тэвчээрийн чадвар харамсалтай нь хөгжөөгүй байдаг ч оролдоод үзэх л хэрэгтэй. Хүн зовлонтой байх нь ууранд тэсрэх шахам байгаа бөмбөгтэй адил юм. Тэвчээргүй байвал өчүүхэн жижиг зүйл буруудахад л уур болж

тэсрэхэд хангалттай. Аав нь гэртээ орж ирэх тэр агшинд ажил нь бүтэмжтэй, үгүй байсан эсэхийг хүүхдүүд мэддэг. Хэрвээ аав нь сайхан аашгүй байвал, цонх хагалсан тухай хэлэх цаг болоогүй, тэгж хэлэхийн өмнө сайхан ааштай болгох хэрэгтэй гэдгийг хүүхдүүд анддаггүй. Зовлонтой байдлаас уур үүсэхийг зогсоохын тулд Энэтхэгийн их бандида Шантидева гэгээнтэн, хэзээ нэг цагт зовлонтой болох үедээ өөрсдөөсөө ”Болохгүй байгаа зүйлийг засаж болох уу? Хэрвээ засаж болохоор байвал зовохын хэрэг юун? хэмээн асуугаарай. Хэрвээ засах учиргүй аваас бас түүнээ зовохын тус юун? хэмээн асуугаарай. Галд тос нэмэх адил уурлах нь илүү их хорлолд өртөж байгаа шүү дээ” гэж айлджээ.

Энэ айлдварыг зүрх сэтгэлдээ анхааран авч, хүн иддэг бартай ширэнгэн ой модон дундуур ганцаараа чимээ гаргахаас айн сэрэмжлэх адил зовлонтой байдалд орохоос сэрэмжтэй байхад анхаарах хэрэгтэй. Хамгийн аймшигт дайсантай зуузай холбоо дөхөж байгаа нь зовлонт байдлаар мэдэгдэх бөгөөд ууранд амьдаараа идүүлэхээс хамгаалах зэвсэг нь тэвчээр юм. Энэ зэвсгийг хаанаас олох вэ? Тэвчээрийг гагцхүү саад бэрхшээл л үүсгэх бололцоотой, тиймээс уурлуулдаг хүн юмуу зүйлүүд бол бидний хамгийн том холбоотон хэмээн авч үзвэл зохистой юм, учир нь, тэвчээртэй байх бололцоог тэд гаргаж өгдөг. Үүний талаар бодоод үзье: тэвчээртэй болохын тулд бидэнд заавал болохгүй юм БАЙХ хэрэгтэй.

Уураас зайлсхийх өөр арга бол уурлуулж байгаа хүн уурандаа аймшигтай шаналж байдгийг ойлгох, үүнд бид шууд бус замаар буруутай бөгөөд өс хонзонгоор хариу муугаар хандвал, тэднийг улам их ууртай болгоно. Маргааныг хамгийн ухаалгаар зохицуулах арга бол уучилж чадах, уучлал гуйх, анд нөхөр бололцох явдал юм.

Тэвчээрийг улам багтай болгохын тулд зовлонг даах чадвар хэрэгтэй. Тариачид, загасчид, цэргүүд түр зуурын гавьяа шагналын төлөө цаг агаарт уурлалгүй туйлын их хүнд нөхцлийг тэвчиж чаддаг. Дурлагч нар өөрсдийн хүслээ түр зуур хангахын тулд хүнд бэрхшээлийг даван туулдаг. Тэгвэл бид яагаад хүйтэн хоол, шумуул хазах, тоомжиргүй харц зэрэг өчүүхэн жижиг таагүй зүйлтэй тулгарахдаа уурлахгүй байж болдоггүй гэж? Жижиг зүйлээс эхлэн сэтгэлээ тэвчээртэй болгож дадуулбал асар бэрхшээлийг уурлахгүйгээр даван туулж чадахаар үл барам бэрхшээлүүд ч оргүй алга болдог.

Ийнхүү бодож чадвал таагүй нөхцөл байдлуудыг сайн болгож хувиргаж чадна. Хайрлал бол уурын эсрэг бөгөөд уурыг дарвал бусдыг хайрлах сэтгэл дахин төрнө. Бусад хүмүүс таныг хариуд нь хайрлаж, үүний үр дүнд бий болсон аз жаргал уурыг улам улмаар багасгаж, эцэст нь билиг ухаанаар ул мөргүй арилгах болно.

Түрэмгийлэл

Хүүхэд байхдаа би том хүмүүс яагаад өчүүхэн зүйлээс болж байнга, ихэнхдээ хорсолтойгоор хэрэлдэж нэг нэгнийгээ дандаа гомдоодог юм бол гэж олонтаа бодон толгойгоо гашилдаг байж билээ. Манай ангийн бүх найзуудын гэр оронд ч гэсэн гэр бүлийн иймэрхүү төстэй хэрүүл маргаан байдгийг мэдээд би том болоод хэзээ ч уурлаж, гэр бүлийнхээ эе эв түнжинг эвдэхгүй дээ гэж шийдсэн байлаа. Хожим нь энэ гамшигтай сэтгэлийн хөдлөл миний сэтгэлд байгааг мэдэхэд аймаар санагдаж, сул зоргоор нь тавивал ямар ч хянахын аргагүй их хүчтэй болдгоос эмээдэг байлаа. Сэтгэл мэдрэлийн эмнэлэгт ажиллаж байхдаа урьд нь хэзээ ч төсөөлж байгаагүй их уур ил болон далд хэлбэртэй байдгийг харж байлаа. Өвчтөнүүдэд сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэхийн тулд цохидог зөөлөвч байрлуулсан өрөөтэй байх талаар хариуцсан эмчид санал болгож билээ.

Дургүйцэл, өсөөрхөл, дайсагнал, үзэн ядалт, айдас эдгээр бүхэн уураас гаралтай ба уур нь манай өвчтөнүүдийн хамгийн гол зовиур болж байлаа. Миний шинжлэх ухаанч бодлоор, уур нь эволюцийн хөгжлийн үр дүнд бий болсон учраас уур хүрэх, түүнийгээ илэрхийлэх шаардлагатай, илэрхийлэх ч ёстой, учир нь энэхүү зүй ёсны сэтгэлийн хөдлөлийг дарж хаавал сэтгэцийн олон талын асуудал бий болно гэж үзэж байлаа. Энэ итгэл үнэмшлийн баталгаа нь миний нүдний өмнө, өвчтөнүүдийн байдал байлаа. Мөн амьд үлдэхийн тулд түрэмгийлэл зайлшгүй хэрэгтэй гэдэг нийгэмд тогтсон итгэл үнэмшлийг батлах маш олон баталгаа байлаа. Дэлхийг ноомой даруу байсан нь өвлөнө гэсэн библийн сургаалийн тухай ор тас мартаж, хайр дурлал, наймаа, спорт, улс төрд амжилттай байх цорын ганц зам нь зөвхөн өөрийнхөө зорилгыг түрэмгийлэн гүйцэлдүүлэх ба энэ явцад өөрийн хомхой үйлдлээс болж хэнийг ч хохироож, хорлохоос сийхгүй байх гэж үздэг.

Жараад оны сүүл үед биологич Роберт Адри The Territorial Imperative (“Газар нутгийн амин чухал зүйл”) номыг бичжээ. Түүний ном нь, амьтны зан байдлыг судалж, төрөл, зүйл хоорондын түрэмгийлэл амьтны ертөнцөд байх ба хүний нийгэмд ч оршдог тухай өгүүлжээ. Түрэмгийллийг ийнхүү шинжлэх ухаанд байр суурь эзлэх болгож, хэт материалист үзлээр бол дайн ба арьс өнгөөр ялгаварлах үзлийг зөвтгөж болохоор болжээ. Өөр нэг түгээмэл үзэл бол эр хүйсийн түрэмгий шинж эм хүйсийн хүлцэнгүй шинж чанартай зохицдог учраас энэ нь зүйлийн үржлийн зөв арга зам болдог гэсэн үзэл юм. Тэр үед байсан, одоо ч байгаа нэг маргаан бол хүн ба амьтны зан араншинг шинжлэх ухааны судлалд оруулах уу, үгүй юу гэсэн асуудал юм. Материаллаг ертөнцийн хувьд, эрдэмтэд, хөдөлгөөнд оршиж байгаа химийн элементүүд, биетүүдийн байдлыг ажигласны үндсэн дээр тогтсон дурмийг гаргаж чадна, тэдгээр элементүүд сэтгэлгүй учраас тэдгээрийн сэрэхүй юмуу жинхэнэ санааг анхаарахгүй байж болно. Харин амьтан, хүний ертөнцийн хувьд, ганцхан зан байдлын ажиглалтаас үндэслэн хөдөлшгүй дүрэм тогтоох хэцүү, учир нь, зан байдал нь тухайн нэг үйлийг үйлдэх гол шалтгаан болдоггүй.

Зан байдлыг шинжлэх ухааны түвшинд ойлгоход гагцхүү сэтгэлийн үүргийг ойлгохоос хамаарах ба бидний ихэнх нь бусдын сэтгэлийг мэдэх чадваргүй учраас зан байдлын судалгааны салбар нь хүний өөрийн сэтгэл дотор явагдах шаардлагатай. Энэ салбарын анхдагчдын нэг болох Зигмунд Фрөйд тэргүүтэй эрдэмтэдийг хэтэрхий субъектив хандлагатай хэмээн тохуурхан үздэг байжээ. Энэ хавхаас зайлсхийхийн тулд сэтгэлийг

шинжилж, түүний үйлдлийг ойлгох тодорхой, нарийн газрын зураг хэрэгтэй. Түүнийг үйлдэх онол ба арга барилыг хоёр мянга таван зуун жилийн тэртээ Бурхан багш тайлбарлажээ. Олон тооны бясалгаачид мөрийн үр, нирваан, гэгээрэлд хүрснээр Бурхан багшийн сургаалийн зөв гэдгийг баталсан байна. Шинжлэх ухаан нь баримтын субъектив нарийвчлалын талаар болгоомжтой хандах олон шалтгаантай байх боловч бодит байдлыг мэдэх мэдлэгт шинжлэх ухааны хэрэгслээр хүрэх бололцоогүй, харин сэтгэлээр түүнийг мэднэ. Бурхан багшийн айлдсан бодит байдлын тухай сургаалийг нотлох ганц арга нь бясалгах ба түүнийг өөртөө үзэж мэдэх юм. Шинжлэх ухаан ба шашин хоёрын ялгаа нь мэдлэг ба сүсэг бишрэлдээ биш. Ганцхан бодит байдал байгаа, зөв сүсэг бишрэл ба мэдлэг нь хоёр системийн аль алины чухал хэсэг болдог. Алдаатай мэдлэг ба итгэл үнэмшил нь буруу ойлголт, хүмүүс хоорондын зөрчилд хүргэдэг бөгөөд шинжлэх ухаан ба шашин хоёрыг зэрэг сэвтүүлдэг.

Эволюцийн хөгжлийн дутуу онолоор зан байдлын тухай тайлбартай харшлаагүй боловч Бурхан багш өөрийн сэтгэл хийгээд өөрийн тухайн зан байдлыг сэдэж байгаа сэтгэлийн хөдлөлүүдийг шинжлэн ажиглажээ. Бурхан багш, өөрийн үндсэн хоёр хэрэгцээг хангах буюу жаргалтай байх ба зовлонгүй байхад ямар сэтгэлийн хөдөлгөөн хэрэгтэй ба ямар сэтгэлийн хөдөлгөөн хэрэггүй вэ гэдгийг тодорхойлжээ. Тэрээр эхнийхийг хэрхэн дадлагажуулж, харин сүүлийнхийг орхин тэвчих замыг нээн, урьд хэзээ ч байгаагүй нирвааны амгаланд хүрчээ. Бусад хүмүүс тэрхүү аргыг дагаснаар бас нирваанд хүрсэн нь бүх сэтгэл ерөнхийдөө адилхан байдалтай гэдгийг тийнхүү тодорхойлсон юм.

Тэгш эрх гэж өнөөгийн улс төрийн ариун эрхэм зарчимыг Бурхан багш сургаальдаа өгүүлэхдээ ямар ч хүн, амьтаны аль ч хувь төрөлхтөн аз жаргалтай болох, зовлонгоос ангижрахад нэг нөгөөгөөс илүү эрхгүй гэжээ. Бурхан багш, юу ажигласнаа тайлбарлахдаа, хүмүүс жаргалтай байж, зовлонгүй байхаар зорихдоо өөрийн эрх өөр нэгнийхээс илүү байна гэж ойлгосноос өөрийн зорилтоо санаандгүй улам их холдуулдаг аж. Зовлонд дургүйцэх нь жаргалд шунах аминч хүсэлд саад болж байгаа зүйлд аяндаа уурлах, өсөрхөхөд хүргэдэг, гэвч уурласнаар жаргалтай байх ямар ч боломжийг үгүй хийдэг. Энэ ажиглалт нь үнэхээр шинжлэх ухааны үндэстэй, учир нь хүн ба амьтны зан байдал хийгээд түүний үр дүнгийн тухай тогтсон дүрмийг дүгнэн гаргаж болно. Жишээ нь: уур буюу дургүй хүргээд байгаа эд зүйлийг хорлох юмуу устгахыг хүсэж байгаа сэтгэлийн түгшүүртэй, ухаангүй байдал нь эрээд байгаа тайван байдалд ч, жаргалд ч хүргэдэггүй.

Үүнийг амьдралдаа болж байгаа зүйлсийг ажиглаж, уурлах нь үр бүтээлгүй ба гагцхүү зовлонг бий болгодог бодит байдлыг харах замаар батлах бололцоотой. Дараа нь уургүй болж, хүсээд байгаа тайван, жаргалтай байдалд хүрэхийг хүснэ. Хүн, амьтны үйл амьдралтай хамаатай өөр нэгэн тогтсон дүрмийг олно: тэр нь асрал хайрлал буюу бусдын аз жаргалтай, зовлонгүй байгаад баярлах сэтгэл нь сэтгэлийн угийн аз жаргалтай байдал бөгөөд түүний хаа байгаа газар ямагт тайван, баяр баясалыг түгээдэг.

Олонхи хүмүүс түрэмгийллийг зөвтгөхдөө хэрвээ тэмцэхгүй бол хорлолд гүйцэгдэнэ гэж үздэг. Бурханы шашины үзлээр бол үзэн ядалт нь өөрөө хорлол бөгөөд ямар ч нөхцөлд түүнээс зайлсхийх ёстой байдаг. Өөрийг хамгаалахад хүчээр тулгасан үед дайсандаа энэрэнгүй хандан хамгаалах ёстой. Ихэнх тохиолдолд бидний өөрсдийн зөрчилт байдал бусад хүмүүс бидэнд дургүйцэх, дайрах шалтгаан болдог; хэрвээ үргэлж энэрэнгүй сэтгэлээр

ярьж, үйлддэг бол дайсантай байх хэцүү. Бурхан багш өөрийг нь хөнөөх гэсэн агаач, ууртай хүмүүстэй тулгарч байсан боловч тэрээр ямар ч нөхцөлд энэрэнгүй ханддаг нь тэднийг хорлох бололцоогүй болгож байжээ.

Уургүйгээр хувь хүний болон нийгмийн шудрага бус явдлыг эсэргүүцэх боломжгүй, эсвэл уурлахгүй бол сул доройн шинж гэж үзэх нь утгагүй. Харин түрэмгий байх нь сул доройн шинж юм, хулчгар хүний арга зам. Зөрчлийг уураар биш хайраар шийдэхэд хамаагүй илүү их зориг шаарддаг. Бусдын сэтгэлд байгаа уурын галын дөлөөр өөрийн сэтгэл дэх уурын галыг ноцоовол бид болон дэлхий ертөнц алдагдана. Хэрвээ эрх мэдэлтэй байвал түүнийг хавчигдаж, дарлагдаж байгаа хүмүүсийг хамгаалахад ухаалаг, энэрэнгүй байдлаар ашиглаарай. Үнэндээ бол эдийн засгийн юмуу арьс өнгөөр ялгаварлан дайн хийж байгаа хирнээ түүнийг хүмүүнлэгийн довтолгоон гэж зөвтгөвөл туйлын муу ёс суртахуунгүй явдал юм.

Уурыг, түүний ерөндөг тэвчээрээр зогсоож, түүний эсрэг хайраар урвуулбал сэтгэлийн хөдлөлийг дарах, түүнээс үүсэх сэтгэцийн тэнцвэргүйдэлд орох аюулгүй болно. Ганцхан гарах үр дүн нь аз жаргал.

Сүсэг

Шашины нэр томъёоны хувьд сүсэг гэдэг үг хүн нэг нэгэндээ учруулах төсөөлж болохуйц аймшиг бүрийг зөвтгөсөн бохир нэр болж хувирсан юм. Шинжлэх ухааны үүднээс, сүсэг ба шалтгаан хоёр нь мэдлэгийн хүрээний хоёр эсрэг төгсгөлүүд юм. Сүсгийг үгүйсгэх ёсгүй юм. Энэ нь сэтгэлийн үйл ажиллагаа бөгөөд хэрвээ түүнгүй бол энэ насны харьцангуй жаргалыг олох хэцүү бөгөөд оюун судлахуйн холын зорилтын талаар бүр ярих ч аргагүй.

Эхлээд, сүсгийн утгыг тодорхойлохгүй бол бидний ярилцлага хаашаа ч явахгүй. Бурханы сургаалийн хувьд, сүсэг бол өөрт батлагдаагүй ч шууд туршлага болон учир шалтгаанаар үгүйсгэгдэхгүй, өөртөө харшлахгүй тухайн нэг зөв хүн, зөв үзэл бодолд итгэх, хүндэтгэлтэй хандахыг хэлнэ. Энэ тодорхойлолт ёсоор сүсгийн орон нь зовлонгоос хамгаалах ба жаргалын зүгт хөтөлж чадах тал дээр заавал зөв бөгөөд найдвартай байна. Тиймээс, сүсгийн орон нь зовлонгийн гол шалтгаанууд буюу өөрийг төвчилөх мунхаг, шунал ба уурын эсрэг байх нь. Буруу үзэл санаанд итгэх, найдваргүй хүнд итгэх нь сүсэг биш, энэ бол мухар сохор сүжиг болно. Хорон санаат, амьгүйг баримтлагч хүн зөв сүсэгт тийм муу нэр өгсөн нь хүн төрөлхтөний түүхэнд сэтгэлийн зовлонг ихэд учруулсан.

“Намайг дан ганц хүндэлсэн учраас миний сургаалд шууд бүү орогтун, дархан хүн алтыг худалдаж авахын өмнө сайтар шинжилдэг шиг нарийн шалгаж үзээрэй” гэж Бурхан багш айлджээ.

“Нарийн шалгаж үзээрэй” гэсэн гол үг нь сүсгийн орон зөв байна уу, үгүй юу гэдгийг тогтоогоорой гэсэн үг. Кристофер Колумбус баруун зүгт аялж явснаараа ертөнцийн хязгаараас доош унахгүй гэдэгт сүсэгтэй байсан. Хэрвээ тэр буруу байсан бол тэр доошоо унаж байгаа хэвээрээ байх байсан, үүнийг бид сүсэг гэж нэрлэхгүй байх байсан. Үүнийг тэнэглэл гэх байсан.

Өдөр тутам бид хүрээлэн буй юмсад бага зэрэг сүжиглэж байдаг. Онгоцонд суухдаа онгоц сүйрэхгүй, банкинд мөнгө хадгалахдаа буцааж мөнгөө авна гэдэгт итгэл сүсэгтэй байдаг. Онгоц, банк гэх мэт эгэл жирийн зүйлс биднийг сүйрлээс хамгаална гэдэгт бүрэн найдаж болшгүй. Бурханы сургаалд өгүүлснээр сүсэглэх гурван орны гол чанар нь бүрэн найдвартай хамгаалагчид, болдог бөгөөд өвчин, өтлөлт, үхэл, дахин төрөхийн аймшигт зовлон зэрэг бүх л сүйрэл гамшгийг зогсооход хөтөлдөг. Тэд найдвартай байдаг шалтгаан нь зовлонгийн үндэс шалтгаан-мунхаглал, үйлийн үрийг тайлбарлаж-тэдгээр шалтгаануудыг хэрхэн сөрж, арилгахыг заадаг.

Сүсгийн тэргүүн орон бол Бурхан байдаг, Бурхан бол билиг билгүүн хийгээд энэрэн нигүүлсэхүй сэтгэлийн төгөлдөржилтөд хүрсэн хүнийг хэлнэ, түүхэн бурхан Шагжмуни бурхан багшаар төлөөлүүлдэг. Бурхан гэдэг нь сэтгэлээсээ зовлонгийн үндсэн шалтгааныг арилгаснаар айх аюул, зовлонгоос бүрэн гэтэлж гарсан хүмүүсийг хэлнэ. Төрөлхтөн бүрийг алагчлалгүй энэрч, бүхнийг ойлгодог ба энэрэнгүй сэтгэлээ бодитой хэрэгжүүлэх арганд мэргэжсэн байдаг.

Бурхад бусдад туслах арга нь сэтгэлийн мөн чанарыг тайлбарлах, жаргал ба зовлонд

сэтгэлийн гүйцэтгэх үүргийг тайлбарлах байдаг. Ингээд төрөлхтөнд сэтгэлээ хэрхэн засах хийгээд зовлонгоос гарах өөрсдийн туулж ирсэн замыг зааж өгдөг. Түүнийг Дхарма буюу Бурханы ном гэх бөгөөд сүсгийн хоёр дахь орон юм. Энэ үг шууд утгаараа “зовлонгоос гарахад дэмждэг” гэсэн утгатай. Хувь хүн тус бүрийг хамгаалах Бурханы ном бол мунхаглал, уур, шунал тачаал, омог бардам гэх мэт нисваанисыг сөрөх хувь хүний сэтгэлд ижилшсэн билиг ухаан юм.

Сүсгийн гурав дахь орон нь Хуврагын чуулган буюу Бурханы зарлигийн утгыг өөрсдийн сэтгэлд машинд ухаарсан шавь нар ба бусдыг Бурханы хутагт хүрэх газар багшилдаг, хөтөлдөг хүмүүс юм. Хамгийн сайн хөтөч гэж тухайн газраар урьд нь зорчиж байсан хүнийг хэлдэг, хуврагын чуулган нь эрдмийн увьдасыг олоход учрах саадыг даван туулсан хүмүүс учраас бусдыг мөн тийм үр дүнд хүрэхэд бүрэн туслах чадвартай.

Бурхан ба Хуврагын чуулган нь гадаад байдлаараа бурханы номын эрдмийг сэтгэлдээ хөгжүүлэхэд бидэнд тусалдаг. Дараа нь түүний хариуд бид өөрсдийн эрхээр Бурхан болж, бусдын сүсэглэх орон нь болдог. Тиймээс, Бурханы шашинд сүсэглэх туйлын илрэл бол зам мөрийг дагах зориг ба шийдэл, төгс төгөлдөрт хүрч чадна гэж өөртөө итгэх итгэл юм. Сүсэг нь буян хийгээд бурханы хутгийн зам мөрт дэвшил олохын суурь юм.

Хэрвээ бурхан үнэн зөвийг айлдсан бол түүнийг бид өөрсдөө олж тогтоохыг өөртөө үүрэг болговол нэг л өдөр бүгд энэ замд орох шийдийг гаргана. Сүсгээс өөр юу ийм шийдвэр гаргахад нөлөөлж чадах билээ дээ? Зам мөрийн үр болох зовлонгоос гэтлэхэд түүнийг эдлэхээс нааш мэдэх бололцоогүй юм, тиймээс шууд мэдлэгийн эсрэг болох сүсэг нь чухал юм. Энэ сүсэг нь Бурхан багш, түүний сургаал ном, сургаалийн хэрэгжүүлж буй хүмүүсийн үнэн зөв хийгээд хүндэтгэл төрөх шинж чанаруудыг тодорхой таньж чадсан дээр үндэслэнэ.

Сүсэг нь гурван талтай: Баясах сүсэг. Энэ нь Бурханы номыг сонсох эрдмийн үр дүнд бий болсон, Бурхан багш, хуврагын чуулганы явдал мөрийг үзээд биширсэн сэтгэлийн тунгалаг байдлыг хэлнэ. Итгэх сүсэг нь Бурханы номын утгыг учир шалтгааны үндсэн дээр сайтар тунгааж, өөрийн амьдрал дээр загварчлан шинжиж, бурханы номын үнэнд бүрэн төгс итгэлтэй байхыг хэлнэ. Зорих сүсэг нь гэгээрэлд хүрэх зам мөрийг зэрэгчлэн бүтээх эрмэлзэл юм. Бурханы номыг бодож, бясалгасны үндсэн дээр тэдгээр зорилгуудад хүрэх бололцоотой гэдгийг мэдсэнээс бий болно.

Бурханы шашины сүсгийн дээрх гурван хэлбэр нь тус бүр гурван эрдэм болох: сонсох, бодох, бясалгах эрдэмд үндэслэсэн байна. Тэдгээрийг “мухар сохор” гэж хэлэхийн аргагүй, яагаад гэвэл Бурханы сургаалийн гол утга нь энэрэнгүй сэтгэл учраас хор хөнөөлтэй байж чадахгүй. Нөгөө талаас, шашины сүсгийг үгүйсгэн, шинжлэх ухаан, технологи дангаараа зовлонгоос гэтэлгэж чадна гэж итгэж найдахыг жинхэнэ “сохор” гэгчээр нэрлэж болно. Жаргалд хүрэх саад тотгоруудыг билиг ухаан, энэрэнгүй сэтгэлээр арилгаагүй цагт зовлонгоос ангижран тайван, чөлөөтэй байх гэсэн зорилгод хэзээ ч хүрч чадахгүй.

Монгол орны өргөн тал нутгаар саяхан аялж байх үед, хэдийгээр далаад жилийн турш шашин шүтэх хатуу хориотой, бурханы номын талаар хязгаарлагдмал мэдлэгтэй хирнээ хүмүүс Бурхан багш, Бурханы ном, Хуврагын чуулганд сүсэглэх явдал гүн гүнзгий хэвээрээ байгаад маш их сэтгэл хөдөлж билээ. Айл бүрт намайг дээдлэн хүндэлж, хүн бүр адис аван, гэр

хотлоо адислуулж байсан юм. Хүмүүсийн сүсэг нь баясах сүсгийн түвшинд байсан хэдий ч чухамхүү энэ л сүсэг Монгол түмний хүчтэй байх, сэтгэлийн мөн чанар болж байдаг болов уу. Монголд бурханы шашныг музейн эд өлгийн зүйл шиг хадгалж ирээгүй бөгөөд харин Монголын ард түмний зүрхэнд сүлд, золбоо хийморь нь болж байсан нь үндэсний бахархал бөгөөд дэлхийн даяны амар амгалангийн үнэт эх булаг юм. Дээрхийн гэгээнтэн Далай лам "Миний шашин бол энэрэнгүй үзэл болой" хэмээн айлддаг. Харамсалтай нь, Төвд орныг дэлхийн энх тайвны онцгой бүс болгох зорилт хэцүү санагдах талтай боловч Монгол орны хувьд энэ нь бүрэн бололцоотой юм.

Буянд сүсэглэхгүй бол ариун ёс суртахуун суурь үгүй болно.

Шунал, уур хилэн, хувиа бодох сэтгэлийн эрч хүчийг барьж тогтоох ямар ч зүйл үгүй болно, ингэснээр Монголчууд одоогийн Барууны олон орнуудын хот, хөдөөг аль хэдийнээ тодорхойлдог түгээмэл шинж нь болоод байгаа бүхнийг үгүйсгэх гутралд орох аюулд хүрнэ.

Хэрвээ Монголын ард түмний Бурхан, Бурханы ном, Хуврагын чуулганд сүсэглэх нь Барууны орныхны мунхаг сэтгэлийг устгахаасаа илүү түүнийг өмгөөлж хаацайлсан үнэлэмж, итгэл үнэмшлээр хүчээр эзлэгдвэл маш гүн эмгэнэл болно.

Ёс суртахуун

1960-аад онд Барууны уламжлалт ёс суртахуунд чөлөөт хайрын эрин үед шүүрэгдсэн залуучуудын зүгээс доргилт гарсан юм. Би тэр үед сайн ба муугийн тухай үзэл санааг дахин тодорхойлохыг хүссэн тэдгээр залуучуудын нэг нь байлаа. Эцэг эх, багш нар, улс төрчид, шашны зүтгэлтэн зэрэг хүмүүсийн зовлонтой байдал, ам, ажил хоёр нь зөрөөтэйг хараад нийгэм өөрөө бидэнд юу буруу, юу зөвийг шүүн тунгаах чадлыг үгүйсгэж, өөрсдийн гаргасан “хэрвээ сайхан санагдаж байвал хий” гэсэн зан байдлын хуулийг мөрдөх болсон юм.

Жаргалд умбаж цэнгэсэн байдлыг байнга тогтооход хэцүү гэдэг нь мэдэгдлээ. Ойрын харьцаатай хүмүүс салах, өвчин зовиур, архи, тамхины дон, сэтгэлийн тогтворгүй байдал, үхэл хагацал зэрэг аймшигтай тулгараад ирэхийн цагт бид өөрсдийнхөө ёс суртахуунд эргэлзэж эхэллээ. Энэ эргэлзээнээс үүдэн Бурханы шашинд сонирхох сонирхол бий болсон юм. Бурханы сургаалийн атеист буюу шашингүй үзэл нь бидэнд сайшаалтай санагдахаас гадна зовлон нь зөвхөн өөрийгөө бодсоноос бий болдог гэсэн тайлбар тэр үеийн Барууны олон хүмүүс Бурханы шашиныг сонирхох болсон нь холбоотой юм. Үүнийг бидний хувьд шууд мэдэж болох байлаа. Өөрийн жаргал цэнгэлд хэтэрхий их автсан байсан бөгөөд өөрсдөдөө хангалттай үнэнч хүмүүс тохиолдсон бэрхшээлүүд нь ихэнхдээ өөрийн хариуцлагатай холбоотойг үгүйсгэж чадахгүй байлаа. Мөн Бурханы шашины үл захиран тушаах үзэл нь биднийг татаж байлаа. Бурхан багш хэзээ ч үүнийг хий, түүнийг бүү хий гэж айлдаагүй. Тэрээр зөвхөн учир зүйг тайлбарлаад хүн өөрийн зан байдлаа тохируулан засах эсэх нь өөрийн шийдэх асуудал болгон үлдээсэн. Жинхэнэ ёс суртахуун дотоодоос буй болохоос бус хууль дүрэм юмуу хүчээр тогтоож болшгүй.

Бурханы сургаалийн ёс суртахууны утга нь хүн ба амьтанд хорлолтой үйл үйлдэхээс зайлсхийх явдал юм. Шунал, уур, мунхагаар амьтны амь хөнөөх, хулгай хийх, буруу хурьцах нь бусдыг хорлодог биеэр үйлдэх үйлүүд. Шунал, уураас бусдын амийг хөнөөх нь ойлгомжтой. Мунхагаар амьтныг хөнөөх гэдэг нь амьд амьтан юмуу хүнээр тахилга үйлдэснээр тухайн хүн өөрт нь болон амиа алдаж байгаа хүн ба амьтаны аль алинд нь сайн гэсэн итгэл үнэмшилтэй холбоотой.

Хулгай хийх гэдэг нь өөрт эс өгснийг хулгайлан авах болон хууран авах явдал юм. Уур болон шуналаас болж хулгай гардаг олон жишээг бодож олж чадна, мунхагаар хулгай хийх тохиолдол нь татварын тооцоо бүртгэлээс зайлсхийхдээ бусадтай адилхан байхад би буруугүй гэсэн бодолтой байхыг хэлнэ.

Буруу хурьцах гэдэг нь хурьцлын замаар бусдыг шууд болон шууд бусаар хорлохыг хэлнэ. Ихэнх тохиолдолд, буруу хурьцал нь өөрийн хүслийг биелүүлэх үүднээс эр эмийн тогтсон харилцааг санаатайгаар бусниулснаар гуравдагч хүнийг хорлодог. Хүчирхийлэх, бага насны хүүхдийг хурьцалд татан оруулах болон бусад байдал нь буруу хурьцлын жишээ. Мунхагаар буруу хурьцал үйлдэх гэдэг нь жишээ нь, эрэгтэйчүүд нь эмэгтэйн талын мэдрэмжийг бодолцохгүй, тэднийг түүдэг цэцэг, иддэг хоол шиг авч хэрэглэж болдог байдлаар хандан хурьцалаар зугаацахыг хэлнэ.

Худал хэлэх, гүтгэх, хараал хэлэх, чалчих нь хэлээр бусдыг хорлох үйлүүд юм. Худал хэлэх нь

үнэн гэдгийг мэдсэн хирнээ үгүй гэж үгүйсгэх юмуу мэдэхгүй хирнээ мэдэх юм шиг дүр үзүүлэхийг хэлнэ. Үүнд мэдсээр байж бусдад буруугаар ойлгуулах, санаатайгаар муу зөвлөгөө өгөх, бусдад гэм олж зүүх юмуу тэдний сайн талыг үгүйсгэх орно. Мунхагийн улмаас худал хэлэх нь зугаатай эсвэл худал хэлэхэд буруудах юмгүй гэж бодоод худал хэлэх явдал юм. Гүтгэх нь найзуудын хооронд хагарал үүсгэх юмуу аль хэдийнэ үүссэн байгаа хагаралыг даамжруулахыг хэлнэ. Шуналын улмаас хүсэж байгаа хүнээ өөрийнх нь амрагийн эсрэг эргүүлдэг, үзэн ядалтаас болж хэн нэгнийг өөрийнхөө дайсны эсрэг хандуулан эргүүлдэг, мунхагаар шашины хүмүүсийг өөрийн хязгаарлагдмал үзлээр тэдэнд юу хамгийн сайн гэж тооцож байгаа номлолд урвуулан оруулахын тулд багшийнх нь эсрэг хандуулдаг. Мунхагаас үүдсэн хараал үг нь хэн нэгнийг шоолох юмуу тохуурхан ярих ба түүнийгээ ухаантай, моод гэж бодох, тэгээд ч нөгөө хүнийг гомдоож байгаа нь хамаагүй болдог. Мунхаглан чалчих нь цаг агаар, спорт, хувцас загвар зэргийн тухай үнэхээр их ач холбогдолтой байдлаар ярихыг хэлнэ.

Дээр дурьдсан бие, хэлний долоон буруу үйл нь шунал, хорт сэтгэл, буруу үзэл хэмээх сэтгэлийн гурван муу үйлдлээс гардаг. Зөв ёс суртахуунтай амьдрах гэдэг нь дээрх арван нүглийг үйлдэхийг тэвчээд зогсохгүй тэдгээрийн эсрэг үйлүүд болох-амьтны амь аврах, үнэнч шударга байх, үнэн зөв, зөөлөн аядуу ярих зэрэг юм.

Өөрийг төвчилсөн мунхаглал, шунал, уур хилэн нь бидний сэтгэлд маш гүн үндэслэсэн байдаг тул нэг өдрийн дотор буян болж хувирах бололцоогүй, тиймээс нүгэл үйлдэхээс сэрэмжлэх замаар ариун ёс суртахууныг төлөвшүүлэх олон янзын аргыг Бурхан багш айлджээ. Бурханы сургаалийн ёс суртахууны үндэс нь өөрийн муу сэтгэлүүдийг өвчин эмгэг мэтээр ойлгох явдал юм. Бурхан багш бол мэргэшсэн эмч адил бөгөөд өвчнийг зөв оношилж, ариун ёс суртахууныг уух эмээр бичиж өгчээ. Ариун ёс суртахуунтай амьдрахаар сонгох нь эмийг уухтай адил бөгөөд эрдэмтэй багшид сүсэглэн бишрэх нь эдгэхэд тусалдаг сувилагчид итгэхтэй адил юм.

Тиймээс зөв ёс суртахууны эхлэл нь арван нүгэлт үйлийг тэвчин жаргалд хүрье гэсэн зорилго юм. Дараагийн шат нь арван нүглийг богино хугацааны туршид юмуу насан туршдаа тэвчих амлалт өгөх байдаг. Гэргийтэн хүмүүс сахиж болох таван сахилыг Бурхан багш хайрласан: амьтны амь хөнөөхгүй, хулгай хийхгүй, худал хэлэхгүй, буруу хурьцахгүй, согтууруулах унд уухгүй байх юм. Эхний дөрөв нь мэдээж нүгэл. Хууль ёсны эхнэр нөхөртэйгээ зохистой эр эмийн харьцаанд зохицуулалттай орох, мөн согтууруулах ундыг тааруулж уух нь мэдээжийн нүгэл бус. Согтууруулах ундаас зайлсхийх бололцоог ийнхүү олгож байгаа хэрэг бөгөөд учир нь, архи уун согтуурснаар оюун ухааны эрүүл байдал алдагдаж, мэдээжийн нүглийг ямар ч хязгаарлалтгүй үйлдэхэд хүргэдэг. Бидний сэтгэлийн одоогийн байдлыг илт харуулах нэг илэрхийлэл бол барууны Бурханы шашинтай ихэнх сүсэгтэнүүд эхний үед эхний гурван сахилыг авдаг. Харин тодорхой хугацаа өнгөрсөний дараа буруу хурьцах, согтууруулах унд уухыг тэвчих дараагийн хоёр сахилыг нэмж авдаг.

Сайн дураараа нүглийг тэвчих дараагийн шат нь эрэгтэй болон эмэгтэй хуврагын олон түвшний сахил авах байдаг. Эдгээр сахилд бэлгийн харьцаагүй байх, архи уухгүй байх багтдаг. Олон Монголчууд хуврага хүнийг архи уудаг, эхнэртэй байж болдог гэж ойлгодог. Мөн бүх хуврагуудыг лам гэж нэрлэдэг, гэвч энэ нэрийг зөвхөн эрдэмтэй, номын хөтлөгч

хүнд өгдөг. Лам хүн бол сахилтай юмуу гэргийтэн хүн аль нь ч байж болно. Тиймээс лам нар сахилтай байх албагүй, сахилтай хүн лам байх албагүй. Гэхдээ Бурханы шашины эрэгтэй болон эмэгтэй хуврага заавал гэр бүлгүй байдаг.

Эрэгтэй ба эмэгтэй хуврагын сахилууд нь голдуу бие, хэлээр үйлдэх нүглээс хориглосон байдаг бөгөөд сэтгэлээр сахих сахилтай харьцуулбал хялбар байдаг. Гэвч, ариун ёс суртахуун нь бусдыг хорлох бодол үүсгэхээс ч ангижирсан байх ёстой бөгөөд түүнд хүрэхийн тулд Бурхан багш тухайн үед цөөн хэдэн сахиж чадах шавь нарт тусгай сургаал айлджээ. Тэдгээр сургаалийг Махаяна буюу Их Хөлгөний сургаал гэнэ. “Их” гэдэг нь хамаг амьтныг зовлонгоос гэтэлгэн аврах үлэмж их хариуцлагыг өөртөө үүрч буй бодь сэтгэлийг хэлдэг. Энэ бол сайн дурын тэвчилийн дараагийн хоёр шат-бодьсавын ба тарнийн сахилын үндэс юм.

Бодьсавын сахил нь бие, хэл, сэтгэлийн нүглийг тэвчих нь Бурхан багшийн өөрийн туулсан, гэгээрэлд хүрэх Бодьсавдвгийн зам мөрийг даган дуурайх арга юм. Бодьсавда гэж нирвааныг хүсэлгүй, амьдралын хүрдэнд оршиж, тоолшгүй олон төрөл авахдаа хамаг амьтанд тусыг бүтээн, Бурхан болох шалтгааныг аажмаар хурааж байгаа хүнийг хэлдэг. Жаргалаас зугтаахын оронд өөрсдийн сахилын тусламжтайгаар бодьсавда нар жирийн амьдарлыг буян болгон хувиргадаг.

Тарнийн ном нь Бурханы хутгийг илүү хурдан бүтээх арга болдог. Тарнийн номоор явахын тулд дээд зэргийн магад гарахуйн сэтгэл, сэтгэлээ захирах чадварыг шаарддаг. Түүнд голдуу сэтгэлийн нүглийг тэвчих тарнийн сахилууд болох сэтгэлийн муу үйлдлүүдийг хорих замаар хүрнэ. Бодлыг хянахад хамгийн хэцүү, тиймээс эдгээр сахилыг сахихад хамгийн хэцүү. Мөн тэдгээр сахилууд хамгаас их нууц байдагийн учир нь амархан буруугаар ойлгогддог. Дахиад л Монголд гэж онцолмоор байна. Тарнийн нууцлаг байдал нь дээрчилснээс болсон хэрэг бус. Тарнийг ойлгох бэлэн бус хүмүүс байдаг бөгөөд нууц байдал нь тэдгээр хүмүүсийг өөрсдөдөө болон бусдад хорлол болох алдаатай тайлбараас хамгаалсан хэрэг.

Ямар ч бүлэг хүмүүс, нийгмийн дотор нэг нэгнээ үл хорлох ёс суртахуун тогтсон байж тэнд амар тайван байдал бий болно. Хэдийгээр Бурханы сургаал нийгэмд зориулсан сургаал бус ч гэсэн. Бурханы сургаал, номын үйлүүд нь хувь хүнд зориулсан байдаг, учир нь ариун ёс суртахуун зөвхөн дотоодоос бий болно. Хэдий тийм ч, хэрвээ хангалттай олон хүн ариун ёс суртахууныг дадуулбал эдийн засгийн хөгжлөөс үл хамааран энх тайван, амгалан байх болно. Хамгийн эрхэм зүйлээ цэгцэлсэн байгаа цагт Бурханы сургаал

эд баялаг, эдийн засгийн өсөлт, технологийн хөгжил дэвшлийг эсэргүүцдэггүй. Хамгийн чухал зүйл юу вэ гэвэл сэтгэлийн дотоод хөгжил, зөв ёс суртахуун, ухаалаг байдал, бусдыг дээдлэх чанарын эд баялаг нэгдүгээрт тавих явдал юм.

Хэрвээ жараад оны үед хэн нэг нь намайг насныхаа ихэнхийг гэргийтэн бус, Бурханы шашины хувраг болно гэж хэлсэн бол, их бага хэмжээгээр Арван тангарагийн дагуу амьдарна гэж хэлсэн бол би үхтэлээ инээх байсан. Үүнийг бодоод үзээрэй, би ингэж л үхнэ.

Хүсэл

Хэрвээ биднийг өөртөө байгаа бэрхшээлүүдийг жагсаагаад гарга гэвэл хуудас дүүртэл гомдол гаргах байсан, тэдгээр дотор хүслээ биелүүлж чадаагүй хэсэг нь дийлэнхийг эзэлнэ. Гэвч бидэн дундаас хэд нь хүслийг бэрхшээл болгож жагсаах бол?

Бурхан багш хүслийг хамгийн том бэрхшээлүүдийн нэг хэмээн айлджээ. Хүсэл бол жаргалд шунасан сэтгэлийн төлөв байдал бөгөөд жаргалын тухайн нэг орон болох хүн юмуу материаллаг эд зүйлийг өөрийн болгож авахыг хүсэж байгаа байдал юм. Хүсэл нь тухайн хүн юмуу эд зүйлийн сайн талыг хэт дөвийлгөдөг учраас жинхэнэ байгаа байдлаасаа илүү дээр харагддаг ба ямар ч муу талыг нь харж чаддаггүй. Тухайн нэг хүнд татагдахад хүсэл нь тэр хүнийг дэлхийн хамгийн сайхан хүн болгож харагдуулдаг. Тэр хүний бие, хоолой, хувцас зэрэг нь төгс, бүх юм нь ид шидээр адисласан байдаг. Биеийн хувьд тэр хүний биед тачаадаг, сэтгэлийн хувьд, тэр хүн намайг хувь хүн гэдэг талаас нь хүлээн зөвшөөрөхийг хүсэж байдаг. Өөрийгөө сайн, хайр татсан хүн юм байна гэж батлахын тулд тэр хүний инээд, хайр хэрэгтэй байдаг. Өдөр, шөнийн алинд ч тэр хүнийг бодохгүй байж чадахгүй бөгөөд сурлага ном юмуу өөр ямар нэг зүйлд төвлөрөх бололцоогүй болдог. Хэрвээ найзууд маань тэр хүний муу талыг зааж хэлбэл, тэдний зөвлөгөөг үл хэрэгсдэг. Бид ердөө ямар ч дутагдлыг олж чаддаггүй.

Хүсэл тачаал нь аз жаргал биш. Энэ нь сэтгэлийн цухалдуу, зовлонтой, хүсэж байгаа зүйлээ хүртэхгүй л бол аз жаргалтай байж чадахгүй хэмээн итгэсэн байдал юм. Хүсэл биелээгүй цагт идээ хоолонд дургүй, уцаартай, тайван байж гэр бүлийн хүмүүстэйгээ эвтэй байж чадахгүй, амьдарлыг үзэн ядаж, тэр бүү хэл өөрийгөө ч үзэн ядна. Эцэст нь, хүссэн зүйлээ авсан ч гэсэн хүсэж байсан зүйл нь бодсон шиг тийм сайн биш байсан гэдгийг мэдмэгц удалгүй тэр хүссэн зүйл үнээ алддаг. Эсвэл уйдаж, сэтгэл дундуур болж, илүү сайн зүйл юмуу хүнийг хайж эхэлдэг.

Хүсэл тачаал нь өөрсдийн эд хөрөнгө, хүүхдүүд, эцэг эх, найзуудынхаа сайн чанаруудыг товойлгох ба хэт дөвийлгөдөг бол уур бол түүний эсрэг. Дургүй хүргэдэг хүмүүсийн сайн чанаруудыг харахгүй болж, муу чанаруудыг хэт дөвийлгөх юмуу байхгүй муу чанаруудыг тохоодог. Хүсэл тачаал ба уураар найз нөхөд болон дайснуудын сайн ба муугаар харагдах байдлыг үнэн гэж итгэдэг. Тэдгээр нь бидний сэтгэлийн тусгалууд болохыг мэддэггүй. Сэтгэл хангалуун хийгээд амар тайван байх бололцоогүй, учир нь, бусад буруутай гэж бодсоноос ханилж байгаа хүнээ, худалдаж авсан машинаа хаяж, шинэ ажилд орж, шинэ газар нүүх зэрэг нь үхэн үхтэл үргэлжлэх боловч сэтгэл ханаж чадахгүй.

Хүссэн хүнтэйгээ гэрлэсний дараа удалгүй найзуудын зөв байсныг мэднэ. Шинэ нөхөр, эхнэр нь бидний хүслийн тусгаж байсан тэдгээр хүмүүс биш байж. Тэд хэт их уудаг, залхуу, хүчирхийлэлтэй, тэр байтугай шивэртэй.

Ухамсартай болон ухамсаргүйгээр хүсэл тачаалд туссан шиг бүх талаараа санаанд хүрч чадаагүйд тэднийг шударга бусаар буруутгадаг. Ханилж байгаа хүнээ өөрийн өмч юмуу өөрийн амиа бодох үзлийн үргэлжлэл мэтээр ойлгож, бас л ухамсартай хийгээд ухамсаргүйгээр өөрийн санаснаараа байлгах юмуу миний ханилж байгаа хүн хэрхэн харагдах болон биеэ авч явбал зохилтой талаар өөрийн бодсон байдалд нийцүүлэхийг оролддог. Энэ нь

тэднийг боогдуулж, хувь хүн байх орон зайг үгүй болгож, тухайн хүн өөрөөрөө биш байх гэсэн бололцоогүй зүйлийг шаарддаг. Бид ч мөн адил тэднээс бидэнд хандсан хүслийнх нь итгэл найдлагын хэмжээнд хүрч чадаагүй учраас хоорондын харилцаанд үл нийцэл үүсэж, өөр хэн нэгнийг хайж эхэлдэг. Үдэшлэгийн үеэр өөр нэг царайлаг хүнтэй танилцана, ингээд сэтгэл маань хүсэл тачаалын эрхэнд дахин нэг орно. “Энэ хүн бол яг төгс хүн, би түүнд хайртай” гэх болно. Урьдын анд нөхрөө орхиж, ээлжит зовлонт аялалд гарах нь тэр. Өөртэй нь хамт хөдлөх урт модны үзүүрт уясан лууванг хөөж байгаа илжиг адил хэзээ ч үл биелэх зорилгыг үүрд хөөсөөр.

Хэрвээ шинжилж үзвэл жаргалыг мэдэрч амгалан байх нь гагцхүү хүрэлцэх, амтлах, хөгжим сонсох зэрэг хүссэн зүйл маань юу байна түүнийг сайхан гэж тодорхой хэмжээгээр сэрэхээс үүсдэг. Амгалан байхын гол шалтгаан бол хүсэл зогссоноос үүдсэн тайвшрал юм. Харамсалтай нь, хүсэл түрхэн зуур зогсдог. Удалгүй хорт хавдар мэт амгаланд дурлах хүсэл сэтгэлд дахин сэргэж сэтгэлийн амгалан тайвныг эвдэж эхэлдэг.

Амьдралын жаргалд шунах шунал үхэл ойртох тусам хүчтэй болдог. Үхэхийг хүсдэггүй, үхэл нь бидний амьдарлаа зориулж ирсэн зүйлийн эсрэг нь байдаг ба жаргалын эцэс төгсгөл мэт санагддаг. Энэхүү хүсэл нь дахин төрөл авч, амгаланг хайсаар байхыг бататгадаг. Амьдралыг хүсэх нь бидний сэтгэлд үйлийг боловсруулж, өөрийн эрхгүй хойд төрөлд хүчээр ордог. Гэвч дараагийн удаа хүний биеийг олж төрөх хувь дутаж магадгүй. Бид там гэж нэрлэдэг амьд хар дарсан зүүдэнд зовлонт амьтны биетэй төрөх, хуурай зэлүүд газар бирдийн эцэнгир туранхай биетэй, эсвэл адгуусны өдтэй, хайрстай, сортой биетэй болдог. Бурханы сургаалийн домогт, нэг эмэгтэй өөрийн биеийг сайхан гэж үнэхээр их дурладаг учраас хойд төрөлдөө могой болж төрөөд, урьд төрлийн эмэгтэйн араг ясан дотор амьдардаг байсан тухай өгүүлдэг.

Хүсэл тачаал ба хайр нь адил биш. Хайр нь өөрт дадуулах хэрэгтэй эерэг сэтгэлийн хөдөлгөөн байдаг. Хайр нь хэн нэгнийг аз жаргалтай болгох гэсэн ариун бодол эрмэлзэл байтал, хүсэл тачаал нь зөвхөн өөрийгөө л аз жаргалтай байлгахыг боддог. “Хэн нэгэнд дурлах” хэмээх сэтгэлийн хөдөлгөөн бол хүсэл тачаал ба хайрын холимог бөгөөд энэхүү нөхцөлтэй холбоотой гардаг шаналсан байх гол шалтгаан нь хүсэл тачаал юм. Зүрх сэтгэлд шаналал үүдэн бий болбол тэр нь хүсэл тачаал илрэн гарч байгаа хэрэг, тиймээс түүний ерөндөгийг хэрэглэж, сэтгэлээ нирваан хийгээд гэгээрэлд хандуулаарай. Сэтгэлээ шуналаас буцаахын тулд эхлээд хүсэл тачаалын тэнэг, ихэсгэл хэтрүүлэл, сайхан чанарыг хэт тохоох, энхрийлэх зэргийг санаж, түүний дараа хүсэл тачаал төрүүлсэн зүйлийг жинхэнэ чанараар нь харах буюу таны тусгалаар хоосон, түр зуурын юм үзэгдэл болохыг ойлгох. Жаргалтай байх хийгээд сайхан зүйл хоёр нь хоёулаа хий үзэгдэлтэй төстэй, тэд жинхэнэ, чухал мэтээр харагддаг боловч сайхан зүүднээс илүү гарах чанар үгүй. Тэд удалгүй явж, дахин сэргэхгүй.

Бурхан багш бясалгаач нарт хандан, гоё сайхан биед шунах буруу төсөөллүүдийг дарахын тулд тэр биеийг үхэж, үрэгдэн бутарч, араг яс болж байна гэж бодоорой хэмээн айлджээ. Таны зүрхийг эзэмдээд байгаа хэн нэгнийг ийнхүү бодоод үзээрэй. Үл шунах сэтгэлээр шуналын манангаас сэтгэлээ чөлөөлж чадсан тэр үед ариун хайрын амгаланг мэдэрнэ.

Өөрийгөө Үнэлэх Үнэлэмж

Бид эхээс мэндэлж байсан үеийг санахгүй боловч ”Энд одоо юун там болоод байнаа? Намайг эндээс гаргаах!” гэсэн иймэрхүү бодолтой байсан гэдэгт би итгэлтэй байна. өгүүлэх эрхтэн маань хараахан хөгжөөгүй байсан учраас часхийтэл уйлахаас өөрөөр дургүйцлээ илэрхийлж чадахгүй байсан байх. Энэ нь тэнд байгаа хүмүүст инээд баяр болох нь хүн тамлагчдын ертөнцөд мэндэлснийг итгүүлэн өвдөж байхад улам гомдооно. Тэр үеэс эхлэн “бидний эсрэг ертөнц” боллоо. Бидний шаардлага энгийн байлаа: ертөнц бидэнд аз жаргал, магтаал, хайр, өмч хөрөнгөний өртэй байлаа.

Бүхий л амьдралын туршид эдгээр дөрвөн шаардлага биелэгдсэн, эсвэл гонсойлгосон эсэхээс шууд хамааралтайгаар өөрийгөө үнэлэх үнэлэмж дээр, доор болдог. Аз жаргал, магтаал, хайр, өмч хөрөнгө зэргийг тэдгээрээс бий болдог шууд амгалан хийгээд өөрөө өөртөө итгэх итгэл хоёрт шунадаг учраас хүсдэг. Хичнээн амгалантай болох тусам өөрсдийнхөө амьдралыг хянаж чадаж байна гэж боддог, зовлон гэдрэг ухарч, адал явдалд илүү дурлаж эхэлдэг. Нөгөө талаас, өвчин, шүүмжлэл, дургүйцэл, ядуурлаас үүдэн зовлон зүдүүртэй болсноор өөртөө итгэх итгэл сүйрнэ гэж үздэг учраас айдаг. Хайр, хүндлэл, эсвэл амьжиргааны аргагүй болсноор өөрийг доогуур үнэлэх үнэлэмжийн доош уруу чиглэсэн ороомогоор унан, сэтгэлийн хямралтай болж, аз жаргал, магтаал, хайр, эд баялагтай болох бололцоо нь улам хумигддаг.

Үзэж туулсан амьдралаа сайтар, нарийвчлан үзвэл өлгийд байхдаа авсан анхны тоглоомоос эхлээд энэ жил шинэ машин худалдаж авах хүртэл; эсвэл бага байхдаа эцэг эхдээ ах дүүгээсээ илүү эрхлэхээр өрсөлдсөнөөс эхлээд бусдын эхнэр нөхөртэй нөхцөх эсвэл эхнэр нөхрөө хууран мэхлэх хүртэл амиа бодох замаар тэдгээр зорилтуудад хүрэхийн төлөө амьдарчээ. Том хүний зан байдал нь нялхасын дуртай, дургүйн боловсронгуй хувилбар юм. Бие өсөж нас биед хүрснээс бус сэтгэл ухаанаар нэмэгддэггүй. Тэгээд аз жаргал, магтаал, хайр, өмч хөрөнгөний төлөө улангасан явсны үр дүнд юу болов? Гонсрол, хагацал, алдагдал, хоосон ирээдүй, хий дэмий өнгөрүүлсэн хугацаа. Амьдралд бүтэлгүй явдал тохиолдох, ялангуяа үхэж байхад өнгөрсөн цагт эдэлсэн биеийн бүх жаргал цэнгэлийн хэрэг яаж гарав? Хураасан эд хөрөнгө, хайртай найзуудын хэрэг яаж гарав? Өнгөрсөн сайхан цагийг эргэн дурсах нь одоог сайхнаар мэдрэхэд саад болдог, мөн хүүхдүүдэд ч гэсэн уйтгартай болдог, тэд: “Аав маань хуучинсаг бодлоо болиосой” гэнэ.

Энэ бол муу мэдээ. Цааш нь үргэлжлүүлж болох боловч энэ нийтлэлийг та уншиж дуусгах хэрэгтэй.

Өөрийн үнэлэмж хоёр хүчин зүйлтэй-үнэлүүлэх “би” хийгээд дээрх дөрвөн шаардлага биелэгдсэн эсэх нь үнэлгээний суурь юм. Хүсэж байгаа зүйлүүдийг харвал тэр хувьсан өөрчлөгдөх мөн чанартай, найдваргүй учир тэдгээрийн бий болгох жаргал цэнгэл ч мөн адил түр зуурын бөгөөд тогтоон барихад хэцүү. Шингэж байгаа нарны үзэсгэлэнт сайхан байдал харанхуйгаар солигдоход тэр өнгүүд түр зуурын байсныг мэдэх учраас гонсойдоггүй. Харин хүүхэд байхдаа тоглохын жаргал хэзээ ч дуусахгүй гэж бодож байсан учраас далайн эргээс гэртээ харих болоход уйлдаг байсан. Мөн том болсон хойноо эхнэр, нөхөр маань бидэнтэй үүрд хамт байна хэмээн итгэснээс тэднийг алдсандаа уйлдаг. Амьдралыг зовлонтой болгож

байгаа зүйл бол жаргалд шунах шунал, жаргалын юмсыг амьдралд байнга тогтсон байх мэтээр бодсоноос болдог. Юмсын түр зуурын мөн чанарыг санаснаар тэдгээрийг үгүй болоход араас нь гуниглан санахгүйгээр аз жаргалтай байж чадна.

Хүсэл төрүүлэгч эд зүйлсийн түр зуурын хийгээд найдваргүй чанар нь бидэнд тохиолддог ганцхан зовлон биш. Бидний зүгээс сэтгэл ханахгүй байхын аймшигт өвчнөөр энэлэн зовдог. Юмс бүтэмжтэй үед амарч чаддаггүй. Эхнэр, нөхөр, ажил, машин зэргийн өөг харж эхэлдэг, ингээд тэднийг өөрчлөх, аль нэг, хэн нэгээр улам сайжруулах тухай мөрөөддөг. Сэтгэл ханахгүй байдал одоогийн жаргалыг мэдрэх бололцоогүй болгож, найз нөхөд, эд хөрөнгөө хаях зэрэг хожим нь харамсах үйлдлүүдэд хүргэдэг.

Үнэлж байгаа би-гийн хувьд, оршиж байгаа би хийгээд бидний төсөөлсөн би хоёрын хооронд ялгах хэрэгтэй. Биднийг “Жорж”-той танилцуулахад энэ нэрийг тухайн нэг хүний биеийн төрхтэй холбож ойлгодог. Хожим нь, хэн нэг “Тэр хүн хэн бэ?” гэж асуувал бид тэр хүнийг Жорж гэж зөвөөр тодорхойлно. Зөв нэр хийгээд Жоржийн төрх хоёрын холбоос нь нийтээр хүлээн зөвшөөрсөн байдлаар Жорж байгааг тодорхойлж байна. Энэхүү нэрлэх үйл явцаас цааш гарах Жорж байхгүй, Жорж гэж тодорхойлох илүү юу ч байхгүй. Өөрийгөө үнэлэх нь өөрийн эрхээр оршдог, бие, сэтгэл, нэрээс хамааралгүй гэж боддог “би” дээр үндэслэсэн байдаг. Уг чанартаа, тийм би үгүй бөгөөд, гэвч өөрсдийн бие, сэтгэл тэр байтугай амьдарлын амжилт, уналтын түүх зэргийг төсөөллөөр бүтээсэн, ангид тусгаар би-гийн өмч хөрөнгө юмуу жинхэнэ чанарууд хэмээн боддог.

Бидний төрх өнгөрсөн үед ертөнцтэй өрсөлдсөнөөс үлдсэн чимэг зүүлт юмуу сорвитой улмаас заримдаа сайхан, заримдаа муухай харагддаг. Өөрийн оршин байгааг хэрхэн тусгаж авснаас хамааран өөртөө дуртай юмуу дургүй байдаг. Энэ л бидний хамгийн том алдаа юм. Өөрийн төрхийг жинхэнэ Би мөн хэмээн алдаатай бодож, “Би урьд нь чадаагүй юм чинь одоо чадахгүй” гэх мэт бодлоос болж ирээдүйд аз жаргалтай байх бололцоо хумигддаг. Тийнхүү цааш явах зориг мохсон, амьдралдаа өвдөг сөхөрсөн хэдэн тэрбум хүмүүст нэмэгдэн нэгддэг.

Хоолоо сойж турах гэсэн бүсгүйчүүд, биеэ бялдаржуулагчид өөрийн төрхийн биеийн талыг сайжруулахад хэт их захирагдаж байгаагаараа үхсэн морийг ташуурдаад байдаг. Нэр хүнд, алдар гавьяа хөөцөлдөн нэг нэгэнтэйгээ өрсөлдөн байгаа эрдэмтэд сүүдэр хөөдөг. Туйлын дээд эрх мэдэл ба хөрөнгийг эрж байгаа толгой баячууд үүлэн дээр хөвж байдаг. Тэд алдаа унал гаргах нь зайлшгүй, учир нь тэдний жаргалтай болгох гээд оролдоод байгаа Би нь тэдний төсөөлж байгаа шиг оршдоггүй. Эрүүл бие, нэр алдар, хайр, эд хөрөнгө зэрэг нь ангид тусгаар оршигч би-гийн хөрөнгө юмуу угийн чанар нь биш юм.

Хэрвээ бид хүн алах гэх мэт хүнд үйл үйлдсэн бол муу хүмүүс болох нь мөн боловч угийн муу хүмүүс биш юм. Муу толбыг чин сэтгэлээсээ гэмшин, тухайн үйлийн үрийг ариусгах үйлүүдээр арилгаж болно. Өөрийгөө угийн муу хэмээх алдаатай итгэл нь мухардалд оруулж амиа хорлохоос өөр ямар ч гарцгүй мэт санагдана. Төвдийн их бясалгаач Миларайба залуу байхдаа маш олон хүний аминд хүрсэн боловч гэгээрэлд хүрч чадсан. Түүнтэй нэгэн адил ямар нэг сайн зүйл хийсэн бол бид угийн сайн хүмүүс гэсэн үг биш омог бардам сэтгэлээс болгоомжлоорой.

Өөрийгөө үнэлэх хүчтэй үнэлэмж ба жинхэнэ аз жаргал гагцхүү Би-г ангид тусгаар оршихоос

хоосон гэдгийг ойлгосон цагт бүтэх бөгөөд бусдад хариу нэхээгүй аз жаргал, магтаал, хайр, бэлэг өгч чадах зоригийг олно. Бусадтай өрсөлдөх гэсэн дотоод бачуурлаа амархан орхиж, ертөнцийг анд нөхөр болгон харна.

Ингээд хүүхдүүддээ: “Би хүсэж байна”, “Би хүсэхгүй байна” гэдэг бол гутралын тарни, “Танд би яаж тус болох вэ?” гэдэг бол аз жаргалын тарни гэдгийг зааж өгөөрэй. Хэрхэн зааж өгөх вэ? гэвэл өөрсдийн төгс үлгэр дуурайлаар.

Омог

Бидний хамаг зовлонг сэтгэлээс үүсэлтэй хэмээн Бурхан багш олон дахин айлдсан билээ. Зовлонгийн үндэс нь хувь хүн өөрийнхөө талаар алдаатай бодсон бодол юм.

Бодит байдал дээр бидний би бол бие, сэтгэлийн нийлэмжийг бидний нэрээр нэрлэсэн, тохиролцоо төдийгөөс цаашгүй юм. Мөн чанартай, өөрөө орших би бие ба сэтгэл дээр оршихгүй байтал бид өөрсдийгөө мөн чанартай, бие даан оршиж буй хувь хүмүүс хэмээн дотоод буруу бодолтой байдаг. Энэхүү буруу бодол нь хамаг зовлонгийн эх үүсвэр болдог-учир нь байнга би-гийн тухай бодож, оршихгүй байгаа би-г жинхэнэ би гэж итгэснээс уур, шунал, омог гэх мэт хорт сэтгэлийг үүсгэж, тэдгээр хороор бусдыг болон өөрийгөө хорлодог. Айх зэвүүцэл юмуу өөрийг хэт тоох адил энэхүү зохист бус итгэл үнэмшил нь бидний сэтгэлийг боолчлон эзэмдэж, амьдарлын бодит байдлыг гуйвуулан хувиргадаг. Өөрийн хуурамч дүр төрхөд бүрэн автсан үед түүнийг ямар нэгэн байдлаар заналхийлэхэд ухаангүй уурлана. Өөрийн төрхийг баярлуулахад хөөрөмшсөн шунал үүснэ; өөрийг бусдаас илүү дээгүүр бодсоноор хямсгар болно.

Залуу байхдаа бүсгүй хүнтэй нэг найзалж, нэг салах үед сэтгэл хөдлөлийн “галзуу хулгана” тоглоомын доогуур явах үедээ нэгэн удаа бүхнийг тодруулагч гэрлийн нөлөөнд миний хамгийн том дайсан бол омогт сэтгэл минь юм байна гэдгийг зарлаж билээ. Миний зовоод байгаа нь өөрийгөө хэрхэн танин мэдэж байгаа хийгээд бусад намайг хэрхэн мэдэхийг хүсэж байгаа зэрэг өөрийн тухай хэтэрхий их бодохтой холбоотой байжээ. Ойр дотны хүнтэйгээ харьцахдаа ая зөнгөөрөө байж чадахгүй; миний үг яриа, үйлүүд этгээд болох гэсэн аястай байсан юм. “Жинхэнэ би”-гээ бүрхэвчээс нь гаргахыг үнэхээр их хүсэж байсан боловч алдаа, хэлэх үгс, үйлдэх үйлүүдээ “лаг” байлгахгаар тооцоолдог байлаа. “Жинхэнэ би”-г бүрхэвчнээс гаргахыг цөхрөн хүсэж байлаа, гэхдээ бүтэлгүйтэл, сул тал хоёрыг нь хүлээн зөвшөөрөхөөс айж, миний санаанд хүрээгүй бүсгүйтэй үерхсэн хэвээр байна гэдэг хэт омог бардам сэтгэлтэй надад байж болшгүй байлаа. Нэг талаас хүмүүс миний “жинхэнэ би”-гийн сайн талуудыг мэдээсэй, хайрлаасай хэмээн хүсэх хийгээд нөгөө талаас “жинхэнэ би”-гийн сул талуудыг олоод мэдчих вий хэмээн айх хоёрын хооронд зөрчил байсан юм. Түүнээс болж ганцаардах нь тэсэхэд хэцүү байлаа. Өөрийнхөө байгаа байдалд сэтгэл зовниж байсан тэр үеэ эргэн санахад тэр үед надад хэн нэгэн нь жинхэнэ сайн чанар, жинхэнэ сул тал, жинхэнэ би байдаггүй гэдгийг хэлээд өгсөн ч болоосой гэж бодогдоно.

Бурхан багшийн айлдсанаар, омог нь өөрийгөө чухалд үзэх хөөрөмшил ба түүн дотор өөрийн төрхийг анхнаасаа алдаатай тусгаж, дараа нь өөрийгөө бусдаас илүү дээгүүр хэмээх итгэл багтдаг. Омог нь энэ хуурамч дээгүүр дүр төрхөө хэт хүчтэй барьж, бусдыг үл хүндэтгэдэг, ингэснээр эргэн тойрны хүмүүс болон өөрөө амар тайван байх боломжгүй түгшүүртэй, нөхөрсөг бус уур амьсгалыг бий болгодог. Өөрийн төрхийн тухай бодлоос хамааралтай байгаа цагт омог ямагт өөрийг хамгаалах эсвэл бусдыг буруутгаж шүүмжилдэг.

Омог бардамналын долоон хэлбэрийн эхний гурав нь эд баялаг, нийгмийн байдалтай холбоотойгоор үүсэн гардаг. Өөрөөс доогуур байр суурьтай хүмүүс дорой харагдаж, өөрийгөө дээгүүрт тавина. Адил байр суурьтай хүмүүстэй харьцахдаа өөрийгөө тэднээс онцгой, дээгүүр хэмээн бодно. Өөрөөс дээр байр суурьтай хүмүүсийн алдаа дутагдлыг түрэмгий

байдлаар зааж, өөрийгөө тэднээс бас л дээгүүр боддог.

Омгийн дөрөв дэх хэлбэр нь өөрийн бие ба сэтгэлийг төгс төгөлдөр “би” хэмээн боддог. Энэ омог бардамнал толинд туссан бидний тусгалыг ширтэн хараад “Би сайхан байна” гэж хэлдэг. Заримдаа үүнийг зөвхөн өөрийгөө эрхэмлэгч омог гэх бөгөөд энэ нь бие, сэтгэлийн хувьд, төгс төгөлдөр гэсэн итгэл юм. Бусдад ялагдахыг тэсвэрлэж чаддаггүй.

Омог бардамналын дараах хэлбэр нь шашины хүмүүст ажиглагддаг бөгөөд тэдгээр хүмүүс өөрийгөө хэт чухалчлан, ном эрдэм төгөлдөр болж, Бурхан багшийн юмуу Ертөнцийн эзний шадар тойруул болсон мэтээр аяглах байдал юм.

Хуурмаг даруу зан нь омог бардамналын зургаа дах хэлбэр юм. Алдартай хүний дэргэд даруу загнаж, харин дотроо их зантайгаар: “Би их чухал хүн учраас энэ алдартай хүний хажууд байгаа юм” гэж бодно.

Омог бардамналын эцсийн хэлбэр бол буруу бардамнал юм, жишээ нь, өөрийгөө бусдаас онцгой, ёс суртахууны ердийн хэмжээнд захирагдахгүй түүнээс дээгүүр хэмээн итгэснээс бусармаг үйл үйлдэх. Энэ бардамнал ялангуяа олны итгэл найдвар хүлээсэн, эмч, Христийн номлогч, Бурханы хуврага гэх хүмүүст гарах их аюултай.

Дээрх долоон хэлбэрийн омог бардамналын талаар илүү жишээ татах хэрэг байна уу? Хэрэггүй, үнэхээр дүн шинжилгээ хийвэл бид бүгд омог бардамналаас болж зовдог нь илэрхий. Бардам сэтгэлтэй гэдгээ мэдэж, түүний гэмийг ойлгох нь энэ чөтгөрөөс салах анхны алхам болно.

Жинхэнэ би-г бие ба сэтгэлийн дотор юмуу бие ба сэтгэлийг эзэлсэн тусдаа оршдог зүйл хэмээх буруу ойлголт дээр үндэслэсэн бардамнал нь өөрийн сайн талыг хэт дөвийлгөж, дараа нь энэхүү зохиомол чанарыг үнэн гэж итгэдэг. Тэгэхлээр бардамналыг шийдэх арга шууд тодорхой болно: “жинхэнэ би” үндсээрээ оршихгүй гэдгийг таньж мэдэх юм. Ийм бодол аймаар санагдаж болох бөгөөд учир нь бид өөрсдийнхөө би-гийн төрхийг маш их эрхэмлэдэг бөгөөд “би үгүй” хэмээх санаа асар их айлгана. Бүхнийг бодитой бус хэмээн үгүйсгэх үзэлд амархан унах магадтай. Туйлын, “жинхэнэ би” оршихгүй хэмээн үгүйсгэж байгаа нь харьцангуй оршиж байгаа би-г үгүйсгээгүй юм. Жинхэнэ би-гийн тухай үзэл буруу учраас буруу үзлээс салах нь чухал, учир нь сэтгэлийн тусгалын ээдрээнээс ангижран, зөнгөөрөө бололцоотой гэж мэдрээд байгаа тэр хязгааргүй аз жаргалыг эдлэх цорын ганц зам болно.

Би үгүйн үзлийг бардам сэтгэлийн ерөндөг болгож хэрэглэхдээ гаргаж болзошгүй өөр нэг алдаа бол бусдын төлөө хариуцлагаа умартах явдал юм. Бид: “Тэд нар чинь үнэхээр оршихгүй байгаа, тэдний зовлон бол тэдний төсөөлөлд байгаа юм. Би яаж ч тусалж чадахгүй” гэж бодож болох юм.

Би үгүйг мэдэх нь аз жаргалтай болоход Бурхан багшийн өгсөн жорын зөвхөн тал нь юм. Нөгөө тал нь, хамаг амьтныг асран хайрлах юм. Хамаг амьтад зөвхөн нэр төдий оршдог нь тэднийг үлэмж ихээр асран хайрлах нь багасна гэсэн үг бус. Хамаг амьтан тохиролцсон хүрээнд оршдог учраас тэднийг тохиролцсон хүрээнд асран хайрлах зүй ёсны орон болдог. Үнэндээ, асран хайрлахад хоосон чанарын тухай ойлголтыг шаарддаг, учир нь, тэр билиг

ухаан үгүй бол бусдыг шунал, уур хилэн, мунхаглалаар ялгаварлахаас салж чадахгүй.

Омог бардамналын хамгийн муу тал нь их зантай бодлоор хайрлаж болохгүй хэмээн тооцсон хүмүүсийг хайрлаж чадахгүйд хүргэдэг. Бид өөрсдийгөө хэт чухалчилж, танихгүй хүн, дайснаа бүү хэл гэрийнхээ хүмүүсийг хайрлаж чаддаггүй. Омог бардамнал биднийг ганцаардлын шилэн бүрхүүлд тусгаарладаг бөгөөд тэр шилийг даруу зангаар хагалах ёстой болдог. Даруу зан нь сул доройн шинж биш. Харин ч өөрийн муу сэтгэлээ сөрж, өөрийг чухалчлах үзлийн буруу тусгалыг үгүйсгэж, түүний оронд бусдын сайн чанарыг харж, тэдний аз жаргал, сайн хувь заянд үнэн сэтгэлээсээ баясахад илүү их хүч тэнхээ хэрэгтэй. Энэ л Матай гэгээнтэний “Зөөлөн аядуу зан энэ дэлхий ертөнцийг залгамжлан өвөлнө” гэдэг сургааль (Библийн) үгийн утга мөн болов уу гэж бодном.

Зовлон

Цонхны тавцан дээр хэвтэж, нарны дулаан гэрэлд биеэ тавтайхан ээн жаргалтай байгаа миний муур бүх хүн болон амьтан ялгаагүй аз жаргалтай байх, зовлонгүй байх нэгэн адил амьдралын зорилготой байдгийн дүрслэл юм. Өөрийнхөө зан байдлын цаад шалтгаануудыг эргэцүүлэн бодвол өдөр тутмын үйлс бүгдээрээ биеийн ая тух, аз жаргалын төлөө юмуу ая тухгүй байдал, зовлонгоос зайлсхийсэн байдаг. Аз жаргал эдлэх, зовлонгоос зайлсхийхэд буруугүй боловч асуудлын гол нь тэдгээр зорилтдоо сайтар хүрч чаддаггүйд байгаа юм. Ямар нэг хэмжээгээр аз жаргалтай боллоо гэхэд түүнийгээ нурааж, үдэшлэгийн сайхан байдлыг томоохон пид пад болгохдоо гарамгай байдаг.

Бурхан багш гэгээрэлд хүрсэн даруйдаа нэлээд удаан дуугүй байсан гэдэг. Сайн мэдээг түгээхдээ ийнхүү эргэлзсэн нь “Би оршихуйн гүн үнэнийг олж мэдлээ; тэд (та биднийг хэлж байгаа) үүнийг хэзээ ч ойлгохгүй” хэмээн бодсоноос болсон байжээ.

Аз болоход Хурмаст, Эсрүн тэнгэр зэрэг дээд төрөлхтөний үгэнд орж өөрийн мэдсэнээ бусдад нээжээ. Тэрээр анхныхаа сургаалийг, амьдрал бол зовлон юм хэмээн эхэлжээ. Үүнийг Энэтхэгчүүд хэрхэн хүлээн авсныг мэдэхгүй, гэхдээ Бурханы шашины хувраг эмэгтэй Австралийн Перт хотод олон нийтийн хичээлээ мөн энэ өгүүлбэрээр эхлэхэд сонсогчид шууд алга ташин хүлээн авсан гэдэг. Бурхан багшийн дараагийн сургааль олонд тийм ч их мэдэгдээгүй байж болох юм, тэр нь “Тэр зовлонгийн шалтгаан нь таны сэтгэл” юм.

Бид: “Хөөе байзаарай. Улс төрчдийг солиод өгчих, тэгээд надад маш сайхан, өндөр цалинтай ажил, сайхан гэр бүл, далайн эрэгт байшин аваад өгчих, тэгээд амьдрал зовлонтой байна уу, үгүй юу гэдгийг үзүүлээд өгье” гэж хариулж болох юм.

Далаад оны эхээр Лондонгийн эмнэлэгт эмчээр ажиллахын тулд Энэтхэгээс Англи хүртэл газраар аялж, тэр зуур материаллаг ертөнцөд дахин нэг гүнзгий нэвтрэх санаатай байлаа. Өөртөө шинэхэн нээсэн Бурханы сургаалийн гүн ухааныг хүлээн авахаас өмнө “жинхэнэ ертөнц”-ийг дахин нэг амтлах хэрэгтэй гэж бодож байлаа. Ийнхүү аялах замдаа Норвегийн усан тээврийн компаний эзний гэрт зочилж билээ, сайхан эхнэртэй тэрээр Крет гэдэг нам гүм тэнгисийн эрэг дээр мөрөөдлийн гоёмсог сайхан байшин барьж байсан билээ. Гэвч эхнэр нь байшин барьж дуусахаас өмнө хорвоогийн мөнх бусыг үзүүлэхэд нөхөр нь маш их ганцаардаж билээ. Хэдийгээр би тэр үед Төвд лам нарын номлодог сургаалийг сонссон байсан боловч тэр номыг үнэн гэж хүлээн зөвшөөрөөгүй байсан цаг билээ. Би төгс төгөлдөр сайхан эхнэртэй болох, сайхан ажил, дундаршгүй аз жаргалыг хайдаг байлаа. Миний хувьд Скандинав найзын минь байдал лам багш нарын хичээлд заасан: “Аз жаргал өгнө хэмээн бидний итгэж найддаг зүйлс болон нөхцөл байдлууд удаан үргэлжилдэггүй учраас найдвартай бус юм. Ертөнцийг үхэл ба мөнх бус удирддаг” гэсэн сургаалийг бодоход хүргэлээ.

Амьдрал зовлонтой хэмээн айлдсан анхны сургаалийг цааш гүнзгийрүүлэн, Бурхан багш зовлонгийн гурван түвшнийг тайлбарлажээ. Зовлонгийн зовлон гэдэг нь бид бүхэн зовлон хэмээн хүлээн зөвшөөрдөг, биеийн өвчин шаналал, осол эндэгдэлийг хэлнэ. Тэдгээрийг тайлбарлах шаардлагагүй, харин хоёр дах түвшин буюу урвахын зовлонг ойлгоход илүү хэцүү.

Урвахын зовлон нь бидний хэлж заншсанаар аз жаргал юм. Ихэнх хэлд мэндчилгээний тогтсон хэллэг байдаг, тэдгээр нь: “Сайн уу, таны бие сайн уу?” гэж асуудаг. Заримдаа чин үнэнээр “үнэхээр аймаар” гэж хариулдаг, гэхдээ ихэнхдээ хичнээн бүтэмжгүй байлаа ч гэсэн тогтсон хэм хэмжээгээр “дажгүй, та сайн уу?” хэмээн хариулдаг. Үнэнийг тэгшилж засах хэрэгтэй болдог.

“Та аз жаргалтай байна уу?” гэхэд,

“Тийм” гэж итгэлгүйхэн хариулна.

“Та үнэхээр аз жаргалтай байна уу?” гэвэл,

“Тийм гэх үү дээ, яахав өнгөрсөн долоо хоногоос арай дээр” гэнэ, эсвэл мэлмэртэл уйлж ч магадгүй.

Шүд өвдөхөд өвчин намдаах эм уухад хэсэг байсны дараа өвчин хэвээр байлаа ч гэсэн “их сайхан байна” гэж хэлнэ. Сайхан байна гэдэг нь урьд нь өвдөж байснаас багассан зэргийг илэрхийлж байгаа юм. Хэдийгээр аз жаргал гэж нэрлэсэн ч гэлээ зовлон хэвээрээ байдаг, энэ нь ертөнцийн амьдарлаас гаргаж авахыг хүсэж байгаа бусад бүх жаргалд хамаатай.

Амьдрал дугуу, ямар нэг сайжруулалт хэрэгтэй санагдах явдлаар дүүрэн байдаг. “Аз жаргал” сэтгэлийн түгшүүрээс түр амсхийсэн хэрэг юм. Цөөн хэдэн агшинд цаад зовлонгоо мартаж болох боловч үүрд үргэлжилдэггүй, шалтгаан ба нөхцөлүүдийн хуримтлал дээр бий болдог учраас аз жаргал тогтдоггүй. Аз жаргалын эх үүсвэр нь оршихгүй болмогц “найр ингээд л дууслаа” гэх маягийн зайлшгүй гунигтай хоцордог. Тийм биш бол “Ү Ланг Си” (Auld Lang Syne)-гийн ая төдий нь бүгдийн нүдэнд нулимс яахан хуруулах билээ?

Дотоод талдаа, аз жаргал нь зовлон болдогийн шалтгаан бол шунах сэтгэлээр бидний сэтгэл аз жаргал хүртээгч тухайн зүйлс болон аз жаргалыг хатуу барьдаг. Хайртаасаа хэзээ ч салахгүйг гэнгэртэл гуниглан хүсдэг болохоор ганцаараа байхдаа шаналж, өөрийн эрэгтэй юмуу эмэгтэйг өөр хэн нэгэнтэй муу саналгүй ярихад хардах юмуу өсөрхөлд автдаг. Эцэст нь, хагацал болоход шунал нь өнгөрсөн аз жаргалыг дурсан санагалзахад хүргэж, биелэгдэшгүй ирээдүйн аз жаргалын зөгнөл мөрөөдөлд амьдардаг.

Аз жаргалыг зовлонд урвуулдаг дараах бодол бол аз жаргалыг бүрдүүлж буй зүйлийн өөрийн гэсэн мөн чанар нь аз жаргал гэж итгэдэг ба тухайн зүйлийг хүртэхийн төдийд шууд аз жаргалтай болчих юм шиг санадаг. Далайн эрэг дээр мууртай адилхан наранд ээн дулаан байхыг жаргал гэж бодно. Халуун нь удалгүй тэсвэрлэшгүй болж, буцаад усанд ороход сэрүүн байх нь жаргал юм гэж бодно. Хүйтэн байх нь тэсвэрлэшгүй болоход дахин элсэн дээр гарч, дулаан байх нь жаргал юм гэж бодно. Биет эд хогшлуудын хувьд мөн адил нөхцөлтэй. Гараж, дээвэр доорх агуулах, хаяг тэмдэглэсэн дэвтэр зэрэг нь урьд нь биднийг аз жаргалтай болгоно хэмээн итгэж байснаа хаягдаж хэрэггүй болсон эд зүйлс, хүмүүсийн нэрсээр дүүрэн байдаг. Гэтэл санаснаар болоогүй нь бидний хүсэл горьдлого буруу байснаас тэр. Найз нөхөд, эд зүйлс нь бидний урьдчилан хүлээж байсан шиг аз жаргалын мөн чанартай эх үүсвэр биш байжээ.

Бурхан багшийн өгүүлсэн, гурав дахь түвшний зовлон бол арай гүнзгий, зовлонгийн бүр таагүй дотоод шалтгаан юм. Түүнийг түгээмэл хуран үйлдэхүйн зовлон буюу ямагт үйл, муу сэтгэлүүд, үхлийн эрхэнд байхыг хэлнэ. Үйл бол урьд нь өөрийн үйлдсэн үйлүүд бусдад үзүүлсэн үр нөлөөтэй төстэй явдлуудтай учрах сэтгэлийн хандлагыг хэлнэ. Амьдарлын түр зуурын ч болов аз жаргал тогтоно гэсэн баталгаа өгөх аргагүй, учир нь сайн үйл барагдахад аз жаргалын гол шалтгаан алдагдана. Ингээд урьдын хорт үйлүүдийн цуурай сэтгэлд боловсроход хичнээн их хөрөнгө, найз нөхдийн том хүрээг өөрийн эргэн тойронд бүрдүүлсэн байлаа гээд аз жаргалтай байх ямар ч бололцоогүй. Үхэл хэзээ ч тохиолдож болзошгүй буюу болсоор байдаг, түүнийг сайнаар хүлээн авах нь ховор. Нэг агшинд уурлах төдийд хурд хэтрүүлэн давхиж, машинаа эвдэж, дүрэлзэх их галын дунд орох үйлийг боловсруулдаг. Өөр нэг үйл хойд төрөлд ямар ч сонголтгүй шидэх болно. Тэр үйлийг барахын тулд хэдэн галваар тамд үргэлжлэн шатаж үхэх нь санаа тайвшрах баталгаа бус. “Амгалан нойрс доо” гэдэг хэллэг бол оршуулгын газрын дэврүүн төсөөлөл юм.

За, бяцхан муур минь, одоо чиний дурлаад байсан нарыг чинь хаахаар үүл гараад ирлээ. Үйл, муу сэтгэлээс хэт оройтоогүй дээр нь сэтгэлээ ариусгаарай.

Магад гарах сэтгэл

Бид бага байхдаа царайлаг ханхүү үзэсгэлэнт гүнжтэй учран үүрд сайн сайхан аз жаргалтай амьдарчээ гэдгийг сэтгэлдээ сонсож мэдсэнээс хойш Агуу Америкийн Мөрөөдөл буюу Үүрд сайн сайхан амьдран суух газрын тухай үзэл санааг хөөсөөр иржээ. Ханилж байгаа хүн болон ертөнц бидний эрж байгаа хангалуун байдлыг хангаж өгнө гэсэн хүүхэд шиг итгэлийг маань зар сурталчилгаа, зугаа цэнгэлийн салбарын үйлдвэрлэгчид дуртайяа ашигладаг ба тэдний домог болсон төгс хүмүүс болж, төгс амьдрал, төгс эд зүйлтэй болохоор унаж байдаг. Мөрөөдөж байгаа хүндээ сэтгэгдэл төрүүлэхийн тулд биеийнхээ өө сэвийг нуун дарах энгэсэг, үнэртэн, загвар бүхий хувцаснаас болж ихээхэн хэмжээний мөнгөнөөс хагацдаг. Цаг хугацаа өнгөрөхийн хирээр жинхэнэ аз жаргал бодитой болохгүй болмогц дотоод тавгүй байдал болон амьдрал хаашаа чиглэж байгаа талаарх эргэлзээг нуусан хөгжилтэй дүртэй болдог. Дандаа өөрийн тухай бодох түгээмэл сэтгэлийн өвчнөөр зовохдоо нэг нэгэнтэйгээ өрсөлдөж, өөртөө болон бусдад баяр баясгалантай байгаа хуурамч дүр эсгэдэг нь бүтэлгүйтсэнээ хүлээн зөвшөөрөхөөс айснаас болдог.

Одоо таныг сэтгэлээр унахаас өмнө төгс аз жаргалтай байх бололцоотой гэж хэлэх ёстой. Энэ нь жирийн амьдралд бус, харин муу сэтгэлүүд болон ертөнц ба өөрсдийн талаарх мухар сохор итгэлтэй байдлаас сэтгэл арилсан нирвааны хутагт байдаг. Мухар сохор итгэл, амиа бодох, уур, бардамнал, шунал тачаал нь жаргалыг хаадаг жинхэнэ саад тотгорууд юм. Нирваан нь тэнгэрт байдаг диваажин биш, мөн түүнийг юу ч бүтээгээгүй. Нирваан нь тэдгээр муу сэтгэлүүд болон итгэл үнэмшлийг арилгаснаар урт удаан үргэлжлэх амар тайван хийгээд амгаланг эдлэх сэтгэлийн уг чанар юм. Одоогийн аз жаргал түр зуурын байдгийн учир нь бид ертөнц юмуу сэтгэлээ хянаж чаддаггүйд байдаг. Бид хэзээ ч ертөнцийг хянаж чадахгүй бөгөөд, гэхдээ үйлийн шалтгаан ба үр дагаварыг ойлгох нь амьдарлын хүсмээргүй явдлууд тохиолдоход сэтгэлээ үймрэхээс хамгаалж болдог. Нөгөө талаас, бид сэтгэлээ хянах хяналтыг тогтоож болно. Муу сэтгэлүүд болон мухар сохор итгэл үнэмшлүүд нь эхлээд магад гарахуйн бодлыг төрүүлж, дараа нь бясалгалын төвлөрөл ба эцэст нь, би-гийн туйлын чанарыг илт хүртэн мэдэх билиг ухаанаар арилдаг. Энэ билиг ухаан нь бүх муу сэтгэлүүд болон хуурмаг итгэл үнэмшлийн үндэс болсон өөрийг төвчлөх мунхаглалыг үгүй болгодог.

Магад гарахуйн сэтгэлээр төгс амгаланг амьдралын хүрдний хаанаас ч олдошгүйг ойлгодог. Магад гарах сэтгэл нь бат найдваргүй ертөнцөд итгэхийг ухаалгаар орхиж, нирваныг олоход өөрийн эрмэлзлийг чиглүүлнэ гэсэн үг юм. Бусад шашинууд биеийн цэнгэл жаргалыг буруу гэж сургаж, дагагч нарыгаа хүний жаргалыг огоорон тэнгэрийн төрөлд төрөхөд хөтөлдөг. Гэвч, ертөнцтэй нэгэн адил бидний бие болон амьдрал маань Бүхнийг бүтээгчийн бүтээл болохоор “сайн” гэж тооцогддог, үнэнч сүсэгтэнүүд тэнгэрт төрөхөд жаргалд шунах шуналтай хэвээрээ байх ба амьдарлын хүрдэн дотор байдаг. Тэд зовлонгоос гэтэлж гараагүй байдгийн учир нь, өөрийн мөн чанартай орших би болон амьдрал төгс жаргалтай болж чадна гэсэн алдаатай итгэл үнэмшлээ гэтлэн гараагүй байдаг. Тэнгэрт амьдрах үйлийн үр барагдаж дуусахад дахин муу төрөлд төрнө. Бурханы шашин, ертөнц болон амьдарлыг мунхаглал болон хүсэл шуналын бүтээгдэхүүн гэж тодорхойлон үздэгээрээ онцлог. Бурханы сургаал нь, төрөлхтөн тус бүр өөрийн мунхаглал хийгээд хийгээд үйлийн үрийн эрхээр сэтгэл дундуур ертөнцөд баригдахын түгээмэл зовлонг огоорох тухай айлдаж, түүнээс гарахын тулд: би-гийн

хоосон чанарыг илтэд онох билиг ухааныг бий болгох арга замаар тайлбарладаг.

Магад гарах сэтгэл нь зовлонгийн бүх талыг шалган үзэж, түүнийг үйл хийгээд муу сэтгэлүүдээс үүдэлтэйг ойлгон, сэтгэлээ нирваны хутагт хүрэхэд чиглүүлснээр бий болдог. Энэ нь голдуу өөрийг зугаацуулах чиглэлтэй урсгал бүхий нийгмийн татлагын эсрэг хөдлөх ёстой гэсэн үг юм. Юдэо-Христос шашины ёс суртахууны нөлөөгөөр Барууны нийгэм бидний аз жаргалыг хайх ба зовлонгоос зайлсхийх дотоод тэчъяадсан хүслийг өөгшүүлдэг. Бидний ихэнхийн хувьд, амьдарлын зорилго нь харах, сонсох, үнэртэх, амтлах, хүрэлцэхийн жаргалыг эдлэхэд оршдог. Хэрэв арга нь байлаа ч гэсэн, тэгэхдээ байхгүй л дээ, галзуу сэтгэлээ номхруулж, билиг ухааныг дадуулахад ямар ч хичээл зүтгэл гаргадаггүй. Түүний оронд мансууруулах бодис, архи хэрэглэн сэтгэлээ тайвшруулж, спорт болон бусад хоббигоос сагаарлыг хайдаг. Аз жаргалын төлөө шунал хүсэл амьдарлын цорын ганц шалтгаан болоход хүн төрөлхтөний түүх аюул руу чиглэж байгааг харуулдаг. Шашин биш харин зөвхөн зугаа цэнгэлийн төлөөх амьдрал нь ард түмнийг мунхруулагч хар тамхи мөн.

“За болиод өгөөрэй, аз жаргалыг хүсэхгүй амьдрахын хэрэг юу байна вэ? Энэ нь өөрийнхөө зовлонг дарахад тусалдаг шүү дээ, хэдийгээр би төгс жаргалыг олохгүй байлаа ч гэсэн, ямар нэг байдлаар дандаа сэтгэл хангалуун болдог шүү дээ” гэж хэлнэ байх.

Болгоомжтой байгаарай. Мөрийтэй тоглоомчид багахан хожихоороо зориг ороод мөрийгөө ихээр тавиад алддаг. Амьдралын тотгортой зүйлс үнэхээр үй олноор овоолоостой байдаг бөгөөд хичнээн тэрбум хүн дотроос нэг нь ч өмнө нь гарч, ялж байгаагүй. Та яаж анхных нь болох юм бэ? Ертөнцийн жаргалд шунах нь энэ гаригийн хамгийн их, хамгийн хөнөөлтэй муу зуршил, бүх муу зуршлуудыг төрүүлдэг эх юм. Өөрийгөө төвчлөн аз жаргалын төлөө хөөцөлдөх нь мансууруулах бодис хэрэглэдэг ямар ч хүний муу зуршлаас илүү хөнөөлтэй.

Та амьдралынхаа бэрхшээлийг хэрхэн давах вэ? Энэ бол амархан. Өөрийгөө мартсанаар тэдгээрийг мартаж, бусдын зовлонгийн тухай бодож эхэл. Та өөрийнхөө амьдралыг асрахуйн сэтгэлээр тамиржуулж, хөдөлгө. Хэн нэгэнд инээмсэглэл бэлэглэх бүрт, тэр нь жинхэнэ жаргал болно.

Аз жаргалыг хүсэх нь яагаад бэрхшээл болдог вэ? Ертөнцийн аз жаргалыг хөөхөд зургаан гэм бий хэмээн Бурхан багш айлджээ. Эхнийх нь, батгүйн гэм. Ямар ч хүмүүсийн хоорондох харилцаа юмуу аз жаргал үүрд байна гэж найдаж болохгүй. Гэрлэлт нь салахын зовлон юмуу үхлээр хагацахын урьдал болдог, шинэ хүүхэд мэндлэх нь эцэстээ хүүхдээсээ хагацахын шалтгаан; ямар ч жаргалтай байлаа гэсэн түүнийг алдахын зовлонг мэдрэх нөхцөл болдог. Аз жаргалтай байх нөхцөл бүр нь аз жаргалыг баригч зүйлс болох найз нөхөд, эд хөрөнгө гэх мэтийг өөртөө аль болох удаанаар байлгах гэсэн зовнил санаашралыг байнга дагуулдаг. Цаг хугацааны урсгалтай тэмцэлдэх нь ялагдал хүлээсэн тулалдаан болдог бөгөөд аз жаргалын эд зүйлсийг хичнээн өөртөө чанга барьсан ч гэлээ салааны завсраар урсан холдоно. Найз нөхөд байвч дайсан болно, эд байвч элэгдэж хуучирна, цаг хугацаа өөрчлөгдөнө. Тэр байтугай хайран биеэ ч хаях болдог. Ертөнцийн ямар ч нөхцөл байдалд бүрэн дүүрэн аз жаргалтай байх баталгаа байхгүй.

Хоёр дах гэм нь, сэтгэл хангалуун бус байх. Хэдийгээр түр зуур ч болов найз нөхөд, эд хөрөнгөтэй байлаа ч гэсэн сэтгэл ханашгүй байдал нь сонирхол буурах, алдаа дутагдлыг

харах, ямар нэгэн, хэн нэгэн илүү сайныг эрж гардаг. Хайр найргүйгээр аз жаргалынхаа эх булгийг хаяж, хожим нь ихэнхдээ харамсах боловч нэгэнт оройтсон байдаг. Сэтгэл хангалуун бус байснаараа өөрсдийнхөө амьдралыг нураадаг.

Дараагийн гэм нь биеийг олон дахин орхих. Хүн болон тэнгэрийн оронд ямар ч сайхан биетэй төрсөн хэзээд урам хугална: бид үхэж, аймшигтай газар муухай биетэй төрдөг. Бие болон түүнээс гарах жаргалд шим үгүй атал ялангуяа Барууны оронд биеийг аз жаргалын сүм мэт тахин шүтдэг. Биеэ угаах, хооллох, дасгал хийх, цэмцгэр сайхан харагдуулах, хувцаслахад хир их цаг хугацаа зарцуулсан бол? Хүмүүсийн нийтлэгийн хүрээнд тогтсон стандартад биеийн төрх хүрээгүй гэж үзсэнээс хичнээн их зовсон билээ? Эцэст нь, тэр бүх зүтгэл огт хэрэггүй болдог. Өтлөх тусам бие муухай болж, өвчнөөр шаналж, хичнээн тордоод ч үхэх болоход биеийг орхидог. Тэгвэл аз жаргалын төлөө насаараа хөөцөлдөж, ихээхэн нүгэл хураасны эцэст тэдгээр бүх аз жаргал хаашаа одов?

Дөрөв дэх гэм нь олон дахин төрөл авах. Өнөөгийн цөвүүн цагт зовлонгоос салах аргыг амиа хорлох гэж олон хүн үзэх болжээ, гэвч энэ нь тийм биш. Хүссэн хүсээгүй үйлийн эрхээр дахин төрөл авах бөгөөд үхэхдээ ууртай, гонсгор байвал дараагийн төрөл нь энэ төрлөөс дээрдэж чадахгүй. Ямар ч зовлон эдэлсэн гэсэн түүнийг олон дахин, дахин дахин эдэлдэг. Урьд төрлүүддээ зовж уйлсан нулимс дэлхийн бүх далайн устай адил.

Дараагийн гэм нь байр сууриа олон дахин алддаг. Амьдралд хураасан юм бүхэн зайлшгүй задран тархдаг. Төрсөн бол үхнэ, өндөр бол намсана, найз нөхөд салж хагацна. Хүн төрөлхтөний болон бидний түүх бүх юм нэгэн үед дэвжих, доройтохыг олонтаа давтан дүрслэн харуулах боловч эрх мэдэл, төгс төгөлдөрийг хүсэн, үүрд аз жаргалтай байх биелэшгүй зорилтын төлөө явсан хэвээр л байдаг. Баян нь ядуурч, гэр бүлийн хүмүүс дахин нийлэшгүйгээр хагацах, хүч чадалтай нь сул дорой болдог. Хүн нь амьтан болж төрнө; тэнгэр нь тамд төрнө.

Сүүлийн гэм нь ямагт ганцаардах. Төрөх, үхэхийн зовлон, айдсыг ганцаараа эдэлдэг. Төрөх үеийн айдсыг тайвшруулах юмуу үхэх цагт хэн нэг нь хамт үхэхгүй. Ганцаардлын зовлон нь насан туршид хамт байдаг. Ханилахын тулд гэрлэдэг, гэвч хэсэг хугацааны дараа эхнэр юмуу нөхрөө намайг ганцаар орхидог ч болоосой

гэж хүснэ. Тэр байтугай хичнээн ойр харилцаатай байлаа ч гэсэн, хамгийн сайхан харьцаатай байлаа ч гэсэн, сэтгэлийн дотоод мэдрэмжээ бүрэн хуваалцах ямар ч боломжгүй. Эхнэр, нөхөр нь үгүй болсноос ганцаардахад урьд байснаас бүр ч илүү ганцаардана.

Эдгээр зургаан гэмийг сайтар бодсоноор гадаад ертөнц нь аз жаргалын бат найдвартай эх үүсвэр хэмээн алдаатай итгэлээс магадтай гарах зориг төрнө. Магад гарах сэтгэл нь ямар нэгэн юмаа алдлаа гэсэн байдлаар бус өөрийн зүрх сэтгэлийг бусдад нээлттэй болгоход хүргэх бөгөөд бясалгал үйлдэх эрч хүчтэй болж, билгүүний бамбарыг асаан сэтгэлдээ буй мөнхийн амгалангийн цэцэрлэгийг нээн гэрэлтүүлнэ.

Төрөл, амьдрал ба үхэл

Ихэнх хүүхдүүдийн хувьд, өнөөгийн Интернэтийн эринд эцэг эхээс илүүтэй компьютерүүд амьдарлын баримтын тухай мэдээллийн гол эх сурвалж болжээ. Эр ба эм бэлгийн эсүүд хоорондоо нийлдэг тухай хэвшсэн тодорхойлолт хангалтгүй хэмээн Бурханы сургаальд үздэг. Гурав дах хүчин зүйлийн оролцоо байдаг, тэр нь ухамсарын урсгал юм. Эцэг, эх хоёр хамтдаа таныг бий болгох хувийн үйлдлүүдээ үйлдэж байна гэж бодож байхад өөр хэн нэгэн бас тэр үед байсан нь-та юм. Яг одоогийн байгаа та биш л дээ, гэхдээ зуурдын төрөл буюу бардо-д байгаа хий үзэгдэл шиг хүн байхдаа үйлээрээ эцэг эхдээ татагдаж, бардын төрөлхтөний сэтгэл таны сэтгэл болжээ. Тиймээс үр тогтох үед эцэг эхийн хромосомын багцуудад агуулагдсан генийн өв залгамжлал дээр нэмж үйлийн чадамж, санамж, урьд төрлүүдийн цувааны сайн болон муу сэтгэлийн ул мөрүүд цуглуулга хэлбэрээр сэтгэлийн өв залгамжлал нийлдэг.

Буддын тарнийн номд, сэтгэл өөрөө боловсорсон эсийг хүний биеийн асар нарийн бүтэцтэй болгон хувиргах цаадах зохион байгуулалтын хамгийн чухал хүчин зүйл гэж үздэг. Сэтгэл бол танин мэдлийн энерги бөгөөд түүний идэвхтэй бүрэлдэхүүн нь санаа буюу хүсэл тэмүүлэл бөгөөд энэ нь үйлтэй төстэй юм. Санаа нь биет өгөгдөлгүй боловч ямагт нарийн биет энерги болох “хий” буюу төвдөөр, лүн-тэй холбоотой. Ирээдүйн эцэг эх хүүхэдтэй болох байдалд үйлээрээ татагдсан бардын төрөлхтөн үгүй болж, түүний сэтгэл хамгийн нарийн болж, хийн энергийн хамт эхийн умайд орж, боловсрох гэж буй үртэй нийлдэг. Өндгөн дотор сэтгэл эвдэршгүй дусал хэмээн нэрлэдэг капсултай адил бүтцэд суурьшдаг. Энэ нь эх, эцгийн аль алианаас олсон биет элементүүдээс бүрддэг бөгөөд “эвдэршгүй” байдаг нь үр тогтсоноос эхлээд үхлийн яг өмнөх мөч хүртэл хөдөлшгүй хэвээр байдаг. Хамгийн нарийн сэтгэл ба түүний тулгуур хийн нэгдлийг мөнхийн дусал гэж нэрлэдэг, учир нь үргэлж өөрчлөгдөх замаар тэргүүлшгүйгээс эхлэн оршсоор ирсэн ба ирээдүйд үүрд үргэлжлэн оршсоор байх болно.

Үйл сэтгэлийг идэвхжүүлнэ. Түүнээс болж хий эвдэршгүй дуслас гарч хоёр чиглэлд урсах явцдаа эхийн болон эцгийн биет элементүүдээс заримыг авч байдаг. Эцгийн талын элементийн дийлэнхийг тээсэн хийн чиглэл биеийн дээд хэсэг болдог ба эхийн талын элементийн дийлэнхийг тээсэн чиглэл нь биеийн доод хэсэг болдог. Эвдэршгүй дусал нь зүрхний хүрд гэж нэрлэгддэг цэг дээр үлддэг ба урсаж байгаа хийн нөлөөгөөр үүсэж бий болсон хийн салбар судлуудын систем нь үр хөврөлийн эсүүдийн бүдүүн биеийн хэлбэрийг зохион байгуулах загвар болдог.

Жирэмслэлтийн үеийн эхний хорин таван долоо хоногийн туршид идэвхтэй боловч нойртой адил байдалд байдаг. Одооноос эхлэн тунгалаг байдалд сэргэж, зөн совингоороо урьд ба энэ төрлийн холбоог мэддэг. Хүний амьдралын хүрд эргэж буйг ойлгосон учраас меланхолик байдлаар “дахиад л энд явж байна” гэх маягаар боддог.

Урьд насны тухай санамж эхээс мэндэлсний дараа ч хадгалагдаж байдаг боловч хэлд ороогүй учраас бусдад хэлж чадахгүй. Эдүгээ шинэ төрлийн тухай мэдлэг улам давамгайлсаар урьд төрлийн тухай мөдхөн мартдаг. Хэдийгээр урьд төрлийн тухай ярьлаа ч гэсэн “утгагүй юм битгий яриад бай, хоолоо хурдан ид” гэж хэлүүлдэг. Олон янзын соёл ард түмний

хүүхдүүдийн дунд урьд төрлийнхөө тухай ярьдаг болсон явдлууд олон байдаг. Хүүхдүүдийн ярьж байгаа урьд төрлийг худлаа гэж үгүйсгэхийн тулд тэдний яриаг анхааран үзэж, тэр дагуу нарийвчлан шалгаж үзсэн ба тэдний өмнө нь амьдарч байсан гэх газарт хүргэж өгч байжээ. Тэгэхэд хүүхдүүд урьд төрлийнхөө гэрийг таньж, ямар өөрчлөлт гарсныг хэлж, урьд төрлийнхөө хамаатан садны хүмүүсийг нэрлэж байжээ.

Амьдрал бол төрөл, үхэл хоёрын хооронд сэтгэл, биеийн тусламжтайгаар аль болох их жаргал эдлэх хугацаа юм. Мөнхийн дусалд хамаарагддаг ухамсар байнга оршиж байдаг боловч сэтгэлийн бүдүүн хувьт үйлдлүүдээр халхлагдсан байдаг учраас анзаарагдахгүй болдог. Хамгийн нарийн хий ба сэтгэлийн хослол нь нэгдмэл зүйл бөгөөд би-г нэрлэх эцсийн суурь юм. Та үүнийг “сүнс” (Христийн номынхоор) гэж хүсвэл нэрлэж болно, гэвч энэ хэллэг нь өөрийн мөн чанартай, ангид тусгаар оршдог гэсэн санааг агуулдаг учраас хэрэглэхгүй байх нь дээр. Түүнийг би-гийн “нэрийн суурь” хэмээн нэрлэж байгаа би мөн гэж хэлж байгаа хэрэг бус. Түүнийг шилжин явагч би гэж нэрлэхэд зохимжтой, учир нь, тэрээр нэг амьдарлаас нөгөө амьдралд, үйлийн ул мөрүүдийг тээсээр явдаг. Би бол хийсвэр нэгж, “би төдий” бол бие ба сэтгэл буюу суурь дээр “би” хэмээх нэрийг тохоож байгаа үйлдлээр бий болдог. Амьдралын туршид сэтгэл болон хийн энергиүд бидний сэргэг буюу идэвхтэй үе, унтах гэж нэрлэдэг идэвхгүй үе хоёрын хооронд хэлбэлздэг. Бүдүүн бие нь сэтгэлийн орших хугацааг гүйцэхгүй учраас эцэстээ өтөлж, үхнэ.

Үхэл бол нарийн хий ба сэтгэл хоёр, биеэс аажмаар салах үйл явц юм. Нойр хүрч байгаатай адил боловч сэтгэл гэгээн гэрлийн түвшинд хүртэл очиж, дараагаар нь биеэс сална. Үхлийн үйл явц таван үе шаттай ба шат тус бүр харилцан адилгүй үргэлжлэх цаг хугацаатай. Бүдүүн хувьт сэтгэл, бүдүүн хувьт биеэс салж эхлэх, үхлийн нэгдүгээр үед биеийн чадал доройтож, хамгийн гол ноёлогч мэдрэхүйн эрхтэний үйл ажиллагаа алдагдан-хараа бүдгэрэн сүүмэлзэн, харанхуйлдаг. Биед шахагдан дарагдах мэдрэмж үүсэж, элсэн доор булуулсан юм шиг эсвэл гэнэт тулгуургүй болж унаж байгаа мэт болдог. Унтах үед мөн үүнтэй төстэй байдлаар зүүрмэглэдэг. Хэрвээ төгс төгөлдөр болсон бол Бурханы таван цаглашгүй бэлгэ билгэ болдог таван чанараас олон юмсыг нэг зэрэг ойлгох, толь мэт билгийг алдаж, дотоод үзэгдэл нь жирвэгнэсэн, элсэн цөлийн мөнгөлөг- хөх зэрэглээ адил байдаг.

Хоёр дахь шатанд, амгалан ба шаналалыг сэрэх хүчгүй болдог. Юмсын адил төстэй хэлбэрийг ялган таних билгийн чадвар алдагддаг. Биеийн шингэн алга болж, нүд, ам хуурай болдог. Усаар энэ хатанги байдлыг зогсоож чадахаа больдог. Намайг анагаахын сургуульд байхад сувилагч нар үхэж байгаа хүмүүс энэ үед багахан мөс хөхөж амаа норгох дуртай байдаг гэж хэлж байсан юм. Сонсох чадваргүй болж, ойр хамаатан садны хүмүүс ярихын тулд чанга хашгирах хэрэгтэй болдог; дотоод үзэгдэл нь утаагаар дүүрсэн өрөө шиг болдог.

Гурав дахь шатанд, аливааг ялгах чадвараа алдана, найз нөхөр, хамаатан саднаа танихгүй, нэрийг нь санадаггүй. Захаасаа эхлээд бие хөрж эхэлдэг, амьсгал суларч, үнэрлэх чадваргүй болдог. Ойрын хүмүүс гар, хөлийг хичнээн дулаацуулан үрсэн ч мөс шиг цэв хүйтэн хэвээр байдаг. Дотор үзэгдэл нь хар дэвсгэр дээр улаан оч үсэрч байгаа мэт болдог.

Дөрөв дэх шатанд, өөрийн хүсэл санааг алдана. Амжилтын тухай мэдлэг үгүй болох учраас амьдралын зорилгоо мартаж, амтлах, хүрэлцэхүйн мэдрэмж зогсож, дотоод үзэгдэлд харанхуйн дунд зүүний үзүүр төдий гэрэл бий болж; амьсгал зогсоно. Амьсгал хэдий зогссон

боловч сэтгэл биеийг орхихоос нааш үхээгүй байдаг. Жирийн хүмүүсийн хувьд амьсгал зогссон даруйд сэтгэл биеийг орхин гарч болно, эсвэл гурван өдөр байж болно. Бясалгалын эрдмээр далдыг харах чадвартай болсон хүн үхэл үнэхээр болсон эсэхийг хэлж чадна, тийм учраас Бурханы шашинтнууд эрдэм чадалтай Ламд үзүүлж, сэтгэлийг нь үймүүлэлгүйгээр цогцосыг хэзээ гаргахыг асуудаг.

Үхлийн тав дах шатанд, буян ба нүглийн тухай бодох бүх үйлүүд сэтгэл улам нарийсахын хирээр зогсдог. Хийн энерги дотооддоо чиглэх хөдөлгөөнтэй болдог, биеийн дээд хэсгийн хий зүрхний хүрдийг чиглэн доош урсахад дотоод үзэгдэл нь шөнийн цэлмэг тэнгэрт тэргэл сар байх адил цагаан өнгөтэй болдог. Дараа нь, биеийн доод хэсгийн хий зүрхний хүрдийг чиглэн дээш урсахад үзэгдэл нь шингэх нарны туяа адил улаан болдог. Бүх хий дахин буцаж эвдэршгүй дусалд шингэхэд үзэгдэл нь хар болдог. Эцэст нь, үхлийн сүүлчийн үзэгдэл нь үүр цайхын өмнө тэнгэрийн зүүн хаяанд үзэгдэх анхны гэрэлтэй адил гэгээн гэрэл болдог.

Нарийн хийд тулгуурласан сэтгэл одоо биеэс гарах ба энэ үед гүн нойрсож байснаа зүүдэлж байгаатай адил болдог. Эвдэршгүй дуслын нээгдэх байдал нь заримдаа хамрын нүхээр гадагшлах улаавтар шингэн болон нууц эрхтэнээс цагаавтар шингэнээр мэдэгддэг. Сэтгэлийн нөлөөгөөр идэвхжсэн нарийн хий нь Бардо-гийн төрөлхтөний биеийг үүсгэдэг ба тэрхүү төрөлхтөн таван эрхтэний мэдрэхүйтэй ба бодож чаддаг. Эхлээд, хүүрийг тойроод уйлж байгаа ойр дотны хүмүүсийг хардаг. Тэдэнтэй ярихыг хичээдэг боловч тэд бардын төрлийн амьтныг харж, сонсож чаддаггүй. Гутралын байдалтайгаар урьд төрөлтэй холбоо тийнхүү тасарч, үхэх үеийн сэтгэлийн байдлаас хамааран сайхан зүүд юмуу хар дарсан зүүд мэт эрлэгт ормуй.

Үхлийн гурав дах шатанд боловсорсон үйлээр бардын төрөл дэх биеийн төрх хойд төрлийн биетэй төстэй болдог. Хэрвээ хойд төрөлдөө үхэр болж төрөх байвал бардын төрөл үхэртэй төстэй, хэрэв хүн болж төрөх бол хүнтэй төстэй, зургаан настай хүүхдийн хэмжээтэй байдаг. Бардын төрөлхтөн хатуу биетийг нэвтрэж гарах чадалтай, тухайн нэг газрын тухай бодох төдийд тэндээ гэнэт очдог. Эцэстээ, ирээдүйн эцэг эхийг, эр эмийн зохиролт харьцаанд орших байдалтай тааралддаг. Үйл боловсрох үед хүйс тодорхой болсон байдаг бөгөөд эцэг эх хоёрын өөрөөс эсрэг хүйстэйд биеийн хүсэл үүсгэдэг. Түүнээс болж эхийн хэвлийд эсэргүүцэж болшгүй их хүчээр тагдаг. Эцэг эхийн ижил хүйсийн хүнд дургүйцэл төрүүлдэг учраас энэхүү түгшүүрээс болж бардын төрөлд үхсэнээр гардаг. Сэтгэл дахин гэгээн гэрэлтэй болж, эхийн умай дах өндгөнд нэвтрэн ордог. Хэрэв үр тогтолт болоогүй бол бардод хэвээрээ дахин сэрдэг. Бардын ихэнх төрөлхтөн дөчин ес хоногийн дотор ямар нэг төрөл авдаг. Ийнхүү бидний амьдралын хүрд нэгэн удаа бүтэн эргэдэг ба эхлэлгүй цагаас аваад эргэн орчсоор ирсэн билээ.

Бэрхшээл, бэрхшээл, бэрхшээл

Амьдралд олон зүйл бүтэхгүй тийшээ хандах нь элбэг, наад зах нь хүссэнээр болдоггүйг анзаарсан байх. Хүүхэд байхдаа “бэрхшээл, бэрхшээл, бэрхшээл” гэдэг улигт үгийг өдөр тутмын амьдралын төлөө тэмцэлд бий болдог улам илүү төвөгтэй болсон хариуцлага, үүргүүдийн далайд живж буй хүмүүсийн тусламж хүсэн орилохыг нэг бус удаа сонсож билээ. Санаж чадаж байгаа тэр үеэс хамгийн сайн нь түр зуурын жаргалд хүрэх, хамгийн муудаа гэхэд шулуухан уналтанд орох зэргээр ертөнцийг өөрчлөх замаар зовлонгоос зайлхийхийг хичээсээр иржээ. Ихэнхдээ муу хэзрүүдээс их зүйлийг бүтээх гэж чадлынхаа хирээр хичээсэн ч бүдэрдэг. Дэлхийд хэн бүхний хамгийн дээр гарч чадсан юм бэ? Майк Тайсонтой өрсөлдөж байгаатай бага зэрэг адил, хэн ч ялж чадахгүй. Хэн ч ялангуяа өвдөх, өглөх, үхэх, дайсантай учрах гэх мэт хувь хүний зовлон зэрэг зовлонгуудыг арилгахад амжилт гаргаагүй гэдгийг хүн төрөлхтөний түүх харуулдаг. Гэхдээ зовлон гэдэг үгийг таны үгийн сангаас арилгах нэг арга байна.

Бид голдуу уйтгар, бухимдал, ууртайгаар ханддаг тэдгээр бүтэмжгүй зүйлүүд аз жаргалтай болоход учрах саад биш харин ч аз жаргалын эх үүсвэр болж болно. Ийнхүү шидтэй байдлаар өөрчлөгдөх түлхүүр нь зугаалгаар явах гэж байсан хүмүүсийн хувьд бороо ороход дургүйцэж байхад тариачдын хувьд жаргал болдог шиг тухайн зүйл зовлон мөн үү, үгүй юу гэдэг бидний өөрсдийн баримтлах үзэл бодлоос хамаарна. Бэрхшээл бүхэнд өөрийг төвчлөн түүнд хорслоор хандаж, гадаад ертөнцийг өөрийнхөө зовлонд буруутгасаар байвал юмс ямагт бидний эсрэг эргэсэн юм шиг санагдаж, хэзээ ч уйтгар, айдас, уураас ангид байж чадахгүй.

Бэрхшээлд зовохгүй байхын тулд эхлээд, бүтэмжгүй байдлыг хүсэхгүй байх хандлагыг зогсоох ёстой. Юмс хэзээд л бүтэлгүйтэж байдаг, тиймээс тэр үед зовох нь юунд ч хэрэггүй гэдгийг таньж ухааран, зовлонг дургүйцэхээ болих ёстой. Хэрвээ бэрхшээл зовлонг засаж болохоор байвал уйтгартай байх хэрэггүй. Хэрвээ түүнийг шийдэх бололцоогүй бол уйтгарлах нь тус болохгүй, харин ч шархан дээр давс үрнэ.

Орчин үеийн сэтгэл судлалд, уйтгар гунигаа илэрхийлэхийг зүй ёсны үйл ажиллагаа хэмээн тооцож, хэрвээ уйтгарлахгүй бол гажиг байна гэлцдэг. Зүй ёсны байх болон сайн байх хоёрыг адилхан гэж Бурхан багш таалаагүй. Тэрээр, бусдыг анхаарах нь сайн, учир нь өөрт болон бусдад жаргал олгодог, харин амиа бодох нь муу, учир нь өөрийг болон бусдыг хорлодог гэж айлджээ. Эхнийх нь билиг ухаан ба асрал хайраас гардаг, харин хоёр дах нь мунхаглалаас үүсдэг. Уйтгар гунигийг дарснаар улам бэрхшээлтэй болох нь үнэн, гэхдээ хэрвээ ямар ч уйтгаргүй бол түүнийг хааж хорих гэж зовохгүй, уйтгарлах гуниг ч үгүй болно.

Зовлонтой байдалд хүчтэй дургүйцэхээ болих хэрэгтэй, учир нь айдас, түгшүүр зөвхөн зоригийг мохоож, хорлолыг улам хүнд нэмэгдүүлдэг. Тариулахаас айдаг, айдаггүй хоёр хүүхдийн хувьд тариулахад ямархуу санагдах нь тэнгэр ба газар шиг өөр байдаг. Өчүүхэн төдий зовлонг тэсэшгүй хэцүү болгодог түгшүүрийг эдгээхийн тулд бэрхшээл зовлонтой нүүр тулж, тэдгээрийг бидний сэтгэл хэрхэн дэвэргэж ихэсгэснийг ойлгох хэрэгтэй. Энэ дасгалын гол зорилго нь зовлон бэрхшээл тохиолдохыг зогсоох бус харин бидний дотоод амгаланг хорлохоос хамгаалж байгаа хэрэг юм.

Бүтэмжгүй байдалд дургүйцэх нь түгшүүрийн үндэс болдог тул түгшүүрийг гэтлэн туулж, зовлон бэрхшээлээс аз жаргалыг гарган авахын тулд зовлон тохиолдоход аз жаргалтай байх хандлагыг датгах. Бусдыг анхаарах, амиа бодохыг орхиход сэтгэлээ датгах бололцоог бэрхшээл олгодог учраас ач тустайгаар ойлгох хэрэгтэй. Зовлон бэрхшээлийг эрж байна гээд туйлширч хатуу үйлээр биеэ зовоох хэрэггүй. Бэрхшээл хэзээд биднийг олж чадна, тэгээд түүнтэй учрахын цагт олон ухаалаг замаар шийдэж болно.

Архи уух хорт зуршлаас салахын тулд архичин хүн согтуурах нь жаргал юм хэмээх хий төөрөгдөлийг арилгаж, өөрт болон бусдад ганцхан зовлон уддаг бодит байдлыг ойлгох хэрэгтэй. Гадаад эд зүйлс аз жаргалтай болгоно гэсэн хий төөрөгдөлөөс ангижрахын тулд шагнуулж авсан эд зүйлээ зайлшгүй алдах, хайртай хүн нь талийгаач болох зэргийг бодит байдлыг ойлгох бололцоо хэмээн ойлгож, түр зуурын ертөнцийн аз жаргалд дурлах хорт зуршлыг сэтлэн чөлөөлөх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, зовлон бэрхшээл нь гэгээрлийн эхний шат болох магад гарахуйн сэтгэлийг үүсгэхэд тусалдаг.

Зовлонтой байхдаа өөрийгөө мартаж, өөртэйгээ адил зовлонтой бусдыг бодож, тэднийг энэрэх сэтгэл төрүүлбэл агшин зуур өөрийн зовлон багасаж, энэрэнгүй сэтгэлийн хүч ихэсдэг. Зовлонг миний зовлон хэмээн тодорхойлох бус бусдын энэ зовлонг өөртөө сайн дураараа авсан гэдэг талаас нь харвал өөртөө харамсах зовлонгоос сэтгэлээ их аз жаргалд хувиргаж чадна. Хамгийн сайн эмчилгээг хүсэж байгаа бол тантай адил өвчтэй эмчийг ол-тэр эмч таны зовлонгоос хуваалцаж чадна. Түүнтэй адил, хэрвээ бусдад туслахыг хүсэж байгаа бол тэдний юу мэдэрч байгааг мэдэх шаардлагатай, мөн өөрийнхөө зовлонг ч тустай талаас нь харж болох бөгөөд учир нь түүгээр дамжуулан бусдын зовлонг мэдэж, чин зүрхээрээ энэрэнгүй хандахад тусалдаг.

Омог бардамнал нь аз жаргалыг үгүй болгодог, гадаад саад бэрхшээлээс илүү том бэрхшээлийг үүсгэдэг учраас өөрийн бэрхшээлд тулгуурлан ихэмсэг зан, бусдыг зэвүүцэхийг зогсоох боломжид хувиргаж болно. Хэрвээ бид өөрсдийгөө еэ еэ, бөөвөө гэж шоолж, бусдад өөрийнхөө алдааг хэлбэл омгоо үгүй болгож, алдаагаа нуух гэсэн мэдрэлийн цухалдалд орохоос хамгаална. Хүмүүс биднийг шоолох бус харин ч сайнаар хандаж, илүү итгэнэ.

Хамгийн аюултай дайсан болох уурын ерөндөг нь тэвчээр байдаг шиг тэвчээртэй байхын тулд бэрхшээл тохиолдох шаардлагатай. Хорлож байгаа хүмүүс үнэндээ бидний хамгийн сайн найз юм, учир нь юунаас ч долоон дор хорлодог уурыг даван туулах бололцоог олгодог.

Эцэст нь, хэрвээ үйлийн тухай мэддэг бол ямар ч шалтгаангүй юм гэж байхгүйг мэднэ. Нүглээс зовлон гарна, буянаас жаргал гарна. Бүтэлгүй тохиолдол болбол нүгэл нимгэрч байна гэж бодон тайвширч, үлдсэн нүглээ ариусган, буян хураах урам зоригтой болно. Тиймээс бэрхшээлүүд хэрэгтэй байх нь, учир нь, “надад ийм юм учрах ёсгүй” гэх аймшигтай бодлыг арилгахад тусална.

Эдгээр зөв сэтгэлээр зовлонд хандаж чадвал таны сэтгэл улам хөнгөрнө. Өөртөө итгэх итгэлд тэр байтугай хүндхэн бэрхшээл ч муугаар нөлөөлж чадахгүй, харин бэрхшээлтэй болгохын оронд жаргалын эх үүсвэр болдог. Өнөөгийн хэцүү цагт аз жаргалтай сэтгэлийн хамгаалалт хэрэгтэй. Хэрэв үргэлж сэтгэл дундуур, зовиуртай байвал бидний биеийн байдал тэнцвэргүйтэн, түүнээс үүдэн өвчин бий болж, улам аз жаргалгүй болно. Амьдралын

нугачаан дээгүүр явж, тэр байтугай тэдгээрээс аз жаргалыг гаргаж авбал, бие эрүүл байж, сэтгэл улам их аз жаргалтай болно.

Бүх жаргал ба зовлон сэтгэлээс үүсдэгийг мэдвэл гадны ямар ч зүйлд хорлогдохгүй. Хэрвээ аз жаргалыг гадаад эд зүйлээс хайвал ертөнцийн эрхэнд орж, өчүүхэн шүүмжлэлээс болж гутрана. Харин зөв сэтгэлийнхээ эрхэнд орох нь үлэмж дээр, илүү хялбар юм. Гагцхүү мунхгууд гомдоллодог; ухаантнууд юм бүхнээс ухаарлыг олмуй.

Бодит байдал

Өсвөр насны хүүхдүүдийн эцэг эхчүүд “Хүүхдүүдтэй хэл амаа олж чадахаа больжээ, эдний үе огт өөр болжээ” хэмээн олонтаа гомдоллодог.

Мөн хүүхдүүд нь “Манай ээж аав гэж бодит байдлын талаар юу ч мэдэхгүй, өөрсдийнхөө өчүүхэн амьдралаас цаадахыг харж чадахгүй болжээ” хэмээцгээнэ.

Бурханы шашины үүднээс дээрх хоёр гомдол урьд нь төсөөлж байгаагүй гэдэг талаасаа хоёулаа үнэн. Бурхан багш, бүх зовлон сэтгэлээс үүдэн гардаг хэмээн айлджээ. Мөн бүх жаргал ч сэтгэлээс үүдэн гардаг хэмээжээ. Ингэж бодохоор дэлхийн амьдрал тэр чигээрээ сэтгэлээс үүдэлтэй юм шиг санагдана, тийм, Бурхан багш бас тийнхүү айлдсан юм.

Гадаад ертөнц хатуу хөдөлшгүй байдлаар, сэтгэлээс ангид тусгаар, хүн бүрийн хувьд ав адил, ертөнц дотор бид идэвхгүй ажиглагч байдлаар амьдардаг хэмээх таамаглал буруу юм. Сэтгэлээс ангид орших гадаад ертөнц гэж үгүй. Хүн бүр өөрийн сэтгэлийн тусгалаар бүтээсэн ертөнц дотор амьдардаг: хоёр хүн юмсыг яг адилхан мэдрэнэ гэж үгүй. “Манай ертөнц” хэмээн ярьж болохуйцаар юмсыг тусгаж авах нийтлэг зүйлс олон бий. Гэвч “манай ертөнц” гэдэг бол зөвхөн ерөнхийлөл юм. Хэрвээ амьдарлаа сайтар ажиглавал хүн тус бүр өөр өөрийн гэсэн тусгалын загвартай байдаг учраас түүгээрээ дан ганц өөртөө өвөрмөц нэг ертөнцийг бүтээдэг. Хүн бүр өөрийн ертөнцөд амьдардаг.

Жишээлбэл, дурласан үед, цэцэг ногоо сайхан өнгөөрөө гэрэлтэн, шувууд хамгийн сайхан дуугаа дуулж, ертөнц маань амлалт, аз жаргалаар дүүрэн санагддаг. Харин гутарсан үед ертөнцийн өнгө урсан нүүж, зэс нь цухуйж, бүх юм буруу, утгагүй мэт болдог. Гутарсан болон дурласан хүн хоёр нэгэн ижил гудамжаар явах үед тэр хоёрын алд дэлмээр ялгаатай ертөнцөөс гадна өөр нэг ертөнц тусдаа оршиж байна уу? Тэр гудамж нэгэн зэрэг сайхан, муухай байна гэж үү?

Гудамжинд буй байшин, мод, цэцэрлэгүүд өөрөөсөө бүтэж оршихгүй хэмээн Бурхан багш тайлбарлажээ. Тэдгээр нь сэтгэлд олон янзаар үзэгдэж болох чадамжтай нэргүй зүйлүүд байдаг. Сэтгэлийн тухайн байдлаас болоод эдгээр чадамжуудын аль нэгийг харж, тэр нь бидний хувьд бодит байдал болдог бөгөөд тухайн зүйлийг хэрхэн ойлгож мэдсэнээрээ нэрлэдэг. Өөр нэгэн хүн өөр сэтгэлийн байдлаар өөр үзэгдэх чадамжийг харснаараа өөр бодит байдлыг хардаг. Энэ зарчмын дүрслэл нь цэцэгний үзэгдэх байдал юм. Гэрлийн долгионы уртад хүний нүднээс илүү мэдрэмтгий зөгийний хувьд цэцэг нь хүнд харагдах байдлаас өөрөөр харагддаг. Бидний хэн нь жинхэнэ цэцгийг харж байна вэ? Цэцэг гэж ажиглаж байгаа сэтгэлээс хамааралгүйгээр өөрөө, бие дааж бүтсэн жинхэнэ цэцэг байхгүй. Олон чадамж бүхий нэг суурь байх бөгөөд хүн харж байгаа тохиолдолд хүний нүдэнд үзэгдэх цэцэг болно. Бусад тохиолдолд зөгийний-хувьд-цэцэг, шувууны-хувьд-цэцэг гэх мэт олон янзаар үзэгдэнэ.

Цаашилбал, цэцгийг хогын ургамал хэмээн тооцдог тогтсон үзэлтэй хүмүүсийн хувьд цэцэг хараад баясахгүй, дайсан гэж харна. Цэцэг, хогын ургамлыг ялгахгүй хүмүүсийн хувьд шарилж байлаа ч сайхан цэцэг байна гэж харж, жаргалтай болно. Цэцгийг нөхөр юмуу

дайсан болгож харах нь сэтгэлээс үүдэлтэй. Нөхөр эсвэл дайсан байх биеэ даан оршиж байгаа цэцэг байхгүй. Миний амьдралд тохиолдсон таатай үүрэг даалгаварын нэг нь өмнөд Францад Төвдийн Бурханы шашины хийд барихад туслах явдал байлаа. Эхний зорилт маань цэцэрлэгтэй болох байлаа, ингээд би удалгүй, шарилж болон зэрлэг нил цэцэгт ханддаг хандлагаа өөрчилж, хогын ургамал гэхээсээ илүү сарнайн цэцэрлэгийн нэг хэсэг болгон харж чадвал ажлынхаа ачааллыг маш ихээр бууруулж, илүү жаргалтай болж болохыг ухаарч билээ.

Бурханы сургаалд, юмсыг ойлгоход үйл хэрхэн нөлөөлдөг болохыг үзүүлсэн сонгодог жишээг өгүүлдэг, хүний хувьд цэвэр ус байхад тэр нь бирдийн хувьд бохир, ууж болшгүй шингэн байдаг, тэнгэрийн төрөлхтөний хувьд, амгалангийн рашаан байдаг хэмээн өгүүлжээ.

Эрдэмтэд өөрсдийгөө ертөнцийн бодит дүр төрхийг тайлбарлаж байна гэдгээрээ бахархдаг боловч туйлын утгаар, ажиглах байдал нь ажиглаж буй зүйлийг тодорхойлох хүчин зүйл болдгийг тэд хүртэл хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Абсолют бодит байдал гэж байхгүй; Ньютоны физикчид харьцангуй онолд байраа тавих ёстой.

Карл Жунг өвчтөнүүдэд зураг үзүүлснээр тэдний сэтгэлийн дотоод байдлыг мэдэх бололцоог олгодог хэмээн баталсан ба хожим нь сэтгэл судлаачид жүжиг, элсэн дээр тоглох болон бусад аргуудыг ашиглан гадаад илэрхийллээр нь хүмүүсийн сэтгэлийн дотоод ертөнцийн талаар мэдлэгтэй болжээ. Уран сайхны гадаад илэрхийллээр үл барам бидний амьдралын хэв байдал бүхэлдээ ертөнцийн оршихуйн талаар ойлгох ойлголтын тусгал байдаг хэмээх Бурхан багшийн сургаалтай нийцэж байгаа юм. Бид жаргал хөөж, зовлонгоос холдохыг оролдохдоо ертөнцийг биет байдлаар нь хувиргахыг байнга эрмэлздэг. Ийм зан байдал нь хүн төрөлхтөний тэнэглэлийн туйл бөгөөд тайван, амгалан байхын тулд ердөө сэтгэлээ л өөрчлөх хэрэгтэй юм.

Зарим хүмүүсийн боддог шиг Бурхан багш “ертөнц бол хоосон үзэгдэл” хэмээн айлдаагүй юм. Тэрээр хоосон үзэгдэл мэт хэмээжээ. Мунхаглал, уур, шунал нь өөрийн тухай болон ертөнцийн юмсыг гажуудуулан, тэдгээрийг өөрсдийн мөн чанартайгаар бүтэхдээ сайн, муу, ямар ч ялгаагүй хэмээн үздэг. Толинд туссан тусгалд хуцдаг хав шиг тэдгээр хуурамч тусгалуудыг үнэн гэж санаж, сэтгэлтэй ямар ч холбоогүй мэтээр ханддаг. Алдаатай тусгалуудын ертөнцийн хүрээлэлд орсноор хэн нэг нь алдааг хэлж өгөхөөс нааш улам ч мунхаг, шуналтай, ууртай болдог. Бидний алдааг үзүүлэх цорын ганц хүн бол өөрсдийн сэтгэлээс төөрөгдөлийн эх сурвалжийг арилгаж чадсан хүн байх бөгөөд тийм хүнийг олоход хэцүү. Одоо та хүүхдийн-поп хөгжим нь эцэг эхийн-поп хөгжмөөс огт өөр гэдгийг санан, хүүхдүүдтэйгээ сайхан харилцаж чаддаг болоход хангалттай зүйлийг мэддэг боллоо. Сэтгэхүйн ялгаварлах үзлээ орхиж, өөрийн бага насыг санаж, оройтоогүй дээр нь хүүхдүүдтэйгээ байх нандин бололцоог үнэлцгээгээрэй.

Итгэл

Нэг гэрийн үрсийн өрсөлдөөнөөс эхлээд олон улсын хүрээнд хүртэл нийгэмд зөрчил түгээмэл орших агаад түр зуурын тайван үеийн хуурамч инээмсэглэл нь “Би чамд итгэхгүй байна” гэсэн дотоод бодлыг нууж байдаг.

Өнөөдрийн нийгэмд гэрлэхээс өмнө салах үеийн гэрээ гэж байгуулдаг нь хүн нэг нэгэндээ итгэхээ больсоны сонгодог жишээ юм. Энэ төгс бус ертөнцөд хэн ч төгс бус, өөрийн эрх ашгийг бодох нь нийтлэг муу сэтгэлийн дадал мөн боловч эрээгүй зан байдлаа засаж, нэг нэгэндээ итгэх аргыг дахин олох арга байна уу?

Хэдийгээр зөв санаатай байлаа ч гэсэн бусдын сэжиг санаа, шууд үл итгэх байдлаас зайлсхийхэд бэрх. Миний бодлоор өөртөө тэр байтугай итгэдэггүй учраас бусдад итгэддэггүй гэж бодож байна. Бидний амьдрал, өөрийн жаргалыг хүсэх сэтгэлийн сул дорой байдал бүхий дотоод бодит байдлаа гэлбэлзэн нуусан багт наадам болдог. Гадаад зөрчил нь чөтгөр оршиж буй сэтгэлийн дотоод зөрчлийн тусгал юм. Тэр чөтгөр эвэр, сүүлгүй бөгөөд тэр нь мунхаглалаас төрсөн өөрийн дүр төрхөд дурлах байдал юм. Өөрийгөө хэн бэ гэдэгт харалган хандсанаар өөрөөсөө бүтэж оршсон, бүх зүйлтэй ямар ч холбоогүй би-г санаанаасаа зохион бүтээдэг. Энэхүү хуурамч би-г үнэн хэмээн итгэж, өөрийн төрхийг бүхнээс илүү хайрлаж, түүнийгээ нүдний цөцгийдөө хамгаалах болон бусдад ямар байдлаар харагдуулахын хүссэнээс болж муу зан байдалд ордог.

Бүдүүн хувьт муу сэтгэлүүд бол шунал, үзэн ядалт, бардамнал юм. Шунал бол өөрийн төрхөд таалагдах юмуу түүнийг дөвийлгөх зүйлийг авах зуршил; хорсол нь өөрийн төрхөд үл таалагдах юмуу хорлох зүйлийг холдуулж түлхэнэ; бардамнал нь бусдаас хөндийрүүлдэг хамраа сөхсөн байдал юм. Эдгээр нь тус бүрдээ өөрийг төвчлөх үзэлтэй холбоотой нь тодорхой байна. Харин эдгээрээс илүү нарийн, хуурамч дүр үзүүлэх болон үнэнч биш байх зэрэг муу сэтгэлүүд байдаг. Хэрвээ итгэл хүлээсэн байхыг хүсвэл эдгээр хоёр сэтгэлийн хандлагыг таньж, хорих ёстой юм.

Башир гэдэг нь материаллаг эд баялаг юмуу бусдаар сайшаалгахын тулд өөртөө сайн чанаруудын тухай зохиож олоод түүнийгээ үнэн болгож үнэмшүүлэхийг хичээдэг. Энэ баширыг олонтаа давтдаг учраас өөрөө түүндээ үнэмшин итгэж, бодит байдлаас улам цаашлан холддог. Бурханы шашины санваартан хуврагуудын хувьд баширлах нь хуурамч даруу зан гаргах, зусардах замаар хүний аргыг олох, үг цухуйлгах, сүрдүүлэх, хариуд нь ихийг авахын тулд бага зүйл өгөх зэрэг таван буруу амьдралын хэв маягийн далд шалтгаан болдог. Бурхан багш өөрийн шавь нарт бусдаас өглөг гуйхдаа нээлттэй бай хэмээн айлджээ, харин тэдгээр буруу амьдралын хэв маяг бүр нь бусдыг өөрт өглөг өгөх ёстой гэсэн далд санаатай байдаг. Гэвч зөвхөн хуврагууд ийм зан байдлыг гаргадаггүй шүү дээ.

Заль мэх нь материалаг эд зүйл, бусдаас сайшаал олохын тулд өөрийн дутагдлыг нуух замаар тэднийг төөрөгдүүлэхийг хэлнэ. Энэ нь мөн зориудаар нуухаас эхлээд өөрийн худал хуурмагийг үнэн гэдэгт итгэх хүртэл багтана. Баширлах, заль мэх гаргаснаар эцсийн үр дүнд өөрсдийгөө мэхлэх бөгөөд итгэл даахгүйг бусад мэдэх учраас бусдыг холдуулдаг.

Амьдрал гэдэг хагуу, хэрэв итгэх хүн байхгүй бол тэсвэрлэхэд бүр ч хэцүү. Бусдыг хуурснаар өөрөө хүнд итгэж чадахгүй болж, найз нөхдийн таатай, аюулгүй хүрээнээс өөрийгөө тасалж байгаа хэрэг гэдгийг өөрийнхөө сайн сайхны тусын тулд ойлгох хэрэгтэй. Бусдад хүлээх хариуцлагын хувьд, тэдэнд хэрэгтэй ая тух, аюулгүй байдлыг хүртээж чадахгүй. Гэр бүлийн хүмүүс, ер нь ямар ч хүнд, тэр байтугай өөртөө өгч болох хамгийн сайхан бэлэг бол итгэл хүлээж чадах явдал юм. Тиймээс өөрийн сэтгэлийг сайтар ажиглаж, тухайн сайн чанар өөрт байхгүй атал байгаа мэтээр баширлах болон өөрийн гэм алдааг нуух зэрэг дадсан зуршлаас ангижрах хэрэгтэй юм.

Худал хуурмаг аргаар амьдрах нь хавдар биеийг идэх адил сэтгэлийн амгаланг идэж үгүй хийдэг. Шудрага байж, өөрийн алдааг хүлээдэг, уучлал гуйх нь тэр даруйд сэтгэлд тайван, аз жаргалыг бий болгодог. Ингэснээр бардамнан ганцаар тусгаарлагдахаас чөлөөлж, уурлах, шунах хандлагыг багасгана. Ихээхэн худал хэлэхийг хэлээгүй боловч энд хамааруулж болох юм. Хамгийн гол онцолж байгаа зүйл бол өөрийн бие, сэтгэл, эд хөрөнгөний сайн сайхныг дөвийлгөх юмуу санаанаасаа сайхан мэтээр зохиох, эсвэл алдаагаа нуух зэрэг нь мунхаглалын түлхэцээр үүсдэг болохыг өгүүлсэн юм. “Энни буугаа гаргаад ир” гэдэг сэтгэхүйгээр “Чи чадсан бол би чадна, илүү дээр...” гэх байдлаар хүн бүртэй өрсөлдөх, тэр байтугай эхнэр нөхрийнхөө эсрэг эцэс төгсгөлгүй өрсөлдөөний орооцолдоо үүсгэдэг.

Өөрийн бие, эд хөрөнгийг өөрийн төрхийн салшгүй нэг хэсэг болгосноор хуурмаг зүйлд дурлах бидний тэнэг занг ашиглахдаа нэг хором ч алдаж үзээгүй, дөвийлгөх юмуу нуух урлагийн мэргэжилтэнүүд болох зар сурталчилгаа, загварын үйлдвэрийнхний мөлжлөгөд өртөхөд өргөн нээлттэй бэлэн болдог. Хүнийг эд хөрөнгө, биеийн гадаад байдлаар үнэлдэг болсон нь нийгэм хөөрхийлэлтэй байдалд орсных юм. Капиталист маягийн эдийн соёл Монголд хүч түрэн ирж байгаа өнөө үед, улс төрчдийн гарт бараг үгүй болж, коммунист суртал ухуулгыг мулгуу тоть адил давтаж байгаа евангелист номлогчдын довтолгоонд Монголын уламжлалт Бурханы шашины үнэ цэнэ Монголд хурдан мөхөж байна. Хүмүүс өөрсдөө соёлоо алдах явдлаас сэрэмжилж түүнийг хамгаалахад оролцохгүй байна. Зарим нь номын хувцас өмссөн хирнээ гэргийтэний ёсоор эхнэр авч, архи ууж, амь зуух арга болгон ном унших байдлаар Бурханы номын наад захын зүйлд үл хүндлэлтэй хандаж байна. Залуучууд эцэг эх, багш нар, улс төрчдөд итгэх итгэл алдарсан бас эдгээр хувраг-бусчуудын дорой явдал залуу үе хэн нэгэнд итгэх сүүлчийн боломжийг үгүй хийж байна. Тиймээс Монголын залуучууд одоогийн Барууны орны залуусын дунд түгээмэл байдаг юуг ч утгагүйд боддог, юунд ч сонирхол төрүүлэхгүй үгүйсгэгч үзэлд унах их аюулын даваанд тулаад байна. Итгэж болох хэн ч байдаггүй.

Монголын болон бүх дэлхийн хамгийн дээд итгэл найдвар эцэг эхчүүд, багш нар, улс төрчид, шашины зүтгэлтнүүд бид өөрийн би-г эрхэмлэх үзэл, башир, заль мэхээ орхин, бусдын итгэлийг хүлээж чадах замаар нийгэмдээ гүйцэтгэх үүргээ биелүүлцгээе.

Үйлийн үр

1979 онд Ешэ Лам багш Австралид олон нийтэд ном айлдах үеэр нэгэн эмэгтэй түүнээс “Үйлийн үр гэж юу вэ?” гэж асуусан юм.

Ешэ багш “ТА бол үйлийн үр” гэж хариулсан юм. Танхимд чимээгүй боллоо. Араас нэг эрэгтэй хүн: “Энэ хариултыг ойлгосонгүй” гэж хэллээ.

“Үгүй” гэж Лам багш тэр дор нь хариулаад: “Яагаад гэвэл энэ хариулт чамд биш, тэр эмэгтэйн хариулт байсан юм” гээд:

“Чи ойлгосон уу. Тийм үү, хонгор минь” гэхэд тэр эмэгтэй: “Тийм” гэж билээ.

Хэрвээ та Ешэ Лам багшийн хариултыг ойлгосон бол энэ нийтлэлийг унших хэрэггүй, ойлгоогүй бол үргэлжлүүлж уншаарай.

Олны өмнө сайн ярихын тулд сонсогч нар өөрийн санааг хэрхэн хүлээн авч байгаа байдалд тохируулан яриагаа өөрчилж чадах арга хэрэгтэй болдог. Түүний нэгэн адил амьдралд амжилттай байхын тулд тухайн өөрчлөгдөж байгаа нөхцөл байдалд тохируулан чиглэлээ өөрчилж чаддаг уян хатан байх хэрэгтэй болдог. Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод машин барьж байгаа жолооч нартай адилхан байж сурах хэрэгтэй, учир нь аюулгүй байхын тулд “Санаанд оромгүй зүйлийг санах хэрэгтэй” гэсэн дүрэм баримталдаг. Амьдралын зүйл бүрийг төлөвлөж байтал бидний хянаж чадахгүй байгааг илтгэх санаанд ороогүй зүйл гарч ирдэг.

Амьдралд үйлчилдэг хоёр хүч байдгийн нэг нь Улаанбаатар хотын замын хөдөлгөөний эмх замбраагүй байдал шиг хүч, нөгөөх нь дэс дараатай хүч, энэ нь үйлийн үр юм. Үйлийн үр бол бидний сэтгэл хийгээд гадаад орчин хоёрын холбоосоор бүтсэн амьдралын хэв маяг юм. Гариг дэлхий болон түүнд агуулагдах юмс үйлээс хамаардаг гэдэг утгаараа биес үйлийн, сэтгэл бол үйлийн үр, бүх юмс үйлийн үр юм.

Ньютон тодорхойлсноос бус нээгээгүй таталцах хүч нь материйн түгээмэл хууль болдог шиг Бурхан багш тодорхойлсноос бус нээгээгүй үйлийн үр нь сэтгэлийн түгээмэл хууль болдог. Үйлийн үрийн хууль бол энгийн юм: сэтгэлээр өдөөгдсөн бие, хэл, сэтгэлийн бүх үйлүүд тухайн санаагаар үйлдсэн үйлийн шууд үр дагавартай төстэй явдал ирээдүйд тохиолдоход холбож өгөх хүч бүхий чадамжийг сэтгэлд үлдээдэг. Бусдыг баярлуулах санаагаар үйлдсэн үйл ямагт ирээдүйн амьдралын сайхан явдалтай холбож өгөх чадамжийг бүтээдэг байхад бусдыг хорлох үйл ямагт ирээдүйд таагүй амьдралын явцтай холбож өгөх чадамжийг бий болгодог. Хэрвээ сэтгэлд тухайн амьдралын явцтай холбох үйлийн чадамж байхгүй бол зовлон ч бай, жаргал бай ямарваа нэгийг шалтгаангүйгээр амсах гэж үгүй.

Бидний сэтгэлийн урсгалууд эвдэршгүй бөгөөд тэргүүлшгүй цагаас эхлэн нэг төрлөөс нөгөө төрөлд эргэлдэхдээ урьд төрлүүдийн цуурайг тоолшгүй олон үйлийн чадамжийн хэлбэрээр тээсээр байдаг. Сэтгэл дэх үйлийн чадамж үйлийн үр дагавар болж боловсрох хүртэл хэдэн төрөл дамжсан ч өөрийн чадамжийг хэзээд алддаггүй. Өчүүхэн төдий чадамж томоохон үр

дагаварт хүргэх хүчтэй байдаг, учир нь тэд цаг хугацааны туршид арвижих хандлагатай байдаг. Юутай ч атугай эерэг сайн чадамжууд уурын нөлөөгөөр доройтох болон үгүй болж устгах, мөн сөрөг муу чадамжууд гэмших сэтгэлд тулгуурласан дөрвөн ерөндөгийн нөлөөгөөр сулрах болон тэр байтугай үгүй болох бололцоотой.

Бидний бие, эд зүйлс, хүмүүсийн харилцаа гэх мэт амьдралын бүх л зүйлүүд байнгын өөрчлөлтөнд оршдог. Юу ч нэг мөчөөс дараагийн мөчид шилжих хүртэл өөрчлөгдөхгүй хэвээрээ байна гэж үгүй. Энэ бол үйлийн үр биш харин өөрчлөлт хувирлын ердийн шинж төлөв юм. Өөрчлөлт хувирлын далай дунд амьдралынхаа төлөө сэлэхдээ аз жаргалын аюулгүй газарт хүрэхийг оролдож, зовлонд живэхээс зайлсхийдэг. Эерэг чадамжууд бидний зүгт урсаж байгаа далайн давлага, муу чадамжууд нь бидний эсрэг зүгт урсаж байгаа далайн давлага ус юм.

Энэ үед уян хатан чанарын тухай ойлголт бүрдэнэ. Ихэнх хүмүүс үйлийн үрийн талаар огт мэдлэггүй байдаг бөгөөд амьдрал дунд түлхэлдэн оршихдоо шавхай онгичин амандаа таарсан сайн, муу бүхнийг идэх гахай адил амьдардаг. Үл мэдэхийн мунхагаас болж тэдгээр хүмүүс өөрсдийн сэтгэлд сайн, муу ямар ч сэтгэлийн түлхэцээ дагаснаар тухайн үйлийн хожмын үр дагавар юу болохыг мэддэггүй. Үйлийн үрийн тухай мэдлэг нь сэтгэлийнхээ ямар түлхэцийг дагах вэ гэдгийг сонгоход уян хатан байдлыг олгодог. Уур, амиа бодох, шунал зэрэг муу, хөнөөлтэй түлхэцийг сөрөн зогсож, энэрэнгүй сэтгэл, асрахуй, тэвчээр зэрэг зөв, бүтээлч зан байдлыг дадуулах хэрэгтэй. Амьдралын урсгалаар хөвөх модтой адил тэр чигтээ байхыг хүсэж байгаа бол энэ нь таны сонголт. Ухаантнууд давлага усыг хянаж чаддаг болж, үүрд далайгаас холдохыг сонгох нь лавтай.

Онолын хувьд, хэрвээ үйлийн үр гэгч байгаагүй бол алдаанаасаа суралцаж, зан байдлаа улам сайжруулах тусам амьдрал байнга аз жаргал өөд дэвших байсан. Харин бодит байдал дээр нас нэмэгдэх хирээр илүү аз жаргалтай болж чадахгүй байна. Бурханы шашин үүнийг түлхэц бүхий санаагаа жинхэнээр хянаж чаддаггүй явдалтай холбон тайлбарладаг.

Жишээлбэл, хэн нэгнийг баярлуулах бодлоор шоколад өгвөл, үүний зорилго нь ямар нэг хариу хүлээгээгүй бол бидний сэтгэлд эерэг үйлийн чадамж бий болдог. Хойд төрлүүддээ шоколаднаас хэзээ ч хоцрохгүй. Хэрвээ анхны сайхан санаа өөрчлөгдөж, шуналаас болж шоколадаа өөрөө идэхээр шийдвэл сэтгэлд муу үйлийн чадамж бий болдог. Түүний үр дагаварт хойд төрөлдөө бирд болж төрөх болзошгүй ба түүний дараа төрөлд хүн болж төрөхөд хэн ч шоколад өгөхгүй.

Дээрх хоёр үйлдэлд хамгийн гол хэсэг нь тэдгээрийн цаад санаа байсан. Эхний санаа нь бусдыг хайрлах буяны бодол байсан бол хоёр дах нь өөрийг эрхэмлэх шунал юмуу уур байсан. Эдгээр жишээнүүдийн хувьд сэтгэлийн үйлдэл болох санаа нь үйлийн үрийн шалтгаант тал юм. Санаат үйл нь өөрийн чадамжийг шинээр үүсгэсэн байх бөгөөд тэдгээр үйлийн чадамжууд үр дагавар болж боловсрохын тулд сэтгэлийг тухайн нэг зүйлтэй өөр нэг санааны тусламжтайгаар холбож өгдөг. Энэ хоёр дахь санаа бол үйлийн үрийн үрт тал бөгөөд түүгээр бий болох амьдралын туршлагыг үйлийн боловсрол хэмээдэг. Секунд бүрт шинэ тутам санаа үүсэж байдаг, гэхдээ тэдгээр бүгд нь үйлээс гарахгүй, зарим нь энэ насандаа бий болгосон сайн, муу зан байдлын загвараас гардаг.

Амьдарлын хүрдэнд тоолшгүй олон удаа төрлүүд, тэр байтугай сайн төрлүүд ч гэсэн бидний санаатай үйлдлүүдийн шууд үр дагаварууд байсан юм. Хэрвээ там, бирд, адгуус, эсвэл адгуусны муу төрлийг авахгүй байхыг хүсэж байгаа бол ухаанаа гаргаж, зөвхөн буяны үйлүүд-бусдад тусыг үйлдэх хэрэгтэй. Тиймээс үйлдэл бүрт түүнийг үйлдэх болсон зорилгоо лавтай мэдсэн байх хэрэгтэй. Түүний дараа харин нүглийн санааны түлхэцийг дагах эсэх буяны санааг дагах эсэхээ сонгох бололцоотой. Бид дангаараа ирээдүйгээ шийдэх бололцоотой; хэн нэгэн өөр хүн бидний хувь заяаг хянаж чадахгүй, учир нь үйлийн үр бидний сэтгэлд байгаа болохоос тэнгэрт байгаа аварга том данс хөтлөгчид биш.

Бид урьд нь олон удаа хүн болон тэнгэрийн төрөлхтөн болж төрж байсан боловч тэдгээр төрлүүдийн биеийн болон сэтгэлийн жаргалд шунасан хэвээр байдаг. Амьдарлын хүрднээс бүрэн чөлөөтэй байхыг хэзээ ч үзэж мэдрээгүй нь бидний бүх үйлүүд бодит байдлыг үл мэдэх мунхагаар сэвтсэн байсан учраас тэр. Тэнгэрийн төрөлд төрөхөөс хамаагүй илүү нь нирван буюу билиг ухаанаар мунхаглалыг устгаж, амьдарлын хүрднээс гэтлэн гарахыг зорих юм. Ингээд, үлэмж их энэрэнгүй сэтгэлд тулгуурласан дээд зорилт бол хамаг амьтаныг зовлонт төрлүүдээс үүрд гэтлэн гаргахад бүрэн эрдэмтэй болохын тулд Бурхан болох зорилт билээ.

Рэмбогийн хүчин үйл

Нэгэн цагт хайр бол хамгийн их түгээмэл үг болж, тэврэлт нь хэмжээгүй их байлаа. Зарим нь уулзсан хүн болгоныг, тэр байтугай ижил хүйстнээ, заримдаа бүр мод ч тэвэрдэг байлаа. Тэдний хувьд, “хайр”-ын утга нь хэмжээ хязгааргүй секс, хүмүүсийн эрх чөлөө, ялангуяа хүүхэд өөрөө л аз жаргалтай байвал дураар нь байлгахаар тайлбарладаг байсан юм. Гэтэл удалгүй зарим таньдаг хүмүүс толгойны өвчин болж, хүүхдүүд нь толгой дээр гарсан чөтгөрүүд болж, найз нөхөд, эхнэр нөхөр ч хоорондоо хонь чоно болсоныг ойлголоо. Хайр, хайр, хайр хэмээх итгэлдээ дахин нэг нухацтай хандах шаардлагатай болсон юм. Харамсалтай нь, Шинэ үеийн гүн ухааны “Өөрийгөө хайрла” хэмээх гол үзэл баримтлалаар солигдсон юм. Өөрийгөө хайрлаж чадахгүй бол бусдыг хайрлаж чадахгүй гэсэн санаагаар зөвтгөсөн Шинэ үеийнхэн нуугдмал би-гийн төрхийн аюулыг мэдэхгүй байлаа. Хамгийн аюултай дайсан буюу би-г эрхэмлэх үзлээ нүдэн балайгаар хаацайлан, өөрийгөө зугаацуулахыг загвар моод болгож, энэ нь тэдгээрийн найз нөхдийг улам хөндийрүүлж байсан юм.

Бусдын төлөө сэтгэлийг дадуулах бололцоотой болон хэрэгтэй гэдгийг онцолсноороо Бурханы шашин жараад онд биднийг буцаасан гэлтэй. Бурханы шашины хайр, хайр, хайр хэмээх чухал үзэл санаа нь нэг зүйл дээр үндэслэдэг бөгөөд тэр нь бүх амьтан урьд төрөлдөө тоолшгүй олон удаа бидний ээж байсан учраас бүх төрөлхтөн хайрыг хүртэх зүй ёсны орон юм. Хайрыг ийнхүү хамгаалж байгаа нь замбраагүй секс, юу хүссэнээ хийх тухай хэлээгүй байна. Бурхан багшийн айлдсан сургаал ёсоор бид өөртөө хураан дадуулах ёстой хайр нь ээжийгээ бодох, харах, ялангуяа аз жаргалтай байх үед элэг зүрхэнд үүсдэг дулаан, баясгалантай мэдрэмжийн тухай өгүүлж байгаа юм. Энэ бол бусдыг аз жаргалтай байлгахыг хүссэн, тэднийг жаргалтай болгох санааг агуулсан амиа бодоогүй сэтгэл юм.

Уншигч та нарын зарим нь ээжийгээ үзэн яддаг байж болох юм, гэхдээ бага зэрэг тэвчээр гаргахгүй юу? Төрөлхтөн бүр тоолшгүй олон удаа бидний аав, нөхөр, эхнэр гэх мэт ойрын хүмүүс байсан бөгөөд эхийн онцгой холбоо нь эх маань биднийг арчаагүй нялх байхаас аваад бие, хайр хоёроо зориулдаг. Гагцхүү бидний аз жаргалын төлөө бидэнд ярих, явах, юмсыг хэрхэн хүртэхийг зааж өгдөг. Бидний инээд л байхад эх хүн өөрийгөө золиосолсны шагнал тэр. Эх хожим нь алдаа гаргасан ч түүний буруу биш. Тэд бидний нэгэн адил “би”-г эрхэмлэх мунхаг сэтгэлийн өвчинд шаналдаг.

Энэ насны ээжийн сайхан сэтгэлийг санаснаар түүний сайхан сэтгэлийн ачийг хариулахыг хүсэж, ээжийгээ элэг зүрхний илч хайрын гэрлээр харна. Хэрвээ ээж маань биднийг хайрласан хайрынхаа хариуд чин зүрхний хайрыг зүй ёсоор хүртэх эрхтэй юм бол урьд олон төрөлдөө ч гэсэн таны ээж байсан гэж бодвол тэднийг хичнээн илүү их хайраар хайрлавал зохилтой вэ? Эхнэр, нөхөр, хүүхдүүд, гудамжинд өнгөрөх танихгүй хүмүүс, яршиг төвөг болдог хүн хүртэл, гал тогооны жоомнууд бүгд урьд төрөлдөө тоолшгүй олон удаа бидний эх байсан юм. Энэхүү бодит байдлыг гүнзгий ойлгосны дараа бидэнтэй учирч байгаа төрөлхтөн болгон элэгний илч хайрыг хүртээх орон, бидний аз жаргалын эх үүсвэр болдог. Хэн нэгэн юмуу ямар нэгэн зүйлд өчүүхэн төдий туслах нь эхийгээ багахан зүйлээр баярлуулж дайлсаныг хэдэн тэрбум дахин үржүүлсэн баярыг өөрөө мэдэрдэг. Харин мод тэврэх гэж санаа зовох хэрэггүй, мод бол сэтгэлгүй зүйл, биднийг бяцхан алтан зул цэцэг байхад эх

цэцэг байгаагүй нь лав. Бид хэзээ ч алтан зул байгаагүй. Модыг хамгаалах уу гэвэл, мэдээж, яагаад гэвэл бидний жинхэнэ эх байсан олон амьтдын гэр орон, хоол хүнс нь болж байдаг учраас тэр.

Гэхдээ эргэн тойрноо харвал эх болсон төрөлхтөн нар жаргалгүй байна. Тэд өвчин, өтлөлт, үхлийн асар их зовлонг эдэлж байна, маш ихээр ганцаардаж, сэтгэлийн самуурал, зовлонтой байна. Үйлийн үрээрээ адгуус, бирд, тамын амьтан болж, түүндээ хэрхэн зовдогийг, хүний төрлийг түр авсан хүмүүс бид төсөөлж ч барахгүй. Тэгвэл тэдэнд туслах нь хэний хариуцлага вэ? Энэ насны ээж минь шатаж байгаа байшин дотор байхад өөрсдөө хол зогсоод, хэн нэгнээс түүнийг авраач гэж гуйх уу? Мэдээж үгүй, ээжийгээ аврахын тулд өөрийн амийг гаргуунд хаяна. Дүрэлзэх галыг зоригтойгоор сөрж, ээжийгээ аюулгүй газар хүргэх нь зүй ёсны хариуцлага, мөн түүнчлэн төрөлхтөн бүрийг зовлонгоос гаргах нь зүй ёсны хариуцлага юм. Энэ бодлыг Рэмбогийн хүчин зүйл гэнэ.

Холливуудын кинонууд өгүүлэмжийн хувьд баатар нь гунигтай байдалд орсон эмэгтэйг аврах болон Маршалл хотыг аварч байгаа тухай гарахаас өөр сэтгэмжгүй болсон. Өнөө үед баатар эрэгтэй болон эмэгтэйчүүд гал, дэлбэрэлт болон олон төрлийн сэтгэмж бүхий хорлол сүйтгэлтэй тулгарч бүхэл дэлхий ертөнцийг муу хүмүүсээс аварч байгааг өгүүлэх болжээ. Кино зохиолчийн үзэгнээс бий болсон бусдыг ихэд бодох сэтгэл бага зэрэг бодитой бус, Холливуудын кинонуудаас болж угийн сайн залуучууд хэрэгтэй цагт гарч ирдэг гэдэг тогтсон итгэлтэй болсон. Тэгвэл хэн нэгэн үнэхээр бусдын төлөө байж болох уу?

Хэдийгээр өөрийгөө бодолгүй бусдад туслах нь угийн хариуцлага мөн боловч бидний угийн хүсэл тэмүүлэл байж чаддаггүй. Бидний дотоод өөрийг төвчлөх үзэл удалгүй аль хүртэл бусдын төлөө өөрийгөө орхих вэ гэдэг тал дээр зааг шугам зурдаг. Бусдыг бодох нь зөвхөн Холливуудийн зохиомж бус юм. Хамаг амьтныг зовлонгоос аврах хувь хүний өөртөө үүрэг аван хариуцах зориг ба шийдвэр буюу Рэмбогийн хүчин зүйл нь үлэмж их энэрэнгүй сэтгэлээс үүснэ. Энэрэнгүй сэтгэл нь бусад өөртэй нь адил жаргалтай байхыг хүсдэг, зовлонг хүсдэггүй; өөрийн хэрэг нь бусдын хэрэгтэй харьцуулбал өчүүхэн; хэрвээ өөрт буй зовлонг анагаах эмийг бусадтай хуваалцахгүй бол амиа бодохын туйл болно гэж үздэг.

Зовлонг анагаах эм бол би үгүйг онох буюу амиа бодохын төгс ерөндөг ба энэ нь бусдын төлөө сэтгэлийг төрүүлэхэд чухал туслагч болдог. Эцэг, эх нь хүүхдээ шилжилтийн насны үеийн аюулаас хамгаалахыг хүсдэг шиг үлэмж их энэрэнгүй нь өөрт-төвчлөх төөрөгдөлийн торонд баригдсан бүх амьтдын зовлонг ойлгож, тэднийг гэтэлгэхийг хүсдэг. Энэрэнгүй сэтгэл элэг зүрхний илч хайраас гарна, тэр нь төрөлхтөн бүр урьд төрөлдөө бидний эх байхдаа хязгааргүй их энэрэхүйн сэтгэлээр хандаж байсан учраас тэдэнд өртэй гэдгийг ойлгосноос үүдэн бий болно.

Эх болсон амьтдын зовлон нь өөрсдийн амийг бодох, уур, шуналаас гардаг учраас тэдгээрийг аврах манай баатруудын ганц арга зам нь тэдний уурын гал, шуналын дэлбэрэлт, би сэтгэлийнх нь хорон муу санааг даван гарах замыг зааж өгөх юм. Тэгэхлээр эхлээд тэд өөрсдөө зам мөрийг дагаж байж баатрууд эхчүүдээ аюулгүй газар аваачиж чадна. Тэдгээр баатруудыг Бодьсадва хэмээн нэрлэх бөгөөд өөрийгөө зөвхөн бусдад зориулахаас өөрийг боддоггүй хүмүүс юм. Өнөөдөр энэ дэлхийд байгаа тэмдэггүй хирнээ орших олон Бодьсадва нар байгаа бөгөөд бусдад олон замаар тусалж байна. Хүйтэн дайныг эцэс төгсгөл болгохоор

Зөвлөлт Холбоот Улсад Горбачев олон өөрчлөн байгуулалт бүтээж байх үед би Австралийн Сидней хотод болсон Буддын шашины хоёр төвийн хоорондох жил бүрийн крикетийн найрсаг тэмцээнийг үзэж байлаа. Нэг төвийн суурин Лам багш надад хандаж хэлэхдээ: “Горбачёвын өнөө дэлхийд хийж байгаа үйл нь Бодьсадватай адилхан байгаа юм даа” гэж билээ.

Бясалгал

Ирээдүйтэй хөл бөмбөгчин гэгдэх миний дүүгийн хүүхэд нэгэн удаа “Манай баг тоглохынхоо өмнө бясалгадаг” гэж хувраг авга ахдаа гайхуулахыг оролдон хэлэхэд, би:

“Ямар сайн юм бэ? Тэгээд ямар бясалгал юм бэ?” гэж асуухад, тэр догдлонгуйгаар: “Үзэн ядахын” гэж өөдрөгөөр хариулсан юм.

Тэр бясалгал нь яахав нөлөөтэй байсан байж болох юм, гэхдээ энэ нь бясалгалын хүчний зөв зориулалт биш. Бурханы шашины ёсонд бясалгалын зорилго нь эхлээд сэтгэлийн зүг чиггүй янз бүрийн бодол, хөдөлгөөний шуугианыг намдаах, дараа нь өөрийн оршин буй талаар сайтар шинжлэн бодоход тэрхүү төвлөрөлөө чиглүүлэх юм. Зөв удирдамж, зохих хичээл зүтгэлтэй бясалгавал оршихуйн уг чанарыг шууд ойлгоход хүргэж болдог. Энэхүү билиг ухаан нь хамаг зовлонгийн шалтгаан болсон би-г эрхэмлэх мунхаглалыг арилган үгүй болгодог. Бясалгалын хоёр дахь үүрэг бол асрахуй тэргүүтэн буяны сайн зүгт сэтгэлээ дадуулахад хэрэгтэй. Ингэснээр хөлбөмбөгийн тэмцээнд ялахгүй ч гэсэн таны амьдралыг маш ихээр сайжруулж, өөртөө итгэх итгэл, аз жаргалын түшиг тулгуур болж, түүн дээр тулгуурлан хичээл зүтгэл бадран, билиг ухаанд хүрнэ.

Хүн бүгд сайхан харагдах, бусдаар хайрлуулахыг хүсдэг, тиймээс хамаг мөнгө, цагаа аль болохоор биеэ сайхан харагдуулахын тулд гоёж гоодоход зарцуулдаг. Гэтэл ихэнх хүмүүс угаасаа наад зах нь биеийн гоёор гайхуулж болох генийн өгөгдөлгүй эсвэл спортын талбай, дэлгэц, загвар үзүүлэн гунхах загвар өмсөгчдийн биеийн төгөлдөр байдалд хүрэх бололцоогүй. Нөгөө талаар, хүн бүрт тэвчээр, асрахуй, билиг ухаан зэрэг дотоод гойд сайхан чанарт хүрэх сэтгэлийн чадамж бий. Эдгээр сэтгэлийн чанарууд жинхэнэ гоо үзэсгэлэн мөн. Хэдийгээр бие нь согогтой хүн байлаа ч сэтгэл нь асрахуйн сэтгэлээр гэрэлтэж байгаа үед хэн хүний элэг зүрхэнд илч, баяр баяслыг төрүүлдэг. Хамгийн царайлаг, дасгалжуулсан биетэй хүн ч гэсэн ууртай үедээ муухай харагдаж, харамч үедээ дургүй хүрмээр, түрэмгий үедээ дотор муухай оргимоор, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах зэрэг буруу үзлийг олон нийтэд ухуулах үедээ аймаар харагддаг.

Тэгэхлээр, хэрвээ бусдаар хайрлуулахыг хүсэж байгаа бол бясалгалын олбог дээр ихэнх цагийг, харин толины өмнө бага цагийг зориулах хэрэгтэй. Бясалгахад туршлагатай хүний заавар, түүний үлгэр дуурайл, чимээгүй, тухтай газар, Олимпийн алтан медаль авахын төлөө бэлтгэж байгаа тамирчнаас илүү шийдэл зориг хэрэгтэй. Бүү санаа зов, ийм хичээнгүй нь бясалгалын ач тусыг амтлах үед үүснэ.

Бясалгаачид сэтгэлээ тухайн сонгосон орон-Бурханы дүрийн сэтгэлийн дүрслэл дээр төвлөрүүлж, тэрхүү орныг сэтгэлээ сарниулалгүй тогтоон барьдаг. Эхний үед, сэтгэл баригдахгүй эмнэг шиг байх бөгөөд төвлөрч байгаа орноо нэг секундээс илүү тогтоон барьж чаддаггүй. Морио сайн уяагаар уяж болдог шиг хичээнгүй зүтгэлээр орондоо төвлөрч чадна. Тэр уяа бол сэрэмж бөгөөд сэрэмж нь дүрээ санаж, сэтгэлээ түүнд тогтоодог. Сэрэмж бүрэн хэмжээгээр хүчтэй бэхжих хүртэл сэтгэл голдуу хүслийн төсөөлөлд хальтран орж, чөлөөтэй сарнин, тэр байтугай бясалгаж байгаа гэдгээ ч мартаж орхидог. Зуршил ёсоор, бид хувийн алдар нэр, хайртай хүнээ хүч чадлаараа байлдан дагуулж байгааг өдрөөр төсөөлөн зүүдэлж,

хэдэн өдөр, бүр хэдэн сарын хугацаанд бясалгал бүрт үргэлжлэх үйл явдлуудад төөрөлдөнө.

Эдгээр сэтгэлийн догшролтын тотгоруудыг зогсоож, тухайн орноо тогтоон барих үед өөр нэг тотгор буюу будангуйрал бий болдог. Хэдийгээр төвлөрөлийн орон байгаа боловч түүний тодорхой байдал нь алдагдаж, сэтгэл харанхуйлдаг. Нойр шиг байдалд шилждэг бөгөөд сайн бясалгал болж байна гэж боддог боловч бодит байдал дээр үхэр шиг мохоо сэтгэлтэй болох үйлийг бүтээдэг. Догшрох болон будангуйрах хоёр тотгор тухайн орны төвлөрөлийг удаа дараа тасалдуулдаг учраас мэдэмсэр буюу маш нарийн байж болох эдгээр хоёр тотгорыг сэтгэлд үүсэх эсэхийг ажигладаг. Мэдэмсэр нь дохио дуугаргаж, сэрэмж нь сэрч, сэтгэлээ бясалгалын орондоо дахин байрлуулна. Үр дүн нь ихэнхдээ аажим гардаг ба өөрийнхөө сэтгэлийг урьдын адил галзуу хэвээрээ гэж боддог хүмүүст анзаарагдахгүй. Гэхдээ хүмүүс: “Ийм юм болж байхад чи яаж тайван байна аа, чи ямар эм уугаад байгаа юм бэ?” гэж асуугаад эхлэвэл ямар нэгэн зүйл болж байна гэж мэд.

Өөрийгөө төвчлөх бодол гүнзгий байдаг учраас хэн нэгэнд бясалгадаг тухайгаа хэлэхгүй байх нь дээр, эс тэгвэл омог бардамналын буруу зүгт сэтгэл амархан төөрөлдөхийн зэрэгцээ гадаад саад тотгорууд бий болно. Хэдий тийм боловч өөрийн туршлагаас хуваалцмаар санагдаад байна, учир нь энэ л хувраг хүн миний ажил юм шүү дээ. Хувраг болох гэж шийдэхээсээ өмнө би Австралийн бутан дунд, айхыг үл мэдэх амьтад, шувууд тойрсон бөглүү газар ганцаараа гурван сар бясалгал нинбад суусан юм. Оройн бясалгалд байхад сарьсан багваахай дулаанд нь ээн гар дээр минь эвхрэн унтана, өдөр нь бяцхан шувууд, аяганд буй өдрийн хоол цагаан будаа, вандуйнаас шүүрэн авч, анх удаа тэдгээрийн амтыг мэднэ. Өдөрт найман удаа нэг цагаар бясалгах, өдөрт хоёр удаа хоол идэх хатуу хуваарь баримтална, модны хожуул, хогын овооноос олсон материалаар хийсэн модон байшингийн горооноос гадагш гарахгүй байлаа. Бурханы сургаалийн холбогдолтой унших ёстой олон ном байлаа, харин гадаад ертөнцтэй ямар ч холбоогүй байсан юм.

Тэр үед саяхан амьдралд тохиолдсон үйл явдлууд бодогдсоноо алга болж, өнгөрсөн үеийн амьдрал ээлжлэн тодрохдоо тухайн байдалтай холбоотой сэтгэлийн хөдөлгөөнүүдийн хамт бодол санаанд минь орж ирж байлаа. Заримдаа нулимс хацар даган урсана, заримдаа инээдээ барихад хэцүү болдог байлаа. Бурханы шашин бол ерөнхийдөө сэтгэл судлалын тогтолцоо бөгөөд бясалгалд суусан явдал нь Бурханы шашины номлолын хүрээг туршиж үзэх хангалттай материал болсон юм. Тогтолцоо бүрдсэн юм. Хэрвээ би өөрийг төвчлөх үзэл, өөрийг эрхэмлэх, өөрийгөө зөвтгөх байдлаас ангижирсан байсан бол надад өмнө нь тохиолдсон амьдралын таагүй учрал хэзээ ч болохгүй юмуу хэмжээ нь бага байх байсан гэдэг нь маш их тодорхой болж байсан юм. Өөрийгөө мартаад бусдыг хайрлаж байсан үед амьдралд тохиолдсон аз жаргал улам их сайхан болж байжээ. Гурван сарын турш эрчимтэй сэтгэлзүйн шинжлэл явуулснаар сургааль нь шинжээч болж, миний сэтгэлийн сайхан, муухайг тольдон харуулж байлаа. Чухал зүйл нь гэвэл Бурхан багшийн 2500 гаруй жилийн тэртээ Энэтхэгийн ард түмэнд айлдсан үнэн сургаал орчин үеийн бидэнд ч мөн үнэн хэвээрээ буйг бясалгал маань нотолж өгсөн юм.

Бясалгал өндөрлөсний дараа уулын довны оройгоос харахад баруун талд мод зөөдөг хуучин тракторын мөр онгон ширэнгэ ойн гүнд замхарсан байлаа. Зүүн талд нөгөө зөрөг найзын минь тосгон руу орсон харагдлаа. Дахин баруун тийш харан, үүрд алга болохыг хүсэж байсан

боловч дэлхий ертөнцийг дахин нэг хармаар санагдлаа. Гурван сар юу ч дуугаралгүй байгаад ярихад сонирхолтой санагдаж байлаа. Зүлэг ногоо дэлгэрсэн, хаврын цэцэгс найгасан цэлгэр хөндий наранд гийх нь ойн гүний харанхуйгаас гарч ирэхэд диваажин шиг харагдана. Тэр орой нийгмийн дэгийг эсэргүүцдэг хиппи залуус тосгонд тэргэл сарны дор үдэшлэг зохиож байлаа. Ямар ч унд, бодис хэрэглэх хэрэггүй миний сэтгэл тэднийхээс илүү дээгүүр байлаа, удалгүй үдэшлэгийн чимээ шуугианыг орхин модон байшингийнхаа нам гүм анирт буцаж очлоо.

Түүнээс хойш нэг сарын дараа Мельбурн хотын эмнэлэгт ажлаа хийх зуур бясалгалд суух үед болсон явдлын тухай хамт ажилладаг залуу эмчдээ ярилаа. Над руу маш их гайхан: “Гурван сар аа! Чи яаж чадав аа? Чиний тушаал дэвших чинь юу болж байна?” гэж асууж билээ.

Өөрийг нь аажмаар идэх тогтолцоонд хүлэгдчихээд байгаа түүнийг би өрөвдөж байлаа. Дээр өгүүлсэн бясалгал нь хэний ч хувьд албан тушаал болон амьдралдаа байлгах хамгийн сайхан зүйл юм.

Том болох

Бид эхээс мэндэлмэгцээ гэр бүлдээ од болж, хүн бүхний хөөршөөлийг татан, хүссэн болгоныг нь өхөөрдөнгүйгээр өгдөг болохоор өөрийгөө дэлхий ертөнцийн төв мэтээр бодоход буруудахгүй мэт. Харин том болоход эцэг эхийн дэгэнд орох, ах, эгч дүүгийн атаархалд өртөхөд гэнэт цочирдоно. Өөрийнхөө төлөө тэмцэх хэрэгтэй юм байна гэдгийг ойлгон; юу хүсэж байна; юу хүсэхгүй байна; юу нь минийх вэ гэдгээ бүрэн дүүрэн мэдэж тэмцэлдэж байсан. Муухай аашаар давшилж үзээд, тэр нь санааны зоргоор бүтэхгүй бол зодоон болж хувирна, тэгснээ төд удалгүй буугаад өгнө. Юутай ч атугай ах, эгч нарын зөрчилд туйлдаж, бидний уйлахыг сонсохоос өөр тэднийг баярлуулах юм үгүй. Дараа нь хүч хэрэглэж үзнэ. Дэлхийн төвд байх өөрийн байр сууриа дахин олохыг хүссэн эгч, ах нарынхаа гарт амь насаа алдсан олон хүүхэд намайг түргэн тусламжийн тасагт ажиллаж байхад ирж байсан юм. Биеийн хүч хэрэглэж санасандаа хүрэх аргыг дийлэнх нь орхиж, зусардах, хуурамч инээх гэх мэт илүү нарийн аргатай болно. Амиа бодох нь улам нарийсах зан байдлыг том болох гэнэ.

Нэгэн цагт бүгдийн хайр, анхаарлыг татаж байсан тэр үеийн сэтгэгдлүүд бидний сэтгэхүйд агуулагддаг ба санахгүй боловч хаа нэгтээ оршдог хэмээн итгэдэг тэрхүү алдагдсан диваажингаа дахин нээх дотоод шуналд автагддаг. Нэг нэгнийхээ эсрэг эд хөрөнгө, биеийн жаргал, магтаал, алдар нэрийн төлөө өрсөлдөөний цаад талд далд төгс төгөлдөрийн хүсэл оршдог. Нялх байх үеийн зүүд мөрөөдлийн хотхоныг дахин бүтээх бололцоогүйд урам хугарахдаа боловсронгуй нарийн дүр байдлаа алдаж, буцаад нялх хүүхдийн зан байдлын загварт ордог. Их Бодьсадва Шантидэвагийн айлдсанаар:

Элсэн гэрээн эвдэрвээс

Эхэр татан уйльюу нялхас

Эгшиг магтаал, энгүй алдар нь доройтохуйд

Эгээрэхүй сэтгэл минь нялхас адил болох

(“Бодьсавын явдалд орохуй” номын 86-р тал.

Орчуулсан Т.Булган) хэмээжээ.

Сонголт олдохгүй цөхөрч, зөрчлөөр дүүрэн амьдрал, биелэгдээгүй мөрөөдлүүдээс болж итгэл найдвар алдардаг. Өтлөлт, үхэл нь илүү хурдтай ойртох үед өөртөө итгэл найдвар тасран, хүндлэл бишрэлээ үр хүүхдүүддээ шилжүүлнэ. Бид тэдний амьдарлыг төлөвлөж, бидний олж чадаагүй жаргалыг тэд олж чадна гэж найддаг. Гэтэл хүүхдүүд нь том болсон хэдий ч бүр өөрөөс нь дордон, тэднийг ч гэсэн сэтгэл хангалуун байдал тойрон гардаг. Дараа нь ач зээдээ итгэж найдахад биднийг гутралд оруулж амжихаас өмнө өөрсдөө үхэх байх. Одоо байгаадаа сэтгэл ханахгүй байгаа учраас гурван үеэрээ аз жаргалын төлөө эрэлд бүтэлгүйтэж байна. Тэдний сэтгэл өнгөрсөн аз жаргалыг дурсан санах болон ирээдүйн аз жаргалыг зөгнөн мөрөөдөх хоёрын хооронд сэмэрсэн байдаг.

Жинхэнэ том болсон хүн энэ өргөст хорвоод маш ховор цэцэг бөгөөд сэтгэл нь одоо цагт ямагт тайван, амин хувийн мөрөөдлийг хөөхөөс ангид, өнгөрсөн сайхан явдалд шунахаас ангид байгаа хүнийг хэлнэ. Тэрээр эд мөнгө, аз жаргал, магтаал, алдар нэрийн хойноос шунахгүй, гарз, зовлон, шүүмжлэл, доромжлолд хөдөлшгүй бат зогсдог. Хүн болгон ингэж том болох бололцоотой бөгөөд энэ нь Бурханы зам мөрийн зорилго юм. Энэ нь билиг ухаан ба асрахуй буюу бодит байдлыг харах чадвар ба бусдын аз жаргалаар баяр баясалтай болох сэтгэлийн өөрийн дотоод чанаруудыг бүрэн хэмжээнд хөгжүүлсэн үр дүн юм. Бурханы сургаал ёсоор том болно гэдэг нь Бурхан болох чадвараа бүрэн гүйцээх явдал бөгөөд энэ бол бусдыг болон өөрсдийгөө жинхэнэ аз жаргалтай байлгахын тулд эцэстээ бид бүгдээрээ гарах зам мөр юм.

Тарнийн ном бүтээл нь энэ зорилгод хүрэх хамгийн гүнзгий бөгөөд дөт арга юм. Тарнийн бүтээлчид өөрийн бие, хэл, сэтгэлийн чадавхийг билиг ухаан, асрахуйд урвуулахын тулд арга, билгийн ёсны аль нэгэн Бурханыг өөрийн дуурайх эх загвар болгодог. Тарнийн дүрүүд олон байдаг нь олон бурхан байна гэсэн үг хэмээн зарим хүмүүс эндүүрэн үздэг. Бясалгалын дүр болгон нь төгс гэгээрсэн Бурханыг төлөөлдөг ба дүр байдлаараа гэгээрсэн сэтгэл таалалын тухайн талыг бэлгэдэн харуулдаг. Олон тэргүүн, мутар, өлмий гэх зэрэг нь зам мөрийн олон тал болон бурхадын гэгээрсэн үйлсийг бэлгэддэг. Бурханы хутагт хувь хүн талаас зорьж торнихдоо хувь хүний өөрийн шинж чанараас хамааран тарнийн бүтээлчид өөрт тохирсон тухайн дүртэй бурханыг голчлон бүтээхээр сонгодог.

Гэгээрсэн таалал бол дээдийн билиг ухаан ба энэрэнгүй амгалангийн нэгдэл юм. Бидний сэтгэлийн аргын талын төгөлдөржилт нь энэрэнгүй амгалан; билгийн талын төгөлдөржилт нь дээдийн билиг ухаан бөгөөд энэхүү хоёрын төгс хослолыг тарнийн бурхадын дүрийн эр эмийн зохиролт байдлаар дүрсэлдэг. Үүнийг бурханы шашингүй болон бурханы шашинтай боловч нялхас адил биеийн жаргалыг хөөх явдлаа орхиж чадаагүй хүмүүсийн өөр нэгэн буруу ойлголт болох- эр эмийн эгэл жирийн явдал огт бус. Одоогийн Шинэ Үе тарнид сонирхож, өөрсдийгөө тарнийн багш нар гэж цоллоод олон номын санааг наана цаана нь оруулан жижиг жижгээр арай гэж эвлүүлэн ярьцгааж, тарнийн номыг үзэхээс өмнөх суурь болох магад гарахуй, бусдын төлөө сэтгэл, билиг ухаан байхгүй байгаа нь өнөөгийн цөвүүн цагийн гунигтай дохио юм.

Том болоход загвар дуурайл шаардлагатай. Үүний өмнөх нийтлэлд эцэг эх, багш нар, улс төрчид, спорт, дэлгэцийн одод болон муурын явдлаар явагч загвар өмсөгчид үлгэр дуурайл болж чадахгүй тухай өгүүлсэн. Рок хөгжмийн оддын тухай өгүүлээгүй ба тэд өөрсдийгөө ямархуу гэдгээ тэртээ тэргүй илэрхийлж чадна. Тухайн нэг баатрыг даган хувцаслаж, адилхан зан аашыг гарган дуурайдаг хүмүүсийн клуб нь жирийн зугаа цэнгэл боловч баатартай адилхан байх гэсэн бидний дотоод хэрэгцээг илтгэн харуулж байгаа юм. Өөр хандлага нь- эсрэг баатар юмуу эмгэнэлтэй дүртэй адилхан байх нь-бидний сэтгэлийн дотоод эмгэнэлийн гунигтай тусгал юм. Орчин үеийн амьдрал учир утга, зорилгогүй болсныг мэдрэх нь мансууруулах бодис хэрэглэн донтох тахал гарах, амиа егүүтгэх, дэлхий даяар нүүрлээд байгаа хүчирхийллийн гол хүчин зүйл болж байна.

Шашины олон зүтгэлтнүүд уйтгар гунигтай амьдралтай байдаг эсвэл хоёр нүүртэй хууран мэхлэгч хэмээх булай дэлгэгддэг, баатар ч биш, эсрэг баатар ч биш гэж тооцогддог. Тэгээд юу

үлдэв? Бурхан болно гэдэг бүхнийг бүтээн үйлдэгч болно гэсэн үг биш, тийм байх ямар ч бололцоогүй гэж тооцогддог, харин билиг ухаан ба энэрэнгүй сэтгэл хоёрын төгөлдөржилт бол хүн бүрийн хүрэх бололцоотой зүйл юм. Хэрвээ үүнийг ойлгох хувьтай, Бурханы хутгийг олъё гэсэн бишрэл төрүүлбэл бүх талаараа дээд оргилд хүрсэн бурхадыг даган дуурайх нь цорын ганц зохимжтой үлгэр дуурайл болно. Тэдний лагшин, дуу хоолой, таалал сэтгэл нь үлэмжийн асрахуй, амгалан, билиг ухаан ба хүч чадлын төгс чанаруудыг бэлгэддэг.

Тарнийн бурхад амгалан, хагас амгалан эсвэл догшин дүртэй байдаг. Гэгээрэлд зорин сэтгэлээ дадуулах үед тухайн дүр төрх нь айдас төрүүлэх бус, бидний сэтгэлийн тухайн муу талыг дарахад чиглэсэн үүрэгтэй байдаг. Монгол болон Төвд орнуудаар аялсан жуулчид хөмсгөө зангидан: “Энд хүмүүс чөтгөрийг шүтдэг юм байна” гэсэн аястай бувтнан буцдаг. Бурханы шашины тарнийн бурхадын дүрүүдэд бүү дургүйцээрэй. Тэдгээр нь гүнзгий утгатай, үүрэг нь ертөнцөд маш чухал хэрэгтэй.

Хүн гэдэг талаас нь үзвэл Төвдийн Далай ламтан бол Бурханы шашины санваартан, ухаалаг улс төрч, энэрэнгүй гэдэг утгаараа загвар дуурайл юм. Энэрэнгүй Жанрайсиг бурханы тарнийн дүрийн хувьд гэгээрэлд хүргэх төгс төгөлдөр хөтлөгч билээ. Дэлхий дээрхи түүний энэхүү өвөрмөц байдлыг Барууны орны хэвлэл мэдээллийнхэн тохуурхан “God-King” (Эзэн тэнгэр-Хаан) хэмээх утгагүй цолоор нэрийддэг. Энэ нь надад өөр нэгэн их Гэгээнтний хэрээс дээр бичсэн “Йеудын Хаан” хэмээх шоглонгүй бичээсийг санагдуулж байдаг. Бурхад энэ ертөнц дээр биднийг хөтлөхийн тулд байнга заларч байдаг. Бидний үйлийн үрээс хамааран түүнийг жирийн төрөлхтөн эсвэл дайсан гэж үзнэ. Миний багш нэг удаа: “Энэ дэлхий дээр өнөөдөр хэн нэг нь Бурхан мөн гэж үзвэл тэр нь Дээрхийн Гэгээн Далай багш мөн” гэж айлдсан билээ.

Лам багш

1974 оны нэг сарын бясалгалын хичээлийн гуравны нэгт суугаад байсан тэр үед Ешэ ламтан морилно гэсэн сураг гарсан юм, тэр үед надаас гадна хоёр зуу гаруй Барууны залуучууд Бурханы шашны бясалгал, лекц, мэтгэлцээний эрчимтэй хичээлд суух үедээ Копан хийдээс гарч болохгүй дүрэмтэй байлаа. Энэ нь хэцүү биш байлаа. Копан хийд уулын энгэр дээр байрлах бөгөөд дээрээс нь Катманду хөндий тэр чигтээ харагдана, үргэлжлэн харагдах уулсын алсын бараа, цагаан будааны талбай, сэвшээ салхинд найгах аварга хулс мод, энэ бүхэн цаст Гималайн оргилын дэвсгэр дээр үзэсгэлэнтэй сайхан харагдах нь хэзээ ч мартагдсан аргагүй.

Залуус бүгдээрээ гайхамшигтай Ешэ ламтаны тухай сонссон боловч ихэнхи нь түүнийг үзээгүй болохоор үзэх гэсэн сонирхол маш их байлаа. Томоо гэгч майханд бүгд ламыг хүлээж байх зуур нэгэн хувраг майхны ард бүдрэх чимээ гаргахад бага зэрэг анхаарал сарнив, орхимжнийхоо үзүүрээр нүүрээ тагласан, нөгөө хувраг ч урьд эгнээнд газар зассан Барууны хуврагуудын суудалд суулаа. Цаг явсаар байв, хүлээлт улам хүчтэй мэдрэгдэж байлаа. Хүн болгон гол хаалгыг ширтэцгээн суутал түрүүний хожимдсон хуврагаас гэнэт хашгирах шахам чанга чанга хөхрөн инээх дуу гарлаа. Тэр бол Ешэ лам байлаа. Инээсэн чигээрээ сэнтий дээр залран, гол хаалгаар орж хүндлүүлэх биш биднийг хууран өөр газраас чимээгүй орж ирэх гайхамшигтай даруу байдал нь миний зүрх сэтгэлд тэр даруй хүндэтгэл төрүүлсэн юм.

Би нэлээд олон удаа хичээлээ хаяж явах шахсан юм. Үйлийн үр, хойд дүрийн тухай ойлголт нь шинжлэх ухаанаар ертөнцийг үзэх миний үзэлд тохирохгүй байсан бөгөөд Бурханы шашин нь бас л амьдралыг утга агуулгатай болгох өөр нэг мухар сохор оролдлого хэмээн бодож байсан юм. Чарльз Дарвин, физик, хими, биологи зэрэг нь миний хувьд хангалттай байлаа. Гэсэн хэдий боловч тэнд намайг нэг л юм уяд байв, энэ нь мэдээж хоол биш. Лам багш нарын айлдсан сэтгэл гэж юу вэ, сэтгэлийн үйлдэл хэрхэн явагддаг тухай ярианууд нэлээд сонирхол татаж байлаа. Ешэ лам багшийн айлдсан хариултууд нь миний итгэж чадахгүй байсан үйлийн үр болон хойд дүрийн тухай асуултыг бүрэн тайлаагүй боловч намайг Бурханы шашины сэтгэл судлалын тухай улам ихийг мэдэх гэсэн хүслийг оргилуулсан юм.

Ешэ ламаас би шизофрени тухай асуусан юм. Лам багшийн хариулт нь түүнийг өвчний мөн чанарын тухай сайн ойлголттой гэдгийг харуулж, бие махбодь юмуу сэтгэл зүйн шалтгаанаас үүсэж болно гэж тайлбарласан нь утга төгөлдөр байлаа. Нэгэн ухаантай залуу хүнээр жишээ авч, тэрээр эцэг эх, нийгэм болон өөрийнхөө сэтгэлийн шахалт дарамтнаас болж аажмаар өөрийн бодол, зан байдлаа удирдах чадвараа алддаг тухай өгүүлсэн юм. Энэ тодорхойлолт нь Австралид сэтгэцийн эмнэлэгт ажиллаж байхдаа өвчтөнүүдийг ажигласан байдалтай тохирч байлаа.

Яагаад энэ асуултыг сонирхсон гэвэл бусад олон янзын төрөлхтөнийг тодорхойлохдоо гагцхүү хүмүүсийн сэтгэлзүйн янз бүрийн тохиолдлуудыг үзэмж оруулсан талаас нь би хүлээн зөвшөөрч чадах байлаа. Тамын амьтад, өөрсдийнх нь сэтгэлийн төсөөллөөс бүтсэн чөтгөрүүдэд тамлагддаг гэдгийг, өөрийг нь бусад үзэж яддаг хэмээн сэжиглэдэг шизофрени өвчний зөв тодорхойлолт гэж бодож байсан юм. Харамч хомхойгоосоо болж туйлын их өлсөж, ундаасдаг бирд болсон амьтдын хувьд их мөнгөө нуун дарсаар байгаад өлсөж үхдэг

хүмүүс, эсвэл дэлхийн хамгийн их баян Хоуард Хьюс мэтийн шунах нь эрээ цээргүй болж, үнэхээр зовлонтой амьдралтай хүмүүсийг тодорхойлж байдаг хэмээн бодож байлаа. Амьтан шиг бодол, зан байдалтай хүмүүсийн жишээ асар олон бий. Асурийнхан тэнгэрт атаархсандаа дайн тулаан хийдэг нь эрх мэдэл, эд хөрөнгөнд шунах улс төрчид, армийн тушаалтнууд, бизнесийн толгой баячуудыг тодорхойлсон байлаа. Тэнгэрийн орны зугаа цэнгэлтэй амьдрал нь дур ханах үе буюу сэтгэцийн таатай мөчийг тодорхойлсон байлаа.

Дараагийн удаа Ешэ ламтай Австралийн Мельбурны Их Сургуульд хийсэн уулзалтын үеэр таарсан юм. Олон нийтийн ярианд ирэхэд хаалгыг нь онгойлгож өгөхөөр машин руу очсон юм. Намайг хаалга онгойлгож амжаагүй байтал цонхоор гараа гаргаж ирээд миний сахлаас татаж байгаад өөрийнхөө нүүрэнд намайг тулгав. Догшин дүртэйгээр: “Би чамайг таньж байна. Копан хийдэд олон юм асуугаад байсан залуу чи мөн байна” гэснээ чангаар инээд алдаж билээ.

Тэр үед уучлаарай гэсэн санаатай бувтнаж билээ. Арван хоёр сарын туршид үйлийн үр ба хойд төрөл байдаггүй гэдгийг нотолж чадаагүй л байлаа, тэгээд ч шинжлэх ухааны үзэлтэй харшлахгүй байсан юм. Үнэндээ, шинжлэх ухааныг нөхөх бололцоотой гэдгийг ойлгосон учраас би Бурханы шашинтан болсон юм.

Долоо хоногийн дараа далайн эрэг дээр Ешэ лам багшийн аяны гэр-машинд таван-өдрийн бясалгалд суух үедээ багшаас: “Би Бурханы номыг аль болох ихээр үзэхийг хүсэж байна, надад хоёр арга зам байна. Нэг дэх нь надад илүүтэй санагдаж байна, тэр нь хэн нэгтэй хамт амьдраад хамтдаа ном үзэх. Хоёр дахь нь хувраг болох” гэлээ.

Сайхан инээдээрээ инээн, орон дээр хөхрөхдөө эвхэрэн бөмбөрсний дараа цэх сууж, инээгээд гарсан нулимсаа арчих зуураа гэнэт нухацтай болж ирсэнээ: “Хонгор минь, бололгүй яахав. Эхнэртэй болоод хоёулаа хамт номоо сурч болно. Гэхдээ энэ хэцүү. Нэг галзуу сэтгэл байхын оронд хоёр галзуу сэтгэл байна гэсэн үг шүү дээ” гээд дахин сөхрөн унатлаа инээв.

Би өөрийгөө хамгаалах санаатай: ”Тэгвэл хувраг болбол юугаараа илүү юм бэ?” гэхэд тэр шууд л: “Чи өдрийн хорин дөрвөн цагийн турш ном үзнэ” хэмээн аль болохоор их ном үзмээр байна гэж анх хэлсэндээ хүрэхийг уриалж байгаа байдлаар хариулав.

Тэр ярилцлагын дараа Австралид Лам багш нарын айлдсан нэг сарын хугацаатай хичээлд суув. Дараа нь бутан дунд модон байшин барьж гурван сарын бясалгалд суусан юм, үүний тухай өмнөх нийтлэлд өгүүлсэн байгаа. Лам багшийн явуулын гэрт болсон ярианаас хойш долоон сарын дараа Копан хийдэд би буцан очиж, бусад Барууны арван хүмүүсийн хамт Бурханы шашины хуврагын равжүн сахилыг хүртсэн юм. Ёслол болсоны дараа Ешэ лам багш: “Одооноос эхлэн би та нарын ээж, аав, найз залуу, найз охин чинь байх болно. Та нарын юу хүссэнийг би хүртээнэ” гэж билээ.

Ешэ лам амлалтаа биелүүлсэн юм. Копанд зуун Төвд, Балба хуврагуудын зэрэгцээ Барууны орны хорин таван эрэгтэй, эмэгтэй хуврагууд сууж байсан бөгөөд бидний албан ёсны сургалт боловсрол болон амьдралын бусад бүх талыг лам багш маань байнга маш их анхааран санаа тавьдаг байсан юм. Бурханы хувраг нарын жишгээр энгийн даруухан идэж ууж, амьдрахыг

эрмэлзэж байгааг ажиглаад хэн нэг хүнээс биднийг өглөөний цайндаа голдуу юу иддэгийг асуусан байж. Маргааш өглөө нь Ешэ лам багш манай гал зуухны өрөөнд байж байлаа. Ширээ маань эрдэнэ шиш, шарсан өндөг, бяслал, шарсан талх, жимсний чанамалаар дүүрэн найрын ширээ болсон байлаа.

“Та нар сайн хооллох ёстой, тэгэхгүй бол та нарын бие хатуужлыг гүйцэхгүй шүү” гэж хэлээд гараад явав.

Өөр нэгэн удаа Гималайн өндөр ууланд хатуу чанга дэглэмтэй бясалгал эхлэх үед би орон дээрээ суун, миний өрөөнд оруулж ирсэн өглөөний хоолыг дургүйцсэн байдлаар харж байлаа. Их тосонд шарсан дан ногоо л байлаа. Би “Ийм аймаар хоол идээд яаж энэ бясалгалд суух юм бэ?” гэж бодож байтал өрөөний цонх онгойж, Ешэ лам багшийн гар дотогш орж ирж, Вежимайт буюу Австраличуудын хамгийн дуртай амттаныг түрхсэн төвд талхтай таваг барьсан байлаа. Нэг ч үг дуугаралгүй талхаа өгчихөөд цааш явлаа. Түүнээс хойш дахиад би хоолоо голохоо больсон юм (дээрдээгүй ч).

Төвдөөр “Лама” гэдэг бол буяны садан гэсэн утгатай. Цөөн хэдэн хүн Лам хүний эрдмийг олсон байдаг учраас бүх хувраг Лам биш. Бидэн шиг мунхагийн намагт унасан төрөлхтөний хувьд амьд байхад агаар хэрэгтэй байдаг шиг оюунаа судлахуйн мөрт тэдгээр садан нөхөд хамгаас чухал хүмүүс билээ.

Ганцаардал

Гималай уулсын Балбын хаант улсад тогтсон заншил ёсоор нэгэн охиныг тэнгэрийн элчээр сонгож, орд харшид суулган, гэр орон, найз нөхдөөсөө тусдаа амьдардаг юм. Охинд хэрэгтэй материаллаг эдийг их хэмжээгээр өгөх боловч түүний үсий нь тайрахгүй, хөлий нь газар хүргэдэггүй ёстой. Нэг удаа кинонд эдгээр тэнгэрийн охидын нэг, цонхоор Катмандугийн хөл ихтэй гудамжийг санасан байдлаар ширтэн харж, царай нь уйтгартай байгааг үзүүлж байсан юм. Сарын тэмдэг нь анх ирэх үед эндээс чөлөө өгнө, “хараал зүхэл” нь түүний хувьд аврал нь болж, дараа нь өөр нэгэн золгүй охин түүний оронд ирнэ. Хүмүүс эдгээр охидыг азтай гэж үздэг, харин тэнгэрт итгэдэггүй Бурханы шашинтан миний сэтгэл тэднийг хүчээр тусгаарлаж, ганцаардуулсаныг бодохоор өрөвддөг юм.

Зарим хүмүүст, Бурханы шашины хуврагууд гэр бүлийн харьцаагүй байх нь мөн гажууд юм гэж санагддаг. Австралид байх сүүлийн ажлын өдөр Балба руу хувраг болохоор нисэхийн өмнө эмнэлгийн уламжлал ёсоор бусад залуу эмч нарын хамт үдэлтийн үдэшлэг хийхээр хажуугийн нэгэн уушын газар орсон юм. Тэнд ирээдүйн нэг хувраг амандаа навчин тамхи зуугаад, урдаа нэг шил пивотой, хоёр залуухан эмэгтэй эмчийг мөрөөр нь тэвэрчихсэн сууж байлаа. Өөрөө дотроо эргэлзэж байсан, үлдсэн амьдарлаа ганцаараа өнгөрөөж чадах болов уу гэсэн бодлын маань цуурай болгон тэдний нэг нь:

“Чи тэгээд энхрий тэврэлтийг үгүйлэхгүй гэж үү?” гэж асуув.

“Би мэдэхгүй байна, гэхдээ би оролдоод үзэх хэрэгтэй гэж бодож байна” гэж хариулав.

Ганцаардал бол миний хувьд тийм ч шинэ зүйл биш байлаа. Хэдэн жилийн өмнө хайртай бүсгүйгээ Австралид орхиод анагаах ухааны эрдмийн ажил хийх, туршлагатай болох, үнэндээ бол адал явдал эрэлхийлэн Англид очсон байлаа. Адал явдал, найз нөхөд, сонирхолтой ажил, судалгаа шинжилгээ гэх мэт хүсэж байсан бүх зүйлээ оллоо, гэтэл найз бүсгүйгээс минь захианууд ирж, дурсамжууд сэтгэлийг минь эзэмдэхэд, хөгжилтэй сайхан санагдаж байсан Лондон хот энэ дэлхийн хамгийн уйтгартай хот болов. Би түүнийг надтай хамт, миний жаргалыг хуваалцахыг хүсэн мөрөөдөж байлаа.

Гэвч ганцаардах эрсдэлийг хүсэж, хувраг болохоор шийдсэн маань лам багш нарын үлгэр дуурайл болон Бурханы номыг ухаарсантай холбоотой байлаа. Амьдралдаа тааралдаж уулзсан олон хүн дотроос миний лам багш нартай тэнцэх ухаантай, аз жаргалтай, алия хошин нь байсангүй. Хэрвээ би лам багш нарын адил сэтгэлийн үйлдэл хэрхэн явагддагийг сурч, түүнийг хэрхэн хянахыг мэддэг болбол би өөрийгөө ганцаардал болон бусад аз жаргалгүй байх бүх хэлбэрээс ангижирна гэж боддог байлаа. Бурханы сургаал бол ердөө энэ юм.

Бид бүгдээрээ тодорхой хэмжээгээр ганцаардлыг амьдарлынхаа туршид амсдаг, өөрсдийнхөө тусгаарлагдмал байдалд бусдыг үл тоомсорлох байдал болон нийгмийг ерөнхийд нь буруутгадаг.

Ганцаардахад гадаад нөхцлүүд байдаг нь үнэн, гэхдээ ганцаардах зовлонгийн хамгийн гол шалтгаан бол хэн нэгэнтэй хамт байхгүй бол аз жаргалтай байж чадахгүй гэсэн алдаатай

бодол юм. Хэн ч хамаагүй хүнийг хүсдэггүй. Бид сэтгэлдээ өөрийг ойлгох төгс тохирсон хүний дүр төрхийг бий болгодог. Өөрийнхөө тогтоосон хэмжээнд хүрч чадах хүнийг олж чадахгүй болмогц өөртөө дутуу санагдаж, бусдад зовлонтой байгаагаа нээхээс айж, өөртөө үл итгэх ертөнцөд ухран ордог. Энэ нь бусдын юу хүсэж байгааг мэдэх бололцоог бүрхэгдүүлж, хайрлах чадвар багасан, ханиа олоход улам бүр хэцүү болдог.

Ээж биднийг нялх байхад сүүгээрээ биеийг өсгөн бойжуулж, хайраараа сэтгэлийг тэжээсэн. Аажмаар хөхнөөс гардаг боловч ээжийнхээ элэг зүрхнээс гараагүй байдаг, тэгээд том болох тусам бие даах хэрэгцээг мэдэрч эхийн анхаарлаас өөрсдийгөө тусгаарладаг. Бид эхийн хайрыг хүсдэг хирнээ түүний бидэнд тавьж байгаа шаардлага, хүүхэд шиг болгож байгаад дургүйцдэг. Шинээр хүмүүстэй танилцахдаа тохиолдох бэрхшээлд тэр байтугай эхийгээ буруутгадаг том хүмүүс олон байдаг. Тэдний зарим нь-зөв. Жинхэнэ бэрхшээл бол ээжээсээ урьд өмнө авдаг байсан хайр, сайшаагдах, үнэлэлт авахыг хүсэж байгаад юм. Өөрийн хүсэж байгаа эхийн хайрыг авах нарийн, сэтгэлзүйн шаардлагыг эхнэр, нөхөртөө тохоодог боловч энэхүү шахалтаас эсрэг үр дүн гардаг. Бусдаас хайр хичнээн шаардах тусам төдийчинээ тэд хайраа буруулж, биднээс холддог.

Хайрыг хүссэн үед “Би чамд сэтгэлтэй” гэдэг үгсийг сонсвол аз жаргалын дээд туйлд хүрч, “чамд сэтгэлтэй биш болсон” гэж хэлбэл туйлын их гутарч, тэр ч байтугай амиа хорлох, хүн алахад хүрнэ. Ганцаардлын зовлон нь өөрийгөө хөөрхийлөх гүн худаг болж, түүнээс гарах ганц зам бол бид хайрыг хүсэж байгаа шиг бусад ч гэсэн хүсэж байгаа, тиймээс авах биш өгөх үүргийг өөртөө авах юм. Бусдын хайрыг үгүйсгэ гэж хэлж байгаа биш, миний санаа бол өөрийнхөө тухай бодохоо орхиж, гагцхүү бусдад хэрэгтэй зүйлийн тухай бодож, хайраас хамааралтай байхаа болих тухай юм.

Хачирхалтай нь, бусдыг хариу нэхэлгүйгээр хайрласнаар бусад хүмүүс бүр ч илүүгээр таныг хайрлаж, сайшааж, үнэлдэг. Тиймээс ганцаардлыг анагаагч нь бусдыг явцуу биш, шаардлага тавилгүйгээр хайрлах юм. Энэ бол амархан. Зүгээр л юу үйлдэж, юу хэлбэл бусдыг баярлуулах бол гэдгийг бодоод, түүнийг л үйлд. Хэрвээ үүнийг том хүмүүстэй хэрэгжүүлэхэд хэцүү байвал хүүхдүүдэд хайраа өгч болно. Тэнгэрийн залуу охид ч хайрлуулах хэрэгтэй байдаг.

Өглигч сэтгэл

Голландад нэг эмэгтэй арван мянган ам.доллар бүхий дугтуй олсон тухай би саяхан сонссон юм. Гээгдсэн эд хөрөнгийн газар нь тушаан өгөхөд эзэн нь мөнгөө авсан бөгөөд тэр шударга эмэгтэй хариуд нь шагналын мөнгө авахыг хүсээгүй аж. Дараа долоо хоногт тэр эмэгтэй нэг сая ам.долларын сугалаа хожжээ.

Надад тохиолдсон нэгэн явдал түүнийх шиг тийм онцгой биш боловч төстэй юм. Бурханы шашиныг ихэд сонирхож эхэлж байсан тэр үед нэг удаа дэлгүүрээс гарахдаа таван доллар надад илүү хариулж өгснийг мэдэв. Хамт явсан найз маань: “Наадахаа өөртөө ав” гэлээ. Хэлснийг нь дагах гэсэн боловч тэр дөнгөж сая шоронгоос гарсаныг санахаас гадна “Бурханы шашинд үнэхээр сонирхож байгаа бол би энэ мөнгийг эргүүлж өгөх ёстой” гэж бодлоо.

Дэлгүүрт буцаж ороод байдлыг худалдагчид хэллээ. Гэтэл тэр: ”Өө, тийм үү? Би өөрийн тэнэгээсээ болж тэгсэн юм чинь чи ав даа” гэв. Энэ явдал надад болон миний найзад анхны сургамж боллоо.

Бурханы шашины тухай бага зэрэг мэддэг болоод одоо бодоход, шалтгаан үгүй бол ямар нэг зүйл тохиолдохгүй гэдэг нь маш тодорхой юм. Зүгээр л нэг аз таарч, ямар ч урьдал шалтгаангүйгээр сайн, муу зүйл тохиолдохгүй. Халуун зуны өдөр сэрүүн салхи үлээхэд жаргалтай болохоос эхлээд хүний төсөөлж чадах хамгийн дээд аз жаргал хүртэл, зүүгээр хатгах төдий зовлонгоос эхлээд галт уулын дэлбэрэлтэд амьдаараа шатах хүртэл энэ бүхэнд сэтгэлд заавал хоёр шалтгаан байх ёстой. Эхнийх нь тэргүүн шалтгаан буюу сэтгэлийн маань урьд насны эзэн бусдад санаатайгаар сайн, муу үйл үйлдсэнээс урьд насны сэтгэлд үлдсэн үйлийн чадамж юм. (Тийм. Таны сэтгэл хуучин. Таны амьдрал төгсөхөд дараа нь шилжүүлэх учраас сайн харж хамгаалж байгаарай).

Жаргал, зовлонтой холбох хоёр дахь зүйл бол сэтгэлийн хандлага байдаг. Жишээлбэл, хэрвээ бид өглигч бол энэхүү өглигч байдал нь өглөг үйлдсэн үйлийн чадамж боловсрох зохимжтой суурь болдог. Хорин харамч хүн гудамжаар явахдаа газар байгаа арван долларын дэвсгэртийг харахгүй өнгөрнө, харин нэг өглөгч хүн явж байвал тэр “азтан” болж, мөнгийг олж харна. Сэтгэлд боловсорч байгаа үйлийн чадамж ямар нэг байдлаар газар байгаа мөнгийг харах байдалтай холбож өгдөг. Чухам яаж ийм ид шид болдогийг одоохондоо би хэлж чадахгүй. Гэхдээ мэдэхийн төлөө мэрийж байна.

Жинхэнэ Бурханы шашинтан байна гэдэг бол мөнгийг өөрийн гэж тооцохын өмнө эхлээд эзнийг нь тодруулахын тулд сайтар хичээх хэрэгтэй. Бурхан багшийн зөвлөснөөр энэ тохиолдолд, дөрвөн зүг ээлжлэн: ”Энэ мөнгөний эзэн байна уу?” гэж хашгирна. Хэн ч хариулахгүй бол тэр мөнгийг өөрийн болгоход хулгай хийсэн үйл болохгүй. Орчин үед гээгдсэн эд зүйлийг олж өгөх тусгай газар аваачиж өгвөл зохино, тийм биз?

1979 онд Австралийн баруун эрэг орчим суудаг хоёр залуу, Ламтан Зопа Ринбүүчий болон Түвдэн Ешэ багш ламтан нарын Австралийн зүүн эрэг орчим Мельбурн хотод зочлох гэж буй сургийг сонсжээ. Тэд лам багш нартай уулзахыг туйлын их хүсэж байсан ч тэр газар хүрэх мөнгөгүй байжээ. Тэдний нэг нь амьдардаг хуучин байшингийнхаа цэцэрлэгт нүх малтаж

байх зуураа лам нартай яаж уулздаг юм билээгэж бодож байж. Гэтэл түүний хүрз зэвэрсэн лаазан савыг цохиж тулахад түүн дотор хоёр найз Мельбурн хүртэл автобусаар явахад хангалттай мөнгө байжээ. Тэр байшингийн хуучин эзэн нь хамаатан садангүй ганцаар суудаг зожиг хүн байж. Тэр хоёр залуугийн нэг нь хувраг болж нөгөө эрэгтэй болон түүний эхнэр хоёулаа Бурханы шашины бишрэлтэн нар болжээ. Энэ бол үйл хэрхэн ажилладагийг харуулж байгаа юм.

Сөрөг талаас, хэрвээ бид ууртай, хэн нэгнийг доромжлох, гомдоох хүсэл үүсгэсэн юмуу сэтгэл дургүйцлээр дүүрэн байх үед эдгээр хандлагуудаар урьд нь хэн нэгнийг хорлосон үйлийг эдлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Нохойд хазуулах юмуу гудамжинд согтуу танхай хүнд зодуулах байх. Амьдралд тохиолдож байгаа юм бүхэн үйл хийгээд сэтгэлийн хандлагын илэрхийлэл байдаг.

Та бүхэн бүгдээрээ баян болох хүсэлтэй гэдгийг би мэднэ, хүн төрөлхтөний уралдаанд тавтай морил, гэтэл чиний сэтгэлийн өмнөх эзэд хомхой харамч байсан бол бууж өгсөн нь дээр. Баян болох үйлийн чадамжийг бүтээгээгүй бол ямар ч бололцоогүй, энэ насны үйл энэ насанд боловсрох нь ховор. Гэхдээ бүү цөхрөөрэй, баян болох үйлийн чадамж хаа нэгтээ булагдсан байж магад. Миний нэг найз бизнесменүүдэд зориулсан ашиг олох тухай лекц уншихдаа “Мөнгө олох эхний алхам бол эхлээд мөнгийг бусдад өг” гэж хэлж байлаа. Боловсрох өглигийн үйл байхгүй байлаа ч гэсэн таны хүчин чармайлт хий дэмий үрэгдэхгүй. Та өглиг үйлдсэнээр таны сэтгэлийг хойд насанд авах хүний хувьд баян байх шалтгаан болно. Тэгэхлээр та өөрийн урьд төрлийн хүмүүсийг арай илүү өглигч байсан байгаасай гэж бодохгүй байна уу?

Монгол хүмүүс гуйлгачинд хоол, мөнгө өгөх юмуу тэр байтугай хувцасаа өгж болохгүй, буянаа ингэж өгөөд байвал өөрөө өлсгөлөн, ядуу болдог гэдэгт үнэмшдэг. Энэ бол цэвэр мухар сохор сүжиг бөгөөд би-г эрхэмлэх үзэл юм. Бусдыг зовлонгоос нь гаргах чин бодлоор өглөг үйлдэх нь зөвхөн сайн үр дагаварыг бий болгоно.

Харамч байх нь бусдаас хөндийрүүлж, золгүй амьдралыг бий болгодог сэтгэлийн зовлон юм. Харамын эсрэг нь өглигч бөгөөд энэ нь бусдад өгөх хүсэл, бусдад тусалснаараа өөрөө жаргал авах юм. Бусдын хүслийг биелүүлснээр сэтгэл асар их хангалуун болдог. Өглөг нь зөвхөн эд зүйл, тухайлбал, ядууст мөнгө, өлссөнд хоол, гэр оронгүйд орон байр өгөх зэргээр хязгаарлагдахгүй. Мөн мөлжигдөж, дарлуулж байгаа хүнийг улс төрийн эрх мэдэл болон нийгмийн өмгөөллөөр хамгаалах аюулгүйн өглиг байдаг. Өглигийн хамгийн дээд хэлбэр нь ёс суртахуун, нүглийн үйлийг тэвчих, буяны үйлийг арвин болгох, энэрэнгүй, билиг ухаан зэрэг зөв сэтгэлийн хандлагыг дадуулан хураах зэргийг заан, бусдыг аз жаргалд хөтлөх явдал юм.

Эцэст нь, хайрлалын өглиг байдаг. Мөнгөгүй, хоолгүй, бусдыг хамгаалах улс төрийн эрх мэдэл, нөлөөгүй байлаа ч гэсэн хязгааргүй их хайрлалыг хүртээж чадах бололцоотой билээ.

Ёс зүй

Бурханы номд хамгийн хүнд нүгэл бол эхийн амийг хороох хэмээн өгүүлснийг эртний Энэтхэгийн нэг шастарт дурьдаад, “Хэрвээ нэг эмэгтэйн савнаас нөгөө эмэгтэйн саванд эсийг шилжүүлэхэд гарсан хүүхэд төрүүлсэн эхээ хороовол энэ нь эхийгээ алсан нүгэлт үйл бас болох уу?” хэмээн төсөөлсөн асуулт тавьжээ.

“Энэ бол хүнд нүгэл, гэхдээ энэ нь өөрийн эхийг алсан үйл биш. Гагцхүү өндгөн эсээ өгсөн эхийг албал хамгийн их хүнд нүгэл болно” гэж дээрхи шастар хариулсан байна.

Энэ асуулт, хариулт нь өнөөгийн анагаах ухаан, хууль зүйн чухал асуудлыг хөндөөд зогсохгүй, барууны хүмүүсийн сохроор боддог мэдлэгийн эх өлгий гэгдэх Европоос өмнө Энэтхэгт орчин үеийн эмэгтэйчүүдийн эх барих шинжлэх ухааны өмнөх аргууд аль эрт байсныг харуулж байгаа юм.

Өндгөн эс болон умайн тухай үргэлжлүүлэн ярихад, урьд төрлөөс дамжин ирдэг ухамсарын урсгал нь үр тогтох дөхсөн үед өндгөн эстэй нийлдэг. Хэдийгээр эхний хорин таван долоо хоногийн турш сэтгэл гүн нойрсолтын байдалд байх боловч түүний нарийн хөдөлгөөн нь үр хөврөлийн боловсролтод чухал байр суурьтай. Тиймээс хойд төрөл есөн сарын дараа биш үр тогтсоноос эхэлдэг, ингээд зориудаар үр хөврөл буюу ургийг хөндөнө гэдэг бол хүний амийг хөнөөж буй үйл болно. Үр тогтсон өндгөн эс, үр хөврөл нь сэтгэлгүй, олон энгийн эсийн бүрдэл гэж үзэх нь эндүүрэл. Хэдийгээр хүсээгүй жирэмслэлттэй тулгарсан бүх эмэгтэйчүүд сонголт байдаггүй ч гэсэн, хэрэв сонголт байдаг сан бол ухаалаг шийдвэр гаргахын тулд тэрээр бүх мэдээлэлтэй байх эрхтэй.

Эмнэлгийн үрийн шинжилгээний гуурсан дахь үр тогтсон өндгөн эсэд ухамсарын урсгал амжиж орсон, ороогүйгээс хамааран хүн мөн эсэх нь тодорхойлогдоно. Хэрвээ сэтгэл ороогүй бол өндгөн эсийг устгах нь хүн алсан үйл болохгүй. Дээр өгүүлсэн эртний номд үүний талаар дурьдаагүй боловч үр тогтсон өндгөн эсийг эхийн умайд оршихоос нааш сэтгэлийн урсгал түүнд ордоггүй болов уу гэж би бодож байна.

Эхний бөгөөд ганцхан удаа радио ярилцлагын нэвтрүүлэгт утасдаж үзсэн тэр үед үр хөндөлтийн тухай сэдэв ярьж байлаа. Нэвтрүүлэгч хүн нь урьд нь Христос шашины номлогч байсан бөгөөд би үр хөндөлтийн тухай санаа бодлоо эмч хүнийхээ хувьд болон цаашдын мэдлэг, туршлагын хувьд өөрчлөгдсөн гэдгийг хэлэхэд нэвтрүүлэгч анхааралтай сонсож байлаа. Гэхдээ Буддист болсон тухайгаа хэлэхэд тэрээр шууд намайг тасалж, уг ярилцлагад шашины тухай ярих ёсгүй гэж хэлээд түүгээр яриа маань дуусаж билээ. Миний хэлэх гэсэн санаа бол шинжлэх ухааны болон эмч хүний хувьд хойд төрлийн тухай Бурханы сургаалийг суралцаж, эргэцүүлснээр ургийн хөгжлөөс эхлээд сэтгэлийн зовиураас үүсдэг өвчин болон сэтгэл судлал хүртэл олон сэдэвт зүйлсийн талаарх ойлголтыг улам өргөжүүлж өгсөн юм. Би Бурханы сургаалийг буруу гэж баталж чадахгүй байлаа. Буруу гэж нотлохыг оролдсон гэдэгт итгээрэй, яагаад гэвэл Лам багш нарын айлдсан бясалгалын эхний хичээлд сууж байхдаа би, хэрвээ Бурханы шашин үнэн бол би хувраг болох ёстой гэж бодож байлаа, энэ бол миний амьдралдаа хийхийг хүссэн хамгийн сүүлийн зүйл байлаа.

Үйлийн үрийн тухай Бурханы сургааль бол бидний амьдралд тохиолдож байгаа бүхний цаад нарийн шалтгаан ба үр дагаварын тухай дүрслэл юм. Сургааль нь хувь хүнд чиглэн, зовлонгийн жинхэнэ шалтгааныг ойлгож, тэдгээрийг хэрхэн даван туулах тухай юм. Энэ бол нийгэмд дэг журам тогтоох ёс суртахууны нээлт биш юм. Бурхан багш ертөнцийн өмнө гарч зогсоод үнэнийг оллоо хэмээн айлдах зоригтой байсан бөгөөд энэрэнгүй сэтгэлийн эрхээр дөчин жилийн турш сэтгэлийн мөн чанарын тухай ном айлдаж, бүх зовлонгийн цаана байх гол мунхаглал, үйлээр дамжуулан мунхаглал нь хэрхэн зовлонд хүргэдэг зэргийг тайлбарлажээ. Түүний сургааль цаг хугацааны хийгээд нэг соёлоос нөгөө соёлд, нэг хэлнээс нөгөө хэлд хөрвөн төлөвших шалгуурыг олон удаа даван туулсан юм. Бурхан багшийн үйлийн үр хэмээн нэрлэсэн шалтгаан ба үр дагаварын тогтолцооны цаана ямар нэгэн дээд тэнгэрийн зорилго байхгүй, мунхаглал нь сэтгэлийн ердийн байдал бөгөөд материйн ердийн байдал таталцах хүчтэй байдаг адил юм.

“Одоо та нар мэдэж авлаа. Мэдсэн эрдмээрээ өөрийн төлөв зангаа номхотгон засах уу, үгүй юу гэдэг та нарын өөрсдийн л шийдэх зүйл” хэмээн Бурхан багш эцэст нь айлджээ.

Мунхаг сэтгэлийн эрхээр аливаа муу үйл үйлдэж байгаа хүмүүсийг бид энэрэх ёстой юм. Үр хөндөлтийг дэмждэг нэг хэсэг, эсэргүүцдэг нөгөө хэсэг хүмүүсийн аль аль нь тэнэгийн жишээ юм. Амьтны туршилтыг эсэргүүцдэг хоёр хүнтэй уулзах үед хойд төрлийн тухай яриа өрнөснийг санагдуулж байна.

“Амьтнаар туршилт хийдэг эрдэмтдийг та нар үзэн ядаад хэрэггүй, туршилт хийснийхээ хариуд тэд лабораторид туршилтын туулай болоод төрж магадгүй шүү дээ” гэж би хэлсэн юм.

“Тийм байгаасай” гэж тэр хоёр нэгэн дуугаар хэлэв.

Ингэж хэлэхэд нь бага зэрэг дургүй хүрч,

“Та нарын их хайрлаад байгаа тэр амьтад чинь урьд төрөлдөө амьтны туршилт хийдэг эрдэмтэд байж болохыг ойлгохгүй байна уу” гэсэн юм.

Бие нь цаашид сэтгэлээ агуулж дийлэхгүй болж, голдуу амьсгал зогссоны дараа сэтгэл биеийг орхин гарахад амьдралын өөр төгсгөл буюу үхэл болно. Биеийн үйл ажиллагааг хиймлээр хэвийн байлгах амьдруулагч машиныг унтраах нь амь таслах үйл биш, учир нь тухайн хүний үхэл өөрийн жамаар ирж буй бөлгөө. Хиймлээр амьдруулагч машинтай холбогдоогүй хүнд өвчтэй юмуу үхэж байгаа хүнийг санаатайгаар үхэлд хүргэвэл, хэдийгээр зовлонгүй болгох энэрэнгүй бодолтой байлаа ч гэсэн, хэрвээ хамгийн зөв үйл хэмээх бодол сэдэлд багтсан бол амь тасалсан үйл болно. Ийнхүү амь таслах нь хамгийн зөв үйл хэмээх голдуу мунхаг үзлээр өдөөгдсөн учраас тэр юм. Яагаад зөв үйл болж чадахгүй байна вэ гэвэл цагаасаа өмнө үхсэнээр хэн нэгнийг санаандгүй байдлаар маш аймшигтай газар хойд төрөл авахуулах болно, харин арай удаан амьдраад үхэхэд үйлээ эдэлж барах ба хойд төрөл нь арай таатай газар байх болох байсан. Далдыг харах эрдэм төгс бясалгаач нар л хүний хойд төрөл сайн, муугийн аль төрөлд чиглэж байгааг мэддэг.

Үхэж байгаа хүнд туслах шилдэг арга бол эргэн тойронд нь асрал хайрын уур амьсгал бий болгох, сэтгэлийнх нь тодорхой чанарыг эвдэлгүйгээр биеийн зовиурыг аль болохоор

намдаах, зовнил шаналалыг нь ухаалаг зөвлөгчийн үгээр тайтгаруулах зэрэг юм. Хойд төрөлд шилжих явцыг төвөггүй болгох олон янзын бясалгалын аргыг үхэж байгаа болон түүний ар гэрийнхэн сурч болно. Одоо тэдгээр аргыг сурах цаг нь даруй мөн бөгөөд үхлийн орон дээр сурна гэвэл хэт хожимдсон хэрэг болно.

Би яагаад үүнийг үйлдэж байна вэ?

Миний үед тогтсон хэмнэлд итгэдэггүй байлаа. Залуу байхдаа бүтэхгүй юм болгонд ихэнхдээ нийгмийг буруутгаж, дураараа амьдрах эрх чөлөөтэй хувь хүн байгаадаа бардам байлаа. Толгойноосоо илүү элэг зүрхээ дагах дуртай байлаа, ялангуяа, ердийн байдлаас эсрэг үйлдэлд. Нэг хэсэгтээ би азтай байлаа, дараа нь бүтэн тонн туйлуу толгой дээр буусан юм шиг амьдрал намайг цохиод авахад зүрхэндээ итгэх итгэлээ алдлаа. Англид хоёр жил болсоны дараа Мельбурнд буцаж ирэхэд давхар хүнд цохилтонд орлоо: найз бүсгүйтэйгээ таарахгүй болж, ээж маань гэнэт нас барлаа. Бурханы шашин надад юм бүхнийг хэвийн байдалд буцаан зохицуулахад тусалж, өөрийн үнэн мөн чанараа мэдээгүй байгаа цагт жаргалд хүрч, зовлонгүй байхад толгойдоо ч, элэг зүрхэндээ ч бүрэн итгэж болохгүй гэдгийг ойлгуулсан юм.

Үүнийг энгийнээр хэлбэл, амиа бодсон зан байдал нь зовлонд хүргэнэ, бусдын төлөө сайхан санаа тавин үйлдсэн үйлүүд жаргалд хөтөлдөг. Тиймээс, амьдралд бүдэрч унахаас зайлсхийхийн тулд амиа бодохоо орхих хэрэгтэй. Энэ нь тийм ч амар биш. Амиа бодох үзлийг бүрэн дарах нь гагцхүү бидний өөрсдийн бодсон би-г хоосон гэдгийг оносон билиг ухаанд хүрсэн үед гүйцэлдэнэ. Тийм билиг ухаанд хүрэх хүртэл өөрийн зан байдлын цаад санааны амиа бодохыг сэрэмжээр хаах хэрэгтэй. Аливаа үйлийн өмнө түр азнаж, “Би яагаад үүнийг үйлдэж байна вэ?” хэмээх асуултыг өөрөөсөө асуух ёстой.

Хүний зан байдал нь “байгаль болон боловсролт”-оос буюу амьдралд генийн бүрдэл болон орчин нөлөөлдөг гэсэн үг юм. Бурханы сургаалд, зан байдалд нөлөөлдөг гурав дахь чухал хүчин зүйл буюу урьд төрлүүдээс залгамжлан авсан сэтгэлзүйн болон үйлийн дуршилт хандлагыг тайлбарладаг. Эдгээр дуршилын хандлагуудаар өөрсдийн тухай тогтсон тодорхойлолттой төрдөг бөгөөд байгаль ба боловсролт нь хэдийнэ урьд байгаа зүйлсэд тохируулга төдийг хийдэг. Тиймээс бид ямар зан байдалтай байх болон хэрхэн амьдрах нь зайлшгүй өөрчлөгдөж болох бөгөөд үүрд хөдөлгөөнгүй байдаг гантиган баримал биш. Генээ хянаж чадахгүй, одоохондоо чадахгүй ч, бүтээлч орчны нөлөөлөл болон сэтгэлзүйн хандлагыг сонгон авч, тэдгээрийн хөнөөлтэй эсрэг талыг орхих замаар зан байдал, төлөвөө өөрчилж болно.

Зан байдлыг сайжруулах бололцоо нь ялган шинжлэх оюуны чанар буюу сэжигээс ангид мэдлэгээр олгогдоно. Зан байдалтай холбоотойгоор, түүнийг ялгах оюун хэмээдэг нь амьдралдаа болж байгаа бүхнийг шинжилснээр өөрт болон бусдад жаргал өгөх талаас зөв, буруу үйлийн хооронд ялгаа салгаа гаргаж ойлгоно гэсэн үг юм. Бүх шашинууд үндсэндээ адилхан ёс суртахууныг айлддаг ба хэдийгээр бид Мосэс, Христ, Бурхан багшид онолын хувьд итгэж байгаа ч гэсэн энэхүү шинжилгээгээр олж авч байгаа ёс суртахууны мэдлэг нь бидний өөрсдийнх байдаг.

Ёс суртахууны далд зарчмыг ойлгоно гэдэг нэг хэрэг, тэдгээрийг дагах өөр хэрэг. Энэ нь дотоод болон үүсмэл амиа бодох, шунал, уур зэрэг зуршилт хандлагаа шууд эсэргүүцэх ёстой болдог учраас их хэцүү байдаг. Энэ үед сүсэг бишрэл хэрэгтэй болно. Өөрийн багш хөтлөгчийн санаа ариун гэдэгт итгэх, гэгээрэх зорилтдоо хүрч чадна гэдэгт өөртөө итгэх итгэл ёс суртахууны зан байдлыг сонгох, сэтгэлд үүсдэг нүглийн түлхэцийг эсэргүүцэх зориг

ба шийдвэрийг өгдөг. Сүсэг бишрэл ба ёс суртахуун нь зовлонгоос гэтлэх зам мөрийн суурь болдог.

Ерөнхийдөө, үйлийг үйлдэх санаа буюу түлхэц импульс нь нэг бол тэнэг эсвэл ухаалаг байдаг. Тэнэг санаа алдаатай итгэл үнэмшлээс гардаг. Эр хүний шинж, нэр төрийн хэрэг хэмээх итгэл үнэмшлээр архи хэтрүүлэн уух нь тэнэг санаанаас гарсан зан байдлын жишээ юм. Согтууран хөлчүүрхэхийн тулд хүсэл шуналаар архи хэтрүүлэн уух нь дээдийн жаргал гэж бодох нь мөн тэнэглэл юм. Өнөө орой болох гэж байсан үдэшлэгийг тань болиулаагүй байх гэж найдаж байна, гэхдээ бид бодит байдалтай тулах нь зүйтэй гэж бодож байна, тийм үү? Амьдралд тэнэг санааны олон жишээ бий.

Ухаалаг санаа бодол нь ариун ёс суртахуун, сайхан сэтгэл, юмсын харьцангуй ба туйлын мөн чанарыг ойлгох билиг ухаанаас үүдэлтэй. Бурханы номын хувьд, харьцангуй билиг ухаан нь бидний эргэн тойрны юмсын өөрчлөгдөн хувирах мөн чанарыг ойлгох ойлголтыг багтаадаг. Хүн бүр, юм бүхэн урьдаас баталгаатай төлөвлөсөн тогтсон ертөнц хэмээн бодох буруу үзлийг баримтлахгүй байснаар илүү тайван байж, өөрчлөлтөнд зохицох чадвартай болно. Харьцангуй билиг ухаан бас үйл ба муу сэтгэлийн эрхээр үүссэн бүхэн үл ханах мөн чанартайг ойлгох ойлголтыг багтаадаг. Бидний бие, сэтгэл, гадаад орчныг төгс бус байдал жолооддог. Одоогийн байгаа байдалдаа баясаж, бүтэлгүйтэх бүрт цухалдсандаа үсээ үстэж зулгаахгүй бол хамт амьдрахад илүү амар хялбар болно. Харин туйлын билиг ухаантай тэдгээр хүмүүс юмсыг өөрөөсөө бүтэж оршихгүйг ойлгодог. Энэхүү билиг ухаан нь бидний ухааныг гүйцээж, амьдралдаа хяналттай болоход тусалдаг. Сэтгэлд хариу нэхээгүй хайр, тэвчээр, энэрэнгүй байх цагт хэзээд ухаалаг бодол санаатай байдаг. Эдгээр хандлага байгаа цагт зүрх сэтгэлдээ итгэж болно.

Хүмүүсийн ойрын дотно харьцаа өөрчлөгдөн хувирах шинжтэй гэдгийг мэдэж байвал өчүүхэн шүүмжлэл, цухалдал, уураас болж нэг нэгнээсээ мэдрэх аз жаргалаа хэрхэн бусниулах билээ? Гоё цэцэг удалгүй гундан хогын саванд хаягдана гэдгийг мэдэж байгаа, гэхдээ гоё байгаа үед нь түүнд хамгийн их зөөлөн, анхааралтай ханддаг шүү дээ. Тэгвэл яагаад найз нөхөд, хамт байдаг хүмүүстэй ийм байдлаар харьцаж болохгүй гэж? Тэд биднийг гомдоосон учраас тэднийг гомдоож, хаях ёстой гэж үзвэл буруутан нь бид л байх болно, тэд биш. Бид хэтэрхий ихийг хүлээж найддаг, төгс бус ертөнцөд төгсийг хүсдэг.

Аливаа үйлийг үйлдэхийн цаад санаа ямар байдаг вэ? Амьдралын үндсэн хэрэгцээ нь бүхний хувьд жаргалыг хүсэж, зовлонг үл хүсдэгээрээ адил. Эдгээр хэрэгцээг дагах үед бидний зан байдал дахь олон өөр нөлөөллүүдээс бий болох сэтгэлзүйн зөрчилтэй тулгарч болдог. Ойлголтын түвшинд, нийгмийн ёс суртахууны хэм хэмжээг баримталж амьдрахыг хичээх боловч урьдын төрлүүдийн ёс суртахуунгүй зан байдлаас хамааран тэдгээр хэм хэмжээг зөрчих зөн совингийн хүчлэлтэй байдаг. Эсвэл хулгайч нарын гэр бүлд төрсөн байж болох ба урьд төрлүүддээ үнэнч шударга байснаараа зөн совингоороо гэр бүлийнхээ тогтсон уламжлалыг эвдэн, хулгайгүй амьдрах хүчлэл үүсдэг. Нөгөө талаас, нийгмийн зөв ёс суртахууны хэм хэмжээг баримтлах хүсэл нь урьд төрлүүдийн зөн совингийн хүчлэлээр улам батжиж болох бөгөөд энэ тохиолдолд жаргалаас жаргалд дамжин амьдарна. Харин хулгай хийх зөн совингийн хүчлэл нь хулгайч муу нөхөдтэй нийлэхэд улам батжидаг.

Тэнэг ба ухаалаг байх хоёр хүчлэлийн хоорондох ялгааг таних аргагүй бол чөлөөтэй байх

бололцоогүй. Мунхаглалын нөлөөн доор тоолшгүй олон урьд төрлүүдэд бидний сэтгэлд гүн суусан, хамгаас хүчтэй би-г эрхэмлэх, уурлах, шунах зэрэг сэтгэлийн хүчлэлийг дагахаас зайлсхийж чаддаггүй.

Бусдыг хорлохгүй байх ёс суртахууныг мөрдлөгө болгох нь зовлонгоос ангижрах эхний алхам юм. “Би яагаад үүнийг үйлдэж байна вэ?” гэдэг асуултыг тавихад сонголт болдог. Хэрвээ тухайн үйл бусдад туслахаас илүү өөрийн амийг бодсон байвал, түүнийг болих хэрэгтэй. Хэрвээ бусдад илүү тустай бол үйлдэх хэрэгтэй. Энэхүү бусдад туслах санаа зорилго төгс төвлөрөл болон өөрсдийн болон ертөнцийн юмсын харьцангуй болон туйлын бодит чанарыг ойлгосон билиг ухаантай хосолсон байвал амьдралдаа эрх чөлөөтэй болно. Санаа зорилгын ариун байдлыг зөн совингийн хүчлэл хэзээ ч бүрхэгдүүлж чадахгүй. Бидний санаа бодол чөлөөтэй байх болно.

Ариусал

Зигмунд Фрейд, хүн сэтгэл хөдлөл, сэтгэлийн гэнэтийн цочирдлоо илэрхийлэхгүй дарснаар урт хугацааны дараа хор уршигтай байдаг гэдгийг баталснаас хойш өөрийгөө илэрхийлэх нь нийтийн сэтгэл зүйд хүчтэй дэлгэрэн, хүн бүрийн салшгүй эрх дарх болж, чөлөөтэй, эрүүл нийгмийн баталгаа болсон юм. Энэ нь хир зэрэг үнэний хувьтай болохыг энд хөндөхөөсөө илүү Бурханы шашины байр суурь болох сэтгэлийн хямралаас тайтгарах шилдэг арга бол муу сэтгэлийн хөдлөл болон гэнэтийн цочирдлыг илэрхийлэх болон дарахаас илүү тэдгээрийг ариусгах тухай өгүүлэхийг хүсэж байна.

Амстердамд байдаг “Шинэ үе” хөдөлгөөний төрсөн газар, Далайн хав шүтэгчдийн газар гэж миний нэрлэх дуртай, Сансарын төвийн байранд миний лам багш, Ешэ багш сэтгэлийн хөдөлгөөнийг хянах тухай ном айлдаж байлаа. Доод давхрын өрөөнөөс хоолойгоо хүчлэн шахсан дуу чимээ гарахад гайхсан багш юу болж байгааг асуусан юм. Цемэнтээр хийсэн өрөөнд хүмүүс нүцгэлэн нэг нэгэндээ чанга дуугаар орилж хашгиран, хараал урсгаж, баас шидэж, (дараа нь шүршүүрээр цэвэрлэж болдог), муу муухай үгээр дайрах замаар эмчилгээ хийлгэж байгаа хэсэг хүмүүс болохыг нэг нь ичингүйрэн тайлбарлаж өгсөн юм.

“Тийм үү?” гэж нэлээд гайхаж, хөмсгөө дээш өргөн, нүдээ хөгжилтэй бүлтийлгэн асуусан миний багшийн байдал Бурханы шашин болоод шинэ үеийн сэтгэл судлалын хооронд асар их ялгааг илэрхийлж байлаа.

Амьдралын болон хүмүүс хоорондын харилцааны маш олон шийдээгүй асуудлууд гутрал, гэмшил, дургүйцэл болон тэдгээрийг бодох бүрт дахин шинээр зовох байнгын шалтгаан болдог. Эдгээр муу дурсамжаас зайлсхийхийн тулд үгүйсгэх юмуу дарах сэтгэцийн арга заль хэрэглэдэг боловч ихэнхдээ шууд танин мэдэхүйд тэдгээр нь хамгийн ойр байдаг. Иймэрхүү байсаар сэтгэлээ илэрхийлэх эрх чөлөөгүй болдог. Гэрийн оройн хоолны ширээний яриа нь тэр чигтээ сэтгэл хөдлөлийн тэсрэлт болон нөгөө хуучин маргааныг үүсгэхгүйн тулд тодорхой сэдвүүдээс болгоомжлон зайлсхийх талбар болдог. Өөрийнхөө амьдралыг жинхэнээсээ илүү сайхан гэдэг хуурамч байдал үзүүлэх байдлаар амьдрал маань хагас дутуу үнэн болж, хүсээгүй нөхцөл байдалд ороход түүнээс гарах өөр сонголтыг олж хардаггүй.

Ешэ лам багш маань хэлдэг шиг, тэгээд сэтгэлзүйн хогоо яах вэ? Өөрийгөө зөвтгөх нь үр дүнгүй, өөрийн сэтгэлд маргааныг дахин сэдрээж өөрийн зөв, бусдын буруу байсанд олон дахин итгэхийг хүссэнээр дуусдаг. Тэгээд ч дайснууддаа тодорхой учир шалтгаантайгаар хэлэхэд тэд ойлгохгүй, харин ч учир шалтгаан хэлэх нь улам уурлуулдаг.

Бид бусдыг өөрчилж чадахгүй, тэгэхлээр өөрийнхөө сэтгэлийг анхаарахаас өөр сонголтгүй болж байна. Сэтгэлээ ариусгах тухай асуудал бол нийтээр хүлээн зөвшөөрсөн асуудал юм. Ариун голын усанд далдлагдаж орохоос эхлээд наманчлах хүртэл, Японд насанд хүрсэнийг тэмдэглэх заншил ёсоор хөлдүү хүйтэн усанд орж сэтгэлээ ариусгах хүртэл соёл бүр өөрийн ариусах аргатай ба ихэнх нь эргэлзээтэй үр дүнтэй. Би хиппи байхдаа хөлөн дээр нь үрэвссэн шархаа эмчлүүлэхээс татгалзаж, өдөр бүр шархнаас их хэмжээгээр гарах идээг “гайхамшигт ариусал” гэж үзэж байсан нэг охинтой таарч билээ. Хэдийгээр тэр их сургууль төгссөн боловч, Шинэ үеийн үзэлтэй, антибиотик бол хор, сайн цагаан хоолны дэглэм

баривал бие өөрийгөө эдгээнэ гэсэн онолд итгэдэг байжээ. Эцэст нь, үрэвсэл ясанд тулж, хөлөө алдах шахсан юм.

Өөрийн хэцүү байдлын талыг нээлттэй судалснаар гэмших, дургүйцэх дарамтнаас чөлөөлөгдөх бололцоотой. Шалтгааныг нь олсноор юуг ариусгах хэрэгтэйг мэдэж авах бөгөөд түүний ерөндөгийг хайна. Хэрвээ асуудлыг шинжилж байх зуур бидний өөрсдийн алдаа байсан бол тэр нь амиа бодох, уур, шуналын муу сэтгэлүүдээс үүдсэн байдаг. Өөрийг буруутайд тооцох шалтгаан байхгүй болно, учир нь, алдаа нь тэдгээр муу сэтгэлд байдаг. Хэдийгээр бусад буруутай байлаа ч гэсэн бидний зүгээс бардамнал юмуу атаархал байсан учраас тухайн байдлыг үүсгэх юмуу улам дордуулсан гэдгийг ойлгосноор дургүйцлийг зогсоож болно. Наад зах нь, үйлийн ул мөр сэтгэлд байснаас тухайн байдлыг нөхцөлдүүлсэн байдаг. Биднийг хорлосон тэд ч гэсэн бидний нэгэн адил муу сэтгэлүүдийн нөлөөнд орсон, ихэнхдээ тэдний зовлон биднийхээс дор байдгийг ойлгосноор өшөөрхөлийг дарж болно. Тийнхүү өшөөрхөлийг энэрэнгүй сэтгэл болгон хувиргах бололцоотой.

Эрж байгаа тайван байдал, жаргалд хүрэхийн тулд муу сэтгэлүүд болон тэдгээрийн үр болон тэдгээр сэтгэлүүдээс бүтээгдсэн үйлийн чадамжуудыг ерөндөглөж, сэтгэлээ ариусгах хэрэгтэй. Бурхан багш айлдахдаа, биднийг аз жаргалтай байлгахыг хүсэж байдаг ч усаар бидний нүгэл хилэнцийг угааж чадахгүй, нүглийг өөртөө авч чадахгүй, өөрийн билиг ухаан ба аз жаргалыг бидний сэтгэлд суулгаж өгч чадахгүй байжээ. Түүний оронд, Бурхан багш, муу сэтгэлүүдийн гол ерөндөгийг дадуулах: бид болон муу сэтгэлүүдийн орнууд нь, тэдгээрт бидний мунхаглалын оноож байгаа сайн болон муу шинж чанаруудаас хэрхэн хоосон болохыг ойлгосон билиг ухаанаар муу сэтгэлүүдээс салж болохыг айлджээ. Гишүүн ерөндөгүүд нь уурыг эсэргүүцэх тэвчээр, хомхойг дарах өглөгч, шуналыг дарах огоорох сэтгэл гэх мэт байдаг.

Нүгэлт үйлийн үр нь муу сэтгэлээр өдөөгдсөн үйлүүдээс бүтэх бөгөөд түүнээс бий болдог үйлийн чадамж нь бидний сэтгэлд тээгддэг. Тиймээс үйлийн чадамжуудыг, тэдгээрийг бүтээсэн шалтгаануудын эсрэг хүчээр ариусгаж болдог. Бүхэл бүтэн үйлийн үр нь дөрвөн бүрэлдэхүүнтэй: үйлийн орон, сэдэл, тухайн үйл, үйлийн төгсгөл эдгээр юм. Эхний эсрэг хүч болох гэмшил нь, үйлээ гүйцэлдүүлсэндээ баярласан үйлийн төгсгөлийг ерөндөглөдөг. Жишээ нь, шөнө уурандаа босож ирээд шумуул цохиж, түүнийг алсандаа баярладаг. Гэмшил нь уурын гэмийг ойлгон, түүнийг өвчинд үзэж, үйлийн үр дагаварыг мэдэн, шумуулыг энэрэхэд бий болно.

Чин сэтгэлийн гэмшлээр алдаагаа хүлээх нь өөрийгөө зэмлэхийг даван туулдаг болохоос түүнийг бүтээдэггүй. Зэмлэл нь өөрийн тухай сөрөг бодолтой байхаас бий болдог зовлонг байдал юм. Өөрийн тухай бодол алдаатай байдаг учраас зэмлэл нь сэтгэлийн алдаатай байдал юм. Хэрвээ эмч биднийг сүрьеэтэй байна гэж хэлбэл өөрийнхөө нөхцөлд харамсах боловч сүрьегийн нян бидний биед байгаад өөрийгөө гэм буруутанд санахгүй. Эмчийн хэлсэн эмчилгээг дуртайяа дагах болно. Түүний нэгэн адил, муу сэтгэлүүд болон үйлийн үртэйдээ харамсаж, тэдгээрийг сэтгэлээсээ арилгахын тул ямар нэг зүйл хийнэ.

Хоёр дахь ерөндөгийн хүч бол нүгэл үйлдсэн оронтой холбоотой. Хэрвээ бид бусдад санаатайгаар хорлол үйлдсэн бол бусдын зовлонг эргэцүүлэн бодож, энэрэнгүй сэтгэлийг төрүүлснээр үйлийн хорлолтой талыг ерөндөглөнө. Гурав дахь ерөндөгийн хүч нь муу үйлийг сөрөх үйл юм. Уучлал гуйж, урьдын үйлдсэн хорлолт үйлээс гарах үр дагаварыг засах үйл

хийх хэрэгтэй. Хэрвээ бусдын биеийг хорлосон бол хорлол, өлсгөлөн, өвчний аюулд өртсөн хүн болон амьтныг асран хамгаалж болно. Хэрвээ хулгай үйлдсэн бол өглөгийг үйлдэж болно. Хэрвээ ширүүн үг хэлсэн бол сайхан сэтгэлээр, зөөлөн хэлж болно. Бурхан багш, гурав дахь алхамыг хамгийн их хүчтэй болгодог маань унших зэрэг олон үйлийг тодорхойлжээ.

Сүүлийн ерөндөгийн хүч нь ирээдүйд тухайн нүглийг дахин хэзээ ч давтахгүй гэж хатуу шийдэх. Энэ нь үйлийн сэдлийн салбарыг ерөндөглөдөг. Тухайн амлалтыг хэр их дааж чадахаас хамааран дараагийн хорин дөрвөн цаг, долоо хоног, сар, амьдарлынхаа туршид тухайн үйлийг үйлдэхгүй байх хүчтэй санааг үүсгэнэ. Амлаад биелүүлж чадахгүй санагдаж байвал амлаагүй нь дээр. Амласнаа алдах нь үйлийг хүндрүүлдэг. Өөрийг төвчлөх, уур, шунал зэрэг нь сэтгэлд гүнзгий үндэслэсэн учраас буцаж буруудаж болох ч гэлээ гэм буруутайд бодож болохгүй. Тухайн байдалд тулгуурлан ирээдүйд муу үйлээс зайлсхийх шийдлийг улам бататгана.

Хэцүү нөхцөл байдалд алдаагаа илэн далангүй хүлээн зөвшөөрч, тэдгээрийг дахин үйлдэхийг тэвчих шийдвэр нь хааж боосон хэрэг биш. Энэ арга барил нь муу сэтгэлүүдийг хянах дэвшилттэй хяналтыг тогтоодог ба эцэст нь, муу сэтгэлүүд болон тэдгээрээс бүтсэн үйлийн үрийг үгүй болгодог. Энэ нь муу сэтгэлийн хөдөлгөөнийг аажмаар хянах бөгөөд амьдралын бэрхшээлтэй тэвчээр болон хайрын нүүрээр тулгаран, өөрөө хүссэнээ аваагүйдээ бухимдах бус бусдад туслах эрмэлзэлтэй болгодог. Өөрсдийгөө мартсан үед уур, шунал, бардамнал гэх мэт үүсэн бий болох суурь тулгуур үгүй болдог. Дөрвөн ерөндөгийн хүчүүд нүгэл хилэнцийн чадамж болон муу сэтгэлүүдийн үрийг сулруулж, эцэст нь устган үгүй болгосноор бусадтай харилцах байдлыг бүтээлч болгон өөрчилж, жаргалын эх булаг болгодог. Энэ нь нэг нэгэндээ баас шидэлцэхээс хамаагүй илүү дээр билээ.

Амьдралын зорилго

Австралийн Ерөнхий Сайд нэгэнтээ, амьдрана гэдэг тийм хялбар биш хэмээн хэлээд тун эвгүй байдалд орсон юм. Түүний хэлснийг хэвлэл мэдээлэл болон сөрөг хүчин, өөрийн Засгийн газрын нийгмийн тулгамдсан асуудлыг шийдэх хариуцлагаасаа зайлсхийх гэсэн оролдлого хэмээн буруутгаж байлаа, энэхүү гэнэн үгийг хүлээж авах байдал нь түүнийг огцруулахад ч хүргэж мэдэх байсан юм. Бурханы шашины номд өгүүлдэгээр, амьдрал амар биш болох нь тодорхой. Энэ нь ч Бурхан багшийн анхны сургаал байсан юм. Дараа нь тэрээр, амьдралын хэцүү нь бодит байдлыг үл мэдэх мунхагаас үүсдэг муу сэтгэлүүд болон тэдгээрээр дамжуулан үйлддэг үргэлжийн алдаанаас болдог хэмээн айлджээ. Түүний дараа энэ мунхагийг хэрхэн арилгах тухай айлдсан байна.

Нөгөө талаас, амьдрал ямар нэг утгатай бус аж. Энэ үг бол тухайн нэг шалтгаанаар бүхнийг чадагч амьдралыг бүтээсэн гэдэг үзэлд хамааралтай. Амьдралд шалтгаан гэж бий, гэхдээ дээдийн зорилготой ямар ч хамаагүй. Ертөнц болон амьдралын анхдагчийн тухай бидний итгэл үнэмшил бүтээгчийн онолыг шаарддаг. Зарим нь амьдралыг бүхнийг бүтээгч Эсрүн тэнгэр, Ертөнцийн эзэн бүтээсэн гэж таамагладаг. Зарим нь Биг Банг (Том тэсрэлт) хэмээн нэрлэдэг механик зүйлээс бүтсэн гэж үздэг. Эхний онол нь Бүтээгч хаанаас ирсэн болох, тэр эмэгтэй юмуу эрэгтэй яагаад энэ их зовлонг ертөнцийг анхнаас нь бүтээх болов гэдгийг тайлбарладаггүй. Хоёр дах онол нь бүх зүйл оргүй хоосноос бүтэж, амьдралыг тохиолдол гэж үздэг. Хэрвээ бид өөрсдийгөө болон орчин тойрныг шинжилж үзвэл шүтэн барилдлагын хууль буюу юу ч өөр нэг зүйлээс хамааралгүйгээр үүсэн бий болж, оршин тогтнох нь үргэлжилж чадахгүй гэдгийг нээж олох болно. Эрдэмтэд үүнийг ойлгож байгаа хирнээ бүхэл ертөнцийг оргүй хоосноос бий болсон гэж үзсэн хэвээр байгаа нь миний ойлголтоос давсан хэрэг. Миний бодлоор, энэ нь учир шалтгааны үндэслэлгүй юм. Бурханы сургаал ёсоор, Бүтээгч болон Биг Бангийн (Том тэсрэлт) онолууд нь анхдагчийн тухай буруу таамаглал дэвшүүлсэн учраас хоёулаа буруу.

Бурхан багш эхэндээ, ертөнцийн эхлэлийн тухай айлдах дургүй байжээ, учир нь түүнийхээр бол хүмүүс энэ сэдвээр үүрд маргалдаж, тэдний маргаан нь өөрсдийн нэн түрүүний зорилт болсон аз жаргалыг олох ба зовлонгоос зайлсхийхэд ямар ч хэрэгцээгүй байх юм. Хожим нь тэрээр, ухамсарт амьдрал эхлэлгүй ертөнцөд оршоор иржээ. Үүнийг учир шалтгаанаар няцаах бололцоогүй бөгөөд буруу гэж батлах бололцоогүй. Биг Бангийн онол нь хэрвээ ертөнцүүд энергийн алдагдалгүйгээр эхлэлгүй цуврал байдлаар гадагш ба дотогш тэсрэлтээс үүсэн бий болж, үгүй болдог байвал хүлээн зөвшөөрч болохуйц юм. Дээрхийн гэгээнтэн Далай лам багш: “Хэрвээ ганц удаагийн биг бангийн онол ертөнцийн жинхэнэ эхлэл үнэн гэдэг нь батлагдвал Буддист сэтгэгчид толгойгоо нэлээд маажих хэрэгтэй болно. Хэрвээ олон удаагийн “биг банг”-ийн санааг дэвшүүлбэл Буддын онолтой сайн таарна” хэмээн айлдсан байдаг.

Энэ эхлэлгүй ертөнцөд үргэлж төрж байхын шалтгааныг одоо бүгдээрээ шалгаж үзье. Саяхан нэг удаа Монголд Бурханы сургаалийн хичээлийн үеэр би оюутнуудаас “Та нар амьдрахын тулд иддэг үү, идэхийн тулд амьдардаг уу?” гэж асуулаа. Нэлээд удаа ярилцсаны эцэст, тэдний амьдралын гол зорилго нь аз жаргалтай байж, зовлонгүй байх явдал хэмээн надтай санал нэгдсэн юм. Цонхны тавцан дээр унтсан хэвээр байгаа миний муур болон амьтад

жаргал хүсэх, зовлонг үл хүсэх тун энгийн зорилготой нь тодорхой. Ихэнх хүмүүс миний мууртай төстэй ба харамсалтай нь тэдгээр наад захын зорилтдоо хүрэхдээ төдийлөн амжилтгүй байна. Энэ насны амьдралаас цаадахыг харж чадахгүй тэд: “Маргааш үхэж магадгүй учраас ид, уу, жаргалтай бай” гэсэн уриатай амьдардаг. Харин үхэхийн цагт жаргалд цэнгэх бололцоо төгссөн учраас өөрийгөө мэхлэгдлээ гэж үзэн илүү амьдрахыг хүсдэг. Энэхүү шунал нь үйлийн чадамжийг боловсруулснаар сэтгэлийг хойд төрөлд шилжүүлдэг. Сайн хойд төрлийг олоход ямар ч бэлтгэл хийгээгүй учраас тэдний давамгайлах үйлүүд нь адгуус амьтан, бирд, тамын төрөлхтөн болж төрөхөд хүргэдэг. Хүний төрлийг дахин нэг удаа авах үйл боловсрохоос өмнө олон төрөлдөө муу заяанд төрдөг.

Харин энэ насны жаргалаас давсан зорилготой зарим хүмүүс байдаг. Тэдний дээд бишрэл тэмүүлэл нь хойд төрлүүд үнэн бөгөөд ирээдүйн аз жаргал энэ насанд үйлдсэн үйлүүдээс хамааралтайг ойлгосон бахдал төрүүлсэн удирдагч багшаас бий болсон байдаг. Тийм багш нар энэрэнгүй сэтгэлээр энэ дэлхийд залран ирж, там мэтийн туйлын их зовлонтой хойд төрлөөс хэрхэн зайлсхийн, хүний төрөл болон олон тэнгэрийн аль нэгэнд тэнгэрийн төрөлхтөн болж төрөхийн тулд хэрхэхийг зааж өгдөг. Тэдгээр багшийн шавь нар сургаалийг эргэцүүлэн бодож, тэнгэр ба тамын төрөл байдгийг хүлээн зөвшөөрснөөр тэд зовлонт хойд төрлөөс эрүүл байдлаар айх айдаст тулгуурласан ариун сахил санваар болон өөрийн хөтлөгч багш нарт хөдөлшгүй бат итгэх зам мөрийг дагадаг. Энэ бол оюуны тэмүүллийн хамгийн энгийн хэлбэр.

Оюуны дунд зэргийн бишрэл нь хойд төрлүүдийн амгаланд шунах шуналын цаана гаргах хөтлөгчийг дагах юм. Тэнгэрт төрөх нь хангалтгүй, учир нь үйл ба муу сэтгэлүүдийн эрхэнд оршиж байгаа цагт тэнгэрээс төрөл доошилж, буцаад муу төрөлд унаж болзошгүй гэдгийг ухаарснаас үүдэн гарна. Ариун сахил санваарыг баримталсан амьдралд тулгуурлан, тэдгээр хүмүүс төвлөрөлийн хүчийг олох ба туйлын бодит ахуй болох хоосон чанарыг оноход сэтгэлээ хандуулна. Энэхүү билиг ухаан нь үйлийн үрийг үгүй болгоно, дараа нь сэтгэлийг бүрхэгдүүлэн хаадаг мунхаглалын улам нарийн хаалтыг аажмаар арилгах болно. Сүүлчийн хаалт арилахад нирвааны хутаг буюу амьдралын хүрднээс бүрэн гэтэлж гардаг. Тэдгээр хүмүүсийн амьдралын зорилго нь амиа бодох, уур, шунал зэрэг муу сэтгэлийг бүр мөсөн орхиход байдаг. Эгэл жирийн амьдралаас буцсан байдаг бөгөөд сэтгэлээ бүрэн ариусгахын тулд сүм хийд эсвэл аглаг газар бясалгалд суудаг.

Оюуны дээдийн бишрэл тэмүүлэл нь нирвааныг хүсэхээс ч илүү гардаг. Энэ их энэрэнгүй сэтгэл гагцхүү өөрийн зовлонгоос гэтлэхийг үгүйсгэн, амьдралын хүрднээс амьтан бүрийг аврах үүргийг өөртөө хүлээдэг. Тэдгээр хүмүүс ертөнцөд үлдэж, бусдад туслах үйл хэргийг бүтээх явцдаа сэтгэл сарнихгүйн тулд ертөнцийн шуналыг огоорох эрчимтэй огооролд суралцдаг. Энэрэнгүй сэтгэлийн хүчийг арвидуулахад хичээнгүйлж, өөрсдийн сэтгэлийг төгс төвлөрөл ба хоосон чанарыг онох билиг ухаанд суралцдаг. Бүх төрөлхтөнд бүрэн тусалж чаддаг болохын тулд Бурханы хутгийг олох нь тэдний хамгийн дээд зорилго болдог. Зам мөрд байхдаа дараах гурван хэлбэрийн аль нэгээр бусдыг зовлонгүй болгоход хөтөлдөг, тэдгээр нь: мал сүргээ өмнөө туудаг хоньчин шиг, зорчигчтойгоо хамт зэрэгцэн явах сэлүүрчин шиг, эсвэл тэргүүнд нь өөрөө явах хаан шиг.

Ийнхүү хүмүүсийн сэтгэлд байж болох амьдралын дөрвөн зорилгын тухай өгүүллээ. Эхнийх

нь, энэ насны жаргалыг хайх нь ертөнцийн жирийн зорилго бөгөөд хэзээ ч биелэгдэшгүй бөгөөд зовлонд зайлшгүй хүргэдэг. Нөгөө гурав нь оюунаа судлах зам мөрүүд бөгөөд үндсэндээ мунхаг ба энэ насны жаргалд шунахыг сөрдөг. Урьдын тоолшгүй олон төрлүүдээс бид сэтгэлдээ эдгээр бүх дөрвөн зорилгын зөн совинг тээсэн байдаг. Өнгөрсөн үеийн оюун судлах зам мөрт үргэлж дэвших эсэх нь энэ насанд учирсан нөхцөлүүдээс хамаарна. Оюуны дээд мөрд дэвших үргэлж бололцоотой байдаг боловч туйлын бодит байдлыг онохоос нааш оюунлаг амьдралын доод төвшний зам мөрт доройтон унах, эсвэл ертөнцийн жирийн замд ч орох аюултай.

Бурханы шашинтай учрахаас өмнө намайг сэтгэл мэдрэлийн эмнэлэгт ажилладаг байхад миний өвчтөнүүдийн нэг Христос шашны номлогч сэтгэлийн хямралын өвчтэй байсан юм. Сэтгэцийн эмч нар тоолшгүй олон удаа цахилгаан эмчилгээнд цохиулж, олон төрлийн химийн нэгдлүүдийг найруулсан ундааг өгсөн хэдий ч тэр аймшигтай их сэтгэлийн хямралтай хэвээрээ байж билээ. Би түүний урт сандалын үзүүрт цэвэр, цэмцгэр хувцаслан хөдөлгөөнгүй суусан байдал, жигтэйхэн соёлтой байдлыг одоо болтол тод дүрсэлж чадна. Би түүнээс: ”Таны юу өвдөж байна вэ?” гэж асуух бүрт, “Эмч ээ, би сүсгээ алдсан” гэж нэг л хэвийн хариулдаг сан.

Тэр үед би ямар ч шашныг хамгийн ихээр эсэргүүцдэг, зөвхөн энэ насны жаргалд сонирхдог хамгийн жирийн хүн миний хувьд, хөөрхий түүнд юугаар ч тусалж чадахгүй байлаа. Өөрсдийн амин хувийн амар жаргалыг хөөцөлдөхөө хамгаалсан энгийн хүмүүс бид номын замаар явж байгаа хүмүүсийг харж байхдаа тэднийг амьдралдаа бүтэлгүйтсэн хэмээн буруутгадаг. Би ийм үзлийг баримталдаг байсан бөгөөд бидний олон бэрхшээл зовлонд шашиныг буруутгадаг байлаа. Одоо бол жинхэнэ бүтэлгүйтсэн хүмүүс гэж аминч үзэл, бардам, шуналаа сөрөн зогсох зориггүй хүмүүс гэж хэлнэ. Хэрвээ шашиныг энэ насны жаргалд хүрэх хэрэглүүр болгон ашиглаж, оюунаа судлах ямар ч зам мөрт орох чин эрмэлзэлгүй байвал хамгийн хэцүү хүнд зовлонг чиглэж байдаг. Нөгөө талаас, шашинтан хүний шүтэн бишрэх жинхэнэ шүтээн нь төгс байх ёстой, эс тийм байвал сохор харгуй зам болж, оюуны зам мөр биш болно. Хэрвээ шүтээн нь төгс боловч түүнийгээ буруугаар ойлгодог бол бас л ноцтой алдаа гаргана. Байгаа тухайн ном сургаалиудыг ялгах оюунаараа сайтар судлан, амьдралынхаа үлдсэн хугацааг хамгийн сайн ямар зүйлд зориулах талаар хатуу шийдэх нь ихээхэн чухал юм.

Өөрийгөө анагаах нь

1999 онд анх удаа АНУ-д очиж, зургаан долоо хоног Бостон хотын сайхан хаврыг үзэж өнгөрүүлээд дараа нь, хоёр сарын турш Калифорни мужийн ойролцоо Санта Круиз хотод улаан модот газар өнжсөн юм. Америкчуудаас надад үлдсэн олон сэтгэгдэл дотроос ойлгосон нь Зүүн эрэг дээр байгаа хүмүүс цөмөөрөө эмчилгээнд (үүнийхээ тухай ярих дуртай), харин Баруун эрэг дээр байгаа нь бүгдээрээ эмчлэгчид (үүнийхээ тухай ярих дуртай) ажээ.

Австралид хүмүүс сэтгэлзүйн эмчилгээнд орох нь ховорхон байдаг, орсон ч гэсэн хэн ч мэддэггүй. Нэг улсыг нөгөөгөөс илүү хэмээн хэлэхийг энд хүсээгүй юм, бүх хүмүүст асуудал бэрхшээл тохиолддог, гагцхүү Америкчууд түүнийхээ тухай бусдад ярих дуртай байхад Австраличууд өөртөө л хадгалдаг. Австралид тэр байтугай сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж байна. Сэтгэл зүйн эмчилгээ болон зөвлөгөөг нийгмээрээ хүлээн зөвшөөрч байна, энэ нь асуудлыг шийдэхэд сэтгэлийн хандлага чухал болохыг эцэстээ ухаарч эхэлж байгаа хэрэг юм. Өөрийн сэтгэлийг анагаахын тулд эхний үед бусдад итгэж найдах хэрэгтэй, дараа нь өөрийнхөө эмч болж сурах ёстой.

Бусад хүмүүс сэтгэлээ хэрхэн засах вэ гэдгийг хэлдэг, гэхдээ засаж чадах хүн нь гагцхүү бид өөрсдөө юм. Сэтгэлээ хянахад чармайлт, зориг, шийдэл шаардлагатай. Амьдралд тохиолдож байгаа тус бүр ялгаатай, санаандгүй нөхцөл байдлыг ухаалгаар шийдэж чаддаг биеэ даасан бодолтой болох хэрэгтэй юм. Мэдээж, ямар нэг шашины юмуу улс төрийн нөлөөтэй хүнийг сохроор шүтэж байж болох юм. Энэ нь ч өөрт сайхан санагдаж, олны нэг хэсэг шиг бодогдоно, гэвч тэр удирдагч өөрийнхөө сэтгэлзүйн асуудлыг шийдэж чадаагүй бол амьдралдаа баримтлах ухаалаг чиглэлийг сонгох эрх чөлөөнөөс хасагдах ба мунхагийн харанхуйд улам цааш хөтлүүлсээр байх болно.

Хүний бие өөрийгөө засах гайхамшигтай зохион байгуулалттай учраас эмч нар бие эдгэсэн явдалд багахан гавьяатай гэж хэлбэл зохино. Харамсалтай нь, сэтгэл тийм сайн зохион байгуулалттай биш. Сэтгэл уур, шунал, атаархал, бардамнал, аминч үзэл гэх мэт өвчнөөр өвчлөхөд анагаах сэтгэл зүйн байгалийн механизм байдаггүй. Мэдээж, гунигийг мартаж, үгүйсгэх, дарах аргаар сэтгэлээсээ гаргаж болох боловч эдгээр нь түр зуурын эмнэл болохоос биш уг анхны зовлонг эдгээхгүй. Дахин гадарга дээр гарч ирэхдээ архаг айдас, зэмлэл, хямрал юмуу хувийн шинж чанар болон ааш зангийн замбараагүй байдлын хэлбэрт ордог. Сэтгэл өөрийгөө зүй ёсоор эдгээж чадахгүйгээр үл барам, уур ба шунал зэрэг муу сэтгэлүүд улам дордсоор байдаг. Сэтгэл ууртай байх тутам ирээдүйд мөн адил ууртай харьцах хандлагатай болдог. Амьдрал улам зовлонтой болж, өчүүхэн зүйл боловч уур хүргэх шалтгаан болдог. Настай хүмүүс аашилж аягладаг нь түгээмэл бөгөөд үнэхээр гунигтай юм. Амьдралын тухай гашуун бодолтой эсвэл эд хөрөнгөдөө харамч байснаар тэд үхлийг чиглэн уур ба авахуйн эргүүлэгт ороогдон түүгээр муу төрөлд доош сорогдоно.

Өөрийн эмч болох суурь нь сэтгэлээ хэрхэн ажилладаг болон тухайн ерөндөгийг хэрхэн тохируулахыг мэдэх юм. Хамаг зовлонгийн ёзоор болдог өөрийг төвчлөх үзэл нь муухай толгойгоо арагш хаялахдаа бусдыг үл тоож, зөвхөн өөрийгөө л бодоход хүргэдэг. Өөрийг төвчлөх үзлийг дарах баатарлаг хандлага нь дээрх хандлагын байрыг сольж, өөрийгөө мартаж, зөвхөн бусдыг бодох юм. Бусдыг харж, адгуус амьтныг бас харж, тэдгээрийн биед

өөрийн сэтгэлийг оршиж байна гэж бодоорой. Дараа нь: “Хэрвээ би энэ эрэгтэй (эмэгтэй, эсвэл адгуус) байсан бол аз жаргалтай болохын тулд юуг хүсэх байсан бол?” хэмээн бодоод үз. Тэднийг аз жаргалтай болоход өөрийн хийж чадах үйлээ үйлдэх хэрэгтэй. Өөрийг төвчлөх үзлийг дарах туйлын дээд эм нь би-гийн хоосон чанарыг оносон билиг ухаан буюу өөрийн боддог шиг би-гээр хоосон гэдгийг онох юм.

Сэтгэлийн өвчнүүдээс хамгийн харгис хүчтэй нь уур юм. Түүний ерөндөг тэвчээрийг эхлээд уурын урьдах шалтгаан болдог уйтгар гансралаас сэрэмжилснээр дадуулж болно. Уур хэзээ ч жаргалтай сэтгэлд үүсдэггүй, тиймээс гомдоллох, гоншгонох, янших, гутрах, гансрах, дүнсийхээ зогсоох хэрэгтэй юм. Тэгэхгүй бол уурлах бөгөөд санаа зовж байгаа зүйлээс илүү дордоно. Ихэнх хүмүүс сэтгэлийн энэхүү зовлонг байдалд дуршилтай болж, өөртэйгээ таарахгүй байгаа бусдын сэтгэлийг унагаан түүндээ баясдаг. Товчдоо, ямарваа болохгүй юмыг засаж болохоор байвал санаа зовох хэрэггүй. Мөн засаж болохгүй байвал санаа зовох нь тус болохгүй. Тиймээс санаа зовохоо боль, за юу? Хэрвээ жаргалтай байхыг хүсэж байгаа бол уурын эсрэг тал болох тэвчээрийг дасга.

Хомхой сэтгэлийг дарах эм нь өглиг юм. Ширүүн, хорлонтой сэтгэлийн хандлагын ерөндөг нь энэрэнгүй сэтгэл юм. Сахил санваарыг сайшаан, баримтлах нь хөнөөлт зан байдлаас урьдчилан сэргийлэх эм юм. Залхуу занг бусдад туслах хичээнгүй сэтгэлээр эмнэнэ. Нийтдээ наян дөрвөн мянга муу сэтгэл байдаг бөгөөд түүнийг дарах наян дөрвөн мянган эмийг Бурхан багш айлджээ. Тэр бүрийг тоочиж барахгүй боловч дээрх жишээнээс сэтгэлээ хэрхэн засах талаар тодорхой ойлголттой болох байх.

Муу сэтгэлүүд болон тэдгээрээс үүсдэг зовлонгууд нь олон янзын шалтгаан, нөхцөлүүдээс үүсдэг. Тэдгээрийн идэвхгүй суурь хөрөнгө үр нь сэтгэлийн урсгалаар урьд төрлүүдээс тээгдэн ирдэг. Та уурладаггүй гэж надад бүү хэлээрэй, танд наян дөрвөн мянган муу сэтгэлийн хөрөнгө байгаа шүү. Гол бэрхшээл нь тэдгээр удаан орших чадварт оршдог ба уур нь уурыг төрүүлнэ, шунал нь шуналыг төрүүлнэ.

Сэтгэл мэдрэлийн ноцтой эмгэг, галзуурал нь үйлийн үрээс бий болж болдог. Урьд төрлүүдэд үйлдсэн тухайн үйлээс болж энэ төрөлд сэтгэл мэдрэлийн эмгэг үүсдэг жишээг Бурхан багш айлджээ. Бусдыг хараал үг, хуурах замаар солиоруулах, хүчээр шахаж хор, согтууруулах унд уулгах, араатан амьтныг айлгах, ой галдан шатаах, бусдыг ангал руу унагаах гэх мэт урьд насны үйлүүд байдаг. Мөн энэ насанд хий дүрийн үзэгдлээс их айснаас, шулмасын хорлол, ойр дотны хүн үхсэнд гашуудах, биеийн тэнцвэргүй байдал зэргээс сэтгэл мэдрэлийн тэнцвэргүйдэл үүсэж болдог хэмээн тайлбарлажээ.

Бусдын сэтгэлийн сайн сайхныг хорлосон ямар ч үйл өөрийн сэтгэлийн тэнцвэргүйн шалтаг болдог. Өөрөө аз жаргалтай, сэтгэлийн зовнилоос ангижрахыг хүсэж байгаа бол бусдыг үймүүлэхээс зайлсхийж, тэднийг амгалан байлгахад өөрийн чадах хирээр туслах хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой байна. Биеийн тэнцвэргүй байдлыг зөв хооллолт, зан байдал, байгаль орчин, шаардлагатай бол эмээр засах боломжтой. Жишээлбэл, сэтгэлийн зовиуртай хүнд Төвдийн анагаах ухааны номд, тослог хоол, улаан мах идэх, архи уух, энгэр зөрүүлэхийг зөвлөж, салхитай болон дээгүүр өндөр газраас зайлсхийх, дулаан байж, улаан өнгийн хувцас өмсөхийг дурьдсан байдаг. Би үүнийг Америк хэсэг оюутнуудад хэлэхэд тэдний нэг нь: “Надад ийм эмийг бичиж өгсөн ч болоосой” гэж хэлсэн юм.

Өөрийнхөө эмч болохын тулд эхлээд уур, шунал, бардамнал зэрэг нь өвчин гэдгийг таних хэрэгтэй. Дараа нь бодолдоо ямагт сэрэмжтэй хандаж, муу сэтгэл үүсэж эхлэхийг шууд мэдэнгүүт зохих ерөндөгийг хэрэглэнэ. Жишээлбэл, уураас зайлсхийхийн тулд хорлолыг хүлээн авах үйлийн ногдол гэдгийг мэдэх шаардлагатай. Бусдыг хорлосон урьдын үйлээс болж хорлолт нөхцөлд татагдах үйлийн хандлагатай болдог, тиймээс уурлах ёсгүй, учир нь, бусдад хорлогдох аюулд оруулж байгаа гол нөхцөл нь бидний өөрсдийн сэтгэлээс урган гардаг. Хоёрдугаарт, уур нь тухайн хорлож байгаа хүнд муу чанарыг хэт тохоох юмуу ихэсгэж байдаг, тиймээс уур бүхэлдээ зохисгүй хариу үйлдэл болох бөгөөд өөрт авсан хорлолтой харьцуулбал голдуу үлэмж их хэтэрсэн байдаг. Эцэст нь, уур ямар ч гадаад хорлогч хүн, эд юмсаас илүү их хорлолтой учраас тэсвэр тэвчээрийг, хайрлах сэтгэлтэй хамт төлөвшүүлэх ёстой юм.

Жараад оны үед Мельбурн хотын нэгэн сэтгэл зүйч эмч, бясалгалыг бие болоод сэтгэлийн өвчинг дарах арга мөн болох тухай өгүүлсэн нэгэн ном хэвлүүлсэн юм. Анагаах ухааны тогтсон хэвшил нь түүний хувьсгалч санааг эсэргүүцэхэд тэрээр уламжлалт хандлагад бууж өгөхийн оронд эмч хийх эрхээ өөрөө түтгэлзүүлжээ. Аз болоход тэдний үед байсан цаг хугацаа өөрчлөгдөж байжээ.

Эрх чөлөө

Ээж маань ах бид хоёрыг халаас дүүрэн гурван пэннитэй илрүүлснээр миний анхны эрх чөлөөний амт бүдүүлгээр таслагдаж билээ. Бид хичээлээ гурван хоног таслан, Сидней хотын “Роуз Бей” гольфийн сургалтын газар цаг нөгцөөдөг байлаа. Бид сургуульдаа өдөр идэх хоолоо муур болон нялх зулзагуудтай нь хуваан идэцгээж, тэнд зөрүүд гольфчидийн буруу цохисон бөмбөг очих ёстой нүхний талбайг тэс хөндлөн өнгөрч горхины усанд ойчих нь биднийг асар ихээр баяжуулж байлаа. Гольфчид бидний уснаас гаргаж авчирсан бөмбөг болгонд гурван пэнни төлдөг байлаа.

Дунд болон их сургуулийн үеийн миний эрх чөлөөний тухай ойлголт нь лекц болон шалгалтуудаа дууссаны дараа хүссэнээ хийх гэж үзэж байлаа. Энэ маань эцэстээ биелэгдэхэд халаасан дахь Энэтхэг мансууруулах тамхи маань баригдахад эрх чөлөөг амталсан маань хоёр дахь удаагаа гэнэт тасарч билээ. Дараа нь эрх чөлөөний тухай миний ойлголт өөрийн санаа нийлдэг хүмүүстэйгээ хөдөө очоод, буцаж дэлхийд ирж, консерватив нийгмийн хавчигдмал, хуучинсаг ёс суртахуунд баригдахгүй хэв маягаар амьдрах явдал байлаа.

Эрх чөлөөний тухай энэхүү гурав дахь удаагийн амт маань би болон миний найз нарын сэтгэлийн дэмий зовнил нь өөрсдөөсөө доорд гэж боддог хүмүүстэй адилхан болохыг мэдэрснээр бүдүүлгээр тасарсан юм. Нийгмээс холдохын тулд хол аялдаг үзэл бодлыг орхиж, эрх чөлөө гэж амьдралын бүх тал дээр бүрэн дүүрэн өөрийн бие даасан байдал хэмээн итгэсэнээр дангаараа өөрийнхөөрөө амьдрах боллоо. Энэ нь бас л болсонгүй. Амьдралын аз жаргал нь бусдаас хамааралтай байдаг, аз жаргалтай байхын тулд зөвхөн бусдаас аваад л байх биш бусдад бас хүртээх хэрэгтэй юм байна гэдгийг би эмтэрсэн элэг шархалсан зүрхээрээ ойлгосон юм. Бие даасан байдлаа хадгалахыг хүсэх болон хамт сууж байгаа хүндээ хүлээх хариуцлага хоёрын хоорондох тулаанд эрх чөлөө дараагийн байранд тавигдлаа.

Дараа нь Балбад Төвд лам нар өөрийгөө төвчлөн үзэх нь бидний бүх зовлонгийн үндэс болдог гэж айлдлаа. Тэдний хэлсэн нь үнэн гэдгийг мэдэж байлаа. Харин тэднийг Бурхан нэртэй хэн нэгэнд сүсэг бишрэлтэй байх талаар болон дахин төрөл авах, урьд хийсэн муу үйлийг цээрлүүлэн тамд төрдөг, сайн үйлийг шагнаж тэнгэрт төрдөг зэрэг үйлийн үрийн тухай ярихад миний сэтгэл: “Шашин! Хүмүүсийг өөрсдийн номхруулж, тэднийг эрх чөлөөнөөс нь салгахад зориулагдсан мухар сохор сүсгээрээ намайг бүү мунхруул” хэмээн хашгирч байлаа.

Би лам нараас болон өөрийн найз бүсгүйгээсээ зугтан Англи улс руу эрх чөлөөг хайхаар аяллаа. Би Бэтнал Грийн дахь нэгэн хоосон байшинд хэт зүүний жигүүрийн үзэлтэй шинэ найзуудтай шинэ найз бүсгүйн хамтаар удалгүй нүүж орлоо. Тэр үед сонгууль болох гэж байсан бөгөөд Хэрни сургууль дээр болсон нэгэн улс төрийн уулзалт дээр Ажилчдын Хувьсгалт намын гишүүн Ванэсса Рэдгрэйв гэгчтэй би маргалдан зогсож байлаа. Би түүнээс цаазаар авах ялын тухай өөрийнх нь намын саналыг асуусан юм. Тэр: “Хөрөнгөтнүүд үүнийг ажилчдын эсрэг зэвсэг болгож олон зууны туршид ашиглаж ирсэн юм” гэж тойруулан хариулсан юм.

Тэгэхээр нь би, “Лондонгийн гудамжаар алхаж яваа хөрөнгөтнүүдийг хэн алах болж байна?”

Тэд таны улс төрийн бодлогыг хэзээ ч зөвшөөрөхгүй, үхэн үхгэлээ энэ хувьсгалын чинь эсрэг тэмцэнэ. Та тэднийг өөрөө алах юм уу, эсвэл энд байгаа хүмүүсийг таны өмнөөс алаад өгөөч гэж гуйх уу?” гэж тэнд цугласан хар ажилчдыг гэсэн санаагаар асуулаа.

“Чи өөрөө юу юм бэ, Христ этгээд юмуу, хаашаа юм?” хэмээн тайзан дээр байсан настай, хүндэт коммунист эмэгтэй намайг эсэргүүцэн хэллээ. Цугларсан хүмүүс намайг дэмжин, үг хэлүүлэхийг хүсэв.

“Үгүй ээ, би ямар ч шашингүй. Би энд нийгмийн шударга бус, тэнцвэргүй байдлыг шийдэх хариултыг мэдэх гэж ирсэн юм, харин би энд зөвхөн үзэн ядалтын тухай л сонслоо. Энэ чинь зөв шийдвэр биш” гэж би хариуллаа.

Сталин болон Маогийн харгислалыг мэдэж байсан болохоор Британийн социализм арай дээр төрхтэй байх болов уу гэж найдаж байсан боловч надад огтхон ч таалагдсангүй. Буддын шашинд нийгмийн асуудлыг хэрхэн тайлбарласан болон шийдэх аргууд нь зөв гэдэг нь улам их мэдрэгдэж байлаа. Хэдийгээр би ямар нэгэн хэмжээгээр эрх чөлөөтэй, сайхан эмэгтэйтэй амьдарч, Лондонд эмчийн ажил их, хэн ч надад эрх мэдлээрээ дарамт үзүүлэхгүй байсан боловч би коммунистуудын адил уураас чөлөөлөгдөөгүй байгаагаа мэдлээ. Миний өмнө уулзаж байсан бүх хүмүүс дотроос Төвд лам нар ямар ч эргэлзээгүй хамгийн жаргалтай бөгөөд тэвчээртэй хүмүүс байлаа, холимог бодол өвөрлөн Энэтхэгт буцаж очоод тэдний нууцыг мэдэхээр шийдлээ. Энэ нь намайг хувраг болгож магадгүйг ч мэдэж байлаа.

“Хайран амьдрал” гэж миний бүсгүй хэлсэн боловч би хариу хэлж чадсангүй. Бурханы шашиныг хүлээн зөвшөөрнө гэдэг нэг хэрэг, хувраг болно гэдэг мэдэгдэж тайлагдаагүй ертөнцөд бүтэн алхах хэрэг байлаа.

Энэтхэгт очиход би урьдын найз бүсгүйтэйгээ тааралдан, бид хамтдаа Варанаси хотод Бирмийн хуврагуудтай бясалгалд суулаа. Дараа нь, Бурхан багшийн гэгээрсэн газар бүтээсэн аварга том сувраганы ойролцоох Бодгаяа хэмээх амар жимэр тосгонд очсон юм. Цагаан будааны усан тариалангаар сэлгүүцэн, уулаар авирч, эртний хүүр булшууд болон их бясалгаач нарын сууж байсан агуйнуудыг олсон юм. Бурхан багшийн доор нь бясалгалд сууж, гэгээрлийг олсон тэр модны үргэлжлэл болсон Бодь модны доор би сууж байлаа.

Уур, шунал, бардамнал, хардалт зэрэг муу сэтгэлдээ боолчлогдон байгаа цагт би хэзээ ч эрх чөлөөтэй болохгүйгээ ойлгосон юм. Там болон тэнгэр нь харийн зүйл байхаа болилоо. Тэдгээр нь миний сэтгэлийн бүтээгдэхүүн байх бололцоотой бөгөөд хойд төрлийг байхгүй гэж нотолж чадахгүй байлаа. Бодгаяад аз жаргалаар бялхсан, өөртөө итгэлтэй, хүчтэй, ухаалаг олон Төвд лам нартай тааралдах боллоо. Тийнхүү би Бурханы шашинтан болсон юм.

Зөн билиг ёсоор арван сарын дараа Бурханы шашины санваартан боллоо. Миний ертөнц бүтэн тойргоор эргэлдлээ. Магад гарахуйн сэтгэл, билиг ухаан, энэрэнгүй сэтгэл нь эрх чөлөөнд хүрэх зам байлаа, ингээд би нуруугаа дахин нийгэм рүү харуулсан байлаа. Энэ удаа ертөнцийг өөрчлөх бус харин сэтгэлээ өөрчлөх дотоод уриа дуудлагтай учирсан юм. Тэр явдлаас нэлээд хэдэн жилийн өмнө намайг хиппи залуучуудын комун байгуулахаар газар эрж байх үед Бурханы шашинтан нэг найз минь захидалдаа: “Чиний хүсэж байгаа зүйл чинь сэтгэлийн амгалан болохоос биш амгалан тайван газар биш” гэж бичиж байж билээ.

Хувраг хүний сахилууд нь эрх чөлөөгөө алдаж байгаа хэрэг биш, муу сэтгэлийн хяналтаас ангижрах, өөрийг нь баримтлахыг хүчлэн тулгадаг нийгмийн хяналтаас бүрэн чөлөөлөгдөх суурь юм. Өөрийн байр сууринаас үл хамааран өөрсдийгөө үргэлж зөв замаар явж байгаадаа бид итгэдэг. Хэрэв бид эргэлзвэл олонхийг аялдан дагадаг, хүсэл, эрх мэдэлд шунах, сэжиг, цэвэр тэнэглэлийн эсрэг зогсохоос айдаг. Бурханы шашины хувраг эрэгтэй болон эмэгтэй хүмүүс нийгмийг туйлын үл дагагчид юм, хүн төрөлхтөний нийгмийн түүхэнд үүрдийн амгалан, аз жаргалыг хэзээ ч авчирч байгаагүй нь илтэд хурцаар мэдэгдсээр байтал материаллаг ертөнцөд итгэлээ хадгалах хүмүүс хуврагуудын итгэл үнэмшлээс айж гэрэвшдэг.

Уян хатан чанар

Улаанбаатар хотод өнгөрүүлсэн уйтгартай арван таван сарын дараа Австралийн Мэльбурн хотын захад диваажингийн орон мэт тансаг байшингуудын эргэн тойрон ногоон зүлэг, мод, цэцэгс алаглаж харагддаг нь санаанд орно. Бүх зүйлийн нэгэн адил үзэгдэх байдал нь үнэн байх албагүй. Мөн дуудлагаар өвчтөн үзэхээр очиход “энэ дэлхийд амьдрахад хамгийн боломжийн” гэж санагдахуйц хотын захын тэдгээр гаднаа гоёмсог байшингууд ихэнхдээ дотор талдаа тэсэшгүй их уйтгар гунигийг нууж байдаг байлаа. Өвдөх, өтлөх, үхэх гэх мэт ерөнхий зовлонгоос гадна, бодоход ч зовмоор гэр бүлийн хүчирхийлэл, хувь хүний уйтгартай зовлонт амьдралын гэрч нь болж хувирдаг байлаа.

Хэдийгээр дайн байлдааны цаг биш боловч нийгэмд энх амгалантай цаг ховор байдаг нь нийгмийг бүрдүүлэгч хүмүүс нь нэг нэгэнтэйгээ эв түнжингүй байдагтай холбоотой. Хүн ганцаараа байхдаа ч гэсэн сэтгэл нь тайван байх нь ховор. Унтаж амрах, дур ханасны дараах цөөхөн тайван хоромыг эс тооцвол учир зүгээ алдсан бодлууд, сэтгэлийн хөдөлгөөний эргүүлгэнд орсон байдал юу ч байлаа гэсэн амгалангүй. “Чөлөөт ертөнц” нь дарангуйлагч улс төрийн системийн хяналтанд биш байгаа улс, “энхийг сахиулагч” нь хүн алахад мэргэшсэн цэргүүдийн тус тус зөөлрүүлсэн нэр томъёо бөгөөд бидний гол хаалганы цаана болж байгаа амьдралын бодит байдлыг нуудаг.

Нийгэмд бүх нийтийн энх тайван байх бололцоогүй байж болох юм, гэхдээ бүгд алдагдсан гэсэн үг биш. Хувь хүнийхээ хувьд, богинохон тайван мөчүүдийг мэдрэх нь бидний сэтгэл самуурлаас чөлөөтэй байх бололцоотойг харуулж байгаа юм. Энэхүү бололцоонд хүрэхийн тулд хүн бүр ойрын холбоо, гэр бүл, нийгмийн харилцааны аюултай талбаруудад тахиралдан ороох энэрэнгүй сэтгэл, билиг ухааны өөрийн зам мөрийг дагах хэрэгтэй болдог. Бясалгалын олбог нь энэхүү зам мөрөөр явахад чухал тус нэмэр болдог, гэхдээ тодорхой дэвшил нь гагцхүү нийгмийн хүрээнд өөрийн билиг ухаан ба энэрэнгүй сэтгэлийг хэрэгжүүлснээр гарна. Оюуны боловсрол хөгжлийн жинхэнэ орчин нь бусадтай харилцах харилцаанд байдаг. Хувь хүний болон олон улсын хоорондын гамшигаас нэг нэгэнтэйгээ билиг ухаан ба энэрэнгүй сэтгэлээр ухаалаг зөв харьцсанаар зайлсхийж болно.

Миний нэг найз, ээжтэйгээ учир зүйгээ олдоггүй зовлонтой. Ээжтэйгээ байхад өдөр болгон түүний хувьд охин нь, ажилтан нь, хамгийн сайн найз гэсэн гурван хүнд байнга хувилах болдог гэнэ. “Энэ байдлын учрыг ухаалгаар олж чадвал аз жаргалтай амьдрах хамгийн сайн аргад суралцах сайхан завшаан болно” гэж би түүнд хэлсэн юм. Хэт ноцтойгоор бүү ханд. Таны амьдралын зорилго бол бусдыг аз жаргалтай болгох юм хэмээн бод, тэдгээр нөхцөлүүдэд тайзан дээр жүжиглэж байгаа байдлаар ханд. Жүжгийн зохиолд гарч байгаагаар зүрх сэтгэлээрээ охин, ажилтан, сайн найзын дүрд тогло. Тэртээ тэргүй жинхэнэ чи гэж оршихгүй байгаа, жүжиглэж байгаа дүрээс илүү бодитой тодорхойлолт байхгүй. Бусдаар сайшаагдаж, өөрөөсөө бүтсэн хувь хүн гэдэг талаас нь харьцдаг байхыг хүсэх нь хамаг зовлонгийн суурь болдог бөгөөд хий хуурмагт үндэслэсэн байдаг.

Уншигч та ”Хүлээгээрэй, амьдралын харууслын нулимс, инээд нь жинхэнэ байдаг юм шүү, тайзны сэтгэлийн хөдөлгөөнүүдийг хуурамчаар үзүүлдэг” гэж үгүйсгэж болох юм.

За тэгвэл, хамгийн сайн жүжигчид тухайн байдал нь хэдийгээр хуурамч байгаа ч тайзан дээрх өөрийн дүрд жинхэнэ байх хүртэл сэтгэлийн хөдөлгөөнөөр тоглодог. Амьдралд харууслын нулимсаар уйлах, инээд хүрэх байдлууд бас л жинхэнэ биш байдаг. Хар буруугаар бодох, тусгаж авах, ихэсгэж дөвийлгөх байдлаар гуйвуулдаг учраас жинхэнэ биш маш олон зүйлийг багтаасан байдаг. Хэзээ ч үзэгдэх байдлаараа байдаггүй гэдгийг санаарай. Өсвөр насны ихэнх хүүхдүүд голдуу эцэг эхийгээ “жинхэнэ байгаасай” хэмээн эелдэгээр шүүмжлэх байдлыг гүнзгий бодолцох хэрэгтэй бөгөөд учир нь, үл ойлголцолоос үүссэн хүмүүс хоорондын харилцааны зовлонтой байдал ба бусдаас тусгаарлагдмал санагдах зэрэг нь өөрийн дүр төрхийг хагуу барьж, юуг үйлдэнэ, юуг үйлдэхгүй дээр уян хатан биш хандсанаас болдог.

Нэг өдөр үхнэ гэдгээс өөр амьдралд багтай зүйл нэгээхэн ч үгүй. Тэр цагт амьдралаа эргэн харахад амьдралдаа хэт ноцтой хандаснаас болж бусдад болон өөртөө зовлон удаж ямар их тэнэг байж вэ гэдгээ ойлгодог. Үхэх үед тэдгээр нь урьд шөнийн зүүдээс хэтрэхгүй санагддаг. Хэрвээ энэ үнэнийг одоо ойлгохгүй бол бардам сэтгэлээр утгагүй гайхуулж, өөрийн дүр төрхийг ууртай, атаач сэтгэлээр хамгаалан, шунал болон харамч сэтгэлээр тэтгэх замаар бусдыг болон өөрийгөө хэрэгцээгүй зовлонд учруулсаар хамаг амьдралаа хий дэмий өнгөрүүлэх болно.

Хэрэв өөрийг чухалчлах тогтсон үзэл баримтлалаа хадгалсаар байгаа бол амьдралын байнга өөрчлөгдөн хувирах, санаанд оромгүй явдлууд хүчтэй салхи хамгийн бат мод болох царсыг таллан хугалах адил таныг мөн хугална. Хэрвээ та далдуу мод шиг уян хатан байвал хамгийн хүчтэй салхи ч унагааж чадахгүй. Миний багш Ешэ лам өөрийгөө хамгаалах, өөрийн бодлыг хэн нэгэнд тулгах шаардлагагүй байсан учраас ямар ч хүнтэй харьцахдаа туйлын өндөр чадвартай байсан юм. Тэрээр хэзээ ямагт бусдад, тэдний амьдрал, санаа бодол, сайн сайхан эсэхэд сонирхдог сон. Түүнтэй байхад хэн ч айх, юмуу уйдах гэж үгүй, тэр ямар ч байдлыг сэтгэл хөдөлгөм, наргиантай болгож, ухааны нүдийг нээх боломж болгон хувиргадаг сан. Хэрвээ бид өөрийн ухаантай бол амьдралдаа Ешэ ламыг хуулбарлах байсан.

Жаргалд хүрэх нууц зам бол амьдралынхаа жүжгийг өөрөө зохиохдоо хамгийн том дайсан болох “өөрийг төвчлөх үзлээ” шоолон бич. Өөрийг тань доромжилж гутаавал, “өөрийг төвчлөх” үзэлд бурууг өг. Ямар ч алдаа гаргасан бай түүний буруутан нь өөрийг төвчлөх үзэл юм. Сайн, муу ямар ч нөхцөлд, уян хатан байх ёстой ба тухайн нөхцөл бүрийг зам мөрд ахиж дэвших таатай нөхцөл болгож, “би”-гийн тухай буруу үзэл таныг дийлэхээс өмнө та урьдаж түүнийг дийл.

Шашин

Бурханы номыг англи хэлнээс монгол хэлнээ орчуулах явцад “шашин” гэдэг үг мухар сохор сүсэг гэдэг үгтэй адил төстэй санагдсан учраас энэ үгээс бэрхшээдэг тухай манай төвийн хичээлд суудаг нэг оюутан өгүүлсэн юм. Түүнд ингэж санагдах нь зүйн хэрэг, учир нь түүний боловсрол эзэмшсэн сургалтын системд бурханы шашины эсрэг коммунист үзэл суртал жинтэй нөлөөтэй байсан юм. Би ч энэ үгийг хэрэглэхээс зайлсхийдэг. Миний хувьд, энэ үгийг мухар сохор сүсэг, хий сэрдэлт, заль мэх, түүхэнд урт удаан үргэлжилсэн, шашины дэмжлэгтэй гарсан аллагат загалмайтны дайнууд, тэрсүүд шашины хүмүүсийг гэсгээж байсантай дүйцүүлэн ойлгодог байлаа. Магадгүй хамгийн үнэнч Христосууд байж болох Катаруудыг Европод хүйс тэмтрэх үед нэгэн Франц тосгонд хэн нь тэрс шашинтан, хэн нь жинхэнэ өөрийн шашинтан гэдгийг нь ялгаж чадахгүй болохдоо цэргийн дарга цэргүүддээ: “Бүгдий нь ал, Ертөнцийн эзэнд итгэдэг нэгнийг эзэн өөрөө ивээж тэнгэртээ төрүүлнэ биз” гэж аймшигт тушаалаа өгсөн гэдэг.

Нэлээд удаан хугацааны өмнө, шинжлэх ухаанч үзэл санаа маань дунд сургуулийн биологийн номын эволюцийн тухай бүлэгт өгүүлсэн ганц өгүүлбэрээр улам цэгцэрч багтай болж билээ. Тэр өгүүлбэрт Библийн сургаалийн Бүтээгчийн талаар “Хүн төрөлхтөний оюунд учирсан аймшигт саа өвчин дотроос бичмэл үгийг хэтрүүлэн хүндэлж, дагаснаас илүү хүнд цохилт байгаагүй” гэж байсан юм.

Намайг та нар, Афганистанд Исламын сүмүүдээс өмнө бүтээсэн Бурханы дүрүүдийг устгах тухай Муллахуудын гаргасан шийдвэрийг ярьж байна гэж таамаглаж болох юм. Энэ үйл нь уучилж болшгүй. Бурханы дүрүүд нь Бурханы зам мөрд ямар их тустай болохыг Мосесийн үеийн Ойрх дорнодын хүмүүсийн дунд түгээмэл байсан бүдүүлэг баримал шүтэхтэй харьцуулах аргагүй. Бурханы дүр нь билиг ухаан хийгээд асрал хайрын сэтгэлийн хослол бөгөөд аминч үзэл болон түүнээс гардаг үзэн ядалт, харам, бардамнал гэх мэт бусармаг санаануудаас бүрэн ангижирсан байдлын бэлгэдэл юм. Бурханы дүрүүдийн үүрэг нь сэтгэлдээ билиг ухаан ба энэрэнгүй сэтгэлийн нэгдлийг үүсгэхийг зорьж байгаа хүмүүст сануулах, дуршлыг төрүүлэхэд оршдог. Лалын шашинтан хүмүүст ариун дээд ном нь эрхэм байдаг шиг Бурханы шашинтануудад Бурханы дүр мөн адил эрхэм ариун билээ. Тэдгээрийн өвөрмөц, хэмжээ сайт дүр нь харсан хэний ч сэтгэлийг амирлуулан адислаж байдаг бөгөөд мунхаг үзэн ядалтаар цэргийн хэрэгслээр онилж харахад ч гэсэн адислаж байдаг.

Би хэсэг найзуудын хамт Афганистаны Жалалбад хотын Кабул голын дээгүүр сүндэрлэх хадан дотор ухаж барьсан Бурханы шашины агуйн сүмийн үлдэгдлийг харж нэг хонож билээ. Мансууруулах тамхины тусламж дэмжлэгтэй хормын дотор гэгээрэх бидний гэнэн оролдлого талаар болсон боловч бид тэдгээр балгаст очсон явдал маань оюун судлах миний зам мөрийн санаандгүй эхлэл байсан юм. Афган хүмүүсийн оюуны нууцлагдмал чадалд миний сэтгэл хүчтэй татагдан бахдаж байсан ба амьдралын тухай Суфи хандлагад нийцүүлэн одоогийн байгаа асуудлаа шийдэх онцгой сайн шийдвэрт хүрсэн юм. Бид Карачи руу явахыг хүсэж байсан бөгөөд бидний салаар гаталсан тэр гол Пакистаны Индус голтой нийлж, ихээхэн ус тэр чигтээ Карачид урссан байлаа. Бид зөвхөн сал хийж, зорьсон газраа хөвөх л байлаа. Тэр гайхамшигт аялал нь нийтийн үзлээр эмчийн амьдралд хүлсэн хөдөлгөөнгүй гавыг сулруулах хөдөлгөөн эрч хүчийг өгч, эцэстээ би Бурханы шашины хувраг болсон юм. Тиймээс би

Афганистаны сайхан сэтгэлтэй, ухаалаг хүмүүст өртэй ба тэдний ихэнхи нь Бурханы дүрүүдийг устгах хүсэлгүй байсан гэдэгт итгэлтэй байна. Тэр шийдвэр бол цөөн хэдэн хүний харалган сэтгэлээс гарсан юм. Бурханы шашинд, Бурханы дүр үгүй болох нь харамсалтай боловч тийм ч их сүйдтэй биш. Бүх зүйл өөрчлөгдөн хувирдаг, мөнх байдаггүй бөгөөд Бурхад хорлогдох бололцоогүй. Бурханы шашинтнуудын сэтгэлийг хамгийн их эмзэглүүлж байгаа зүйл бол түүнийг устгасан тэдгээр харалган хүмүүс өөрсөддөө учруулж байгаа хорлол юм. Тэд өөрсдийнхөө үхлийн шалтгааныг бүтээдэг. Далай Лам багш Төвдүүдийг эх орон, соёл, шашныг нь системтэйгээр доройтуулж байгаа Хятадуудад уурлах бус харин энэрч байхыг олонтаа айлддаг ба Муллахууд өөрсдийн юу хийж байгааг мэдэхгүй байгаа учраас тэднийг мөн энэрэх хэрэгтэй.

Одоо нөгөө “шашин” гэдэг хэцүү үгэндээ орье. Бурханы шашины үзэлд, энэхүү үгийн зүй ёс нь, сэтгэлээ нүглээс буянд хувиргахад хэрэгжүүлдэг үйлүүдийг хэлнэ. Асрал хайр, энэрэл, тэвчээр зэрэг буян нь сэтгэлийн зөв байдал бөгөөд түүнээс өөрт болон бусдад амгалан, сайн сайхан бий болдог. Нүгэл бол эсрэг нь. Нүгэл бол өөрийг болон бусдыг хорлодог уур, атаархал зэрэг сэтгэлийн түгшүүр юм. Далай лам багш, энэ ертөнцөд тухайн нэг өвчнийг анагаах олон төрлийн эм байдгийн адил төрөлхтөнийг аз жаргалд хүргэх олон төрлийн шашинууд байдаг. Дэлхийн тэдгээр шашинууд өөр өөр зан үйл, илэрхийлэлтэй боловч тухайн шашиныг дагагч хүмүүсийг амьтны амь таслах, хулгай хийх, худлаа хэлэх, хов жив ярих зэргийг тэвчиж, тэдгээрийн эсрэг үйлд дадуулах замаар аз жаргалтай болгох нэгэн зорилготой. Өөр шашин шүтлэгтэйгээс болж хүмүүс хоорондоо байлдах, үзэн ядах тохиолдол гарсан гунигтай түүх байсныг Далай багштан онцлон, нэг нэгэндээ өөрийн шашиныг тулгахгүй, шашингүй хүмүүсийг ч үзэн ядахгүй байж эвлэлдэн нэгдэхийг хүсэн уриалсан байдаг.

Шашины нэрийн өмнөөс зөрчилдөх нь хөл бөмбөгийн эсрэг багийн дэмжигчид хоорондоо ноцолдох адил хүүхдийн зан юм. Өнөөдөр дэлхийн хүн ам өсөж буй үед хүний нийгэм түргэн өсөн торниж, тэвчээргүйдлээс ангижрахгүй бол дайны зэвсгээр Бурханы дүрийг устгах биш, хүмүүс нэг нэгнийгээ бүдүүлэг мах нядлагч араншингаар урьд байгаагүй үлэмж ихээр хороох нь Борнеод хүний толгойг таслаад цуглуулдаг хүмүүс аймшигт үйлд дахин ороод байгаатай адил юм. Би хэтэрхий аюул зөгнөөд байгаа бус дэлхийд олон сайхан үйл явдлууд болж байна, гэхдээ үндсэрхэг үзэл, арьсны үзэл, тэвчээргүй байдал дээр үндэслэсэн хорсолт явдлууд удаа дараа тэсрэн гарах нь ихсэж байгаа нь ирээдүйд санаа зовоох боллоо.

Санан дурьдахуй

Гэр бүлийн нэг гишүүн юмуу сэтгэл санааны хямралд байгаа найздаа зөвлөгөө өгөхдөө голдуу “Энэ тийм ч муу биш байна шүү дээ, өөр талаас нь харахыг хичээ л дээ” гэж бид хэлдэг.

Үүнийг өөрсдийнхөө бүх асуудалд хамааралтайгаар хэлж болно. Бурханы сургаалийн гол үйлүүдийн нэг нь юу үйлдэж, хэлж, бодож байгаадаа байнга санан дурьдахуйтай байх бөгөөд учир нь, бид өөрсдийн дадаж зуршсан, төөрөлдсөн байдлаар ертөнцтэй харьцдаг нь ихэнх бэрхшээлүүдийн уг сурвалж болдог. Бэрхшээлүүдийг даван туулахын тулд бид юмсыг алдаатайгаар ойлгодог болохоо таньж бэрхшээлийнхээ зүйлүүдийг үнэн бодит байдлаар нь ойлгох хэрэгтэй болдог. Үйл ба муу сэтгэлээс үүссэн ертөнцийн бүх юмс ариун бус, сэтгэл үл ханах, түр зуурын ба мөн чанараар оршихоос хоосон зэрэг дөрвөн чанартай. Бид төөрөлдсөнөөс болж тэдгээрийг ариун, сэтгэл ханамжтай, өөрчлөгддөггүй ба мөн чанараараа оршдог хэмээн үздэг. Бидний бие мэдээж ариун бус. Хэрвээ биеийнхээ өнгөлөн далдлалт болдог хувцас, энгэсэг, үнэртэнг арилгаж, хэдэн өдөр угаахгүй явахад биеийн угийн ариун бус чанар тодорхой болдог. Тэгээд юу гэж? Асуудлын гол нь бид өөрсдийн биеийг ариун мөн чанартай гэж төсөөлдөг. Биеийн хүсэлд гэнэт автан дурлахад бидний дурлаж татагдсан тэр бие ба хүн нь төгс харагдаж, тэдний алдааг харж чаддаггүй. Яагаад сайн танилаас үл хүндлэл гардаг вэ? Хүслийн халхавчны цаанаас харж байгаа учраас өөрийн санаа биелээгүйд бусдыг бүдүүлгээр буруутгадаг. Хамт байхгүй үед яагаад илүү сайн болдог вэ? Яагаад гэвэл бодит байдлын бүрхэвч дахин нэг удаа халхалсан байдаг. Бие бол төгс бус сэтгэлийн зугаа цэнгэлд автахад зориулагдсан төгс бус багаж хэрэгсэл юм. Бие нь өвчин, өтлөлт, үхлийн зовлонг тагдаг соронз байдаг. Эр эмийн зохиролт үйл аминд хүрч болно, хоол унд аминд хүрч болно, тэр байтугай амьсгалах агаар, ялангуяа Улаанбаатар хотын агаар хүний аминд хүрч болно.

Бие хэзээд хангалуун бус байдаг, үгүй гэж үү? Үс засалт, гоо сайхан, бие бялдаржуулах, гоо сайхны мэс засал, хоолны дэглэм, тураах зэрэг үйлдвэрлэлийн түлш нь юу байдаг вэ? гэж би асууж байгаа юм. Ханилж байгаа хүнийхээ биед бусдыг харахгүй болтлоо тийм хангалуун болж чаддаг билүү? Биеийн яс, эрхтэн бүр өвчлөлд өртөмтгий; бие ба эрүүл мэнд нь түр зуурын байдаг. Хөгшрөх шинж бий болмогц гэнэт балмагдалд орох, үгүйсгэх, хямрах нь биеэ хэвээр байх, хөгшрөхгүй юм шиг буруу санан, биеийн түр зуурын мөн чанарт харалган ханддагыг харуулдаг.

Эцэст нь, бие бол мөн чанараар оршдоггүй. Боловсон хэллэгийг хөөхөд олон утгагүй зүйлүүд байдаг болохоор би түүнд дургүй хэдий ч (энэ миний хувьд алдаа юм, би үүнийгээ мэддэг), хэн нэгнийг царай муутай гэж хэлэхийн оронд сонин царайтай гэж хэлэх хоёрын хооронд ялгаатай гэж бодож байна. Хүмүүст өөрсдийг нь царай муутай гэж хэлбэл гомддог учир нь, тэд биеэ өөрсдийн би-гийн өөрийн мөн чанартай өмч эсвэл нэг хэсэг хэмээн үздэг. Шүхрээр бууж явахдаа хөлөө хугалсан эмчтэй нэг удаа би хамт ажиллаж байлаа. Хэдийгээр тоолшгүй олон удаа хугарсан ясны зургийг харж байсан боловч өөрийнхөө хугарсан хөлний зургийг тэрээр харж зүрхлэхгүй байсан юм. Энэ нь нотлох баримт нь эсрэг талд байгаа ч гэсэн бие бол ”би”-гийн мөн чанартай оршигч нэг хэсэг мөн гэдэг хуурмаг бодлыг баримталдаг болохыг харуулсан тод дүрслэл юм. Бодит байдал дээр өөрийн чанартай бие юмуу би гэж байхгүй. “Сонин царайтай” гэдэг хэллэг нь хэрвээ боловсон хэллэгт дургүй биш бол би-гийн

тухай бодлыг биеэс тусгаарлахад зөвөөр тусалдаг, тиймээс өөрт хамаатай үед тийм ч муугаар хүлээн авахгүй.

Сэрэхүйн хувьд, жаргал ба зовлон нь ариун бус бөгөөд учир нь, илүү их жаргалыг хүсэж тачаадах ба өөрийг зовлонтой болгож байгаа аливаад уурлахад хүргэдэг. Аз жаргалыг сэрэхэд сэтгэл ханамжгүй байх бөгөөд учир нь, хичнээн олон дахин жаргал эдэллээ ч сэтгэл гэсэн хэзээ ч ханадаггүй. Илүүг хүсэн, олон төрлийг хүсэн, жаргалыг хүсэж шунах нь үхэх өдрийг хүртэл үргэлжилнэ. Аз жаргалыг амтлах ханашгүй хүсэл хийгээд ая тухгүй байдалд ихэд дургүйцэх нь одоогийн амьдралд тайван ба сэтгэл хангалуун байдлыг эдлэх бололцоогүй болгодог. Хүсэл шунал ба дургүйцэлээс болж тэнэгээр нүгэл үйлдэж, хойд төрлүүдийг бусниулдаг.

Жаргал өнгөрсний дараа уйтгарладаг, яагаад гэвэл аз жаргал болон түүнийг үүсгэж байгаа зүйлийн түр зуурын шинж чанарыг ойлгодоггүй. Сэтгэл маань жаргал болон түүнийг үүсгэж байгаа зүйлийг хэвээрээ байх мэтээр алдаатай шунадаг. Зовлон болон зовлонгийн шалтгаанууд ч гэсэн түр зуур байдгийг ойлгоогүй учраас сэтгэлийн хямралд ордог. Хямарсан хүмүүс өөрсдийгөө зайлж гарахааргүй, төгсөшгүй аймшигтай байдалд баригдсан мэтээр боддог.

Сэрэхүйг жинхэнэ оршихгүй гэдгийг ойлгохгүй байснаараа жаргалыг жинхэнэ оршигч чанартайгаар тусгаж авдаг бөгөөд дараа нь үүрд түүнийг дахин нээхийг оролддог. Өнгөрсөн жаргалын хий үзэгдэлүүд одоогийн жаргалдаа бүрэн дүүрэн баярлах, тэр байтугай жаргал олох бололцоог өгдөггүй. Одоогийн байдлыг хэт дөвийлгөсөн өнгөрсөн цагийн дурсамжуудтай байнга харьцуулж байдаг. Түүнчлэн зовлонг жинхэнэ оршигч чанартайгаар тусгаснаар хэзээ ч зугтаж чадахгүй аймшгийн чөтгөр мэт санадаг.

Сэтгэл бол цаг хугацаагаар урсах танин мэдэхүйн урсгал юм. Муу сэтгэлүүд болон тэдгээрийн хөрөнгийг агуулдаг учраас ариун бус; агшин тутамд сэтгэлийн мэдрэхүй өөр өөр учраас түр зуурын байдаг. Гал халуун хайраа үүрдийнх гэж тунхагладаг боловч удаан тогтдоггүй бөгөөд цөөн хэдэн жилийн дараа хөрч, цэвдэг үзэн ядалтаар солигдож болдог. Хэн нэгэн ойр дотны хүнээ алдаад тайтгаршгүй их гашуудаж байх нь нэг л дурсамж болж; дахин инээж чаддаг болно. Хэзээ ч сэтгэл дүүрэн байдаггүй учраас ертөнцийн эгэл жирийн сэтгэл эс хангалуун байх бөгөөд шалтгаан, нөхцөлүүдээс хамааралтай учраас өөрийн мөн чанартай оршихгүй.

Үргэлжийн хувирах ертөнцөд юмсыг байнга хэвээрээ байх мэт хуурмаг төсөөллийг ойр барих нь өнгөрснийг санан дурсах дурсамжаар сэтгэлийг дүүргэж, одоогийн байдалд баясах чөлөөгүй болдог. Нас ахих тусам амьдрал маань, нийлэг ингээд дууслаа гэсэн нэгэн урт дүйнгэтсэн сэрэхүй болж хувирдаг. Бидний сэтгэл, бидний өөрсдийн би байнга өөрчлөгдөж байдаг. Өнгөрсөнд тухайн сэтгэлийн хөдөлгөөнтэй үйл явдлын үед байсан тэр хүн одоо үгүй болсон. Өнгөрснийг орхиж чадахгүй байх тарчлаан гагцхүү бидний сэтгэл ба бид өөрсдөө үүрд хэвээрээ хэмээх буруу үзлийг хаясан цагт зогсоно. Хаана ч хатуу тогтсон бодит байдал гэж байхгүй. Амьдрал бол сэтгэл удирдагч нь болдог сэтгэл ба ертөнц хоёрын хоорондох бүжиг юм. Сэтгэл нь хатуу бүтсэн би-г чухалчлах үед бүжиг дэггүй болно. Өөртэйгээ адил бүтсэн нэг ч юм үгүй гэдгийг мэдвэл бүжиг гайхамшигтай болно.

Ариун бус, үл ханах, түр зуурын, мөн чанартай оршихоос хоосон зэргийг ойлгосон билиг ухаан нь зовлонгоос гэтлэх үүд юм. Энэ нь үлэмж их энэрэнгүй сэтгэлийн бат суурь болдог, учир нь өөрийн зовлон болон түүний шалтгааныг ойлгосноор бусдын зовлонг ойлгож, мэдэрч чаддаг.

Хий үзэгдэл

Бурханы шашины ертөнцийг үзэх үзэл дундаас ойлгоход хамгийн хэцүү үзэл санаа бол бидний шууд харж чадахаас өөр төрлийн орнууд оршдог хэмээх номнол юм. Бурхан багш, биднийг тэнгэр, тэнгэр бус төрөлтөн, хүн, адгуус, бирд, тамын төрлүүдэд эхлэлгүй тойрогт төрдөг хэмээн айлдсан байдаг. Үйлээс хамааран нэг төрлийн түвшнээс нөгөө түвшинд эргэлдэхдээ үхэл болон бодит байдлыг эс мэдсэн мунхаглалаас үүсэлтэй үйл ба муу сэтгэлүүдийн хяналтан дор байхаас хэзээ ч чөлөөтэй болдоггүй. Амьдралын зовлонт хүрдэнд баригдсан байдал нь гагцхүү бодит байдлыг мэдэх билиг ухааныг үүсгэж, сэтгэлээсээ бүх төөрөгдөлийг арилгаснаар зогсоно. Дараа нь, гэгээрэлд хүрэх зам мөрийн чухал тал болдог ихэд энэрэнгүй сэтгэлийг төлөвшүүлснээр бусдад туслахын тулд дээрх төрлүүдийн аль нэгэнд сонгон төрөх чөлөөтэй болдог. Мунха болон амиа бодсон байдлыг даран дийлснээр үйлийг үгүй болгосон байх учраас хэзээ ч дахин зовлонд нэрвэгдэхгүй болно.

Лам багш нарын айлдвараас бирд, там, тэнгэрийн амьтад байдаг тухай сонсоод тэдгээр төрлүүд байдаг гэсэн шууд бодит орныг хүлээн зөвшөөрч чадахгүй байлаа. Бурханы сургаал дотор сэтгэл судлалын тухай энгийн бөгөөд тодорхой тайлбарласанд алмайрсан би бусад төрлүүдийг нарийн тод өгүүлсэнийг хүний сэтгэлийн аливаа юмсыг мэдрэх өргөн хүрээтэй зүйрлүүлсэн хэмээн бодож байсан юм. Миний энэ таамаглал тамын тухай дүрслэлд төмөр соёотой аварга шувуу дайрдаг тухай сонсоод улам баттай болсон юм. Бурхан багш эдгээр шувуу болон тамын чөтгөрүүд сэтгэлээс гарсан хэмээн айлджээ. Шувууны тухай дүрслэл нь шизофринитэй миний өвчтөнг санагдууллаа, түүнд үзэгддэг төмөр соёотой аварга том шувуу өөрийг нь хөөн тарчлааж, эр эмийн олон янзын гаж үйл үйлдсэнд буруутган, алахаар завддаг тухай ярьдаг байсан юм. Там нь шизофрини-хий юм харах өвчин, бирд нь харамч сэтгэл, неврозоос болж сайхан амьдарч чадахгүй хүмүүсийг хэлж байгаа нь нээрээ юм байна гэж боддог байлаа.

Харин адгуусны төрлийг хүлээн зөвшөөрч байлаа, гэхдээ миний сэтгэл дунгийн биед орсон байж болохыг төсөөлөхөд хэцүү байлаа. Би дун идэх дуртай байсан юм. Үр хөврөл байхдаа миний бие, сэтгэл дунгаас илүү бүдүүлэг байсан юм байна гэж би бодлоо. Хэрвээ бүх төрөлхтөний сэтгэл гэгээрэх үндсэн бололцоо нь адил юм бол, жишээ нь, миний болон туулайн сэтгэлийн ялгаа нь сэтгэлдээ бус, сэтгэлийн тулгуур болдог мэдрэлийн системээрээ ялгаатай гэдэг нь учир шалтгааны хувьтай санагдаж байлаа. Хэрвээ миний сэтгэлийг туулайны уураг тархинд шилжүүлбэл (ачаалагдах гэж хэлж болох уу?) туулайнаас өөрөөр өөрийгөө яаж илэрхийлж чадах вэ? Мөн туулайн сэтгэлийг хүний мэдрэлийн системд шилжүүлбэл гэнэт бий болсон дэвшилтэт техник хангамжаар хүний оюун ухааны чадвар гарч чадна.

Тэнгэр бус төрөлт амьтадын дүрслэл нь дайнч, эрх мэдлийн төлөө хүсэл, тэдэнтэй их ойрын шүтэлцээтэй боловч тэднээс илүү жаргалтай тэнгэрүүдэд хорссон атаархалд сэтгэл нь автсан төрөлхтөн юм. Тэнгэр бус төрөлхтөн шиг сэтгэлтэй хүмүүсийг би нээрээ мэднэ гэж бодож байлаа. Тэнгэрүүд нь биеийн дээд жаргалд умбахаас эхлээд бясалгалаар дан сэтгэлийн амар амгаланг хүсдэг хүртэл олон янзын түвшинтэй. Мансуурах бодис хэрэглэх юмуу, дур тавих эсвэл энэ хоёрын нийлмэл нь тэнгэрийн байдлын жишээ байж магадгүй шүү? гэж бодлоо. Эхэндээ би ингэж л бодож байсан юм. Харин Лам багш нар тэдгээр бусад төрлүүдийг

бодитой оршдог гэж айлдсаар байв. Жишээ нь, бирдүүд энэ дэлхий дээр дүүрэн байдаг ч бид тэднийг харж чаддаггүй, учир нь хүмүүсийн үйлийн үр хүний ертөнцийг тусгаж байхад тэдний үйлийн үр бирдийн зэвхий, гандуу ертөнцийг тусган хардаг. Бидний ердийн ойлголтоос огт өөрөөр гадаад ертөнц нь өөрөөсөө бүтэж оршсон хатуу бодит байдал биш, тухайн хүн бүр ертөнцийг мэдрэх байдал нь өөрийнх нь сэтгэлтэй холбоотой. Хатуу биет, шингэн, дулаан, хөдөлгөөн зэрэг физикийн нөхцлүүд болон шороо, ус, гал, хий зэрэг дөрвөн махбодь ертөнцөд оршдог, гэхдээ тэдгээр ч гэсэн сэтгэлээс бүрэн тусгаар биш. Материйн үзэгдэх байдал, түүний “бодит байдал” нь түүнийг харж байгаа ухамсараас хамаарна.

Таны хувьд, эсвэл миний хувьд ямар ч ертөнц байлаа гэсэн ертөнцийн бодит байдал гэдэг бол хувь хүн бүрээс хамаарах учраас маш харьцангуй юм. Жишээ нь, нэгэн шингэн зүйл хүнд ус гэж харагдаж байхад бирдэд бохир, уухын аргагүй зүйл, тэнгэрт рашаан гэж харагддаг тухай Бурхан багш айлджээ. Нэг шингэн зүйл гурван өөрөөр харагдах бололцоотой байна, тус бүрийг харах нь тухайн харж байгаа сэтгэл дэх үйлийн идэвхжлээс хамаарна. Өөрөөр хэлбэл, ертөнцийн юмсыг бид өөрсдөө мэдрэхээс нааш таны, миний ертөнц дээр мэдэрч байгаа зүйлүүд оршдоггүй.

Физикчид гэрлийг долгион байдлаар хэмжвэл долгион болдог, хэрвээ гэрлийг матери байдлаар хэмжвэл матери болдог тухай өгүүлдэг. Энэ бол тухайн ажиглаж байгаа зүйлийн бодит байдлыг субъектив сэтгэлээр тодорхойлдог болохын орчин үеийн жишээ мөн үү? Таны найз бүсгүй гагцхүү таны хажууд байгаа үед л оршино. Бусад үед тэр ахдаа дүү нь, ээждээ охин нь, даргынхаа ажилтан нь, өөртөө бол өөрөө байдаг. Таны сэтгэл таны найз бүсгүй гэж мэдэх ганц тэр хүн юм. Тэр байтугай дараа нь тэр өөр хүний найз бүсгүй болоход ч мөн адил шүү дээ, тэнгэр өршөөг.

Би хувраг болсоныхоо дараа Катманду хөндий харагдах уулын үзэсгэлэнт оройд Копан хийдийн дэргэд эмнэлэг байгуулсан юм. Төвд болон Балба хуврагууд, ойролцоо тосгонд суудаг хүмүүс болон хааяа нэг барууны хүмүүст анхан шатны эмнэлгийн тусламж үзүүлдэг байлаа. Австрали нэгэн эмэгтэй эмнэлэгт ирж, тэрээр насан туршдаа хий үзэгдлүүдийг харсан тухай ярьж, Бурханы сургаалд гардаг бирдийн тухай тодорхойлолт түүнд таалагдсан байж, учир нь түүний юу харсаныг баталж байсан учраас тэр гэлээ. Сэтгэл судлалын анги дүүргэсэн тэрээр үнэнч шударга эмэгтэй байлаа. Хүмүүс түүнд үл итгэсэн байдалтай ханддаг болохоор өөрт юу үзэгддэг тухай ярихаа больсон гэлээ. Дараа нь тэр хийдийн гадаа орой болгон Бодь модны доор бөөрөнхий, хар, үстэй, том нүдтэй хий үзэгдэл харагддаг болсон тухай ярьсан юм. Нэг жилийн дараа Аргентинаас ирсэн нэг залуу мөн тийм зүйл модны доогуур явахыг харснаа ярьсан юм. Дахиад нэг жилийн дараа манай төвийн хичээлд суусан найз бүсгүйгээ бясалгалын хичээл өндөрлөхөд авахаар нэг залуу ирсэн юм. Бурханы шашинд сонирхолгүй тэрээр найз бүсгүйгээ бясалгалд сууж байх хооронд явган аялал хийхээр явжээ. Тэрээр амьдралдаа хий үзэгдлийг хэзээ ч хараагүй байж. Сүүлчийн оройн бясалгалын үеэр айж сандарсан хүний дуу гаднаас сонсогдлоо. Нөгөө бөөрөнхий, хар найз маань залуугийн майханд ороод харагдсан нь тэр байж. Хий үзэгдлийг харагддаг тухай би хэнд ч хэлээгүй учраас өөр хүмүүс мэдээгүй байлаа. Гурван өөр гэрчийн ярианаас үзэхэд нээрээ л ямар нэгэн зүйл байдаг юм байна гэж бодох болсон юм.

Нийтийн зөвшлөөр орших

Жинхэнэ би-гийн сэтгэл зүйн хаалтаа зад татан эрх чөлөөнд гарч, хэмжээ захгүй аз жаргалтай байсан амьдралын тоотой хэдэн таатай явдлыг хүн бүхэн санан дурсдаг. Хэдийгээр саад бэрхшээлүүд эсрэг талд овоорч байлаа ч гэсэн тэдгээр нандин мөчүүдийг дахин олж авах, нэмэгдүүлэх хүсэл нь амьдралыг хөдөлгөж байдаг гүн их итгэл найдвар юм. Хамт амьдарч байгаа хүндээ өөрийнх нь “жинхэнэ би”-г сайхан, хайр татсан, наргиантай, уужуу тайван, ухаалаг хүн гэж мэдүүлэхийг хүсдэг. Жинхэнэ би-гээс гарч боломгүй хараалын муу үг хэлчихвэл хэлээ хазаж, “Би яагаад ийм хүн байх ёстой вэ, яагаад зүгээр л би байж болохгүй гэж?” хэмээн боддог.

Харин бусдад алдаа гаргах өчүүхэн ч зай өгдөггүй. Бусад хүмүүсийн зан байдлыг шинжихдээ жинхэнэ тэднээс гарсан мэтээр дүгнэн, өөрөөсөө бүтсэн дуртай эсвэл дургүй хүрмээр зан чанартай хэмээн хөдөлшгүй бодлыг бүтээн бий болгодог. Тийнхүү бидний ертөнц тодорхой нэгжүүдээс бүтсэн болж, өөрсдөө, найз нөхөд, дайснуудыг өөрөөсөө бүтэж оршсон байдлаар харж, эмгэнэлтэй нь бусдыг болон өөрсдийгөө өөрчлөгдөж болохыг анзаардаггүй. Хүүхэд байхдаа сансарын нисгэгч болохоос эхлээд рок од болно, тэгснээ алдартай хөл бөмбөгчин болно гэх мэтээр өөрсдийнхөө тухай бодлыг амархан хувиргадаг байсан бол том болох тусам тэр уян хатан байдлаа алддаг. Өөрсдийнхөө тухай сайн болон муу гэж тогтсон үзэлтэй болж, тэдгээр нь өөрийн гэсэн мөн чанарын нэг хэсэг хэмээн боддог. Ийнхүү өөрийн дүр төрхийг сэтгэлдээ хатуу тогтоох нь маш том алдаа болдог. Буруу байгаад зогсохгүй амьдралын зайлшгүй болон байнгын огцом өөрчлөлтөнд дасан зохицох чадварыг сулруулдаг.

Цааш өгүүлэхээс өмнө, жинхэнэ би-гийн тухай санаа огт хуурамч гэж хэлэх ёстой, учир нь бидний бодож байгаа “жинхэнэ би” оршдоггүй. Энэ бол буруу үзэгдэл. Цөлд төөрсөн жуулчид зэрэглээ өөд ус хэмээн бахардталаа тэмүүлдэг шиг жинхэнэ би-гээ нээж, гадаад ертөнцөд түүнийгээ үзүүлэхийг хүссээр амьдралаа хий дэмий өнгөрөөдөг. Түүнчлэн, бусдад алдаатайгаар тусгасан тэдний жинхэнэ би-д шунал ба уурын зохисгүй сэтгэлээр хандах нь амьдралд үргэлжийн зовлонгийн урсгалыг бий болгодог.

“Би” гэж бодох бүрт сэтгэлд буй болдог би-гийн тухай төрх алдаатай төсөөлөгддөг. Өөрөө бүтэж оршсон, хувиршгүй нэгж байдлаар буруугаар төсөөлөгддөг. Цөлийн зэрэглээ нь ус байдлаар үзэгдэх боловч жинхэнэ ус байхгүй адил, үзэгдэх байдал нь хэдий тийм байлаа ч “би”-д хувиршгүй, тусгаар орших эзэн байхгүй.

Оршиж буй эзэн буюу би нь бие ба сэтгэлийн нэгдэлд чиглэсэн нэр буюу “би” хэмээх бодлоор бий болдог нийтийн зөвшилцөл төдий юм. Тиймээс зөвшилцөл төдий би нь нэр ба нэрлэгдэж байгаа бие ба сэтгэлд тулгуурласан төдийд оршдог. Нэр ч, бие ба сэтгэл ч би биш. Хэрвээ “би” нь төсөөлөгдөж байгаа шигээ тусгаар нэгж байдлаар оршдогсон бол түүнийг эрэхэд олдох байсан. Гэтэл би нь ангид тусгаар нэгж биш, учир нь, хэрвээ хувиршгүй, ангид тусгаар би-г бие ба сэтгэл дотор, эсвэл энэ хоёроос салангид эрвэл олдохгүй. Ангид тусгаар би ийнхүү оршихгүй байгаа нь нийтээр зөвшилцсөн би-гийн уг чанар буюу “хоосон” чанар юм.

Бидний амьдралд тааралдаж байгаа хүмүүс болон бид өөрсдөө зөвшилцөл төдий, бидний үргэлж боддог байсан ахуйгаар хоосон гэдгийг нээх нь сэтгэл зүйн урагш чиглэсэн том алхам

юм. Бүх зовлонг бий болгож байсан хуурамч төсөөллүүдийг үгүй болгож, өөрт болон бусдад хорлолгүй амьдрах бололцоотой болдог. Итгэж байсан шиг тогтсон гадаад ертөнц ул мөргүй алга болоход эхэндээ бага зэрэг аймаар байснаа дараа нь удалгүй юмсын огторгуй адил хоосон чанарт дасан зохицож, тэнгэрт гарамгай алхагчид болдог. Анх удаа шүхрээр үсрэн онгоцноос буухад миний хөл өшигчиж, ардаа орхисон хатуу тогтсон гадаад ертөнцийг хайн тэмтчиж байлаа. Дараагийн удаа үсрэхдээ шинэ нөхцөлд дасаж, уналтаа тогтворжуулж, сэтгэл догдлох, чөлөөтэй болохоор яарч байлаа. Үүнтэй адил оршин буй бүхнийг зөвшилцөл төдийд ойлгох нь үргэлж эрж байсан эрх чөлөөг олгох юм.

Оршин буй бүхэн зөвшилцсөн буюу харьцангуй бодит байдал ба туйлын бодит байдал гэсэн хоёр бодит байдалтай. Зөвшилцсөн бодит байдал нь нийтийн зөвшлөөр бий болдог. Жишээ нь, таныг гадаа гараад цаг агаар шинжээд ир гэж гуйсан байя. Таны харж байгаа зүйл “хөх тэнгэр” хэмээх нийтээр зөвшилцсөн нэрд тохирно. Та буцаж ирээд цаг агаарын мэдээг хэлэхэд “хөх тэнгэр” хэмээх үгс нь нөгөө хүний сэтгэлд зөв дүрслэлийг бий болгож, таныг юуны тухай ярьж байгааг тэд мэднэ. Тэд гадагшаа гарч өөрсдийнхөө нүдээр хараад таны хэлсэн мэдээтэй санал нийлнэ. Энэ бол тэнгэрийн тухай нийтээр зөвшилцсөн үнэн байдал юм. Нийтээр зөвшилцсөн хөх тэнгэр харагдахын хамт өөрөө бүтэж оршсон, бусад бүхнээс тусгаар хөх тэнгэрийн буруу төсөөлөл бий болдог. Энэхүү буруу төсөөлөл нь бидний сэтгэл дэх алдаанаас гардаг болохоос тэнгэрээс гарахгүй. “Туйлын” хэмээх нэр нь жирийн нөхцөл байдалд тухайн нэг зүйл, хэн нэгнийг яг чухам юу болохыг шинжлэхэд анхаардаггүй болохыг илтгэж байгаа юм. Нэг нэгэндээ болон эргэн тойрныхоо юмсад хандахдаа бид зөвхөн нэрд тулгуурладаг. Гэвч хүн, тэнгэр, ямар нэг зүйлийг туйлын шинжлэлд оруулж, яг юу болохыг нь олохыг хичээвэл тухайн яг орон болох юу ч олддоггүй. Тиймээс оршин буй бүхний туйлын бодит байдал нь өөрийн эрхээр бүтэж оршихоос хоосон.

Бидний амьдарлын бүх зовлонгууд “би”-г өөрийн эрхээр орших байдлаар буруу төсөөлөхөөс эхэлдэг. Энэхүү буруу төсөөлөл нь нийтээр зөвшилцсөн би-гийн зөв үзэгдэлтэй холилдсон байдаг, тиймээс хуурмаг үзэгдэл ба бодит байдал хоёрыг ялгахад хэцүү байдаг. Сэтгэл маань тэр хуурмаг үзэгдэлийг үнэн гэж барьдаг ба тэр бодлоо жинхэнэ би-тэй үлэмж их адилтгадаг. Буруу би-г эрхэмлэснээр амиа бодон бусдын хүчээр жаргалд хүрэхээр хөөцөлдөж, түүнийг хорлолын эсрэг ууртайгаар хамгаалдаг. Эдгээр сэтгэлийн хөдөлгөөн нь жаргалыг зөвхөн холдуулж, зовлонг өөртөө татдаг. Бусдыг хайрласнаар жинхэнэ аз жаргалд хүрэх бөгөөд өөрөө болон бусдын хооронд ямар ч ялгаа үгүйг ойлгосноор бусдыг жинхэнээр хайрлаж чадна. Хамаг амьтан бүгд аз жаргалтай байх, зовлонгүй байхыг хүсэх нь адил бөгөөд бүгд нийтийн зөвшилцөл төдий оршдоггоороо адил. Бусдыг шунал, үзэн ядалт, үл тоомсорлох зэргээр ялгаварлах нь толинд туссан хоёр тусгал нэг нэгнээ дурлаад юмуу үзэн ядаж байгаа шиг бодитой бус.

Бурхан багшийн, өөрөө бүтэж оршдоггүй гэсэн утгаараа юмс зөвхөн нийтийн зөвшилцөл мөн хэмээх хувьсгалч гүн үзэл нь зовлонг сэтгэлийг эдгээх ариун рашаан юм. Сэтгэлзүйн шорон болон төөрөлдсөн сэтгэлийн жинхэнэ хэмээн боддог тусгалуудаас чөлөөлөгдсөнөөр, нөгөө талд нэвтрэн гаргаж чаддаг.

Сэтгэлийн хямрал

Сэтгэлийн хямрал бол туйлын их зовлонтой байдал ба түүнийг саяхан Английн БиБиСи радиогийн нэвтрүүлэгт оролцсон ийм зовлонтой хүмүүс харанхуй, цөхрөл, гутралын нүхэн шорон, зугтаан гарахын аргагүй амьсгал боом халуун өрөө, хооронд нь гагнасан төмөр товчтой хүнд хүрэм, наалдамтгай хар давирхай дээр алхахтай адил зэргээр дүрслэн ярьсан юм. Амьдралаа хянаж чадахгүй болох, өөдрөг сэтгэлээ алдах, жаргалыг мэдэрч чадахаа болих шинжийг агуулдаг. Юу үйлдэхээ мэддэг байж болох юм, гэхдээ түүнийгээ үйлдэж чаддаггүй.

Ойр дотныхноосоо үхлээр хагацах, өвчлөх, ажилгүй болох, заримдаа сэтгэцийн хэвийн бус хямралд орох зэрэг нь сэтгэлийн хямралын урьдчилсан байдал болох талтай. Харин Бурханы номд, сэтгэлийн хямралд орох гол шалтаг бол би-г эрхэмлэх буюу өөрийн бие, сэтгэлийн жаргалыг бусдаас илүү тавьснаас болдог хэмээн үздэг. Би-г эрхэмлэх гэдэг нь таныг телевиз үзэх, спортоор хичээллэх, найзтайгаа ярьж байх үед эхнэр юмуу нөхөр тань ямар нэг зүйл гуйхад ундууцахыг хэлнэ. Мөн амттай сайхан хоол идэх, үзвэрийн газар хамгийн тухтай суудал авах, хамгийн сайн дүн авах, нөлөөтэй хэн нэгнээр магтуулахыг хичээх зэрэг хүслийг хэлнэ.

Бид бүхэнд байдаг өөрийн амиа бодох энэ өчүүхэн зүйлээс яагаад том айхтар өвчин болох сэтгэлийн хямрал үүсдэг вэ? Үндсэн хоёр шалтгаантай. Нэгдүгээрт, амиа бодох үзлээс үүсэх зовлон нь улам арвижих шинжтэй. Хүссэнээ авч чадахгүй болох юмуу хүссэнийг нь болиулбал ихэнхдээ тэр байдалд инээд хүрмээр хэтрүүлэн ханддаг. Өөртөө болсон явдлуудыг эргэцүүлээрэй л дээ, өчүүхэн зүйлээс болж хичнээн олон гэр бүлд томоохон маргаан гарч байсан бэ? Өөрийгөө тэнэг зан гаргасандаа олонтаа зэмлэж муушаасан ч дараа нь олонтаа давтсаар байдаг. Гэр орон, ажил, клуб, хаа ч амрахаар очсон, ямар ч газар байлаа гэсэн амиа бодох нь бусдаас үргэлж хөндийрүүлдэг. Амьдралд тохиолдсон өчүүхэн бүтэлгүй зүйлүүд хуримтлагдсаар өөртөө итгэх итгэлийг доройтуулан, аз жаргалтай байх бололцоогүй болж, өөртөө харуусах сэтгэлийн хямралын эргүүлгэнд автдаг.

Өөрийн амийг бодсоноос сэтгэлийн хямралтай болох хоёр дах шалтгаан нь амиа бодсоноор аз жаргалыг найдвартай төрүүлдэг бусдыг бодох үйлээс хөндийрүүлдэг. Өөртөө хэт төвлөрөх нь бусдын тусыг бодолцох санааг бүрэн хааж, бусдад аз жаргал хүртээхээ больдог. “Би гунигтай байна” “Би жаргамаар байна” гэсэн өөртөө төвлөрсөн бодлын хүрд толгойд эргэлдсэнээр гэр бүлийн хүмүүс, найз нөхдийнхөө төлөө санаа тавих нүд харалган болж, тэдэнд юугаар ч туслахаа больдог. Бусдаас хариу асрал хайрыг мэдрэх юмуу бусдыг жаргалтай болгосон сэтгэлийн хав баясал үүсэхгүй байснаар өөртөө итгэх итгэл улам доройтсоор байдаг. Бусдыг жаргалтай болгосноос үүсэх баясал нь ариун байхын учир нь өөрийн зугаа цэнгэл шиг олон дахин хүсэх, хэзээ ч сэтгэл ханадаггүй ариун бус жаргалаас өөр юм. Ертөнц болон хайргүй хүмүүсээс тусгаарлагдахыг мэдрэн, зовлон, өөртөө үл итгэх, галзуурах дөхлөө гэдэг бодолд живдэг. Энэ бол сэтгэлийн хямрал.

Бурхан багш сэтгэлийн хямралыг явцуу хүрээнд юмуу ялгаварлах байдлаар оношлоогүй. Бид бүхэн бүгдээрээ амиа бодох үзэлтэй бөгөөд түүнд амьдралаа атгуулан бусдыг хайрлах, энэрэх сэтгэлээ гэвэл сэтгэлийн хямралын аймшигт замаар орох аюултай. Сэтгэлийн хямрал нь зовлонг үүсгэдэггүй, сэтгэлийн хямрал нь зовлон, хамгийн хэцүү зовлон юм. Ямартай ч

хүний төрөлд. Сэтгэлээр хямрагчид үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байж болох юм, гэхдээ өөр төрөлд бүр ч дор зовлонтой байх талтай. Сэтгэлийн хямрал бий болоход бидний оролцох тал нь хуруугаараа бурууг зааж, зэмлэх явдал биш. Хэрвээ шалтгаан нь өөрийн сэтгэлд байгааг ойлгож чадвал, эм нь бас сэтгэлд байдагийг ойлгоно.

Сэтгэлийн хямралд өртсөн хүмүүсийн өөртөө итгэх итгэл нь сөнөж үгүй болсныг Шинэ үеийн гүн ухааны онолууд “өөрийгөө эхлээд хайрла” үзлээр эдгээхийг эрмэлздэг. Гэхдээ энэ бол шалтгаан болохоос эм бус. Энэтхэгийн их бандида Шантидева ”Та жаргалтай болохыг хүсвэл өөрийн жаргалыг хэзээ ч бүү бод” хэмээн айлдсан. Оронд нь бусдын жаргалыг бодоорой.

Хэрвээ, “Тэгвэл би өөрийгөө зовлонгоос хамгаалах хэрэггүй гэж үү?” хэмээн асуувал,

Шантидева: “Өөрийгөө хамгаалахыг хүсвэл бусдыг байнга хамгаалах хэрэгтэй” гэж айлджээ.

Бурхан багшийн гаргасан жаргалтай болох эмийн жор нь өөрийг мартан, бусдыг хайрлах явдал юм. Хэдийгээр бусдын хайрыг хүсээгүй байлаа ч гэсэн, гэр орны хүмүүс, найз нөхдөө хичнээн их анхааран халамжлах тусам төдий хирээр биднийг хайрладаг. Энэ нь тун энгийн, мэдээж, гэхдээ бид түүнийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Зөвхөн гэр орны хүмүүс болон найз нөхдөөр зогсохгүй бидний амьдралын зорилго бол төрөлхтөн бүрийг зовлонгоос хамгаалах явдал юм. Хамаг амьтадыг халамжлах энэхүү сэтгэлийн хандлага билиг ухаантай хосолбол бид хэзээ ч зовлонг мэдэхгүй.

Прозак зэрэг тайвшруулах эмийг жорлонд хаяад усы нь татна гэсэн үг үү? Үгүй, одоохондоо болоогүй. Багаас эхлэн бусдад тусалдаг болох хэрэгтэй. Хэлүүлэлгүйгээр хогоо асга, гал зууханд тарьсан хогоо өөрөө цэвэрлэ, бусдын гутлыг цэвэрлэ. Хаяа инээмсэглэж бай. Өөрийн амин жаргалын эсрэг сөрөн зогсох хийгээд хамаг төрөлхтөний боол, найз хэмээн өөрийгөө зарлах зориг, шийдвэрийг аажмаар үүтгэ. Үүний дараа, телевизээр хөл бөмбөг үзсэнээс илүү гал тогоонд бусдын тарьсан хогыг цэвэрлэх нь таныг аз жаргалтай болгоно. Энэ нь сэтгэлийн хямралыг арилгаад зогсохгүй, амар амгалангийн зам мөрт оруулна.

Гэргийтэн бус амьдрал

1972 онд хэсэг аялагчид адал явдал хайн дорно зүгт зорчих замд Энэтхэг-Пакистаны дайн болж байсан тул Афганистаны Жалалабадад аргагүй зогсож, наргиан наадам зохиолоо. Итали найруулагч Феллинигийн найруулсан Сатирикон киноны нэг дүрийг дуурайн, нүүр амаа ихэд будаж шунхадсан, эмэгтэй хүний намбаар алхах Африк-Америкийн эрлийз, гомо залуу наргиж байснаа мансууран сууцгааж байсан залуучууд, бүсгүйчүүдийн өрөөнд аяархан орлоо. “Хмм, гаж эр, эмийн явдалтнууд” гэж гетеросекс (өөр шиг нь ижил хүйстэн бишийг гажигт тооцдог) залуусыг дооглон, мушилзаад наргиан болж байгаа өрөөнд буцан орлоо. Сексийн хувьсгал бүрэн эрчээ авсан үе байсан болохоор, ичимхий, даруу байх нь тэр үеийн “нойтон хамуу” өвчинд тооцогддог байлаа. Австралийн сонины сэтгүүлч тухайн үеийн нийтлэг сэтгэл зүйг “Миний бодлоор, гэргийтэн бус байх нь энэ хувьсгалын огцом эсрэг тал болоод байна” гэж бичиж байсан юм.

Гэтэл барууны чөлөөт сексийн хувьсгалчдаас олон хүн Бурханы шашинд орон, хувраг болж, хурьцал үл үйлдэх сахил санваар авсан. Тэд яагаад ингэв? Яагаад гэвэл, тэд өөрсдийн мэдэрч байсан хичнээн их эр эмийн явдал, мансууруулах бодис, рок-н-ролл хөгжимд цэнгэж жаргасан ч гэсэн сэтгэл ханахгүй, сэтгэл дүүрэн болохгүй байгааг Бурханы сургаал баталсантай тодорхой хэмжээгээр холбоотой. Яагаад хэмээх шалтгааны Бурхан багшийн тайлбар болох өөрийг төвчилөх сэтгэцийн ноцтой буруугаас үүсдэг омог, хүсэл шунал, уур зэрэг хяналтгүй сэтгэлийн хөдөлгөөнүүд гэдэг нь тэдэнд бүгд маш тодорхой байлаа. Ялангуяа, хувраг болох бахдалт хүсэл Лам багш нарын өөрсдийнх нь байгаа байдлаас төрж байлаа. Энэтхэг, Балба орох зам зуурт хиппи нарыг хүн болгон хайртай хүүхэд мэтээр угтан авч, харьцдаг байсан юм. Дэлгүүрт Хашиш мансууруулах бодис наймаална, марихуан зэрлэгээрээ хаа сайгүй ургана, цэцэг барин золгохыг уриалдаг хүүхдүүд өөрсдийгөө диваажингийн орныг оллоо гэж бодоцгоож, өөрсдийгөө Аян замын Хаад мэтээр төсөөлж байлаа. Дараа нь Төвд лам нартай уулзлаа.

Лам нар тэдэнд “Та нарын толгой баасаар дүүрэн” гэж олон хэлээд байх шиг санагддаг байлаа. Ийм маягаар яривал хиппи нар шууд орхиод явдаг байсан ч, лам нарыг зүгээр нэг орхиод явчихаж болохооргүй “чка” хүмүүс байлаа. Лам нарт алиа хошин зан, эрх чөлөө, тайван байдал, аз жаргал зэрэг бусдын эрэлхийлдэг бүх зүйл байлаа. Хиппи нар бардам зангаа залгин, лам нараас “Та нар юу гэх гээд байгаа юм бэ?” гэж асуух шиг ханддаг байлаа. Ийнхүү Бурханы шашин барууны нийгэмд том нөлөө үзүүлэх үйл явц эхэлсэн юм.

Бурханы хутгийн зам мөрийн зэрэгт хүрэхийг хүсэж байгаа бол гэргийтэн бус байх албагүй. Гэргийтэн бус байх нь зөвхөн тус дэмжлэг үзүүлдэг. Нирвааны хутгийг олох зам мөрийн зорилго нь биеийн таашаал эдлэх хүслээ таягдан орхих, таашаалаас бус харин таашаалыг хүсэх хүслээ орхих явдал юм. Ийнхүү орхиход сахил санваар, бясалгал, билиг ухааны үндсэн дээр хүрнэ. Сахил санваартай амьдрах гэдэг нь бусдад санаатайгаар аливаа хор хүргэхээс зайлсхийхийг хэлдэг. Амьтан алах, хулгай хийх, худлаа хэлэх зэрэг нь бусдыг хорлодог нь тодорхой. Өөрийн авааль нөхөр, эхнэртэйгээ гэргийтэн нар энгэр зөрүүлэх нь нүгэл юмуу сахил санвааргүй байдлын аль нь ч биш. Нөгөө талаараа энгэр зөрүүлэх нь хүсэл, сэтгэл ханахгүй байдлыг ихэсгэж байдаг учраас бусдын эхнэр, нөхрийг булаах хүслийг төрүүлж магадгүй. Энэ нь бусдыг гомдоож байгаа учраас нүгэл болдог. Гэргийтэн бус байх сахилын

гол зорилго нь хамгийн их ноёлогч хүсэл болох эр эмийн үйлийн жаргалын хүслийг оргүй болгох, сэтгэлийг чөлөөлөхөд тусалж, сэтгэлд чөлөөт орон зайг үүсгэх юм. Тэр орон зай нь эр эмийн үйлийн тухай байнгын бодлуудад сарнихаас сэтгэлийг хамгаалдаг. Дундаж хүн өдөрт нэлээд олон удаа эр эмийн үйлийн тухай боддог аж. Та үүнийг өөрийн сэтгэлдээ судалж үзээд өөрт тань гэргийтэн бус байх сахил хэрэгтэй, үгүй эсэхийг ойлгож болно.

Аливаа нэг жаргалыг мэдрэх болгонд тухайн жаргалыг хүсэх хүсэл улам нэмэгдэж байдаг, хүслээс төрсөн элдэв хий төсөөллүүд сэтгэлийг байнга сарниулдаг учраас гэргийтний амьдралд бясалгалын төвлөрөл үүсэхэд маш хэцүү болдог. Эрэгтэй, эмэгтэй хуврагууд хүсэл, төсөөллөөс ангид биш хэдий ч эр эмийн үйл үйлдэхгүй гэсэн шийдвэр гаргаж, амлалтаа өөрийн лам багш нарын өмнө өгсөн учраас сахил санваар нь энэ хүсэл шуналыг амархан хөөн гаргах орон зайг сэтгэлд үүсгэдэг. Тиймээс сахил санваар хүч чадлын эх үүсвэр болохоос бус зарим хүмүүсийн боддог шиг сул доройн эх үүсвэр биш. Тойн хуврагууд гэргийтэн бус амьдралыг зөв эсэхэд гагцхүү эргэлзэх үед сул дорой байдал үүснэ. Эргэлзээ нь ямар ч хувраг хүнд тохиолддог саад бөгөөд хэрвээ хувраг хэвээр байхыг хүсвэл эргэлзээг заавал даван туулах хэрэгтэй болдог. Гэргийтэн бус байх өөр нэг давуу тал бол эхнэр, нөхөргүй байснаараа гэр бүл тэжээх хариуцлагагүй болдог. Мэдээж гэр бүлээ хайраараа халамжлах нь сайхан, гэхдээ номоо сурах, бясалгах цаг ба хүч чадал хомс үлддэг.

Сайтар төвлөрөх нь хамаг зовлонгийн үндэс болох өөрийг төвчлөх мунхагийн ерөндөг болсон билиг ухааны суурь болдог. Энэ билиг ухаан нь нирвааны хутгийн үүд, гэхдээ нирвааны хутаг нь Бурханы зам мөрийн цорын ганц зорилт бус. Үлэмж их энэрэнгүй сэтгэл төрүүлсэн, хамгийн дээдийн зорилт нь хамаг амьтныг зовлонгоос гэтэлгэхийн тулд Бурхан болох дээд зорилт байдаг. Бусдад туслахын өмнө Бурханы хутагт хүрэхийг хүлээлгүй, гэгээрэлд хүрэх зам мөрийн эхнээс бусдад тусалж эхэлдэг. Зовлонт амьдралын хүрдний зовлонгоос гэтлэхэд нь бусдад туслахын тулд бие, сэтгэлийн жаргал нь туйлын дээд жаргал мөн гэдэг алдаатай үзлээ орхиход урмаар зоригжуулан зам мөрт хөтлөх хэрэгтэй юм. Эр эмийн үйлийн хүсэл шуналыг орхихын тулд энгийн мэдлэг нь хангалттай бус, сүсэг бас хэрэгтэй. Сүсэгтэй болохын тулд хуврагуудын ариун амьдрал ба дотоод амгалан нь орчлонгийн амьдралыг огоорох бололцоотойг үзүүлж байгааг бахдан үлгэрлэн дуурайснаар биелнэ.

Төвд лам нар өөрсдийн үлгэр дуурайлаар хиппи нарыг татсан шиг өнөөдөр ертөнцөд хүмүүс нирваан ба гэгээрэлд хүрэх зам мөрийн суурь болсон огоорох сэтгэл, сахил санваарт сүсэг бишрэл төрүүлэхэд барууны санваартан хуврагуудын бахдалт үлгэр дуурайл хэрэгтэй болоод байна. Үүнд л Бурханы шашины эрэгтэй, эмэгтэй хуврагуудын гэргийтэн бус амьдрах дээд зорилго оршдог. Тиймээс ч Бурхан багш, сахил санваараа ариунаар сахисан хуврагууд байгаа цагт миний зарлиг сургаал оршино, харин тийм хувраг үгүй болох цагт миний шашин устаж үгүй болно хэмээн айлджээ.

Буруу энэрэхүй

Монгол оронд хоёр өвлийг өнтэй давсандаа омгорхон Австралидаа буцаж очоод ярих зүйл ихтэй болж, тэгэхдээ чөлөөтэй давсалж байгаад гайхмаар болгоод ярихад ямар байх тухай тухтайхан бодож сууна. Мөн кабел телевизээр Үндэсний Газарзүй ба Амьтдын ертөнц гэсэн хоёрхон сувгийг үзэх дуртай болохоор байгалийн талаар чамлахгүй мэдлэгтэй болсноороо сайрхаж болно. Гэхдээ дахиад оцон шувуу, халим, эсвэл Аусси могой баригч галзуу хүнийг харвал өөрөө бүр галзуурах байх, гэхдээ сэтгэлд хамгийн тод үлдсэн гунигтай зүйл болгантай Африкийн Серенгети талд адгуусан амьтад сүрэг сүргээрээ аварга том тойрог үүсгэн давхилдах зураглал байлаа. Хаашаа ч давхих гээгүй атлаа сүргийнхээ аясаар давхилдан хоол, устай болох аз жаргалаа олно гэдэгт итгэсэн нь тэр байлаа. Зарим нь ангаж, өлссөндөө бахардан үхэж байхад, зарим нь амьдаараа том махчин амьтдын хоол болж байлаа ч тэд эцэс хязгааргүй, утга учиргүй тойрогт бусад сүргийн аясыг даган эцэж туйлдан зүтгэсээр байлаа.

Адгуусны энэхүү эмгэнэлт байдал нь эхлэлгүй цагаас бидний дотор нь эргэлдэж байсан сансарын хүрдийг дүрслэх дээд зэргийн жишээ юм. Төрөх тоолондоо урьд бүх төрөлдөө амсаж амжаагүй амгалан, жаргалыг олж, хамаг зовлонгоос ангижирсан байх болно гэсэн шинэ итгэл найдвараар дүүрэн байдаг. Үхэх тоолондоо бага залуу насандаа төгс төгөлдөр гэж бодсон зүйлдээ ч ядаж хүрч чадсангүй гэх уйтгар харууслаар дүүрдэг. Гэр бүлийн хүмүүс, найз нөхөд жаргалынхаа төлөө цуцатлаа гүйгээд балран унасныг харсаар байж төгс амар жаргалын хуурамч үзэгдлийн араас хөөсөөр сайхан амьдрал гэгч рүү арай ядан мацсаар байдаг нь урьдын олон төрлүүдийн нийтлэг мэдрэлийн өвчний тусгал юм.

Бидний олж авсан аз жаргал түр зуурынх бөгөөд байнга өөрчлөгдөн хувирдаг нөхцөл, шалтгаанаас хамааралтай байдаг учраас тэдгээр нөхцөл шалтгаан удалгүй эвдрэн алга болж, өнгөрсөн жаргалтай сайхан үеийг дурсаж авахуйн сэтгэгдэлтэй үлдээдэг. Английн зохиолч Жорж Оруэлийн “1984 Он” зохиолд, одоогийн улс төрийн уур амьсгалд тааруулан түүхийг олон дахин бичдэг түүхчид шиг, гол дүрийн жүжигчид бид муугий нь засаж арилган, сайныг нь улам өнгөлөн, өөрсдөө өөгүй сайхан харагдахын тулд бидний сэтгэл хувийн амьдралынхаа түүхийг байнга олон дахин бичиж байдаг. Энэ нь одоо байгаа аз жаргалаа мэдрэхэд улам бэрхшээлтэй болгосоор байдаг. Хэзээд харьцуулж, үүрд шүүмжилснээр улигт зөнөг хөгшин болоход хүүхдүүд нь хамт байхаасаа дургүйцдэг.

Тийм уйтгар зовлонтой болохын шалтгаан бол “би” үзэл, би буруудсан байж болно, тэр байтугай алдаа гаргаснаа ойлгох, өөр хүний зөв байж болно гэдгийг хүлээн зөвшөөрч чадахгүй болсон улигт санаатай холбоотой. Эхлээд биеийн дохио, зангаагаар санал зөрөлдөж байсан нь хурц, өрсөлдөгч байдлаар өөрийн үзэл бодлыг хамгаалах байдалд шилжих нь олонтаа. Улс төр, шашин ярихаар зарим хүмүүсийн өөрийн үзлээ бусдад тулгах хүсэл нь амархан илэрдэг. Итгэл үнэмшлээ “би” үзэлдээ нэгтгэн, өөрийн салшгүй нэг хэсэг болгосноор учир шалтгааны талыг орхигдуулан, өөр санал бодолтой нэгнийг доромжлох, эсэргүүцэх, тэр ч байтугай амь насыг егүүтгэх ч бий.

“Би” үзлийг хамгаалахын аймшигтай тал нь бусдыг довтолж, өөрийн итгэл үнэмшилдээ татан оруулах нь үүрэг болж хувирдаг. Энэрэнгүйн нэрээр зарим үйлийг зөвгөдөг ч гэсэн Бурханы номд: “буруу, өөдгүй энэрэхүй” хэмээн нэрлэдэг билиг ухаангүй энэрэхүйн том аюул байдаг.

Балбын Покара хэмээх газар амтаг жүржээр нэгэн цагт алдартай байлаа, гэтэл нэг Америк хүн ирээд: ”Та нарт Калифорнийн жүрж хэрэгтэй” гэлээ. Түүний авчирсан моднууд ургаж чадалгүй үхэж, өвчтэй байсан тул нутгийн уугуул жүржийн бутнуудыг хиаруулан үгүй болгосон юм.

Төвдийн Лхас хотод анх удаа Христосын номлогчид очиход Лам нар тэднийг найрсгаар угтан авч, олны өмнө номлолоо чөлөөтэй ухуулахыг хүлээн зөвшөөрсөн байжээ. Лам нарт Христосын номлогчдын сургаалийн учир шалтгааны холбоо төдийлөн сэтгэлд нь хүрч чадаагүй ч сайхан сэтгэлийн үүднээс тэднийг сүмээ барих, хүссэнээрээ залбирал мөргөл үйлдэхийг зөвшөөрсөн юм. Бурханы шашины уламжлал бол энэ юм, бодит ахуйг ухаарах билиг ухаанд хүрэхэд учир шалтгааны тулгын чулууг шүтэж ирсэн бөгөөд билиг ухаан нь үлэмж энэрэнгүй сэтгэлийн тулгуур болдог. Монгол түмний гайхамшигт билиг ухаан, энэрэнгүй сургаалийн өв уламжлал далан жилийн улс төрийн дарамт шахалтанд талхигдан унтрах дөхжээ. Оюун санааны хүч чадал, санхүүгийн эрх мэдлийн хувьд ч гадаад номлогчдын түрэмгийлэлтэй өрсөлдөх бололцоогүй байна. Бурханы номд сүсэгтэй боловч утга учрын талаар өчүүхэн мэдлэгтэй учраас Монголчууд хөрөнгө бэлтэй шашины номлогчдын коммунист үеийн Бурханы шашины эсрэг суртал ухуулгыг чөлөөтэй ашиглаж, өөрсдийн шашинд оруулах олныг хамарсан ажлын нөлөөнд автагдаж байна. Барууны хүмүүсийн үйлдэж буй соёл, шашины түрэмгийлэл нь Дорнын билиг ухааныг үгүйсгэж, өөрсдийн энгийн итгэл үнэмшлээ тулгахыг хүсэж байгаа нь Монголын ард түмэнд ч, дэлхийн нийтэд ч шудрага бус хандаж байгаа хэрэг юм. Хэрэв Монгол улс Бурханы шашины өв соёлоо сэргээх бололцоог алдваас Балбын амтаг жүрж сүйрсэнтэй зүйрлэшгүй их гарз хохирол хүний нийгэмд учирна.

Парламентын гишүүн болсон Шри Ланкийн анхны Бурханы шашины хуврагын уриа нь “Энэрэнгүй сэтгэлээр ажиглаж, билиг ухаанаар шинжил” хэмээх байжээ. Энэ үгийн утга нь хүмүүст туслахыг хүсэхдээ билиг ухаантай бай, туслах гэж байгаа хүмүүсийнхээ соёлыг бүрэн дүүрэн мэддэг байхыг хамааруулдаг. Христийн номлогчид Монголчуудын соёлын итгэл үнэмшлийг нь бодолцохгүй, ихэнх нь үүнийг тоохыг ч хүсдэггүй, тэд хэрвээ зөвхөн өөрийн итгэл үнэмшлийг үнэн хэмээн итгэлтэй байвал тэд жинхэнэ буруу энэрэгчид болж, энэ оронд байх нь тус гэхээсээ илүү ус болно

Үйлийн үрийн тухай цааш нь

Нэгэн өглөө, уг нь бясалгалд сууж байсан хирнээ тогтоон барихад хэцүү сэтгэл маань гэрлэлтийн тухай өгүүллийг зохиож байлаа. Би Грек Зорба гэрлэлтийн талаар юу хэллээ гэдгийг санахыг хичээж байлаа. Бясалгалын дараа аяга мюсли хийж, Английн мэдээллийн БиБиСи Уолд Сервисийг асаалаа. Тэр үед, миний санах гэж оролдож байсан киноны яг тэр дарааллын дууг тавьсан байлаа. Английн сэтгүүлч Зорбагаас та гэрлэсэн үү гэж асуухад, Зорба: “Би гэрлэсэн. Эхнэр, хүүхдүүд, гэр орон, бүх л юм байна. Бүгд сүйрэл” гэж хариуллаа.

Энэ бол ердийн нэг давхцал, гэхдээ иймэрхүү зүйл тохиолдоход хөшигний цаана өөр юу болж байгаа бол гэж бодохгүй байж чаддаггүй. Бурханы сургаалд юм бүхнийг бидний сэтгэлд оршиж буй үйлийн үрээс гардаг гэж үздэг. Амьдралд хэлбэр загвар оруулж байдаг субъектив, сэтгэлийн бүрэлдэхүүн нь дийлэнхдээ үл анзаарагдах юмуу ерөөс танигддаггүй. Тухайн их, бага хэмжээний үйл явдал нь түүний бий болох яг өмнөх үеийн сэтгэлийн байдлаас хамаардаг, учир нь сэтгэлийн хандлага чухам ямар үйл үр боловсрохыг шийддэг. Муу сэтгэлийн хандлагаар муу үйл явдалтай учруулах үйл боловсорно, зөв хандлагаар сайн үйл явдалтай учруулах үйл боловсорно.

Хэрхэн ийм болж байна вэ гэдэг асуулт гарна. Миний сэтгэлийн зарим хэсэг нь нэвтрүүлэг болох гэж байгааг мэдэж байсан учраас БиБиСи-г асаасан гэж хэлэх гээгүй байна. Энэ бол “зохицолдсон холбоос” бөгөөд сайхан сонсогдож байгаа боловч тайлбарлахад төвөгтэй. Үйлийн үрийн тухай бодоход тусалдаг дүрслэл бол тамирчид болон эмэгтэйчүүдийн бүх зүйл санаснаар нь болох, мөрийтэй тоглоомчид байнга хожоотой тоглох, эсвэл бүр эсрэгээрээ, ямар ч шалтгаангүй байтал бүтэлгүйтэх үеүд юм. Бидний хооронд болон эргэн тойронтой маш сайхан байх үеүд байхад заримдаа бүтэлгүй болчих үе бас байдаг. Миний өөрийн туршлага бол эдгээр үес нь миний өөрийн сэтгэлээс хамааралтай бөгөөд миний эргэн тойрны байдал миний сэтгэлийн тусгал төдий гэдэгт бүрэн итгэдэг. Тайван юмуу таагүй ертөнцийн хамгийн анхдагч шалтгаан нь тайван юмуу таагүй сэтгэл юм. Амьдрал зөөлөн урсах, ширүүн урсах, тэр хооронд олон янз болох нь тохиолдол биш. Өчүүхэн төдий байлаа ч гэсэн ямар ч зүйлийн цаана шалтгаант хүчин зүйл байдаг. Альберт Эйнштэйн байгальд эмх журам байгааг ажиглан харж, ертөнцийг шоогоор тоглон шийддэггүй хэмээн хэлсэн шиг Бурхан багш ч гэсэн бидэнд тохиолддог сайн болон муу зүйлийг санамсаргүй тохиолдол болсон гэж үзэх бололцоогүй хэмээжээ. Амьдралд тохиолдож байгаа үйл явдлууд сайн ба муу зүйлтэй учруулах үйлээс хамаардаг. Сайн эсвэл муу сэтгэлийн хандлагаар тэдгээр үйлийн чадамжууд идэвхжих үед зохих туршлага болон тухайн туршлагаар мэдрэгдэж байгаа зүйл нэгэн зэрэг тохиодог. Энэ бол Бурхан багшийн хувьсгалч бодол юм. Сайн үйл нь амьдралын турш зөөлөн явцыг бий болгодог нь Тао мах нядлагчийн хэзээ ч ирлэх шаардлагагүй хутгатай адил хөнгөн, муу үйл нь жаран есөөр Монголын замаар явж байгаа юм шиг донсолгоотой, нугачаатай болох явцыг үүсгэдэг.

Тухайн туршлага болон тухайн туршлагаар мэдэрч байгаа зүйл хоёр, нэгэн зэрэг бий болдог гэсэн юун яриа гараад ирэв? Дээрхийн гэгээнтэн Далай лам багш бодисын ертөнцөд материйн хамгийн нарийн хэлбэрийн үргэлжлэл байдаг хэмээн айлдаад түүнийг огторгуйн хэсгүүд хэмээн нэрлэжээ. Үйлийн боловсролоор бидний сэтгэл болон эдгээр огторгуйн хэсгүүдийн хооронд харилцан үйлчлэл явагдсанаар хувь хүний ертөнцийн биет бодит байдал

үүсдэг аж. Гадаад ертөнц биднийг хүлээгээд байж байдаг гэж бид байнга боддог байсан, энэ бол тэдгээрийг бид мэдрэхээс өмнө оршиж байсан гэсэн үг юм. Тийм биш хэмээн Бурхан багш айлджээ. Тухайн нэг мөчид боловсрох бололцоотой олон учралын гагцхүү нэг нь л боловсроно, энэ нь сэтгэлийн хандлага болон тэр сэтгэлийн хандлагаар боловсрох үйлийн чадамжаас хамаарна. Хүмүүс болон зүйлүүд бидний амьдралд үргэлжлэн оршин байгаа мэтээр харагдах нь үргэлжлэн буй үйлийн боловсролын үр дагавар бөгөөд одоогийн үйл хийгээд сэтгэлийн төлөв байдлаас ангид тусгаар оршдог юу ч үгүй.

“За л даа, миний ээж надаас ямар ч хамааралгүй оршиж байгаа шүү дээ” гэж та хэлэх байх.

Хэдийгээр таны ээж тусгаар бие хүн боловч таны түүнтэй харьцах харьцаа бол ерөнхийдөө таны сэтгэл болон ээжийн тань сэтгэл хоёрын хоорондох үйлийн уялдаа холбоосын нарийн сүлжээний үр дүн юм. Ээж тань хэрхэн үзэгдэж байгаа, тантай хэрхэн харьцаж байгаа, бүх зүйл таны үйлээс хамаарна. Түүгээр ч үл барам таны ээж гэж нэрлэж байгаа хүн таныг төрөхөөс өмнө ээж биш байсан нь тодорхой. Таны хувьд зөвхөн “таны ээж” байгаа нь таны сэтгэл ба түүнтэй тогтоосон онцлог харьцаанаас үүдэлтэй Таны өвөөгийн хувьд “миний охин”, таны эцгийн хувьд “миний эхнэр” болно. Өөрийнхөө зүгээс, ээж тань дээрх хүний аль нь ч биш.

Өөрийгөө ухамсарлах, өөрийн бодож байгаа шигээ өөрийгөө үнэхээр тийм гэж итгэх нь бидний хамаг зовлонгийн үндэс юм. Бусдын санасан хэмжээнд хүрэхийн төлөө санаа зовсноор омог, дээрэнгүй, хомхой зэрэг нь бүгд мөрийтэй тоглоомчид, тамирчдыг алдагдалд оруулахад хүргэдэг. Өөрийгөө мартсан үед л гагцхүү дээд зэргийн үзүүлэлт гарна.

Үйл бол мунхаг, уур, шуналын муу сэтгэлийн нөлөөнд буй төрөлхтөнүүдийн сэтгэл дэх санаа буюу эрмэлзэл хүчийн энерги юм. Хувь тус бүр үйл нь бидний амьдралд олон янзын үйл явдлууд тохиолдох шалтгаан болдог. Хамтын байдлаараа, үйл нь бүхэл ертөнцийн бүтээгч хүч болдог. Материйн физик, химийн энергүүд нь үйлээс ангид орших боловч материйн угийн эмх замбараагүй байдал тодорхой хэмжээгээр дэг журамтай болохдоо төрөлхтөнүүдийн нийтийн үйлээр зохион байгуулагддаг. Бурханы хутгийг олсон хүн нь хувь хүнийхээ үйлээс арилсан байдаг. Санаа буюу эрмэлзэлийн бүтээлч зарчим хэвээр үлдэх боловч харин одоо билиг ухаан ба энэрэнгүй сэтгэлээр аяндаа үйлдэх бөгөөд түүнийг үйлийн үр гэж нэрлэдэггүй.

Гэр бүл, хөрш айлууд, улс үндэстэн хоорондох зөрчил нь өөрсдийн сэтгэл ба үйлийн үүргийг таньж мэдээгүй цагт зайлшгүй байх болно. Жорж Буш дайснаа дарахын тулд сансар огторгуйд зэвсэг тавихыг хүсэж байна. Тэр пуужингаа өөрийнхөө толгойд чиглүүлбэл хамаагүй дээр байхсан, мэдээж зүйрлүүлж байгаа шүү дээ.

Гэрлэлтийн тухай нийтлэлийн хувьд гэвэл бүгдийг нь Зорба хэлсэн шүү дээ, үгүй гэж үү?

Зам мөр

Аз болоход эхээс мэндлэх үед ганцаардаж, айж байснаа санаж чаддаггүй юм. Цаг өнгөрөхийн хирээр толгойг минь эв хавгүй шахаж, амьсгал боогдох шахам болж байгаад эхийн умайгаас гарах үед хэн ч хажууд байж сэтгэл засаагүй билээ. Амьдралын төгсгөл болж үхэхэд мөн л ганцаараа үхнэ. Биетэйгээ хичнээн удаан хамт байхыг хүссэн ч, гэр бүл, найз нөхөд үлдэхийг хичнээн их гуйсан ч тэднийг орхиж, ганцаараа цааш явахаас өөр аргагүй.

Амьд байхдаа ч гэсэн ганцаараа амьдарлыг туулдаг. Хэдийгээр дотоод гүн бодол, мэдрэмжээ илэрхийлэхийг хүсдэг ч гэсэн хэнтэй ч хуваалцахын аргагүй, яагаад гэвэл өөрөөс тань өөр хэн ч сэтгэлд орж чадахгүй. Үхэхэд бие ард хоцорч, сэтгэл сайн, муу бүх чанарууд, дадлуудаа тээн хойд төрөлдөө одно. Зовлонд сөхрөн бууны амаар толгойдоо нүх гартал тэсэлсэн ч сэтгэлийг устгаж үгүй болгохгүй. Бид үүрд сэтгэлтэй байх бөгөөд энэ төрлөөс ч долоон дор байж болох хойд төрөлд зовлонгоо шууд авч явдаг. Биеэс ялгаатай тал нь сэтгэлийн чанарыг байнга сайжруулах бололцоотой ба одоогийн сүйрэлт байдлаас билиг ухаан ба амгалангийн дээд нэгдэлд хүргэж болдог. Үүнийг хэрэгжүүлэхийг гэгээрэлд хүрэх оюун судлахуйн зам мөр гэнэ.

Оюуныг судлах зам мөр эргэлзэхээс зайлшгүй эхэлнэ. Одоогийн байдлаар бидний сэтгэл ертөнц болон өөрсдийн тухай дотоод ба олдмол замбараагүй бодолтой байгаа. Бодит байдалд дөхсөн бодолтой байх тусам амьдрал төдий чинээ аз жаргалтай болно, бодит байдлаас хол байх тусам улам аз жаргалгүй болно. Мэдэх зүйлс хязгааргүй олон, гэхдээ нирвааны амгаланг мэдрэхийн тулд дэлхийн бүх шавьжийг заавал мэдсэн байх шаардлагагүй. Мэдсэн байх шаардлагатай зүйл бол хүн байхын утга учир-туйлын утгаараа хувь хүн байдлаар хэрхэн оршдог ба үйлийн шалтгаан ба үр дагавараар хэрхэн энд ирсэн бэ гэдгийг мэдэх. Эргэлзээ гэдэг бол өөрийн үнэн гэж бодож байгаагаа эргэцүүлэн бодож, шинжлэхдээ учир шалтгааны арга хэрэгсэлийг ашиглан, өөрийн амьдралтай хэрхэн нийцэж байгааг харьцуулахыг хэлж байгаа юм.

Зам мөрд ороход дараагийн хоёр туслагч бол зовлонтой төрөлд төрөхөөс айх айдас ба Бурхан ба түүний сургаальд сүсэглэх. Үйлийг шинжлэхэд там, бирд, адгуус зэрэг аль нь ч хүсээгүй төрөлд очих бололцоог сэтгэл агуулдаг болохыг ойлгож эхэлдэг. Хэрвээ өвдөлт, зовлон, мунхаглал ноёрхсон эдгээр муу төрлүүдээс айхгүй бол тэнд төрөхөөс зайлсхийх юу ч хийхгүй. Тэдгээр төрөлд төрж үнэхээр болзошгүйг ойлговол аз жаргалтай, аюлгүй төрөлд төрөхөд хөтлөх баримжаа чигийг амьдралдаа хайх болно. Тамаас айх хамгийн хүндэтгэлтэй арга нь тэр зовлонг амсаж байгаа төрөлхтөнг энэрч, тэднийг аврах санааг үүсгэх юм.

Амьдралдаа зөв чигийг нээн, баримтлахын тулд эхлээд итгэж болох хэн нэгнийг олох хэрэгтэй. Тэр хүн бодит байдлыг мэддэг, хувь хүний аюулаас гэтэлсэн, таныг хөтлөх чадвартай, ялгаварлал үгүй асрахуй, энэрэнгүй сэтгэлээр үүссэн бусдыг хөтлөх хүсэлтэй байх хэрэгтэй. Хоёрдугаарт, тэр хүнээс тодорхой зааварчлага авсан байна. Гуравдугаарт, зам зуур танд учрах бэрхшээлүүдийг урьд нь даван туулсан хамтран аялагчдын сайхан сэтгэл, дэмжлэг хэрэгтэй болно. Эдгээр гурав буюу хүн, сургаал, туслагч нарт итгэх сүсэг энгийн хүндлэлээс эхлээд тэднийг дуурайх дуршил, өөрт буй болж буй билиг ухаанаар тэдгээрийн орших үнэнд гүн итгэх хүртэл хүрнэ.

Өөртөө найдах ба оюуны зам мөрд үл итгэх үзэл тогтсон өнөө үед өөрийнхөө амьдралыг хэн нэгний гарт өгнө гэдэг тухай бодохын төдийд эсэргүүцэх сэтгэл төрнө. Гэхдээ багадаа энэ дэлхийд орж ирэхдээ аймшигтай байсны дараа арай гэж найзаа олж, ээждээ өөрсдийгөө бүрэн өгч чадсан шүү дээ. Оюутан байхдаа багш нартаа итгэдэг байсан, анхныхаа ажлыг хийж байхдаа зааж сургаж байгаа хүндээ итгэж байсан, гэх мэтээр. Тэгэхлээр хэрвээ бид гэгээрэх зам мөрийг дагахыг хүсэж байгаа бол эрдэм төгс багшийн гарт амьдарлаа өгнө гэсэн үг юм. Оюуны зам мөрт өсөж томрох тусам сэтгэлдээ хураан дадуулсан билиг ухаан ба энэрэнгүй сэтгэл нь бидний дотоод хөтлөгчид болдог.

Ертөнцийн бүх зорилгод хүрэх шуналаас магадтай гарсан сэтгэл дээр үндэслэсэн билиг ухаан ба энэрэнгүй сэтгэл нь гэгээрлийн зам мөрийн утга шим бөгөөд гагцхүү эдгээрээр дамжуулан аюулгүйгээр өөртөө найдаж болно. Билиг ухаангүй бол өөртөө найдах байдал нь би-үзлийн дээрэнгүй байдлыг номын үйлдлээр халхалсан хэлбэртэй болно. Ийм аюултай хавх шашин бүрийн дагагч нарт тохиолддог бөгөөд үүнд унасан хүмүүсийн нэгийг хэлж, нөгөөг үйлдэж байгаа нь шашины холбоотой бүх зүйлд үл итгэх үзлийг төрүүлэх олон гол шалтгааны нэг юм. Бусдын гаргасан алдаанаас болж өөрийн сэтгэлийг зам мөрийн эсрэг урьдчилан буруу бодох нь залхуугийн шинж тэмдэг юм. Бусдын алдаанаас суралцаж, зам мөрөөр өөрөө орон, тэдний алдсан зүйл дээр амжилт гаргах зоригтой байх ёстой. Сургаал хийгээд багш нарыг шинжлээд, тэдний заасан, үйлдсэн болгоныг өөрийн амьдралын туршлагатай харьцуулснаар төлөвшсөн сүсгийн үүрэг үүнд оршдог. Дараа нь тухайн оюун судлахуйн зам мөрийг дагах эсэхээ зөв шийднэ.

Амиа бодох мунхаг болон бусад муу сэтгэлүүд гүн нэвтэрсэн байдаг учраас тэдгээрийг үгүй болгох зам мөрт олон мянган төрлийг зориулах хэрэгтэй болно. Тиймээс тэвчээр ба хичээнгүй хэрэгтэй. Олон хүн дээд эрдмүүдийг олохын төлөө маш их өөдрөгөөр эхэлдэг боловч хэдэн сар, жилийн дараа юу ч болоогүй юм шиг санагдахад түүнээсээ бүрэн татгалздаг. Эсвэл жижиг ололт дэвшлээр сэтгэл ханаж, өндөр настай гэж шалтаглан хойш сууж, үлдсэн амьдралдаа юунд ч санаа зовдоггүй. Харин хоосон чанарыг онох хүртэл хойд төрөлдөө зам мөрөөр явах адилхан бололцоо олдоно гэдэгт баталгаа үгүй. Тиймээс дэмий үрэх цаг хугацаа үгүй бөгөөд мөч бүрийг сонсох, бодох, бясалгах эрдэм, бусдыг хайрлах, энэрэх чадвараа нэмэгдүүлэхэд зориулах ёстой.

Амьдралд ганцаараа байдаг шиг зам мөр ч мөн тийм, дотоод хөгжил, өөрийн зан байдлын өсөлт торнил учраас хэнтэй ч хуваалцахын аргагүй. Ганцаардлын мэдрэмж аажмаар замхран алга болдог ба яагаад гэвэл оюун судлахуйн зам мөрийн хамгийн гол хэсэг нь үлэмж их асрахуйн сэтгэл буюу дэлхий даяар зүрх сэтгэлээ нээдэг учраас тэр. Төрөлхтөн бүр бидний сайн нөхөд болно. Бурханы шашины амьдралын уриа бол яг энэ юм: хамаг төрөлхтөн миний анд нөхөд билээ.

Монголд нинбад суусан нь

Өнгөрсөн зууны эхээр Улаанбаатар хотоос зүүн талд 300 км зайд орших Балдан Бэрээвэн хийдэд гурван мянга шахам лам хувраг шавилан сууж байлаа. Хоёр гурван мянгаад сүсэгтэнүүд ойролцоох сууринд суудаг байлаа. Эхлээд салхин цэцэгтэй төстэй тахал гарч оршин суугчдын олонхийн аминд хүрсэний дараа коммунистууд сүйрлийг тэр чигт нь дуусгажээ. Энэ орны нүүдэлчдийг капиталист систем довтлоогүй байсаар байтал коммунистууд өөрсдийн харалган үзэн ядалтаа сүм хийдүүддээ чиглүүлжээ. Эхлээд хуврагуудад инээд хүрмээр их алба гувчуурыг оноож, түүний дараа гувчуураа төлөөгүй нэрээр 1930-аад онд гурван жилийн хугацаанд ахмад болон сүм хийдүүдийн шилдэг эрдэмтэй лам нарыг баривчлан авч явж хөнөөсөн байна. Түүнийг гэрчлэх хүмүүсийн ярианаас сонсоход коммунистуудын бууны сум тэдний ар толгойд ороход цаашаа унах урт ухсан нүхний ирмэг дагуу Лам нарын шар малгайнууд зэрэгцэн эгнэсэн байжээ. Насаар залуу хуврагуудыг Сибирьт цөлж, хэл чимээ дахин хэзээ ч сонсогдоогүй аж. Хүүхдүүдийг гэрт нь буцааж, малчин болгодог байж. Коммунистууд хотхон шахуу байсан тэр хийдээс бүх хэрэгцээтэй барилгын материалуудыг авч, ариун шүтээнүүдийг эвдлэн сүйтгэж, үлдсэний нь шатаажээ.

Өнөөдөр гол дуганы гадна талын оройгүй хэсэг үлдсэнээс өөр юу ч үгүй. Боржин сууринууд нь хуврагууд болон сүсэгтнүүд хаана модон болон эсгий байшин, гэрт суудаг байсныг гэрчилнэ. Газар, гэр ахуйн болон шашины хагарч гэмтсэн эд зүйлс хөглөрнө, шилмүүст болон цагаан хус моднууд эргэн тойрны боржин өндөрлөгөөс мөлхөн гарч ирсэн нь өөрсдийн хөндийг тунхаглах мэт байлаа. Эндээс хүмүүс нүүцгээжээ, ямар ч фэн-шуй-н хүнд таалагдах байсан хад чулуун хэлбэр нь сайхан байдлаар тогтсон энэ газар зуны эхэн сард ганцхан хөхөө шувуу донгодох нь сонсогдоно. Бурханы сургаал нь амьд байхын тулд содон сайхан хад чулуунаас илүү зүйлийг шаарддаг.

Энэхүү эмгэнэлт дүр байдлыг засах итгэлийн гэрэл нь Сан-Франциско хотын иргэн Марк Хинцкийн хичээл зүтгэл ба тэрээр гол дуганыг сэргээж, хөндийг дахин Бурханы сургаалийг үзэж, судлах газар болгохоор зорьсон Соёлын өвийг сэргээх аялал жуулчлалын төслийн үндэслэгч юм. Монголчуудад сэргээн босголтын ажилд туслахаар ирсэн дэлхийн өнцөг булан бүрийн хүмүүст Марк энгийн байр, хоол ундыг хангаж өгдөг. Соёлын аялагчид хөнгөн хөдөлмөр хийж, тэдний аялалд төлсөн мөнгө төслийг санхүүжүүлдэг ба бусад хувь хүмүүс, ирээдүйн сайхныг боддог байгууллагууд хөрөнгө хандивладаг. Эргэн тойрны байгалийн үзэсгэлэнг баясах цаг зөндөө, тэр хөндий тэр чигээрээ Чингис хааны нутаглаж байсан нутаг байжээ. Мөн тоглох цаг ч олдоно, гэхдээ болгоомжтой байгаарай, би одоо болтол Балдан Бэрээвэн хийдийн 2001 оны Олимпийн шуудайтай гүйлтийн уралдаанаас олсон өвдгийн гэмтлээс өнөөнөөс л эдгэрч байгаа.

Би Балдан Бэрээвэнд 2001 оны 6-р сарын дундуур нутгийн хүмүүс болон сэргээн босголтын ажил эрхэлж байгаа сайн дурынханд Бурханы сургаалийн хичээл заахаар очсон юм. Нэг долоо хоногийн хугацаанд хэсэг Лам нар аймгийн төвөөс сүсэгтнүүдийн хамт маанийн бүтээлд ирж, Энэрэн нигүүлсэхүйн Жанрайсиг бурханы тарнийг олон мянга дахин уншсан юм. Тэдгээр Лам нар ная, ер гаруй насны хүмүүс байлаа, тэд бага байхдаа хийдийг нураахаас өмнө хөөгдөж гарсан жаахан хуврагууд байжээ. Тэд мал хариулж, шашин дахин эрх чөлөөтэй болоход шашин номынхоо амьдралд дахин оржээ. Хүмүүс холоос мориор ирцгээж, тэр

хөндий “Монголын нэг өдөр”-ийг үзүүлсэн алдартай зургийн сонгодог дүртэй адил боллоо. Гэр, майхнууд мөөг шиг ургаж, энд тэндгүй гал дээр хоол хийж, мод түүцгээж, адуу, нохой, хонь, ямаа, мал, хүүхдүүд тоглож байлаа.

Лам, сүсэгтэн нар нийлсэн тавь шахам хүн гол нурангийн хажууд шинээр модоор барьсан дуганд миний хичээлийг сонсохоор суусан юм. Орчин үеийн Монголын гунигтай байдлын тухай миний хэлсэн зүйлтэй санаа нийлсэн настай хүмүүс хөлөө дэвсэн, шалан дээр шүлсээ хаяж, зарим нь бүр нулимс гарган илэн далангүй сэтгэл нь хөдөлж байлаа. Тэдний сүсэг их байсан боловч сүсэгтэн ч тэр, Лам нарын аль нь ч Бурханы сургаалийн талаар үнэндээ сонсоогүй байлаа. Миний яриа нэг цаг хагас үргэлжлэх ёстой байсан ч тэд цагаа уртасгаж өгөхийг хүссэн юм. Бурханы номын төлөө амиа өгсөн Лам нарын ерөөл биелж, Бурханы сургаал хөндийд буцаж ирсэнд тэдний сэтгэл даган баясаж байгаа юм шиг хүчтэй, баяртай энергийг мэдэрч байлаа. Нэгэн залуу Лам сунаж мөргөх тухай, түүний утгыг тайлбарлаж өгсөнд чин сэтгэлээсээ баярлаж буйгаа хэлж билээ. Тэдний хийдийн хорь гаруй хуврага багшгүй учраас намайг хийдэд ирж, багшлахыг хүссэн юм.

Би сайн дурынханд Төвдийн их эрдэмтэн, бясалгаач Богд Зонховын 12 алд өндөр, хөндийн дээд хэсэгт боржин хаданд сийлж бүтээсэн дүрийг хагас булагдсан газраас ухаж гаргахад тусалсан юм. Бууны сумнаас бололтой гэмтэл байсан боловч баримал сайн хадгалагдсан, будаг, алтан шармалын ул мөрүүд байлаа. Дараа нь бид Майдар бурханыг нэгэн цагт залсан байсан сүмийн балгасыг цэвэрлэсэн юм. Шавраар бүтээсэн байсан учраас цэргүүд болон цаг агаарын эрхэнд амархан гэмтсэн байлаа. Балгасанд булагдсан байсан 3 алд өндөр, боржин чулуунд сийлсэн Дарь-эх бурханы дүр болон бас шавраар сайхан урласан зарим дүрүүд олсоны нэг нь Арслан-нигурт Дагина байсан бөгөөд намайг Австрали руу авч явахыг зөвшөөрсөн болохоор би түүнийг Викториа хотын Бендигогийн ойролцоо барьж байгаа Төвдийн Ганцэ сувраган дахь шүтээнүүдийн дунд тавих юм.

Дараа нь би гэр түрээсээр авч, миний орчуулагч Гүнжиймаа бид хоёр нинбад суухаар хөндийг өгсөн зургаан зуун метр хир, нам гүм, цэлгэр газар нүүж очлоо. Тус бүрийн майхандаа унтаж, бясалгалаа хамт гэрт хийж, гадаа гал түлж хоолоо чанадаг байлаа. Ойролцоо урсах горхины ус тунгалаг, хүйтэн байлаа, Чингис Хаан “Шар горхи” гэж нэрлэсэн гэдгийг мэдэхээс өмнө би “Мөсөн горхи” гэж нэрлэдэг байлаа. Эргэн тойрон усан үзмэн ягаан, шар, цагаан, улаан ягаанаараа цэцэгс алаглан, тарваганы нүхний хажууд ихээхэн ургасан гишүүний дундуур явдаг байлаа. Гишүүнэ бидний хоолны амтат нэмэгдэл болж байсан боловч төв зуслангийн байрнаа элсэн чихэр яаралтай авчруулах хэрэг гарч байлаа. Нэг удаа хажуугийн ойд чоно шөнө ульж хоносны дараа Гүнжиймаа тоглон: “Намайг чоно идэх нь гэж бодоод Гурван эрдэнээс аврал их гуйлаа, өчигдөр шөнө л би жинхэнэ Бурханы шашинтан боллоо” гэлээ.

Нинба эхлэхээс өмнө Дэмчог, Нарожажодын ёсны егүзэрүүдийн бясалгалын тусгай орон болж байсан хандмаа нарын хийдийн нурангийг үзэхээр уул даван цул цэцэгтэй газрын цаахна алхан очсон юм. Гэгээрэлд хүрэх энэхүү гүн бөгөөд түргэн мөр нь олон зууны өмнө Энэтхэгээс Төвдөд дэлгэрчээ. Тэр бясалгалын сургаал удалгүй Төвд болон Монголын Бурханы шашинд нэлээд чухал байр суурь эзлэх болсон юм. Тус алс хөндийн таван га газар хандмаа нарын хийдийг сэргээх зөвшөөрөл авсан сүсэгтэн эмэгтэй биднээс туслалцаа хүссэн юм.

Туслахыг хичнээн их хүсэж байлаа ч энэ оронд Бурханы сургаалийг сэргээхэд туслах маш их зүйл хийх хэрэгтэй байгаа болохоор бидний хүч чадал мөхөсдөж байна. Хаана хүчээ илүүтэй төвлөрүүлэхийг мэдэхэд хэцүү. Нурсан хийдийн чулуун завсар Дээрхийн гэгээнтэн Далай ламын хөргийг тавьж, шар хадаг өргөөд Очирт хөлгөний ном дахин дэлгэрэхийг ерөөн залбирч байлаа.


Бясалгал нинбад суусан нь Улаанбаатар хотын хөл үймээнээс зайдуу сайхан амралт байлаа. Ариун дээд номын шимийг хүртээсэн Лам багш нартаа мөргөж, элэг зүрхний угаас үлэмж ачийг дурьдъя. Хоёр долоо хоногийн дараа зуслангийн төв байранд буцан ирж, зэрлэг гишүүнийг амрагчдад танилцуулахад тэд амтархан идэж, ялангуяа ялзарсан модон дээр ургасан мөөгөнцөр илүү амттай байлаа. Мөн нутгийн ойртдоггүй газрын хориог төгсгөл болгохоор хоёр галууг ихээхэн уурлуулж, зузаан бүрхэн урсах өвсөн дээгүүр яван, дараа нь хөндийн голд байрлах нуурыг гаталж сэлсэн юм. Хүмүүс тэр намагт (тэр нь байдаггүй) орвол живж, уулын цаад талын өөр нуурнаас гарч ирдэг “нэг удаа үхэр тэгж гарч ирсэн” хэмээн ярьцгаадаг байжээ.

Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах

Төв-ийн тухай товч танилцуулга



Түвдэн Ешэ ламтан



Түвдэн Зопа Ринбүчий ламтан

Олон улсын төвүүд

Төвдийн их ламтан Түвдэн Ешэ болон түүний дэргэдийн шавь Түвдэн Зопа Ринбүчий нар 1970-аад оны эхээр Балбын нийслэл Катмандуд Копан хийд байгуулсан нь Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах Олон Улсын Төвийн эхлэл болсон юм. Копан хийдийн үйл ажиллагаа 1976 оноос эхлэн одоогийн нэрээр улам өргөжин тэлжээ. Өнөөдөр 130 гаруй Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах Төв дэлхийн олон оронд Бурханы сургааль, номлол, гүн ухааныг зааж, бясалгалын тухай тайлбарлан бясалгал хийх сонирхолтой хүмүүсийг хөтлөн удирдах үйл ажиллагааг явуулж байна. Ийнхүү Буддын номлол сургаалыг заах судлах ажлыг гол зорилгоо болгохын сацуу эрх чөлөөгөө хязгаарлуулсан хоригдлууд, өнчин ядуу хүүхдүүдэд тусламж үзүүлэхэд анхаардаг юм.

Түвдэн Зопа Ринбүчий

1946 онд Балбад мэндэлсэн. Нинма ёсны Лавудо Ринбүчийн хойд дүрээр тодорсон. Тэрээр өөрийн язгуурын багш Ламтан Түвдэн Ешийн хамт Копан хийдийг байгуулжээ. Тус хийдэд 1972 оноос эхлэн олон мянган барууны хүмүүст Бурханы шашныг номлон дэлгэрүүлж байгаа билээ. Лам Зопа Ринбүчий эдүгээ дэлхийд 130 гаруй салбар төвтэй Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах Төвийн шашин номын тэргүүн нь юм. Сургааль номлолоо айлдахаас гадна, тоолшгүй олон амьтны тусын тулд Майдар Бурхан бүтээх төсөл, Иргэний Боловсролын сургууль, эрүүл мэндийн салбарт Майтри, Лэпроси зэрэг нийгэм, хүмүүнлэгийн чиглэлээр олон томоохон төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна.

Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах Монгол дахь Төв

Хэсэг монгол залуус Түвдэн Зопа Ринбүчийд Бурханы ном сургаалийг таниулан заах үйл ажиллагаа бүхий төвийг Монголд байгуулах хүсэлт айлтгасан ёсоор 1999 онд тус төв

байгуулагджээ. Монгол дахь Их хөлгөний Уламжлалыг Хадгалах Төвийн гол зорилго нь Монголын Бурханы шашины үнэт өв уламжлалыг сэргээн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэдэд бурханы сургаалийг тайлбарлан заахад оршино. Тус төвийн гол үйл ажиллагаа нь өдөр бүр шахам Бурханы ном сургаалийн хичээл, айлдвар, бясалгалыг явуулах хийгээд сургааль номыг орчин цагийн монгол хэлэнд буулган хэвлэж олон нийтийн хүртээл болгох нь юм. Үүнээс гадна эмзэг давхаргынханд халуун хоол болон шаардлагатай тэжээл, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх зэргээр нийгмийн халамжийн ажил явуулдаг ба англи хэлийг сурах сонирхолтой хүмүүст зориулан үнэ төлбөргүй сургалт явуулж байна. Үүнээс гадна сүм хийд, эрэгтэй, эмэгтэй санваартнуудын номын үйл, сургалтанд тус нэмэр болох ажлуудыг явуулдаг билээ. Төв үйл ажиллагааныхаа хүрээг өргөжүүлэн, Дархан-уул суманд Алтангэрэл судар төвийг байгуулан тус аймгийн ард иргэдэд Бурханы номыг хүртээх ажлаа эхлээд байна. Их Хөлгөний Төвд Монгол, Түвд багш нараас гадна барууны олон сайн дурын ажилтан багш нар ирж ажилладаг.

Манай хаяг: Барилгачдын талбай, Худалдааны гудамж-16

“Анод” банкны хажууд

“Их Хөлгөний Уламжлалыг Хадгалах Төв”

Утас: 321580

Table of Contents

Удиртгал	
Энэрэнгүй сэтгэл	
Дулаан сэтгэл	
Сэтгэл	
Би гэж юу вэ?	
Уур хилэн	
Түрэмгийлэл	
Сүсэг	
Ёс суртахуун	
Хүсэл	
Өөрийгөө Үнэлэх Үнэлэмж	
Омог	
Зовлон	
Магад гарах сэтгэл	
Төрөл, амьдрал ба үхэл	
Бэрхшээл, бэрхшээл, бэрхшээл	
Бодит байдал	
Итгэл	
Үйлийн үр	
Рэмбогийн хүчин үйл	
Бясалгал	
Том болох	
Лам багш	
Ганцаардал	
Өглигч сэтгэл	
Ёс зүй	
Би яагаад үүнийг үйлдэж байна вэ?	
Ариусал	
Амьдралын зорилго	
Өөрийгөө анагаах нь	
Эрх чөлөө	
Уян хатан чанар	
Шашин	
Санан дурьдахуй	
Хий үзэгдэл	
Нийтийн зөвшлөөр орших	
Сэтгэлийн хямрал	
Гэргийтэн бус амьдрал	
Буруу энэрэхүй	
Үйлийн үрийн тухай цааш нь	
Зам мөр	

